




УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
СУРГАЛТЫН
ХҮРЭЭЛЭН

ПАРЛАМЕНТ



СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

БОТЬ
42

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

“ПАРЛАМЕНТ”

(Судалгааны эмхэтгэл)



- o Эдийн засгийн судалгааны хэсэг
- o Эрх зүй, төрийн байгуулалтын судалгааны хэсэг
- o Байгаль орчин, Хүнс, Хөдөө аж ахуйн судалгааны хэсэг

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР ХОТ, 2023

“Парламент” судалгааны эмхэтгэл (42 дугаар боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа,
сургалтын хүрээлэнгээс эрхлэн гаргав.

Хянасан: Ц.Цогзолмаа
Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл
Р.Оргилмаа

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Төгсзаяа



ГАРЧИГ

I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ

- 1.1 Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсад тулгамдаж буй асуудлууд (СТ-22/409)..... 6
*Ц.Норовдондог (Ph.D), О.Нарантуяа,
Ц.Ариунаа, О.Билгүүтэй, Б.Туул*
- 1.2 “Ковид-19” цар тахал, олон улсын нөхцөл байдлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийн үед иргэдийн орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр бусад орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ (СТ-22/309)..... 22
*Ц.Норовдондог (Ph.D), О.Билгүүтэй, Г.Алтан-Оч (Ph.D),
Д.Халиун, И.Жаргалзаяабямба, Б.Туул, Б.Мөнгөнсувд*

II БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

- 2.1 Төрийн сүлдний бэлгэдэл ба түүхэн уламжлал, шинэчлэл: Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага (СТ-22/220)..... 63
*Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ,
О.Нарантуяа, Б.Туул, Б.Мөнгөнсувд*
- 2.2 БНСУ-ын Үндэсний Ассамблейн хяналт, шалгалт ба томилгооны сонгол болон АНУ-ын Конгрессын нийтийн сонголын талаарх эрх зүйн зохицуулалт (СТ-22/410)..... 137
*Г.Алтан-Оч (Ph.D), И.Жаргалзаяабямба,
О.Нарантуяа*
- 2.3 Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам, түүний хэрэгжилт ба олон улсын жишиг (СТ-22/310)..... 160
*Г.Билгээ, Д.Халиун, О.Нарантуяа,
П.Уранчимэг, Ц.Ариунаа*

III. БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ

- 3.1 Стандартын талаар Монгол Улс дахь хууль тогтоомжийн зохицуулалт болон гадаад улс орны сайн туршлага (СТ-22/218)..... 206
*Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D), Д.Аюуш,
О.Билгүүтэй, С.Золжаргал, Д.Халиун*
- 3.2 Спортын санхүүжилтийн тогтолцооны талаарх гадаадын зарим орны туршлага (СТ-22/225)..... 237
*Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D),
О.Билгүүтэй, Б.Баянмөнх*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮЛЭГ I

ЭДИЙН ЗАСАГ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МОНГОЛ УЛСАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

(Мэдээлэл, лавлагаа)

*Ц.Норовдондог (Ph.D), О.Нарантуяа,
Ц.Ариунаа, О.Билэгүтэй, Б.Туул*

АГУУЛГА

НЭГ.НОМХОН ДАЛАЙ ДАМНАСАН ТҮНШЛЭЛ (THE TRANS-PACIFIC PARTNERSHIP TPP)
ХОЁР.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 17 ЗОРИЛГО
ГУРАВ.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МОНГОЛ УЛСАД
ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД
ДӨРӨВ. ДЭЛХИЙ ДАХИНД ТУЛГАРЧ БУЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СОРИЛТУУД НЭМЭЛТ
МЭДЭЭЛЭЛ

- 1.БАН ГИ МУН САНГИЙН ТУХАЙ (BAN KI-MOON FOUNDATION)
- 2.WALTER H.SHORENSTEIN АЗИ НОМХОН ДАЛАЙН СУДАЛГААНЫ ТӨВ
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

НЭГ.НОМХОН ДАЛАЙ ДАМНАСАН ТҮНШЛЭЛ

(The Trans-Pacific Partnership-TPP)

Номхон далай дамнасан түншлэл нь Америк, Ази болон Австрали тивүүдийн 12 орны эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэх зорилго бүхий олон улсын худалдааны хэлэлцээр юм¹. Уг түншлэлийн хэлэлцээрт АНУ, Япон, Австрали, Перу, Малайз, Вьетнам, Шинэ Зеланд, Чили, Сингапур, Канад, Мексик, Бруней Даруссалам зэрэг 12 улс нэгдэн орсон байна. Номхон далай дамнасан түншлэл нь зохиогчийн эрх, барааны тэмдэг, патент оюуны өмчийг хамгаалсан байдаг байна.²

Номхон далай дамнасан түншлэлийн гол зорилго нь АНУ болон Ази, Номхон далайн бусад 11 орны худалдааны татварыг тэглэх, шударга зохицуулалтын орчныг бүрдүүлэх, худалдааны бусад саад тотгорыг арилгах замаар бараа бүтээгдэхүүн экспортлох, импортлоход хялбар болгох явдал байв.

Номхон далай дамнасан түншлэл (TPP) нь АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагийн Ази руу чиглэсэн стратегийн гол тулгуур стратеги байсан ба Ерөнхийлөгч Дональд Трамп 2017 онд АНУ-ыг энэхүү түншлэлээс эргүүлэн татсан байна.

Номхон далай дамнасан түншлэлийн худалдааны хэлэлцээрийн гол онцлог:

- Тарифыг бууруулах бусад холбогдох асуудлуудыг арилгах;

¹ <https://montsame.mn/mn/read/20435>

² <https://www.cfr.org/background/what-trans-pacific-partnership-tpp#:~:text=Introduction,percent%20of%20the%20global%20economy.>

- "Үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх, худалдааны саадгүй байдлыг хангах";
- "Худалдааны шинэ сорилтууд, дижитал эдийн засгийн хөгжил, дэлхийн эдийн засаг дахь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх үүрэг"-ийг нэмэгдүүлэх;
- "Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд" бүс нутгийн худалдааны давуу талыг ашиглахад нь туслах;
- Цаашид Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудад гэрээ байгуулах боломжийг олгох платформ бий болгох.

Ази, Номхон Далайн Худалдааны Хэлэлцээр (Asian-Pacific Trade Agreement-APTA)

Монгол Улс АНДХХ-т нэгдэн орох хүсэлтээ 2009 онд илэрхийлж, 366 нэр төрлийн барааг багтаасан үндэсний хөнгөлөлтийн жагсаалтаар хэлэлцээрийн оролцогч талуудтай цуврал хэлэлцээ хийж, улмаар нэгдэн орох нөхцөлийг 2018 оны 09 дүгээр сард хангасан. Улсын Их хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар “Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох тухай” хуулийн төслийг соёрхон баталснаар АНДХХ-ийн 7 дахь гишүүн улс болсон бөгөөд хэлэлцээрийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлнэ.³

Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжиж буй орнууд болох Энэтхэг, Өмнөд Солонгос, Шри Ланка, Лаос, Бангладеш 1975 онд өөр хоорондоо худалдааны хөнгөлөлт үзүүлэх зорилгоор “Бангкокийн хэлэлцээр”-ийг байгуулсан. БНХАУ 2001 онд тус хэлэлцээрт нэгдэн орсон хийгээд оролцогч талууд хэлэлцээрийн цар хүрээг 2005 онд өргөжүүлсэнтэй холбогдуулан “Бангкокийн хэлэлцээр”-ийг “Ази, Номхон Далайн Худалдааны Хэлэлцээр (АНДХХ)” болгон ёсчилсон.

Хэлэлцээр нь хөгжиж буй гишүүн орнуудын хоорондын худалдааг өргөжүүлж тэдгээрийн эдийн засгийг хөхиүлэн дэмжих, худалдааг харилцан либералчлах, харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх, гишүүн орнууд хоорондын худалдаан дахь тариф, тарифын бус болон худалдаатай холбогдол бүхий бусад саад тотгорыг бууруулах зорилготой.

АНДХХ-ийн оролцогч талууд 4 удаагийн тарифын хэлэлцээ хийж нийт 10677 бараа бүтээгдээхүүний гаалийн тарифыг харилцан бууруулахаар тохирсон. Тарифаас гадна гишүүн орнууд тарифын бус зохицуулалт, үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх зэрэг асуудлаар тохиролцоонд хүрсэн.

АНДХХ нь хоёр хавсралт, барааны гарал үүслийг нотлон гэрчилгээ олгож, баталгаажуулах үйл ажиллагааны журмаас бүрддэг. АНДХХ-ийн оролцогч талууд Худалдааг хөнгөвчлөх, Хөрөнгө оруулалтыг чөлөөлөх, Үйлчилгээний худалдааг идэвхжүүлэх, чөлөөлөх тухай ерөнхий хэлэлцээрүүдийг байгуулсан.⁴

ХОЁР.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 17 ЗОРИЛГО

“Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) нь 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болж буй “Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл юм. 2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж,

³ Гадаад харилцааны яам, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар www.mfa.gov.mn

⁴ Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим <https://www.mongolchamber.mn/p/331>

2016 оны 01 дүгээр сарын 01-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.

Тогтвортой хөгжлийн нийт 17 зорилго байдаг ба үүнд, ядуурал, боловсрол, уур амьсгалын өөрчлөлт, эрүүл мэндээс эхлээд бидний амьдарч буй нийгэмд, дэлхийн хаана ч очсон түгээмэл тулгардаг асуудал бэрхшээлүүдийг энд багцалсан юм. Эдгээр 17 зорилгод хүрэхэд зайлшгүй биелүүлэх шаардлагатай 169 зорилттой. Төгс төгөлдөрт дөхсөн нийгмийг бүтээх хүн төрөлхтний мөрөөдлийг биелүүлэх эхний алхам бол эдгээр зорилгуудад хүрэх явдал мөн.

- Зорилго 1. Ядуурлыг бууруулах;*
- Зорилго 2. Өлсгөлөнг зогсоох;*
- Зорилго 3. Эрүүл мэндийг дэмжих;*
- Зорилго 4. Чанартай боловсролыг дэмжих;*
- Зорилго 5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах;*
- Зорилго 6. Баталгаат ундны ус ариун цэврийн байгууламжаар хангах;*
- Зорилго 7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх;*
- Зорилго 8. Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих;*
- Зорилго 9. Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх;*
- Зорилго 10. Тэгш бус байдлыг бууруулах;*
- Зорилго 11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих;*
- Зорилго 12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих;*
- Зорилго 13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах;*
- Зорилго 14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах;*
- Зорилго 15. Хуурай газрын эко системийг хамгаалах;*
- Зорилго 16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох;*
- Зорилго 17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх.*

Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг хэрэгжүүлэхээр НҮБ-ын бүх гишүүн орнууд амлалт авсан билээ. Монгол Улс 2016 онд Тогтвортой хөгжлийн зорилтуудыг 4 бүлэг, 44 зорилт болгон өргөжүүлж, Засаглалын зорилтуудыг нэмж баталсан. Үүнийг хэрэгжүүлэх үүрэг амлалтыг НҮБ-ын өмнө хүлээсэн. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн гол зорилт бол Хүний эрхийг бүх талаар хангах, эдийн засаг, нийгэм, байгаль орчин гэсэн гурван салбарын бодлогын уялдаа холбоог сайжруулах замаар Тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдэж байгаа.⁵

Алсын хараа 2050. Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого гэдгийг “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан тусгасан, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хүний хөгжлийг хангах, эдийн засаг, нийгэм, засаглалын хөгжлийг ахисан түвшинд хүргэхэд чиглэсэн урт хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг тусгасан баримт бичиг” гэж тодорхойлсон. Энэ суурь зарчмын хүрээнд хүний хөгжил, засаглал, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй, нийт есөн хөгжлийн зорилгыг тодорхойлж, 2050 он гэхэд Монгол Улс нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно гэсэн зорилтыг дэвшүүлээд байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл. Тус баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан төлөвлөсөн үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичиг юм.⁶

“Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн асуудлаарх Олон Улсын Парламентын Холбооны Ази, Номхон далайн бүсийн хоёрдугаар чуулган”-ыг Олон Улсын Парламентын Холбоо болон Монгол Улсын Их Хурлаас хамтран 2019 оны 05 дугаар сарын 27-28-нд Улаанбаатар хотод зохион байгуулсан.⁷

ОУПХ-ны гишүүн парламентууд ТХЗ-ыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд өөрсдийн чадах бүхнээ хийх үүрэгтэйгээ удаа дараа илэрхийлсэн. Парламентууд ТХЗ-ыг үндэсний хууль тогтоомждоо тусгах, засгийн газруудад хариуцлага хүлээлгэх, төсвийг үндэсний тогтвортой хөгжлийн төлөвлөлттэй уялдуулахаар амласан. Тэд энэхүү амлалтаа хэрэгжүүлэхийн тулд парламентыг улам бэхжүүлж, шийдвэр гаргах үйл явцыг улам сайжруулах шаардлагатайг онцолсон.

2017 оны 05 дугаар сард Ази, Номхон далайн бүсийн орнуудын парламентууд ТХЗ-ыг улс орон, бүс нутагт хэрэгжүүлэхэд тус дэм үзүүлэх тодорхой алхмуудыг хэлэлцэхээр Хо Ши Мин хот (Вьетнам Улс)-д анх удаа чуулсан. Тус уулзалтаар ТХЗ-ыг нутагшуулж, хэрэгжүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэхийг бүх улс орны хууль тогтоогчдод уриалсан төгсгөлийн баримт бичгийг баталсан. Мөн жендерийн тэгш байдал, уур амьсгалын өөрчлөлт, ТХЗ-ын асуудлаарх салбар хоорондын, бүсийн болон олон улсын хамтын ажиллагаа зэрэг хэд хэдэн асуудлаар дорвитой арга хэмжээ авахыг уриалсан.

⁵ <https://news.mn/r/2133954/>

⁶ <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/undp-mapping-SDGs-2021-mongolian-version.pdf>

⁷ <http://www.parliament.mn/files/48098>

Бүсийн хоёрдугаар чуулган нь өмнөх чуулганаар гарсан зөвлөмжийг улам баяжуулах, мөн ТХЗ-д хүрэхэд боловсролын гүйцэтгэх үүрэг чухал болохыг хэлэлцэх боломжийг парламентуудад олгосон. Боловсрол нь ядуурлыг устгахад төдийгүй хувь хүн, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлж, хандлагад нь өөрчлөлт оруулснаар эрүүл мэнддээ анхаарал хандуулж, сайжруулах дадал зуршлыг бий болгоход нэн чухал. Мөн "байгаль орчны боловсрол"-ыг дэмжиж, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулах талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд парламент, парламентын гишүүд юу хийж чадах талаар хэлэлцсэн. Түүнчлэн, нийгэм, эдийн засгийн хувьд эмзэг бүлгийн хүн амыг орхигдуулахгүй байхын ач холбогдлыг онцолсон юм.⁸

ГУРАВ.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МОНГОЛ УЛСАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

ТХЗ-1. Ядуурлыг устгах

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: МУТХҮБ-2030-д ядуурлын бүх хэлбэрийг эцэс болгож, 2030 он гэхэд нийт хүн амын 80 хувийг дундаж давхаргын ангилалд багтаах зорилтуудыг дэвшүүлсэн.

Тулгарч буй сорилтууд:

- Хүүхдийн мөнгө, Хүнсний талон олгох арга хэмжээний хүртээмж хангалтгүй, зохих эзэндээ хүрэхгүй байх жишээ олон;
- Өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлал үндэсний онцлогийг бүрэн тусгаж чадахгүй байна.

ТХЗ-2. Өлсгөлөнг зогсоох

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: Хүн амын хамгийн бага хэрэглээтэй бүлэгт дэмжлэг үзүүлэх “Хүнсний талон” хөтөлбөрийг 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2015 оноос нийт 24642 өрхийн 135413 хүнд, насанд хүрэгчдэд 13000, хүүхдэд 6500 төгрөгийн тусламж олгож байна. Энэ үйл ажиллагаа нь орлого багатай иргэдийг хоол тэжээлийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлж хоногт авах шаардлагатай илчлэгийг авах боломж олгож байгаа юм. МУ-ын Хүн амын хоол тэжээлийн тулгамдаж буй асуудал, 2017⁹ үндэсний V судалгаагаар бичил тэжээлийн дутал нь хүн амын бүх бүлэг, ялангуяа нялх, бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд түгээмэл тархалттай байгааг тогтоожээ. Бичил тэжээл буюу аминдэм, эрдэс бодисын дутал нь 5 хүртэлх насны хүүхдийн дунд хамгийн өндөр тархалттай, тэдний 27 хувь цус багадалттай, 21 хувь төмөр, 70 хувь А аминдэм, 90 хувь Д аминдэмийн дуталтай, эсвэл хангалтгүй нөөцтэй байсан байна. Хүнсний баталгаат байдал (ХББ) нь алдагдсан өрхийн үзүүлэлт нийт бүс нутагт түгээмэл, Хангайн бүс (80%) болон Улаанбаатар хот (68%)-д хамгийн өндөр, Улаанбаатар хотын 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 27 хувьд ХББ ноцтой алдагдсан нь 5 хүртэлх насны хүүхэдтэй ядуу өрхийн хүн ам хэрэгцээт хэмжээгээр хооллож чадахгүй, хүнсний хомстолтой байгааг судалгааны дүн харуулж байна. Хүнсний үнэ тогтворгүй, хүнс баталгаагүй, чанаргүй, генийн өөрчлөлтөд орсон байгааг илтгэх баримт олон байна. Тухайлбал:

- Сургууль, нийтийн хоол, хүнсний үйлдвэр зэргийн хоол хүнсэнд хүмүүс бөөнөөр хордох;

⁸ <http://www.parliament.mn/files/48096>

⁹ Монгол Улсын Хүн амын хоол тэжээлийн тулгамдаж буй асуудал, 2017, ЭМЯ, НЭМТ, НҮБХС

- Хоол хүнсний сав баглаа боодол, усны сав нь хүнсний зориулалтын бус хуванцар нийлэг химийн бодисын сав байх;
- Импортоор оруулж ирж буй хүнс, хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл тодорхойгүй, чанарын баталгаагүй, хугацаа хэтэрсэн, аюулгүй байдалд хийх хяналт шалгалт сул;
- Хүнсний хангамж, түгээлт нэгдсэн системгүй, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах нийтэд үйлчилдэг хөндлөнгийн лаборатори байхгүй зэрэг нь хэрэглэгчдэд аюул дагуулсаар байна.

ТХЗ-3. Эрүүл мэндийг дэмжих

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлээр сүүлийн арван жилд /2006-2016 он/ мансууруулах болон сэтгэгдэд нөлөөт эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, улсын хил нэвтрүүлэх гэмт хэрэг 388 бүртгэгдэж, 1112 хүн холбогдон шалгагдсан бөгөөд дээрх бодисыг улсын хилээр нэвтрүүлэх арга, хэлбэр улам нарийсан, уг гэмт хэргийг зохион байгуулалттай үйлдэх болжээ. 2019 он гарсаар Хар тамхитай тэмцэх газраас 130 холбогдогчтой 67 гэмт хэргийг илрүүлэн шалгаж байгаа бөгөөд холбогдогчдын 80 гаруй хувь нь 18-35 насны залуучууд байгаа нь асуудал маш ноцтой байгааг харуулж байна.¹⁰

ТХЗ-4. Чанартай боловсролыг дэмжих

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: ТХЗ-4.2.1

Эрүүл мэндийн байдал, сэтгэх, суралцах чадвар, нийгэм-сэтгэл зүйн хөгжлийн хувьд зөв төлөвшилд яваа 5-аас доош насны хүүхдүүдийн эзлэх хувь 2013 оны НҮТС-ны дүнгээр 76% байгаа нь 2010 оны түвшнээс (85.1%) буурсан байна. Бие бялдрын ба суралцах чадварын хөгжлийн хувьд 97.8-99.0%-ийн өндөр үзүүлэлттэй гарч байгаа ч хүүхдүүдийн 75.7% нь л нийгэм сэтгэл зүйн хөгжлийн хувьд хэвийн түвшинд явж байгааг анхаарах шаардлагатай. Эрэгтэй, үндэсний цөөнх, тусгай хэрэгцээтэй байх зэрэг нь хүүхдийн хөгжлийн үр дүнд нөлөөлж, бага буюу доогуур оноо авах нөхцөл болж байна.

ТХЗ-5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: ТХЗ-5.2.1 Сүүлийн 12 сарын хугацаанд одоогийн болон хуучин хамтран амьдрагчийнхаа зүгээс бие махбодь, бэлгийн, эсвэл сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж байсан 15 болон түүнээс дээш насны охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь ҮСХ-ны 2017 оны Жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны тайланд 15-49 насны эмэгтэйчүүдийн 14.7 хувь, 15-64 насны эмэгтэйчүүдийн 12.7 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна гэжээ. Сүүлийн 12 сарын байдлаар хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь харилцан адилгүй байгаа бөгөөд энэ үзүүлэлт Өвөрхангай (19.4%), Дундговь (15.3%), Өмнөговь (15.3%) аймагт хамгийн өндөр байна. Гэтэл улсын дундажаас өндөр тархалттай дээрх аймгуудад нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байр огт байхгүй байна. Энэ нь хүчирхийлэлд өртсөн хохирогчийн эрүүл мэнд, аюулгүй байдал хамгаалагдаж чадахгүй байсаар цаг бусаар эндэхэд хүргэж байна.

ТХЗ-6. Баталгаат үндны ус, ариун цэврийн байгууламжаар хангах Жендерийн эрх тэгш байдлыг хангах

¹⁰ <https://police.gov.mn/a/4363>

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр Монгол Улсын нийт хүн амын 72.6 хувь буюу 1922.2 мянган хүн баталгаат ундны усаар хангагдаж байна.

МУТХУБ 2030-ын 2.3.1: Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 30 хувьд хийх зорилт дэвшүүлсэн байна.

ТХЗ-7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: Дэлхий нийтээрээ сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахыг зорьж буй өнөө үед дэлхийн нийт анхдагч эрчим хүчний нийлүүлэлтийн 14 орчим хувийг сэргээгдэх эрчим хүч бүрдүүлж байгаа бол манай улсад энэ үзүүлэлт 4 орчим хувьтай байна. Дэлхийн түвшинд 2016 оны байдлаар нүүрсийг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд эх үүсвэр болгон ашиглаж буй хувь 38.4, харин Ази тивд 54.3 хувь байна. Манай улсад харин 92.7 буюу хэт өндөр хувьтай байна.

ТХЗ-8. Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих Жендерийн эрх тэгш байдлыг хангах

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: Ажиллах хүчний 2018 оны судалгааны¹¹ дүнгээр улсын хэмжээнд нийт 1253.0 мянган хүн хөдөлмөр эрхэлсний 669.6 (53.4%) мянга нь эрэгтэйчүүд, 583.4 (46.6%) мянга нь эмэгтэйчүүд байна.

ТХЗ-8.3. Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацыг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхиүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих;

ТХЗ-8.5. 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй, залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтэд хамруулах, зохистой ажлын байраар хангах, адил үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгох.

ТХЗ-10. Тэгш бус байдлыг бууруулах

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: Тэгш бус байдлыг бууруулах нь манай улсын хувьд тулгамдсан асуудал.

ТХЗ-10-ын дөрвөн зорилт нь улс орны дотоод дахь тэгш бус байдлыг эдийн засаг, нийгэм, улс төрийн хүрээнд бууруулж, хөгжил, цэцэглэлт, оролцоо, нийгмийн хамгааллын үр шимийг хүн бүрт тэгш хүргэх “хэнийг ч орхилгүй хөгжих” гэсэн ТХЗ-ын гол үзэл санааг хэрэгжүүлэхэд чиглэсэн. Иймээс ТХЗ-10-ын зорилт бүрийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах нь ихээхэн ач холбогдолтой.

ТХЗ-10-ын 1-р зорилт: “хүн амын хамгийн¹² бага орлоготой 40 хувийн орлогын өсөлтийг үндэсний дунджаас дээгүүр хэмжээнд хүргэн барих” гэсэн зорилтоор хамгийн бага орлоготой хэсгийн орлогыг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхэд чиглэсэн.

Мөн ядуурал нь нийгмийн тогтолцоо, системийн асуудал болохыг хүлээн зөвшөөрч түүнийг засахын тулд *10.2-р зорилт*: “нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс,

¹¹ Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан, 2018, ҮСХ

¹² “Хамгийн” гэсэн үгийг орхиж орчуулсан байсныг нэмж оруулав. Энэ үгийг орхиж болохгүй. Учир нь хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнг бууруулна.

удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриас үл хамааран хүн бүрийг нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангах”;

10.3-р зорилт: “ялгаварлан гадуурхсан хууль журам, бодлого, зан заншлыг халах, ийм чиглэлийн хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг дэмжих”;

10.4-р зорилт: төсөв санхүү, цалин, нийгмийн хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж, тэгш байдлыг аажмаар хангах”; “2030 он гэхэд шилжин суурьшигчдын хийдэг мөнгөн гуйвуулгын гүйлгээний төлбөрийг 3 хувиас бага түвшинд хүртэл бууруулж, 5 хувиас дээш төлбөртэй мөнгө гуйвуулах үйлчилгээг зогсоох” зэрэг улс орны дотоод дахь тэгш бус байдлыг арилгахад бодитой үр дүн гаргах маш тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон.

ТХЗ-11. Ээлтэй хот иргэдийн оролцоог дэмжих

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: ТХЗ-11.2.1 Нийтийн тээврээр ая, тухтай зорчдог хүн амын эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр Нийтийн зорчигч тээврийн хэрэгслээс зөвхөн автобус, троллейбусаар зорчигчийн картын төрлийг үндэслэн зорчигчдын бүтцийг тодорхойлж байгаа хэдий ч хүйс, насны бүлгээр задлах боломжгүй бөгөөд хэр ая тухтай зорчиж байгааг илэрхийлэх мэдээлэл байхгүй байна. Замын аюулгүй байдал, нийтийн тээврийг өргөжүүлэн сайжруулах замаар аюулгүй, хямд үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг хүн бүрт хүргэх зорилт биелэх нөхцөл хараахан бүрдээгүй байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих ээлтэй дэд бүтэц бий болоогүй байна.

ТХЗ-12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: Хариуцлагатай, тогтвортой хэрэглээг бий болгох ялангуяа хүнс, шатахуун зэргийн нөөцтэй байх тухай бодлого, төлөвлөгөө гарган нэг хүнд ногдох материалын өгөөж, ДНБ-д ногдох материалын хэрэглээ, аюултай хог хаягдал, химийн бодисын тухай, байгаль орчны гэрээ, хэлэлцээр хийх, мэдээлэл солилцох зэрэг олон олон арга хэмжээ авч түүний дагуу ЗГ, зээл, бондоос хөрөнгө хүч гарган ажиллаж, тоолж тайлагнаж байна. Гэвч амьдрал дээр ашгийн төлөө хэт улайрсан бизнесүүд хортой хэрэглээ-газтай ундаа мэтийг сайн хэмээн сурталчилж төөрөгдүүлдэг, тогтвортой зөв зохистой эко хэрэглээний тухай нийтийн дунд мэдээлэл, мэдлэг ойлголт дутмаг, хууль дүрэм журам хэрэгжихгүй байгаа нь тогтвортой эко хэрэглээ бодитоор бий болж төлөвших өнгө төлөв одоогоор огт байхгүй байна. Алт олборлохдоо мөнгөн ус, цианид натри хэрэглэсэн, уран, хар тугалга хүнд металлын үлдэгдэлтэй ундны ус, хэрэглээ газар авсан тухай тайлагнах бүү хэл нэг ч дурдахгүй, аюултай хог хаягдал тоологдохгүй, хаях тусгай цэг тогтоогоогүй, хэрэглэгчид мэдээлэлгүйгээс мэдэхгүй хордсоор байна.

ТХЗ-13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилтуудын хэрэгжилт эхлэл төдий, эрх зүйн орчныг сайжруулахад илүүтэй чиглэж байна.

ТХЗ-14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: МУ-ын УИХ-аас 2005.07.16-ны өдөр “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль батлагдсанаар 240 гаран тусгай зөвшөөрлийг цуцалж, усны эхийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн. Гэтэл

өнөөдрийг хүртэл хэдэн тусгай зөвшөөрөл цуцлагдаж, хэдий хэмжээний газар нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн акт байхгүй төдийгүй МХЕГ, БОАЖЯ, АМГТГ-ын аль байгууллага нь энэ ажлыг хариуцан ажиллах зохицуулалт тодорхойгүй, нэгдсэн мэдээллийн сан, хяналт шалгалтын тайлан мэдээ байхгүй байна. Энэ хугацаанд ЗГ-ын 14 тогтоол, сайдын хоёр тушаал гаргах замаар хуулийн хүрээнд хамаарах газраас чөлөөлсөн тогтоолууд гаргаж хуулийн анхны зорилго хэрэгжихгүй болсон байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012 онд батлагдаж, БОАЖЯ дагаж мөрдөх журмыг одоо болтол боловсруулж батлаагүйгээс 2018 оны жилийн эцсийн байдлаар дээрх хууль хэрэгжиж эхлээгүй байсаар байна. Иймээс Ус үндэсний хөтөлбөр, Усны тухай хуулийн хэрэгжилт хангагдахгүй, цэнгэг усны экологийн тогтолцоо, түүний үйлчилгээ, тухайлбал ой, намаг балчиг, уулс, хуурайшилттай газрыг олон улсын гэрээний хүрээнд хүлээсэн үүргийн дагуу хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах талаар ахиц гарсангүй. Ус бохирдуулсаны төлбөрт тушаах есөн тэрбум төгрөгийн татварыг жилд улсын төсөвт төвлөрүүлж чадахгүй байна.

ТХЗ-16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: ТХЗ-16.1. Хүчирхийллийн бүх хэлбэр, түүнээс үүдэлтэй нас баралтын түвшинг дэлхий дахинд үлэмж хэмжээгээр бууруулах. Жил бүр 10 гаруй хүн хүчирхийллийн улмаас амь насаа алдаж байгаа явдал жендерт суурилсан хүчирхийлэл нэн тулгамдсан асуудал хэвээр байгааг харуулж байна.

ТХЗ-16.1.3. Сүүлийн 12 сарын дотор бие бялдар, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүн амын эзлэх хувь Сүүлийн 12 сард бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувийг нийт хүн амын тоонд тархааж, ЦЕГ-т бүртгэгдсэн ГБХ-ийн улмаас хохирсон эмэгтэйчүүдийн тоотой харьцуулж үзвэл нийт тохиолдлын 0.9 хувь нь албан ёсоор ЦЕГ-т ГБХ-ийн гэмт хэрэг гэж бүртгэгдсэн байна. Эндээс гэр бүлийн хүчирхийлэл нь далд үйлдэгддэг улмаар даамжирч, давтагдаж хүний амь нас эрсдэх аюултай байгааг харж болно. Монгол улсад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай урьдчилан сэргийлэх хууль 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлээд 1 жил 10 сарын хугацаа өнгөрч байна. Улсын төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хуваарилагдаагүй цагт бид хүчирхийлэлтэй тэмцэж чадахгүй юм. Хүчирхийлэлд өртөгсдийн дийлэнх нь ид хөдөлмөрийн 20-44 насны залуучууд, тэдний хүүхдүүд байдаг. Эдгээр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүд орхигдсон, эсвэл орхигдох эрсдэлд байгаа тул бодлого боловсруулагчид тэдний нөхцөл байдалд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна.

ТХЗ-17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

Монгол Улсын нийт төсөвт гадаадын шууд хөрөнгө оруулалт болон Хөгжлийн албан ёсны тусламж /ХАЁТ/ 2017 оны байдлаар 65.8 хувьтай тэнцүү байна /ҮСХ хороо/ гэж мэдээлсэн. Монгол Улсын хувьд гадаадын зээл, тусламж нь эдийн засгийн голлох хүч хөдөлгүүр болдог ба 1991 оноос ХАЁТ-ийн хүрээнд түншлэгч орон, олон улсын байгууллагуудаас хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, буцалтгүй тусламж авсаар ирсэн. Мөн тус улс нь зах зээлийн эдийн засагт шилжсэн эхний үедээ гадаадын улс орон, олон улсын байгууллагуудаас авсан хөгжлийн албан ёсны тусламжийн хэмжээ манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүнээс 1.6 дахин их хэмжээнд хүрч, шилжилтийн үеийн эдийн засгийн хүндрэлийг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн юм. ХАЁТ-ийн хэмжээ 2007 онд ДНБ-ний 8 хувьтай тэнцэж байсан бол 2014 онд 3 хувь хүртэл буурч, 2016 онд

4 хувьд хүрсэн байна. Хөгжлийн түншүүдээс Монгол Улсад үзүүлж буй дэмжлэг туслалцааны хэмжээ 3.2 тэрбум ам.доллартай тэнцэж байна. Хөгжлийн албан ёсны тусламжинд хамгийн их хандив оруулж байгаа нь Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг ЖАЙКА, БНХАУ, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Мянган Сорилын Корпорац¹³ байна гэж МУ-ын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээнд дурдсан байна.

ХӨГЖЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ: АГААРЫН БОХИРДОЛ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ: Монгол улсын нийт хүн амын бараг тал хувь нь оршин суудаг Улаанбаатар хот 2016 оноос хойш дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой нийслэл гэж нэрлэгдсэн ба одоо дэлхийн хамгийн их PM2.5 тоосонцортой хот болсон байна.

1. Ургийн эндэгдэл Агаарын бохирдол хүүхдийг эхийн хэвлийд бүрэлдэх үеэс сөргөөр нөлөөлж, хэвлийдээ эндэх гол шалтгааны нэг болж байна. Хорт агаар жирэмсэн эхийн хэвлийд байгаа ургийн уушиг болон амьсгалын замын тогтолцоонд нөлөөлж, улмаар хугацаанаасаа өмнө төрөх, өсөлтгүй болох, зулбах аюулд хүргэж байна.

2. Нялхсын эндэгдэл улсын хэмжээнд 2018 онд 79.0 мянган хүүхэд төрсний 1465 (1.9%) нь гадаадад төрсөн байна. Манай улсад 77.1 мянган эх амаржиж, 77.5 мянган хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос амаржсан эх 3174 (4.3%)- өөр, амьд төрсөн хүүхэд 3200 (4.3%)-гаар нэмэгдсэн байна.

3. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл улсын хэмжээнд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1310 болж, өмнөх оноос 66 (5.3%)-гаар нэмэгдсэн байна. 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 17 болж, өмнөх онтой адил түвшинд байна. МУТХҮБ-2030-д 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2020 он гэхэд 15.0 болгон бууруулна гэж заасан. Гэвч агаарын бохирдлоос шалтгаалан энэ зорилтдоо хүрэх боломж улам алдагдаж байна.

ДӨРӨВ. ДЭЛХИЙ ДАХИНД ТУЛГАРЧ БУЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СОРИЛТУУД

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үүсэж буй сорилтуудтай холбоотой олон тооны судалгааны ажил, ном, эрдэм шинжилгээний ажлууд одоогоор хэвлэгдээд байгаа хэдий ч үүнийг энгийн үгээр тайлбарлавал хойч үеийнхээ хэрэгцээг хангах байгалийн баялаг, нийгэм, эдийн засгийн нөөцийг алдагдуулахгүйгээр өөрсдийн одоо шаардагдаж буй хэрэгцээг хангах нь хамгийн том сорилт гэж ойлгож болно.¹⁴ Тогтвортой хөгжлийн зорилтууд нь зөвхөн байгаль орчин, байгалийн баялагтай холбоотой асуудал бус нийгмийн тэгш байдал, эдийн засгийн хөгжилтэй ч мөн холбоотой юм. Гэсэн хэдий ч тогтвортой хөгжлийн хамгийн том сорилт нь хойч үедээ тогтвортой ирээдүй, аюулгүй эрүүл хүрээлэн буй орчныг өвлүүлэн үлдээх юм. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь харьцангуй шинэ бодлого мэт авч уг хөдөлгөөн бүхэлдээ нийгмийн шударга ёс, байгаль хамгаалал, интернационализм болон бусад баялаг түүхтэй өнгөрсөн ХХ зуунаас өмнөх хөдөлгөөнүүдийн сорилт, үзэл санаанаас үүдэлтэй.

Тогтвортой хөгжлийн стратегийг илүү өргөн хүрээнд авч үзвэл нийгэм, байгаль орчны шинжлэх ухааныг, ирээдүйн технологитой уялдуулж тогтвортой хөгжлийг бий болгох сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах, байгаль

¹³ МУ-ын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ: Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн төрөлжүүлэх нь 2018

¹⁴ <https://mitefcee.org/sustainability-challenges/>

орчныг хамгаалах, зэрэг манай гарагийн эмзэг экосистемийг тогтвортой байлгах үндсэн зорилтууд дээр төвлөрч байна. Товчхондоо, тогтвортой хөгжлийн бодлого нь бидний байгаль орчин, хүн, экологийн эрүүл мэндийг хамгаалахын зэрэгцээ инновацыг хөдөлгөж, бидний амьдралын хэв маягийг алдагдуулахгүй байхад чиглэж байна.

Хүрээлэн буй орчны тогтвортой байдлын сорилтууд

Хүний амьдралын чанар нь хүрээлэн буй орчны нөлөөтэй нягт холбоотой. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр дэлхий даяар нас баралтын 24 хувь нь хүрээлэн буй орчны хүчин зүйлээс үүдэлтэй байдаг хэмээсэн байна. Хүмүүст амьсгалах цэвэр агаар, уух цэвэр ус, хорт бодис, аюулаас ангид амьдрах газар хэрэгтэй билээ.

Аж үйлдвэрийн өсөлт, эрчим хүчний хэт их хэрэглээний үр дагавар нэмэгдэхийн хэрээр бид эдгээр сөрөг үр дагаврыг арилгах, цаашид хохирохоос сэргийлж, хойч үедээ эрүүл амьдрах газар өвлүүлэхийн тулд ажиллах ёстой.¹⁵

Уур амьсгалын шинэ стратегийг Европын Комиссын дэд ерөнхийлөгч Франс Тиммерманс 2 дугаар сард танилцуулсан билээ. Тэрээр ЕХ-ны төлөвлөгөөний дагуу энэхүү шинэ стратегийг бүх нийтээрээ хэрэгжүүлэх ёстой хэмээн онцолж байна. “Ковид-19 цар тахал нь бидэнд бэлтгэлгүй байх нь ямар ноцтой үр дагаварт хүргэж болохыг тодорхой харууллаа. Хэдийгээр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг вакцин байхгүй ч бид үүнтэй тэмцэж, урьдчилан сэргийлж чадна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг Европын холбоо аль хэдийнээ амссан. Энэхүү өөрчлөлтөд дасан зохицох шинэ стратеги нь бэлтгэлээ түргэсгэх, өргөжүүлэх боломжийг бидэнд олгож байна. Хэрэв бид одооноос урьдчилан сэргийлвэл ирээдүйн уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах боломжтой” гэж Ф.Тиммерманс мэдэгдэв. Бид 2030 он гэхэд шийдвэрлэх шаардлагатай дэлхийн байгаль орчны асуудлуудыг тооцоолон эрэмбэлэх боломжтой.¹⁶ Эдгээрт:

1. **Дэлхийн дулаарал ба хүлэмжийн хийн ялгарал.** Уур амьсгалын өөрчлөлт эрчимжсэнээс болж ган гачиг, гал түймэр, үер зэрэг гамшигт үзэгдлүүдийг бий болгож, дэлхийн бүх экосистемд заналхийлж байна. Тиймээс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахыг зөвлөж байна.
2. **Агаар, усны бохирдол.** Мэргэжилтнүүдийн тооцоолсноор хүн төрөлхтний 90 орчим хувь нь бохирдсон агаараар амьсгалдаг байна. Иймд агаарын бохирдлыг бууруулж, химийн бодисын хэрэглээг багасгах, бохир усыг их хэмжээгээр цэвэрлэж, амьсгалын замын өвчлөлийг бууруулснаар жилд долоон сая хүн нас барахаас урьдчилан сэргийлнэ.
3. **Далай тэнгис, усны бохирдол.** Далай тэнгис нь хуванцар болон синтетик материалын асар том хогийн цэг болсон. Эдийн засгийн сул хөгжилтэй бүс нутгуудын бохирдуулагч бодис, хаягдал ус, түлшний асгаралтаас үүдэн экосистемд хохирол учруулж байна.
4. **Эрчим хүчний шилжилт удаан, сэргээгдэх эрчим хүчний хангалтгүй байдал.** Дэлхийн хүн амын зарим хэсэг нь одоог хүртэл эрчим хүчний хангалтгүй байдлаас болж нүүрсийг ашигласаар байна. Энэ нь эрчим хүчний шилжилтийг сэргээгдэх эрчим хүч рүү шилжүүлж цэвэр, хүртээмжтэй, үр ашигтай болохыг шаардаж байна.
5. **Генийн өөрчлөлттэй хүнсний хор хөнөөл.** Байгалийн нөөцийг хэтрүүлэн ашиглах, байгаль орчныг сүйтгэх нь хөрсийг доройтуулж, далайн экосистемийг сүйтгэж

¹⁵ <https://sphera.com/glossary/what-is-environmental-sustainability/>

¹⁶ The Big Global Environmental Issues We Need To Resolve By 2030, ibedrola.com.

байна. Эрчим хүч хэмнэх, хийн ялгаруулалтыг бууруулах зорилгоор органик орц найрлагатай, ургамлын гаралтай хүнсээр бүх нийтийн хоолны зуршлыг өөрчлөхөд анхаарах.

6. **Амьтны төрөл зүйл устаж, байгалийн унаган төрх алдагдах.** НҮБ-ын мэргэжилтнүүд биологийн олон янз байдлыг хамгаалахыг уриалж, эдгээр аюул заналхийллийг таслан зогсоох, байгалийн өв, тэр дундаа улам бүр ховордож буй ой модыг хамгаалахын тулд тодорхой арга хэмжээ авахыг уриалж байна.
7. **Хот байгуулалтын цогц стратеги бүхий орчин үеийн хотуудыг хөгжүүлэх.** 2030 он гэхэд 5 тэрбум орчим хүн хотуудад амьдрах төлөвтэй байгаа нь ойрын арван жилийн байгаль орчны томоохон сорилтуудын нэг болж байна. Ирээдүйн метрополисууд авсаархан, аюулгүй, хүртээмжтэй, экологийн болон эрчим хүчний хэмнэлттэй, илүү ногоон байгууламж, байгаль орчинд ээлтэй барилга байгууламж, явган зорчигчдын хэрэгцээг авто замын хөдөлгөөнөөс дээгүүр тавьсан байх шаардлагатай. Эдгээрээс үүдэн хотын тогтвортой хөгжлийг хадгалах, шилжилт хөдөлгөөнийг бий болгох зайлшгүй шаардлага гарч байна.
8. **Усны хомстол.** Дэлхийн хүн амын 40 гаруй хувь нь усны хомстолтой байна. Дэлхийн эдийн засгийн форумын мэдээлснээр манай гарагийн хамгийн хуурай орнуудын усны 70 гаруй хувийг хөдөө аж ахуйн салбар хэрэглэдэг байна. Усны нөөцийг хариуцлагатай ашиглах нь хүнс, эрчим хүчний үйлдвэрлэлийг сайжруулахаас гадна усны экосистемийн биологийн олон янз байдлыг хамгаалж, уур амьсгалын өөрчлөлтийг удаашруулахад тусална.
9. **Хүн амын өсөлт, хог хаягдлын менежмент.** Дэлхийн хүн ам 2030 он гэхэд 8.5 тэрбум давах төлөвтэй байна. Иймд хог хаягдлын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгахын тулд дахин боловсруулан эдийн засгийн эргэлтэд оруулж хог хаягдлын хэмжээг эрс бууруулах шаардлагатай байна.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

1. БАН ГИ МУН САНГИЙН ТУХАЙ (BAN KI-MOON FOUNDATION)

“Илүү сайхан ирээдүйн төлөө Бан Ги Муны сан”¹⁷ (товчилсон нэр нь “Бан Ги Мун сан”) нь 2018 онд байгуулагдсан бөгөөд төв нь Сөүл хотод байдаг. Сангийн зорилго нь НҮБ-ын энх тайван, аюулгүй байдал, хөгжил, хүний эрхийн төлөө НҮБ-ын 8 дахь Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Муны ололт амжилт, гүн ухааныг үргэлжлүүлж, цаашид хөгжүүлэх, харилцаа холбоо, зэрэгцэн орших, үнэнч байдал, эв нэгдлийн үнэ цэнийг ухамсарлаж, зөрчил, дутагдалгүй сайхан ирээдүйг бий болгоход хувь нэмрээ оруулах юм.

Сан нь дараах эрхэм зорилгыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Муны алсын хараа, гүн ухааныг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд гадаад, дотоод харилцааг дэмжин, явуулах;
- Тогтвортой хөгжлийн зорилтууд, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар илүү сайхан ирээдүйн төлөө эрдэм шинжилгээний судалгаа, бодлогын санал гаргах;
- Залуучууд, эмэгтэйчүүд, хүний эрхийн төлөө ирээдүйд чиглэсэн үнэт зүйлс, алсын харааг бий болгох үйл ажиллагаа явуулах;
- НҮБ болон олон улсын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, солилцох;
- Дотоод, гадаадын холбогдох эрдэм шинжилгээний холбоо, боловсролын байгууллагатай судалгаа шинжилгээний чиглэлээр хамтран ажиллах;


¹⁷ <http://eng.bf4bf.or.kr> Ban Ki-Moon foundation for a better future

- Солонгос болон гадаад улс орнуудад үйл ажиллагаа явуулах зорилгоор холбогдох сургалт, сурталчилгаа, мэдээллээр хангах;
- Илүү сайхан ирээдүйн төлөө Бан Ги Муны сангийн зорилгод хүрэхэд шаардлагатай бусад үйл ажиллагаа явуулах.

Сангийн бүтэц, бүрэлдэхүүн: Сангийн үйл ажиллагааг 2019 онд баталсан дүрмээр зохицуулдаг. Сан нь улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулдаггүй. Сангийн орлогыг олон нийтийн төлөө буюу эрдэм шинжилгээ, боловсрол болон нийгэмд хувь нэмэр оруулахад зарцуулна.

Сангийн ТУЗ-ын даргаар Бан Ги Мун ажилладаг. Сангийн дүрэмд зааснаар ТУЗ-ын дарга 1, дэд буюу гүйцэтгэх захирал 1, аудитор 2 болон 5-аас доошгүй, 15-аас илүүгүй захирал (тэргүүн, гүйцэтгэх захирал орно)-тай байхаар зохицуулсан. Захирлууд болон аудиторуудын бүрэн эрхийн хугацаа нь тус бүр гурав ба 2 жил байх бөгөөд улиран ажиллаж болно. Удирдах албан тушаалтныг ТУЗ томилж, чөлөөлнө.

Одоогийн байдлаар сан нь захирал 1, гүйцэтгэх захирал 1, ТУЗ-ын захирал 9, аудитор 1 гэсэн удирдах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.



Сан нь Тогтвортой хөгжлийн зорилгууд болон Парисын уур амьсгалын хэлэлцээрийн хүрээнд залуучууд, эмэгтэйчүүдийг чадавхжуулах чиглэлээр ажилладаг. Сангийн төсөл, хөтөлбөрүүд нь манлайлал, боловсрол, хамгаалал, энх тайван ба аюулгүй байдал гэсэн дөрвөн хэсэгт суурилдаг.¹⁸ Сан нь олон нийтийн болон албан бус дипломат үйл ажиллагаагаар дамжуулан дэлхийн иргэний үнэт зүйлс, дэлхийн иргэний боловсролыг

¹⁸ <https://bankimooncentre.org> Ban Ki-Moon centre for global citizens

сурталчлах зорилгоор бүх түвшний удирдагчид, залуучууд, академи, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажилладаг.

Манлайллын хүрээнд олон ургальч үзэл, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр захирлуудын хүчин чармайлтыг дэмжиж, харилцан туслах, дэлхийн иргэн болох сэтгэлгээтэй залуучууд, эмэгтэйчүүдийн манлайллын чадавхыг бэхжүүлэх, дараагийн үеийн удирдагчдыг бэлтгэхэд чиглэдэг.

Боловсролын хүрээнд боловсролын боломжуудыг бий болгож, олон тооны сургууль болон бусад сурган хүмүүжүүлэх байгууллагуудтай хамтран GCED, ESD болон шударга ёсны боловсролын талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилготой. Цахим сургалтуудыг зохион байгуулахаас гадна SDG бичил төслүүдийн тусламжтайгаар дэлхийн иргэн болох үйл ажиллагааг дэмждэг.

Энх тайван ба аюулгүй байдлын хүрээнд одоогийн болон ирээдүйн аюулгүй байдлын сорилтуудыг цогцоор нь зохицуулахад чиглэсэн энх тайвны хүчин чармайлтад залуучууд, эмэгтэйчүүд, шийдвэр гаргагчид, салбарын мэргэжилтнүүд, дадлагажигчдыг оролцуулах, солилцох дэлхийн санаачилгад оролцдог.

Хамгаалал (advocacy)-ын хүрээнд сан нь уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох, залуучууд, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, жендерийн эрх тэгш байдлыг хангах, хүчирхийллийг зогсоох, тогтвортой хотууд болон дэлхийн иргэн болох үйл ажиллагаа зэрэг дэлхийн хэд хэдэн асуудлыг шийдвэрлэхэд олон талт хүчин чармайлтаа чиглүүлэн ажилладаг.

Сан нь ТХЗ-уудыг хэрэгжүүлэх, олон ургальч үзэл, эмэгтэйчүүд, залуучуудыг чадавхжуулах, дэлхийн иргэн болох боловсролыг дэмжих зорилгоо үргэлжүүлэн хэрэгжүүлж эрүүл мэнд, сайн сайхан байдлын талаарх ТХЗ.3-ыг сангийн үйл ажиллагаандаа нэгтгэж, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, жендерийн тэгш байдал, залуучуудад үзүүлэх COVID-19-ийн нөлөөллийг бууруулахад хүчин чармайлт гарган ажиллахаа илэрхийлжээ.

2. WALTER H.SHORENSTEIN АЗИ НОМХОН ДАЛАЙН СУДАЛГААНЫ ТӨВ

Walter H. Shorenstein Ази Номхон Далайн Судалгааны Төв (Shorenstein APARC) нь 1983 онд байгуулагдсан бөгөөд Азийн болон Стэнфордын тэргүүлэх зэргийн эрдэмтэн, судлаачид Азийн орнууд, бүс нутаг, дэлхийн нөхцөл байдал, АНУ-Азийн харилцаанд нөлөөлж буй чухал асуудлуудыг хөнддөг.

Хятад болон Японы эрдэмтдээс бүрдсэн Ази Номхон далайн бүс нутгийн улс төр, эдийн засаг, аюулгүй байдал, гадаад бодлого, олон улсын харилцаатай холбоотой асуудлуудыг өргөн хүрээгээр судалдаг мэргэшсэн багтай байна.

Shorenstein APARC үйл ажиллагаа нь эрдэм шинжилгээний бүтээлүүдийг гарган, хэвлэн нийтлэхээс гадна улс хоорондын харилцааг бэхжүүлж, хамтын ажиллагааны шинэ боломжийг бий болгох болон Глобал Түншлэлийн хөтөлбөр зэрэг бүс нутгийн болон сэдэвчилсэн үндсэн долоон хөтөлбөрийг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлдэг. Үүнд:

- Азийн Эрүүл Мэндийн Бодлогын Хөтөлбөр нь Ази, Номхон далайн бүс нутгийн эрүүл мэндийн тогтолцоо, бодлого боловсруулагчдад хүн амын эрүүл мэндийн асуудалд идэвхтэй хариу арга хэмжээ авах боломжийг олгодог.

- Хятадын хөтөлбөр нь Хятад Улсын мэргэжилтнүүдтэй хамтран судалгаа хийж, хурал, семинар зохион байгуулж, харилцан оюуны солилцоо хийдэг. Стэнфордын Их сургуулийн оюутан, эрдэмтдийг сургах боломжийг өргөжүүлж, Хятадын асуудлаар олон нийтийн форум зохион байгуулж, төрийн албан хаагчид болон мэргэжилтнүүдэд зориулсан боловсролын хөтөлбөрүүдийг санал болгодог.
- Японы хөтөлбөр нь Засгийн газар, Шинжлэх ухааны байгууллага, бизнесийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран Японы хөгжил дэвшилд нөлөөлж буй дотоод, гадаад хүчин зүйл, улс төр, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсийн талаар бүрэн ойлголттой болгохын тулд олон талт судалгаа хийдэг.
- Солонгосын хөтөлбөр нь орчин үеийн Солонгос Улсын ирээдүй, АНУ-БНСУ-ын харилцааг тодорхойлох асуудлаар судалгаа хийдэг. Эдгээр сэдвийг бүс нутгийн болон харьцуулсан соёл, улс төр, эдийн засгийн үүднээс авч үздэг. БНСУ-ын залуу эрдэмтдийг сурган, дэмжиж, АНУ, БНСУ-ын бодлого боловсруулагчдад мэдээлэл өгөх, хоёр орны харилцаа холбоог бэхжүүлэх зорилгоор ажилладаг.
- Өмнөд Азийн санаачилга нь бүс нутгийн чухал асуудлуудыг шийдвэрлэхийн тулд нарийвчилсан судалгаа, нийтлэг сонирхолд нийцсэн нийтлэл, хөтөлбөр, дэлхийн сүлжээг ашиглан гаргадаг.
- Зүүн өмнөд Азийн хөтөлбөр (SeAP) нь орчин үеийн Зүүн Өмнөд Азийн нөхцөл байдал, тэдгээрийн бодлогын үр дагаврыг судалдаг. Үндсэн зорилго нь бүс нутагт нөлөөлж, ирээдүйг тодорхойлох нөхцөл байдлын талаар илүү их ойлголттой болгох явдал юм.

Глобал Түншлэлийн Хөтөлбөр нь Азийн байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, хамтран ажилладаг. Хамтарсан гишүүд нь Shorestein APARC болон Стэнфордын судалгаа, боловсролын олон талт ажилд оролцдог бөгөөд нэр дэвшсэн оюутнууд байна. Тэд судалгааны төвийн оюуны солилцоог баяжуулж, мэдээллээр хангахын зэрэгцээ даяаршсан ертөнцөд манлайлахад шаардлагатай үр чадварыг эзэмшүүлэх боломжоос ашиг тус хүртдэг.



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Council on Foreign Relations <https://www.cfr.org/backgrounder/what-trans-pacific-partnership-tpp#:~:text=Introduction,percent%20of%20the%20global%20economy>.
- Гадаад харилцааны яам, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар www.mfa.gov.mn
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/undp-mapping-SDGs-2021-mongolian-version.pdf>
- <http://www.parliament.mn/files/48098>
- <https://montsame.mn/mn/read/20435>
- <http://www.parliament.mn/files/48096>
- Монгол Улсын Хүн амын хоол тэжээлийн тулгамдаж буй асуудал, 2017, ЭМЯ, НЭМТ, НҮБХС
- <https://police.gov.mn/a/4363>
- МУ-ын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ: Тогтвортой хөгжлийн санхүүжилтийг төрөлжүүлэх нь 2018
- <https://mitefcee.org/sustainability-challenges/>
- <https://sphera.com/glossary/what-is-environmental-sustainability/>
- The Big Global Environmental Issues We Need To Resolve By 2030, ibedrola.com.
- <http://eng.bf4bf.or.kr> Ban Ki-Moon foundation for a better future
- <https://bankimooncentre.org> Ban Ki-Moon centre for global citizens

**КОВИД-19” ЦАР ТАХАЛ, ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН
ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД ИРГЭДИЙН ОРЛОГЫГ ХАМГААЛАХ, НЭМЭГДҮҮЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР БУСАД ОРНУУДЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ**

(Тойм судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), О.Билгүүтэй,
Г.Алтан-Оч (Ph.D), Д.Халиун,И.Жаргалзаяабямба,
Б.Туул, Б.Мөнгөнсүвд*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ.“КОВИД-19” ЦАР ТАХЛЫН ҮЕД МОНГОЛ УЛСЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА
ХЭМЖЭЭ

ХОЁР.“КОВИД-19” ЦАР ТАХЛЫН ДАРААХ ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ, ИРГЭДИЙН
БОДИТ ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР БУСАД ОРНУУДЫН АВЧ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.1 АНУ

2.2 ОХУ

2.3 ИРЛАНД УЛС

2.4 ХБНГУ

2.5 ЯПОН УЛС

2.6 БНКазУ

ГУРАВ.ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНКазУ	Бүгд Найрамдах Казахстан Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕАЭЗХ	Евразийн эдийн засгийн холбоо
ЕХ	Европын холбоо
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОПЕК	Газрын тос экспортлогч орнуудын байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ҮНО	Үндэсний нийт орлого
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЭАА	Хувиараа эрхлэх аж ахуй
ЭЗХАХБ	Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгын дагуу “Ковид-19” цар тахал, олон улсын нөхцөл байдлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийн үед бусад орнуудын иргэдийн орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэлээ.

Сэдвийн хүрээнд АНУ, ОХУ, Ирланд, ХБНГУ, Япон, БНКаЗУ зэрэг орнуудын туршлагыг судалсан бөгөөд “Ковид-19” цар тахлын нөлөөтэй холбоотой эдийн засаг, санхүүгийн зах зээлийн орчны хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тойм болон Орос-Украины дайн, түүний эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээллийг тоймлон бэлтгэлээ.

Түлхүүр үг: *Ковид-19 цар тахал, Засгийн газрын дэмжлэг, Орос-Украины дайн*

Keyword: *Covid-19 pandemic, Government support measures, Russo-Ukrainian war*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

“Ковид-19” цар тахлын үед улс орнуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Судалгаанд авагдсан орнуудад “Ковид-19” цар тахлын үед иргэдийн ажил эрхлэлтийн найдвартай байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг тогтворжуулах, санхүүгийн байгууллага болон зээлдэгчдийн төлбөрийн чадвартай байдалд дэмжлэг үзүүлэх, төсөв, мөнгөний бодлогыг явуулах, зээл тусламжийн ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлэх, экспортыг тогтвортой түвшинд хадгалах, нэмэгдүүлэх, гадаад валютыг хүрэлцэхүйц түвшинд нөөцлөх, дотоодын үйлдвэрлэл, ялангуяа хүнсний салбарын болон жижиг дунд бизнесийг дэмжих, нөөцийн болон дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Дэлхийн улс орнуудын засгийн газраас цар тахалтай холбогдуулан иргэдийн бодит орлогыг хамгаалах нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг дараах байдлаар тоймлон тодорхойлж байна. Үүнд:

- жижиг дунд бизнесийг дэмжих;
- татварын дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх;
- зээлийн хөнгөлөлт үзүүлэх, эргэн төлөх хугацааг хойшлуулах, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
- төрийн үйлчилгээ, зөвшөөрөл олгох, бүртгэлийн ажиллагаа зэргийг хөнгөвчлөх;
- иргэдийн орлогыг дэмжих, ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх;
- банк, санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварыг хангах зэрэг дэмжлэг, тусалцааг иргэдэд хүргэсэн байна.

Монгол Улсын хувьд “Ковид-19” цар тахлын тархалтыг тогтоон барих, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр нь ихэвчлэн санхүүгийн тусламж дэмжлэг, нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдэд чиглэсээр байна. Тухайлбал, иргэдийн орлогыг дэмжих, ажил эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх хүрээнд хүүхдийн мөнгө, эрүүл мэндийн зардал олгох, малчдад тусламж олгох, халамжийн тэтгэвэр олгох, хүнсний талон олгох, залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, хог хаягдлын төлбөр хураамжийг төрөөс хариуцах, шахмал түлшний үнийг үе шаттай бууруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэж ажлын байраар хангах, хүнс, түлш, шатахуун,

малын тэжээл, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийг үнийн зохиомол өсөлтөөс сэргийлэх, малжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байна.

Судалгаанд авагдсан орнуудын зүгээс “Ковид-19” цар тахлын эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засгийг сэргээх, иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаарх мэдээллийг улс орнуудаар нь багцлан хүснэгтээр харуулав. (Хүснэгт 1-ээс үзнэ үү)

Олон Улсын нөхцөл байдал

Дэлхийн улс орнууд “Ковид-19” цар тахлын эдийн засгийн сөрөг нөлөөллөөс бүрэн гарч амжаагүй байтал дараагийн хүндрэлтэй нүүр тулж байна. Орос-Украины дайны нөлөө зөвхөн хөрш орнуудад төдийгүй хүчирхэг эдийн засагтай Евро бүс, АНУ-ын эдийн засагт нөлөөлж, дэлхий нийтэд нийлүүлэлтийн гаралтай инфляцыг дахин өдөөж байна. Судалгаанд авагдсан улсуудын хувьд ОХУ, Украины хоорондын мөргөлдөөн дараах чиглэлд сөрөг нөлөө үзүүлж байна. Үүнд:

- эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүн зэрэг өргөн хэрэглээний барааны үнэ өсөх нь инфляцыг улам өсгөж, орлогын үнэ цэнийг бууруулж, эрэлтийг нэмэгдүүлэх;
- хөрш зэргэлдээ орнуудын эдийн засагт худалдаа, нийлүүлэлтийн сүлжээ, мөнгөн гуйвуулга тасалдах, дүрвэгсдийн урсгал нэмэгдэх зэргээр нөлөөлөх;
- бизнесийн боломж буурч, хөрөнгө оруулагчид тодорхойгүй байдалтай тулгарах нь хөрөнгийн үнэлгээнд сөргөөр нөлөөлж, санхүүгийн нөхцөл байдал чангарч, хөгжиж буй зах зээлээс хөрөнгийн урсгал гадагшлах явцыг өдөөж болзошгүй байна.

Түүнчлэн ОХУ, Украин Улс нь түүхий эдийн гол үйлдвэрлэгч орнууд бөгөөд дэлхийн зах зээл дээр газрын тос, байгалийн хийн нийлүүлэлт тасалдсанаар үнэ улам өсөх төлөвтэй байна.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан орнуудын Засгийн газраас ирээдүйн бодит орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Улсын нэр	Арга хэмжээний төрөл				Иргэдийн орлого нэмэгдүүлэх тусгайлсан арга хэмжээ
	Иргэдийн бодит орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр авч буй арга хэмжээний нэр	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	Нийгмийн халамж, тэтгэмж	Түрээс болон зээлийн эргэн төлөлтийн хөнгөлөлт	
АНУ	2 АНУ-ын эдийн засгийг сэргээн хөгжүүлэх “Илүү сайнаар бүтээе” гурван хэсэг хөтөлбөр; “Америкийг хямралаас гаргах хөтөлбөр”; “Америкийн ажлын байр хөтөлбөр”; “Америкийн гэр бүлүүд хөтөлбөр”.	3 “Америкт үйлдвэрлэв татварын хөтөлбөр”-ийн хүрээнд 2036 он хүртэл 2 их наяд ам.доллар бүрдүүлэхээр төлөвлөсөн.	4 Иргэдийн гарт шууд олгох тэтгэмж; Татварын орлогоос олгох тэтгэмж; Ажилгүйдлийн тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох; Жижиг бизнесийг дэмжих; Эрүүл мэнд, иргэнд үзүүлэх тусламж үйлчилгээнд олгох тэтгэмж; Эрүүл мэндийн улсын даатгалын санхүүжилт; Хүнс тэжээлийн тусламж.	5 “Ковид-19” цар тахлын улмаас орон байраа алдсан иргэдийг “Ковид-19” цар тахлын эсрэг тусламжийн сан”-аар дамжуулан нэн яаралтай түрээсийн байранд хамруулах орон гэргүй иргэдийг 2030 он хүртэл нэн яаралтай болон урт хугацаанд орон сууцжуулах зэрэг үйл ажиллагаанд 27.4 тэрбум ам.доллар төсөвлөсөн байна.	6 “Америкийн ажлын байр хөтөлбөр”-т АНУ-д ирэх 10 жилийн хугацаанд жил бүр 2 сая ажлын байрыг шинээр бий болгох, дэд бүтцийг шинэчлэх зэрэг арга хэмжээ туссан.
ОХУ	“ФОТ 3.0” хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр; “Хөнгөлөлттэй ипотекийн зээл”-ийн хөтөлбөр; “Гэр бүлийн ипотекийн зээл” хөтөлбөр.	Биет алтны арилжаанд ногдуулах 20%-ийн НӨАТ-ыг чөлөөлсөн.	Бага орлоготой өрхийн 8-17 насны хүүхдэд сар бүр 6-12 мянган рублийн тэтгэмж; 8 хүртэлх насны хүүхэдтэй, бага орлоготой өрхөд сар бүр олгох тэтгэмж; 8-17 настай хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхчүүдэд олгох тэтгэмж.	2021 онтой харьцуулахад орлого нь буурсан 30%-аар зээлдэгчдийн хэрэглээний ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшуулсан.	Ажлын байрны 90-ээс доошгүй хувийг хадгалсан нийтийн хоол, зочид буудал, соёл, спортын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд жилийн 3%-ийн хүүтэй, хөнгөлөлттэй зээл олгоно.

1	2	3	4	5	6
<p>ИРЛАНД УЛС</p>	<p>“Аж ахуйн нэгжийн бизнесийн болон өрхийн орлогыг дэмжих” арга хэмжээ; “ЖДҮ-ийг дэмжих” арга хэмжээ; “Аялал жуулчлалын салбарыг” дэмжих арга хэмжээ.</p>	<p>НӨАТ-ын стандартын хувь хэмжээг 23-аас 21 хувиар бууруулах; Хямралд өртсөн бизнес эрхлэгчдийн татвар, өр төлбөрийг хойшлуулах, хүү, торгууль төлөхгүйгээр төлбөрөө төлж, НӨАТ-ын өрийг тодорхой хэмжээгээр хэсэг хугацаанд хойшлуулах.</p>	<p>“Ковид-19” цар тахлын үеийн ажилгүйдлийн тэтгэмж; “Ковид-19” халдварт өвчний тэтгэмж.</p>	<p>Ирланд Улсын Төв Банкаас (СВБ): Зээлдэгчийн төлбөрийн хоцрогдлыг зээлийн төв болон банкны бүртгэл мэдээлэлд оруулахгүй байх; “Ковид-19” -өөр өвчилсөн иргэдэд зориулсан орон сууцны зээл, бизнесийн зээлийн төлбөрийн хөнгөлөлтийг 3-6 сар хүртэл сунгах; “Ковид-19”-ийн яаралтай тусламжийн үеэр нүүлгэн шилжүүлэх, түрээсийн үнийг 6 сараас доош хугацаатай түрээсийн мэдүүлгийн хугацааг 90 хоног болгон нэмэгдүүлсэн.</p>	<p>Ипотекийн зээлийн хүүг 9%-аас 7% болгож бууруулсан. Бага насны хүүхэдтэй гэр бүл – 6%. Үндэсний эдийн засгийг сэргээх, тогтворжуулах төлөвлөгөө; Эдийн засгийг сэргээх төлөвлөгөө.</p>
<p>ХБНГУ</p>	<p>“Даван туулах тусламж IV” хөтөлбөр; “Шинэ гарааны бизнесийн тусламж”. “Нэн хүнд нэрвэгдсэн аж ахуйн нэгжид” үзүүлэх тусламж.</p>	<p>Богино цагийн ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл суулгахгүй байх.</p>	<p>2019 онтой харьцуулахад орлого нь 30% унасан иргэдэд тэтгэмж олгох. Хувийн аж ахуй эрхлэгч нь сард 1 500 евро хүртэл хэмжээний шууд нэмэгдэл авна.</p>	<p>Дэмжлэгт хамарах зардалд тусгай зурвас олгох; түрээсийн үнийг хувиар бууруулах; шинэ гарааны бизнес эрхлэгчдэд хувийн аж ахуй эрхлэгч, нэг хүний ХХК, дүрслэх урлагийн салбарын богино хугацааны ажилтан, бүх салбарын байнгын бус (түр) ажилтан, хөрөнгийн</p>	<p>Аж ахуйн нэгжүүд тогтмол зардлын нөхөн олговор авах; Шинэ гарааны бизнес эрхлэгчдэд хувийн аж ахуй эрхлэгч, нэг хүний ХХК, дүрслэх урлагийн салбарын богино хугацааны ажилтан, бүх салбарын байнгын бус (түр) ажилтан, хөрөнгийн</p>

1	2	3	4	5	6
<p>ЯПОН УЛС</p>	<p>Япон Улсын Засгийн газраас 1 их наяд орчим ам.доллартай тэнцэх төсөв бүхий Эдийн засгийг эрчимжүүлэх багц хуулийг баталсан; Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ЖДҮ-д зориулсан мөнгөн тэтгэмж, хөнгөлөлттэй зээл олгох; “Яваралтай тусламжийн үе, “У” хэлбэрийн нөхөн сэргээх үе” эдийн засгаа дахин сэргээх арга хэмжээ.</p>	<p>2020.02.01-ээс 2021 оны 01.31-ний хооронд татвар төлөх үүргийг нэг жилээр хойшлуулах; Жижиг, дунд компаниудын хөрөнгө оруулалтын татварыг бууруулах; Хэрэглээний татварын тусгай дүрмүүд тогтоох; Төрийн болон хувийн санхүүгийн байгууллагуудтай байгуулсан гэрээг татвараас чөлөөлөх; Татвар хураах хөнгөлөлтийн хугацаа, жижиг, дунд аж ахуйн нэгжийн өмчлөлд байгаа зарим эд хөрөнгийн үл хөдлөх хөрөнгийн татварыг бууруулах.</p>	<p>Өрх, болон иргэдэд мөнгөн тэтгэмж, зээл, хөнгөлөлт, хойшлуулалт, чөлөөлөлт олгох.</p>	<p>Хөл хорио, зайнаас ажиллах нөхцөл байдлаас шалтгаалан орон сууцны түрээсийн төлбөрийг 3-9 хүртэлх сарын хугацаатайгаар хойшлуулах; Цар тахлын улмаас цуцлагдсан соёл, урлаг, спортын арга хэмжээнд оролцохдоо төлсөн мөнгөө буцаан авах хүсэлтээ гаргасан тохиолдолд буцаан олгох.</p>	<p>компани болон хоршоо хамаарна. Орон сууцны зээлд хамрагдах тусгай хөнгөлөлтийн шаардлагыг харгалзан үзэх; Татварын алдагдлыг буцаах замаар татварын буцаан олголтыг 1 тэрбум иенээс бага хөрөнгөтэй компаниудад олгох.</p>
<p>БНКАЗУ</p>	<p>БНКАЗУ-ын Засгийн газрын 2022 оны хөтөлбөр; “Үндэсний үйлдвэрлэлийг 2021-2025 он хүртэл хөгжүүлэх төсөл”; “Даму” бизнес хөгжлийн сангаар дамжуулан, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд ЖДҮ-ийг дэмжих;</p>	<p>ААНОАТ-100% бууруулах (тодорхой нөхцөлөөр); НӨАТ-0% (ЗГ-аас тогтоосон жагсаалтаар); Газрын татвар, газар ашигласны төлбөр-0%; Үл хөдлөх хөрөнгийн татвар-0%; Нийгмийн даатгалын шимтгэл-100% (инновац технологийн паркийн шинэчлэл).</p>	<p>Иргэдийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр: Ажлын байр нэмэгдүүлэх; Хөнгөлөлттэй зээл олгох; Татварын хөнгөлөлт; Хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмж; Ажилгүйдлийн тэтгэмж. Бага орлоготой иргэдэд олгох тэтгэмж.</p>	<p>ЖДҮ дэмжих зорилгоор: зээлийн хүү-6%; 5 сая тенгений хэмжээтэй 2 жилийн хугацаатай эргэлтийн хөрөнгийн зээл; 20 сая тенгений хэмжээтэй 5 жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын зээл; 5 сая хүртэлх тенгений хэмжээтэй 6%-ийн хүүтэй барьцаагүй зээл.</p>	<p>Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн дээд хязгаар тогтоох; Үр тарианы экспортын квотыг нэвтрүүлэх; дотоодын үйлдвэрлэлийг өргөжүүлэх; нийгмийн зорилготой иргэдийн хамгаалж орлогыг хөнгөлөлттэй зээл олгох;</p>

1	2	3	4	5	6
	<p>“Бизнесийн замын зураг-2025”, “Енбек” хөтөлбөрүүдээр төрийн хөнгөлөлттэй зээл олгох; “Эдийн засгийг сэргээх цогц төлөвлөгөө”-д хөрөнгө оруулалт, ЖДҮ, ажлын байрыг нэмэгдүүлэх, цахимжуулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг 160 гаруй арга хэмжээ.</p>		<p>1 нас хүртэлх хүүхэд асарч буй эхчүүд; 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл; Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, түүний асран хамгаалагч.</p>		<p>ипотекийн зээлийн хүүд санхүүжилт олгох; бага орлоготой иргэдийн орон сууцны урьдчилгаа төлбөр бууруулах; анх удаа орон сууц худалдан авагчийн зээлийн шалгуурыг сулруулах, хямдруулах; тэтгэврийн санд хуримтлалтай, чинээлэг гэр бүлд орон сууц худалдан авалтыг хурдасгах, үнийг өсгөх.</p>




СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. “КОВИД-19” ЦАР ТАХЛЫН ҮЕД МОНГОЛ УЛСЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын эдийн засгийн хувьд 2022 оны 9 дүгээр сарын байдлаар инфляцын түвшин улсын хэмжээнд 13.8 хувьтай байна. Нийт инфляцын өсөлтийн 52.1 хувь импортын бараа бүтээгдэхүүний өсөлтөөс шалтгаалжээ. Цаашлаад нийлүүлэлтийн гаралтай саатал, дайны нөлөөллөөс болж газрын тосны үнэ өсөж, улмаар жижиглэнгийн шатахууны үнийн өсөлтийг дагаж бусад бараа бүтээгдэхүүний үнэ өссөөр байна.

Зураг 1. Улсын инфляц (2022 оны эхний 9 сарын байдлаар)



Эх сурвалж: Монголбанк, https://www.mongolbank.mn/dblistcpi_mng.aspx

Цар тахлын эдийн засгийн нөлөөг зөөлрүүлэхэд төрөөс үзүүлсэн санхүүгийн тусламж, арга хэмжээ

2020 оноос эхлэн “Ковид-19” цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралын үед төрөөс иргэдийн орлогыг хамгаалах, тогтвортой байлгах санхүүгийн тусламж, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Хүснэгт 2. “Ковид-19” цар тахлын эдийн засгийн нөлөөг зөөлрүүлэхэд төрөөс үзүүлсэн санхүүгийн тусламж, арга хэмжээний хураангуй

Татвар, хураамжийн хөнгөлөлтийн хүрээнд (ДНБ-ний 3 хувь)	Нэмэлт зардлууд (ДНБ-ний 6 орчим хувь)
<ul style="list-style-type: none"> ▪ НДШ-ийн хөнгөлөлт ▪ ХХОАТ-ын хөнгөлөлт ▪ ААНОАТ ▪ Түрээсээ бууруулсан түрээслэгчдийн татварын хөнгөлөлт ▪ ААНОАТ, НДШ хоцорч төлсний алданги хөнгөлөх ▪ НӨАТ-ын хөнгөлөлт (эрүүл мэнд, хүнсний барааны импорт) 	<ul style="list-style-type: none"> ▪ Хүүхдийн мөнгө ▪ Эрүүл мэндийн зардал ▪ Малчдад олгох тусламж ▪ Халамжийн тэтгэвэр ▪ Ажлын байрыг хадгалахад ▪ ЗГ-ын онцгой байдлын сан ▪ Ноолуурын салбарын дэмжлэг ▪ Хүнсний талоныг 2 дахин нэмэх

Эх сурвалж: Монгол Улсын эдийн засгийн тойм “Тусламж дэмжлэгээс сэргэлт өөд”, Дэлхийн банкны тайлан, 2021 оны 2 дугаар сар

Иргэдийн орлогыг дэмжих, ажил эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Монгол Улсын хүүхэд бүрт олгодог “Хүүхдийн мөнгө” хөтөлбөр;
- эрүүл мэндийн зардлыг төрөөс даах;
- цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, хог хаягдлын төлбөр хураамжийг төрөөс хариуцах ажлын зохион байгуулалтыг сайжруулж, хэрэгжүүлэх;
- ноолуурын салбарын дэмжлэг;
- хүнсний талоныг 2 дахин нэмэх;
- залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх;
- халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгож буй амьжиргаа дэмжих тэтгэмж болон хүүхдийн мөнгөн тэтгэмжүүдийг нэмэгдүүлэн олгох шийдвэрийг хэрэгжүүлэх;
- нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийн санхүүгийн байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний үнийг үе шаттай бууруулах;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэж ажлын байраар хангах, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болон ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж, урамшуулах;
- гол нэрийн хүнс, түлш, шатахуун, малын тэжээл, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн үнийн зохиомол өсөлтөөс сэргийлэх;
- эрчим хүчний салбарын нарийн мэргэжлийн ажилтны хүний нөөцийг бүрдүүлэх;
- малжуулах хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй малгүй болон цөөн малтай иргэн, гэрээт малчин өрхийг малжуулахад санхүүгийн зохих дэмжлэг үзүүлэх.

ХОЁР.“КОВИД-19” ЦАР ТАХЛЫН ДАРААХ ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ, ИРГЭДИЙН БОДИТ ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР БУСАД ОРНУУДЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**2.1 АНУ****Эдийн засгийн нөхцөл байдал**

“Ковид-19” цар тахлын улмаас АНУ-ын эдийн засгийн өсөлтөд урьд өмнө гарч байгаагүй хэлбэлзэл бий болсон бөгөөд эдийн засаг бүхэлдээ 3.5%-аар буурчээ.

2021 оны 3 дугаар сарын байдлаар эдийн засгийн өсөлт нэмэгдсэн нь иргэдийг вакцинжуулалтад эрчимтэй хамруулснаар хөл хориог сулруулж, бизнесүүд үүд хаалгаа нээн, хэрэглэгчдийн зарцуулалт нэмэгдсэнтэй шууд холбоотой байна. Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 1983 оны 12 дугаар сараас хойших дээд хэмжээнд хүрч, үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаа 1990-ээд оны сүүл үеэс хамгийн дээд түвшинд хүрсэн гэж Хангамжийн удирдлагын хүрээлэн (Institute for Supply management)-ээс мэдээлсэн байна.

Жижиглэн худалдааны зарцуулалтын зардал нь (2021 оны 3 дугаар сарын байдлаар) өмнөх сараас бараг 10%-аар өссөн бөгөөд энэ нь айл өрхүүдэд чиглэсэн Холбооны санхүүжилтийн (Federal financial) багц тусламжууд нэмэгдэн эдийн засаг сэргэж эхэлж байгаатай холбоотой гэж үзэж байна. 1 сая ажлын байр бий болж, ажилгүйдлийн түвшин

2 дугаар сард 6.2% байсан бол 6% болж буурчээ. Эдийн засаг сэргэж, хэвийн байдалдаа эргэн орохоор чармайж байгаа ч нийлүүлэлт хязгаарлагдмал байгаа нөхцөлд үнийн өсөлтийг бий болгож, инфляцыг нэмэгдүүлэх хандлагатай байна.

Хөдөлмөрийн яам (US. Deartment of Labor)-ны мэдээлснээр вакцинжуулалт нэмэгдэж, Холбооны Засгийн газраас хэрэгжүүлсэн санхүүгийн багц тусламж иргэдийн гар дээр очсоноор хэрэглээний түвшин төдий хэмжээгээр нэмэгдэж, 2012 оны 8 дугаар сараас хойш тогтвортой байсан өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг 0.6%-аар нэмэгдүүлсэн байна.

Засгийн газраас иргэдийн бодит орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр авсан зарим арга хэмжээ, хөтөлбөр

АНУ “Ковид-19” цар тахлын үед эдийн засгийг сэргээх, тогтворжуулахад шаардлагатай улс орныг бүхэлд нь хамарсан төрийн бодлогыг шат дараатай хэрэгжүүлсээр байна. 2021 онд Ерөнхийлөгч Жое Байден АНУ-ын эдийн засгийг сэргээн хөгжүүлэх **“Илүү сайнаар бүтээе”** (Build Back Better)¹⁹ гурван хэсэг хөтөлбөрийг санаачлан боловсруулсан байна. Хөтөлбөрийн эхний хэсэг **“Америкийг хямралаас гаргах хөтөлбөр”** (American Rescue Plan Act) хуулийг боловсруулан баталж, 1.9 их наяд ам.долларын санхүүгийн багц тусламжийг хэрэгжүүлж эхлээд байна.²⁰ Хөтөлбөрийн 2 дахь хэсэг болох дэд бүтцийг сайжруулах, сая сая ажлын байр бий болгохоор төлөвлөсөн 2 их наяд ам.долларын төсөв шаардагдах **“Америкийн ажлын байр хөтөлбөр”** (American Jobs plan)-ийг боловсруулсан байна.²¹ Хөтөлбөрийн 3 дахь хэсэг дундаж давхаргыг нэмэгдүүлэх зорилго бүхий иргэдийн боловсрол, эрүүл мэнд, хүүхэд асрах үйлчилгээнд 1.8 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдах **“Америкийн гэр бүлүүд хөтөлбөр”** (American families plan)-ийг боловсруулсан байна.²²

Хямралын дараах татварын бодлого

“Америкт үйлдвэрлэв татварын хөтөлбөр” (Made in America Tax Plan)- татварын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2036 он хүртэл 2 их наяд ам.доллар бүрдүүлэх төлөвлөгөөтэй байна. Үүнд дараах арга хэмжээнүүдийг төлөвлөжээ:

- АНУ-ын үндэстэн дамнасан корпорацуудад татварын доод хэмжээг тогтоох;
- татвараас зайлсхийж байгаа улс орнуудад санхүүгийн урамшуулал олгох замаар дэлхийн аж ахуйн нэгжийн орлогын доод татварыг дэмжих;
- Америкт байрладаг гадаадын компанитай нэгдсэн томоохон корпорацуудаар холбооны орлогын албан татвар төлүүлэх;
- оффшор дахь ажлын байрны татварын хөнгөлөлтийг цуцлах, АНУ-д ажиллахыг урамшуулах;
- жилийн 100 сая доллараас дээш ашигтай томоохон корпорацуудын ашгийн татварыг 15 хувиас доогуур тогтоох;
- түлшийг татварын хөнгөлөлтөөс чөлөөлж, хүрээлэн буй орчноо бохирдуулж буй үйлдвэрүүдээс нөхөн сэргээх зардлын төлбөрийг “Superfund”-д төлүүлэх;
- татварын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, корпорацууд болон өндөр орлоготой иргэдийн үйл ажиллагаанд аудитын шалгалтыг хийх зэргээр татвараас санхүүжилтийн орлого бүрдүүлэхээр төлөвлөжээ.

¹⁹ <https://www.whitehouse.gov/build-back-better/>

²⁰ <https://www.whitehouse.gov/american-rescue-plan/>

²¹ <https://www.whitehouse.gov/briefing-room/statements-releases/2021/03/31/fact-sheet-the-american-jobs-plan/>

²² <https://www.whitehouse.gov/american-families-plan/>

Нийгмийн халамж, тэтгэмж**“Америкийг хямралаас гаргах хөтөлбөр”**

2021 оны 3 дугаар сард **“Америкийг хямралаас гаргах хөтөлбөр”** (American Rescue Plan Act) хуулийг боловсруулан баталж, 1.9 их наяд ам.долларын санхүүгийн багц тусламжийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Энэ нь 2020 оны төсвийн 8.8%-ийг эзэлж байна. Энэхүү багц тусламжийг жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих, үйл ажиллагааг нь тогтворжуулах, иргэдийг вакцинжуулалтад бүрэн хамруулах, сургууль цэцэрлэгүүдийг нээх, ажилгүй болсон иргэд, айл өрхүүдэд амьжиргааны тэтгэмж олгох, хүүхдийн татварын хөнгөлөлтөд хамруулах, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах зэрэг ажил эрхэлдэг гэр бүлүүд рүү түлхүү анхаарсан зохицуулалтуудыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Тус хөтөлбөр нь доорх бүтэцтэй байна:

- муж, орон нутгийн засаг захиргааны байгууллагад үзүүлэх тусламж;
- иргэдийн гарт шууд олгох тэтгэмж;
- татварын орлогоос олгох тэтгэмж;
- ажилгүйдлийн тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох;
- жижиг бизнесийг дэмжих;
- эрүүл мэнд, иргэнд үзүүлэх тусламж үйлчилгээнд олгох тэтгэмж;
- Medicaid/Medicare эрүүл мэндийн улсын даатгалын санхүүжилт;
- хүнс тэжээлийн тусламж;
- улсын аюулгүй байдалд;
- хөдөө аж ахуйд;
- тээвэр, дэд бүтцийн салбарт;
- боловсролын салбарт;
- хүрээлэн буй орчныг хамгаалахад;
- цахилгаан, эрчим хүч, усны хэрэглээний үнийг бууруулахад;
- хэрэглэгчийн эрхийг хамгаалахад;
- иргэдийг орон байр, түрээсийн байранд хамруулахад;
- ахмад дайчдад олгох тэтгэмж;
- технологи, цахим орчны хурд, аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд зэрэг болно.

Иргэдийн орлого нэмэгдүүлэх тусгайлсан арга хэмжээ**“Америкийн ажлын байр хөтөлбөр”**

2021 оны 3 дугаар сард Ерөнхийлөгч Жое Байден 8 жилийн хугацаанд 2 их наяд ам.долларын төсвөөр хэрэгжүүлэх “Америкийн ажлын байр хөтөлбөр”-ийг боловсруулан танилцуулсан байна. Энэ нь АНУ-д ирэх 10 жилийн хугацаанд жил бүр 2 сая ажлын байрыг шинээр бий болгох, дэд бүтцийг шинэчлэх, уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох зэрэг томоохон асуудлуудыг хамарч дараах салбаруудад санхүүжилт олгохоор төлөвлөжээ. Үүнд:

- ажиллах хүчний хөгжил;
- үйлдвэрлэл, жижиг бизнес;
- шинэ техник, технологийн судалгаа шинжилгээ, зохион бүтээх, үйлдвэрлэх, ажлын байрны сургалт;
- улсын сургууль, коллеж;
- ахмад дайчдын эмнэлэг;
- иргэдийн байр, орон сууц;
- эрчим хүчний дэд бүтэц/Цэвэр эрчим хүч;
- өндөр хурдны интернэт;
- усны систем/Цэвэр ундны ус;

- байгаль орчны нөхөн сэргээлт;
- нийтийн тээвэр;
- ачаа тээвэр/агаарын болон усан зам, төмөр замын тээвэр/ зэрэг болно.

“Америкийн гэр бүлүүд хөтөлбөр”

2021 оны дөрөвдүгээр сард АНУ-ын эдийн засгийг сэргээн хөгжүүлэх **“Илүү сайнаар бүтээе”** (Build Back Better) багц хөтөлбөрийн 3 дахь нь буюу **“Америкийн гэр бүлүүд хөтөлбөр”**-ийг танилцуулсан байна. Тус хөтөлбөрөөр ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийх, чанартай, өндөр цалинтай ажлын байр бүхий дундаж давхаргыг бий болгоход түлхүү анхаарч боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхэд асрах үйлчилгээ зэрэгт нэлээдгүй хөрөнгө оруулахаар төлөвлөжээ.

- Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс боломжийн ертөгтэй болгох:
 - олон сая Америкчуудад зориулан олон нийтийн коллежид 2 жил төлбөргүй сурах боломжийг олгох;
 - нийт 3-4 настнуудыг сургуулийн өмнөх чанартай сургалтад хамруулах;
 - бага болон дунд орлоготой өрхийн оюутнуудын сургалтын төлбөрийг хөнгөлөх;
 - оюутнуудыг сургуулиа төгсөх боломжоор хангах;
 - багш бэлтгэх, багшийн хомстлыг арилгах, өнгөт арьстай багш нарын тоог нэмэгдүүлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зэрэгт зориулан 9 тэрбум ам.долларын санхүүжилт олгох.
- Айл өрхүүдийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах:
 - мужийн дундаж орлогын 150%-аас доогуур орлоготой иргэн орлогынхоо 7-оос дээш хувийг хүүхэд асрах үйлчилгээнд зарцуулахгүй байхад анхаарах;
 - ажил эрхлэгчдэд шинээр төрүүлсэн хүүхдээ асрах, өөрөө өвдөх, гэр бүлийн гишүүд нь өвдөх зэрэгт цалинтай чөлөө олгох;
 - хоол хүнсний тусламжийг нэмэгдүүлэх, Сургуулийн хоолны хөтөлбөр болон Зуны хоол тэжээлийн хөтөлбөрт хүүхэд болон айл өрхүүдийг хамруулах;
 - эхийн эрүүл мэндэд 3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх.
- Ажил эрхлэгч иргэд болон айл өрхүүдийн татварын хөнгөлөлтийг өргөжүүлэх зэрэг болно.

Тус хөтөлбөрийн тодорхой хэсгийг “Америкт үйлдвэрлэв татварын хөтөлбөр”-ийн дагуу өндөр орлоготой Америк иргэд болон хөрөнгө оруулагчдад ногдуулах татварын өсөлтөөс олсон орлогоор санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байна. Тодруулбал, орлогын албан татварын дээд хэмжээг 2017 оноос өмнөх түвшинд буюу 39.6% болгох, жилийн 1 сая ам.доллароос илүү орлоготой иргэдийн орлогын албан татварыг ойролцоогоор 2 дахин нэмэгдүүлэх, өвлөгдсөн хөрөнгөнөөс татвар авахгүй байх тухай татварын хуулийн заалтыг хасах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.2 ОХУ

ОХУ-ын эдийн засгийн нөхцөл байдал

ОХУ-ын Үндэсний статистикийн алба “Росстат”-аас 2022 оны эхний хагас жилийн байдлаар ОХУ-ын ДНБ-нийг 0.4%-аар буурсан, 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн сайд тус улсын ДНБ-нийг 2022 онд 2.9%-аар агших төлөвтэй байна гэж тус тус мэдэгдсэн.

ОХУ нь Украин Улсад “цэргийн тусгай ажиллагаа” явуулж эхэлснээс хойш гадаад өр, худалдаа болон газрын тос, байгалийн хий үйлдвэрлэлийн статистик мэдээллийг хязгаарлаж, зарим мэдээллүүдийг нийтлэхээ тодорхойгүй хугацаанд зогсоогоод байна.

ОХУ-ын Засгийн газраас “Ковид-19” цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ

ОХУ-ын Засгийн газраас “Ковид-19” цар тахлын үед ажиллах нөхцөл, ажил олгогч болон хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих чиглэлээр 2022 онд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүнд:

ОХУ-ын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 625 дугаар захирамжаар “Ковид-19”-ийн халдвартай тэмцэж буй **эмнэлгийн ажилтнуудын даатгалын нөхөн төлбөрт** 4 тэрбум рубль нэмэлтээр хуваарилсан. 2020 оны 05 дугаар сард гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу эмч, сувилагч болон “Ковид-19”-ийн халдвартай өвчтөн тээвэрлэх явцад халдвар авсан түргэний жолооч нар даатгалын нэмэлт баталгаагаар хангагдах болсон. 2021 онд эмнэлгийн ажилтнуудад 22,2 тэрбум рублийн нэг удаагийн даатгалын нөхөн төлбөрийг төлөөд байна.

ОХУ-ын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 427 дугаар захирамжаар **бизнесийн хөнгөлөлттэй зээлийн “ФОТ 3.0”** хөтөлбөрийн санхүүжилтэд 6,2 тэрбум гаруй рубль нэмэлтээр хуваарилсан. Тус хөтөлбөрийг бизнесийн үйл ажиллагааг сэргээх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 2021 онд эхлүүлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд “Ковид-19” цар тахлын нөлөөлөлд хамгийн ихээр өртсөн нийтийн хоол, зочид буудал, соёл, спортын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд жилийн 3%-ийн хүүтэй, хөнгөлөлттэй зээл олгоно. Зээлд хамрагдах гол нөхцөл нь цар тахлын үед ажлын байрны 90-ээс доошгүй хувийг хадгалсан байх ёстой юм.

ОХУ-ын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 199 дугаар захирамжаар **онцгой албан татвар ногдуулах бараа борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг** (зочид буудал, зоогийн газар, кафе) **аж ахуйн нэгжүүдэд** орон нутгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг олгох хугацааг 2022 оныг дуустал сунгасан. Засгийн газраас энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд дэмжлэг үзүүлдэггүй боловч бизнес эрхлэгчдийг дэмжих багц арга хэмжээний хүрээнд 2020 оны хагасаас эхлэн тус хязгаарлалтыг цуцалсан.

ОХУ-ын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 71 дүгээр захирамжаар эмнэлгийн ажилтнуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор **эмч, сувилагчдын цалингийн зардалд** 17,3 тэрбум гаруй рублийг нэмэлтээр хуваарилсан.

ОХУ-ын Засгийн газраас ОХУ-ын эсрэг авсан хориг арга хэмжээний үед иргэдийн орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ

ОХУ-ын Засгийн газраас ОХУ-ын эсрэг авсан хориг арга хэмжээний үед иргэдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2022 онд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.²³ Үүнд:

ОХУ-ын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 1791 дүгээр тогтоолоор 2018-2022 онд хүүхэдтэй болсон гэр бүлд зориулсан **“Гэр бүлийн ипотекийн зээл”**

²³ ОХУ-ын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 357 дугаар тогтоолоор ОХУ-ын Засгийн газрын дэргэд Ерөнхий сайд Михаил Мишустинаар ахлуулсан Хориг арга хэмжээний нөхцөлд эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх Засгийн газрын комиссыг байгуулсан.

2022 оны 03 дугаар сарын 08-ны өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин хориг арга хэмжээний нөхцөлд иргэд, бизнес эрхлэгчдийг дэмжих нийгэм, эдийн засгийн багц арга хэмжээний тухай хуульд гарын үсэг зурсан. Уг хуульд нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх, энэ оныг дуустал ЖДҮ-ийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг түр зогсоох зэрэг арга хэмжээг тусгасан.

хөтөлбөрийн хугацааг 2023 оныг дуустал сунгаж, ипотекийн зээлийн хүүгийн хэмжээг 6% болгон бууруулсан.

ОХУ-ын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 1663 дугаар захирамжаар **ажил хайж буй** (үүнд, ажлаас халагдах эрсдэл бүхий, ажлын бүтэн бус ажлын цагаар ажиллах горимд шилжүүлсэн, цалингүй амралт олгогдсон зэрэг иргэд) **иргэдэд үзүүлэх түр дэмжлэг**ийн хугацааг 2023 он хүртэл сунгасан. Уг арга хэмжээг 2022 оны 3 дугаар сараас нэвтрүүлсэн бөгөөд түр ажлын байраар хангах, хувиараа хөдөлмөр эрхлэгчээр бүртгүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээ багтаж байна.

ОХУ-ын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 1109 дүгээр тогтоолоор **“Хөнгөлөлттэй ипотекийн зээл”** хөтөлбөрийн зээлийн хүүг 9%-аас 7% болгож бууруулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2022 оны дуустал шинээр ашиглалтад оруулсан орон сууцанд орон сууц худалдан авах, амины орон сууц барих, эсхүл амины орон сууц барих зорилгоор газар худалдан авахад Москва, Санкт-Петербург хот болон Москва, Ленинград мужид олгох зээлийн дээд хэмжээ 12 сая рубль байх бол бусад бүс нутагт 6 сая рубль, урьдчилгаа төлбөр 15%-аас доошгүй байна.

Иргэдэд орон сууц худалдан авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зээлийн дүнг 30 сая рубль болон 15 сая рубль болгон нэмэгдүүлсэн. Ингэхдээ 12 сая рубль болон 6 сая рублийн зээлийг төрөөс санхүүжүүлэх, үлдсэнийг зах зээлийн хүүтэй зээл, эсхүл бусад хөнгөлөлттэй зээлд хамруулна.

ОХУ-ын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 887 дугаар тогтоолоор бага орлоготой өрхийн **8-17 насны хүүхдэд сар бүр олгох тэтгэмжийг** санхүүжүүлэхэд 362,9 тэрбум рубль хуваарилсан. Гэр бүлийн нөхцөл байдлаас хамааран тэтгэмжийн хэмжээ бүс нутгийн амьжиргааны доод түвшний 50%, 75%, 100%-тай тэнцэх бөгөөд нэг хүүхдэд сард дунджаар 6-12 мянган рубль олгоно.

Өдгөө 8 хүртэлх насны хүүхэдтэй, бага орлоготой өрхөд сар бүр тэтгэмж олгож байгаагаас гадна 8-17 настай хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхчүүдэд тэтгэмж олгож байна.

ОХУ-ын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 352 дугаар тогтоолоор иргэд, бизнест дэмжлэг үзүүлэх багц арга хэмжээний хүрээнд **зээлийн эргэн төлөлтийн хугацаа хойшлуулах арга хэмжээнд** хамрагдах зээлийн дээд хэмжээг тогтоосон.

Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хойшлуулах арга хэмжээнд хамрагдах хэрэглээний зээлийн дээд хэмжээг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

- Хувь хүн - 300 мянган рубль;
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч - 500 мянган рубль;
- Кредит картны зээлийн төлбөр - 100 мянган рубль;
- Автомашин зээл - 700 мянган рубль.

Ипотекийн зээлийн хувьд:

- Москва - 6 сая рубль;
- Москва муж, Санк-Петербург, Алс Дорнодын холбооны тойрог - 4 сая рубль;
- Бусад - 3 сая рубль.

Хөтөлбөрт 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд өмнөх онтой харьцуулахад орлого нь 30 хувиар буурсан зээлдэгчид хамрагдах боломжтой.

2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр ОХУ-ын Татварын хууль тогтоомжид оруулсан өөрчлөлтийн дагуу банкнаас хувь хүнд биет үнэт металл (алтан гулдмай) борлуулахад ногдуулах 20%-ийн НӨАТ-ыг тэглэсэн.

2.3 ИРЛАНД УЛС

Эдийн засгийн нөхцөл байдал

Ирланд Улс “Ковид-19” цар тахлын ихэнх хязгаарлалтыг 2022 оны 01 дүгээр сард цуцалснаар эдийн засаг нь идэвхжиж, ажиллах хүчний нөөц хэвийн байдалд орж жижиглэн худалдааны борлуулалтын өсөлт, үйлдвэрлэл, үйлчилгээний салбар идэвхжиж импортын өсөлт нь 2022 оны байдлаар өссөн төлөвтэй байна.

Ирланд Улсын эдийн засгийн төлөв²⁴

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он
ДНБ-ний өсөлт	5.9%	13.5%	5.3%	4.0%
Инфляц	-0.5%	2.4%	7.3%	3.3%

2022 оны хоёрдугаар сард Засгийн газраас 505 сая еврогийн тусламжийн багц баталж, гуравдугаар сард шатахууны онцгой албан татварыг бууруулснаар эдийн засгийн өсөлтөд тодорхой хэмжээний дэмжлэг болж байна.

Засгийн газраас иргэдийн бодит орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ

Засгийн газраас 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдөр бизнесийн болон өрхийн орлогыг дэмжих чиглэлээр баталсан шийдвэрээ 2021 оныг дуустал сунгаж, 3.5 тэрбум евро (ДНБ-ний 1%) байхаар төлөвлөж, Европын холбооны эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сангаас 1 тэрбум еврог зарцуулахаар болсон. Үүнд:

- долоо хоног бүр олгодог 350 евро хүртэлх цар тахлын ажилгүйдлийн дэмжлэгийг 2022 оны 02 дугаар сар хүртэл сунгах;
- цалингийн татаас олгох схем 2021 оныг дуустал үргэлжлэх бөгөөд Засгийн газар уг схемийн үйл ажиллагааг 4 дүгээр улиралд өөрчлөх боломжийг нээлттэй үлдээх;
- татвар, худалдааны хүүгээс чөлөөлөх хугацааг 2021 оны эцэс хүртэл сунгах;
- аялал жуулчлалын НӨАТ-ын хувь хэмжээ 2022 оны 9 дүгээр сар хүртэл 9% хэвээр байлгах;
- ЖДҮ-ийг дахин нээхэд хамгийн ихдээ 30,000 еврогийн буцалтгүй тусламж олгох зэрэг төлөвлөгөө багтсан болно.

Засгийн газраас баталсан хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих - Хөрөнгө оруулалт нь 30%-аар буурсан ажил олгогчдод нэг ажилтанд долоо хоног бүр 203 евро хүртэлх хэмжээний хөнгөлөлт үзүүлэх;
- цар тахлын үеийн ажилгүйдлийн дэмжлэг- тахал өвчний улмаас ажилгүй болсон хүмүүст долоо хоногт 350 евро олгох;

²⁴ https://economy-finance.ec.europa.eu/economic-surveillance-eu-economies/ireland/economic-forecast-ireland_en

- цар тахлын үеийн хязгаарлалт хийгдсэн хэд хэдэн салбар (орон байр, хоол хүнс, урлаг, амралтын газар), аж ахуйн нэгжүүдэд 10-аас 5 хувийн эргэлтийн хөрөнгийн нөхөн олговрыг олгох;
- сургалт, боловсрол, ур чадвараа дээшлүүлэх, ажилд зуучлах, ажилд авах татаас, ажил хайх, туслах арга хэмжээнд 200 сая еврогийн нэмэлт хөрөнгө оруулалт хийж, ажилгүй болсон хүмүүст шинэ ажил хайх, дахин сургах, эсвэл шинэ ур чадвараа хөгжүүлэх, ялангуяа шинээр ажилд орох хүмүүст туслах.

ЖДҮ-ийг дэмжих арга хэмжээний хүрээнд:

- аж ахуйн нэгжийг дахин эхлүүлэхэд зориулсан буцалтгүй тусламж (550 сая евро);
- арилжааны хүүгээс татгалзах;
- зээлийн баталгааны схем: 10,000 еврогоос 1 сая хүртэлх еврог 6 жилийн хугацаатай олон төрлийн зээлийн бүтээгдэхүүний засгийн газрын 80%-ийн баталгаа гаргах;
- бичил болон жижиг бизнесийн зээлийн хүүг бууруулах зорилгоор хөрвөх чадвар, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтын 55 сая еврогийн арга хэмжээний багц;
- Европын Хөрөнгө оруулалтын банктай хамтран урт хугацааны зээл олгох (500 сая евро).

Аялал жуулчлалын салбарыг дэмжих арга хэмжээний хүрээнд:

- 2021 оныг дуустал НӨАТ-ын хүүг 13.5-аас 9 хувь хүртэл бууруулах;
- татварын хөнгөлөлт эдлэх;
- аялал жуулчлалын салбарыг дэмжих сангийн 10 сая еврог дахин эхлүүлэх;
- соёлын салбарын 10 сая еврогийн гүйцэтгэлийг дэмжих схем нь Ковид-19-ийн хүрээнд авах арга хэмжээг төлөвлөхөд туслах болно.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

- НӨАТ-ын стандартын хувь хэмжээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 21 хувиар бууруулах;
- хямралд өртсөн бизнес эрхлэгчдийн татвар, өр төлбөрийг хойшлуулах, хүү, торгууль төлөхгүйгээр төлбөрөө төлж, НӨАТ-ын өрийг тодорхой хэмжээгээр хэсэг хугацаанд хойшлуулах;
- татварын бүх өрийг тохиролцсон эргэн төлөлтөд хамруулж, зээлийн хүүг 3% хүртэл бууруулах;
- өмнө нь ашигтай ажиллаж байсан компаниудад мөнгөн урсгалын дэмжлэгийг нэн даруй үзүүлэхийн тулд арилжааны алдагдлыг эрт буцаан олгохыг зөвшөөрөх бөгөөд ингэснээр татвар төлсөн корпорацын татварын зарим хэсгийг эсвэл бүх хэсгийг нэн даруй буцаан олгох боломжтой болно;
- эмийн чухал бүтээгдэхүүн, эмийг гаалиар чирэгдэлгүйгээр нэвтрүүлж, импорт, нийлүүлэлтийг тасралтгүй үргэлжлүүлэх зэрэг болно.

Нийгмийн халамжийн арга хэмжээ

“Ковид-19” цар тахлын үеийн ажилгүйдлийн тэтгэмж нь: нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын улмаас ажилгүй, ажил эрхлэх боломжгүй болсон иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд олгодог нийгмийн халамжийн тэтгэмж юм.

Харин “Ковид-19” халдварын өвчний тэтгэмж нь: “Ковид-19”-ын халдвараар өвчилсний улмаас хөдөлмөр эрхлэх боломжгүй байх хугацааны тэтгэмжийн хөтөлбөр юм. Эдгээр тэтгэмж, хөтөлбөрийн хугацаа 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр дууссан байна.

Түрээс болон зээлийн эргэн төлөлтийн хөнгөлөлтийн арга хэмжээ

Ирланд Улсын Төв Банкнаас (CBI) зарласан арга хэмжээнд:

- Зээлдэгчийн төлбөрийн хоцрогдлыг зээлийн төв болон банкны бүртгэл мэдээлэлд оруулахгүй байх;
- “Ковид-19”-өөр өвчилсөн иргэдэд зориулсан орон сууцны зээл, бизнесийн зээлийн төлбөрийн хөнгөлөлтийг 3-6 сар хүртэл хугацаагаар сунгах.

Бусад тусгайлсан арга хэмжээ

Үндэсний эдийн засгийг сэргээх, тогтворжуулах төлөвлөгөө (National Recovery and Resilience Plan)

Үндэсний эдийн засгийг сэргээх, тогтворжуулах төлөвлөгөө нь нийгэм, эдийн засгийн сэргэлт, ажлын байр бий болгохтой зэрэгцэн ногоон, дижитал шилжилтийг шийдвэрлэх гурван тэргүүлэх чиглэлийг хамарсан хорин таван хөрөнгө оруулалтын төсөл, шинэчлэлийн арга хэмжээнд үндэслэсэн болно. Үндэсний эдийн засгийг сэргээх, тогтворжуулах төлөвлөгөөг Эдийн засгийг сэргээх төлөвлөгөө (Economic Recovery Plan), Үндэсний хөгжлийн төлөвлөгөө (National Development Plan)²⁵ гэсэн 2 үндсэн төлөвлөгөөнд уялдуулан хийж, Засгийн газар 20.5 тэрбум еврогийн шууд дэмжлэг, 4 тэрбум еврогийн шууд бус дэмжлэгийг багтаасан 24.5 тэрбум еврогийн санхүүгийн иж бүрэн багцыг зарласан байна.

Шууд дэмжлэг

- татварыг хойшлуулах (2.9 тэрбум евро);
- хөдөлмөрийн зах зээлийг дэмжих (11.4 тэрбум евро);
- эрүүл мэндийн салбарын чадавхыг сайжруулах (2 тэрбум евро);
- бизнесийг дэмжих (1.5 тэрбум евро);
- капитал бүрдүүлэх (0.5 тэрбум евро).

Европын Холбооны Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сангаас Ирланд Улсын Үндэсний сэргээн босголтын төлөвлөгөөг санхүүжүүлэх 915 сая еврогийн томоохон хөрөнгө оруулалт хийнэ.

- ногоон эдийн засгийг дэмжих – 503 сая евро;
- дижитал шинэчлэл, өөрчлөлтийг өргөжүүлэх – 295 сая евро;
- нийгэм, эдийн засгийн сэргэлт, ажлын байр бий болгох – 181 сая евро зарцуулахаар төлөвлөөд байна.

Эдийн засгийг сэргээх төлөвлөгөө²⁶

2020 оны 03 дугаар сард “Ковид-19” цар тахал эхэлснээс хойш дотоодын эдийн засагт сөргөөр нөлөөлж, аж ахуйн нэгжүүдийн тоо 2020 онд 10 орчим хувиар хумигдаж, ажилгүйдэл 25 хувь болж нэмэгдсэн байна. Эдийн засгийг сэргээх төлөвлөгөө нь 4 үндсэн тулгуур зорилготой.

- төрийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах;

²⁵ National Development Plan, <https://www.gov.ie/en/policy-information/07e507-national-development-plan-2018-2027/>

²⁶ Economic Recovery Plan <https://www.gov.ie/en/campaigns/709d1-economic-recovery-plan/>

- хөдөлмөрийн зах зээлийн дэмжлэгийг өргөжүүлэх;
- аж ахуйн нэгжүүдийг бодлогын тусламжтайгаар дэмжиж сэргээн босгох;
- бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх.

Төрийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах²⁷

2021 онд ЭЗХАХБ-тай олон улсын татварын хувьд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, дижитал хэлбэрт шилжүүлэх талаар хэлэлцээр хийх зорилго тавин ажиллаж байна. Энэхүү хэлэлцээр нь олон улсын татварын тогтолцоонд тогтвортой байдлыг бий болгоно гэж үзэж байна.

Олон улсын татвар

- Инновацын өсөлтийг үргэлжлүүлэн дэмжих;
- татвар төлөгчид болон хөрөнгө оруулагчдад санхүүгийн баталгаа гаргаж өгөх;
- татварыг хөнгөвчлөх.

Урт хугацааны татвар болон халамжийн бодлого

Эдийн засгийг сэргээх үйл ажиллагааны хүрээнд ажил эрхлэлтийг дэмжих татвар халамжийн хороог байгуулсан. Тус хороо нь төрийн үйлчилгээ, дэмжлэгийн зардлыг дунд болон урт хугацаанд хангах хангалттай эх үүсвэр байгаа эсэхийг баталгаажуулах зорилготой юм.

Хөдөлмөрийн зах зээлийн дэмжлэгийг өргөжүүлэх²⁸

Засгийн газрын 2021-2025 оны хөдөлмөрийн зах зээлийн дэмжлэг нь хүмүүсийг хөгжүүлэх, чадавхыг дээшлүүлэх, тогтвортой ажлын байраар хангах, дахин мэргэшүүлж хуучин ажлын байранд нь ажилд оруулах, шинээр өсөн нэмэгдэж байгаа ажлын байранд дэвшүүлэн томиллох тал дээр илүү дэмжлэг үзүүлнэ. Мөн нийтийн хөдөлмөр эрхлэлтийн чадавхыг өргөжүүлж, дижитал технологи, нийтийн үйлчилгээний чадавхыг өргөжүүлэх, цалин тэтгэмж, цар тахлын үеийн ажилгүйдлийг бууруулах, цалингийн татаас олгоно. Ажил эрхлэлтийн цалингийн татаас олгох схемийг 2021 оны 06-р сарын 30-ны өдрөөс 12-р сарын 31-ний өдрийг хүртэл сунгах болно.

- Хөдөлмөр эрхлэлт цалин хөлсний тэтгэмж олгох;
- Цар тахлын ажилгүйдлийн тэтгэмж олгох;
- 50,000 боловсрол, сургалтын байрны ашиглалтыг нэмэгдүүлэх.

Аж ахуйн нэгжүүдийг бодлогын тусламжтайгаар дэмжих²⁹

2024 он гэхэд хямралын өмнөх үеийнхээс ажил эрхлэлтийн түвшинг ахиулах, 2,5 сая хүнийг ажлын байртай болгох зорилт тавьсан. ЖДҮ эрхлэгчид дотоодын аж ахуй нэгжүүдийн 99,8%-ийг, нийт ажил эрхлэлтийн 68%-ийг эзэлдэг байна. Тиймээс бүтээмж, экспортын үйл ажиллагаа, интернационалчлал, дижиталчлал, бизнесийн бусад салбарын динамик байдлыг сайжруулахын зэрэгцээ бусад салбарын бизнесийг идэвхжүүлэх, олон улсын болгох, дижитал болгох, бизнесийн эрч хүчийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүний тулд:

- засгийн газрын дижитал, ногоон эдийн засгийг хослуулж эдийн засгийг сэргээх;

²⁷ Ensuring Sustainable Public Finance, <https://www.gov.ie/en/publication/d4dcc-sustainable-public-finances/>

²⁸ Pathways to Work 2021-2025, <https://www.gov.ie/en/publication/90e59-pillar-2-helping-people-back-into-work/>

²⁹ Rebuilding Sustainable Enterprises, <https://www.gov.ie/ga/foilsuichan/d28d9-pillar-3-re-building-sustainable-enterprises/>

- бизнесийн үйл ажиллагааг дижитал хэлбэрээр өөрчлөх;
- шинэ менежмент, шинэ технологи нэвтрүүлэх;
- хүний болон биет капиталд хөрөнгө оруулах;
- автоматжуулалт, алсын зайны ажлыг нэвтрүүлэх;
- ЖДҮ-ийг дэлхийн зах зээлд нэвтрүүлэх, экспортлох боломжийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх;
- 2025 он гэхэд 3000 гаруй нэмэлт бичил болон гарааны аж ахуйн нэгжүүдийг экспортлогч болгох;
- шинээр бизнес эрхлэгчдийг дэмжих төлбөрийн дэмжлэгийг 10,000 евро болгон нэмэгдүүлэх дээд тал нь 30,000 еврогийн дэмжлэг үзүүлэх;
- хорио цээрийн үед орлого нь мэдэгдэхүйц буурсан аж ахуйн нэгжүүдэд буцалтгүй тусламж олгох;
- арилжааны үнээс 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 09 дүгээр сарыг дуустал чөлөөлөх;
- татварыг хойшлуулах арга хэмжээг 2022 оны эцэс хүртэл сунгах;
- ажлын байрны цомхотгол хийх нэхэмжлэл гаргах хугацааг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгах;
- аялал жуулчлалын салбарын НӨАТ-ын 9%-ийг чөлөөлөх, амралт зугаалгын газар зэрэг хохирол их амссан салбарт дэмжлэг үзүүлэх;
- хүнсний боловсруулах үйлдвэрт зориулсан хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэх;
- аж ахуйн нэгжийн санг дэмжих үйл ажиллагааг үргэлжлүүлэх;

Тэнцвэртэй хүртээмжтэй сэргэлт³⁰

Засгийн газар нь ард түмэн, бүс нутгийнхаа тэнцвэртэй байдлыг хангах, хүмүүсийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх үүрэг хүлээдэг. Иймд стратегийн хөрөнгө оруулалт, бүс нутгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт, ногоон эдийн засаг, дижитал шилжилт нь нэн тэргүүний асуудал болоод байна.

Үндэсний төлөвлөлт 2040 төслийн хүрээнд:

- жил бүр 33,000 орон сууцыг зорилтот бүлэгт хамруулах;
- хямд өртөгтэй орон сууцны зээлийг эрсдэлийн схемээс хасах;
- үйлдвэрийн өмнөх 33 сая га газрыг нөхөн сэргээх;
- орон нутгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх 20 сая еврогийн голын сав газрын менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- хил орчмын цар тахлын нөлөөнд их өртсөн орон нутгийг хөгжүүлэх, сэргээхэд 1 тэрбум еврогийн нөхөн сэргээлт хийх;

Амьжиргааны түвшинг дээшлүүлэх

Ажил олгогчид болон үйлдвэрчний эвлэлүүдтэй зөвшилцөн төлөвлөгөө боловсруулж, Хөдөлмөр эрхлэгчдийн эдийн засгийн форумыг зохион байгуулж, зорилтот шинэчлэл хийснээр ажил эрхлэлт, амьжиргааны түвшин, нөхцөлийг сайжруулах болно.

- хуулиар тогтоосон олон нийтийн хэлэлцүүлгийг хийсний дараа хуулийн төслийн ерөнхий схемийг нийтэлж, 2021 оны эцэс гэхэд батлах;
- амьжиргааны доод түвшинг хэрхэн тогтоох боломжтойг судалж, судалгааг оны эцэст дуусгасан байх;

³⁰A Balanced and Inclusive Recovery, <https://www.gov.ie/en/publication/bbd3b-inclusive-and-balanced-recovery/>

- иргэдийн хурлаар дамжуулан жендерийн тэгш байдлыг дэмжих, жендерийн цалингийн зөрүүтэй холбоотой мэдээллийн тухай хууль тогтоомжийг цаг алдалгүй гаргах;
- платформын эдийн засгийн зохистой зохицуулалт хийх зэрэг ажлуудыг төлөвлөгөөнд тусгасан байна.

2.4 ХБНГУ

“Ковид-19” цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

ХБНГУ-ын Засгийн газар нь “Ковид-19” цар тахлаас үүдэлтэй иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор аж ахуйн нэгжид үзүүлэх тусламжийг 2022 оны 6 дугаар сарыг дуустал сунгасан байна. Энэхүү 4 дэх удаагийн “Даван туулах тусламж IV” хөтөлбөрийг хувиараа эрхлэх аж ахуйн гарааны тусламж болон нэн хүнд нэрвэгдсэн аж ахуйн нэгжид үзүүлэх тусламжийн багцаар өргөжүүлсэн байна. Харин Холбооны улс болон Муж улсуудад аж ахуйн нэгжийн тусламжийг буруугаар ашиглаж гэмт хэрэг үйлдэхийг таслан зогсоох, тусламж эзнээ олж очиход нь анхаарал тавьж, шаардлагатай бүх арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон байна.

Дэд канцлер бөгөөд Холбооны эдийн засаг, уур амьсгал хамгаалахын сайд Хабекын мэдэгдсэнээр, “Ковид-19” цар тахлын үеэр аж ахуйн нэгжид үзүүлэх тусламжаас гадна богино цагийн ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл суутгахгүй байх зохицуулалтыг мөн 2022 оны 06 дугаар сарыг дуустал сунгасан ажээ.

Холбооны сангийн сайд Линднер “Ковид-19” цар тахлын хязгаарлалтыг сулруулж байгаа тул албан байгууллагуудын үйл ажиллагаа сэргэж, эргээд хэвэндээ орох нь дамжиггүй. Бид бүхий л үйлчилгээг удахгүй бүрэн хүлээн авах бололцоог иргэддээ олгохыг зорьж байна. Энэхүү аж ахуйн нэгжийн тусламжийг сунгаж байгаа нь орлого тасалдсан хэвээр байгаа албан байгууллагуудад дэмжлэг болох юм. Ингэснээр тухайн этгээдүүд хэвийн ажиллагаагаа эргэн сэргээхэд нь дөхөм болно” хэмээн мэдэгджээ.

“Даван туулах тусламж IV” хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгжүүд тогтмол зардлын тодорхой хувийн нөхөн олговор авах нь үргэлжилнэ. Үүнээс гадна “Ковид-19” цар тахалд маш хүнд нэрвэгдсэн аж ахуйн нэгж нь өөрийн хөрөнгийн нэмэгдэл авна.

“2022 оны 2 дугаар улирлын шинэ гарааны тусламж”-ийн хүрээнд нэг хүний үүсгэн байгуулсан буюу хувийн аж ахуй эрхлэгч нь сард 1500 евро хүртэл хэмжээний шууд нэмэгдэл авна.

Аж ахуйн нэгжийн тусламж хүртэх үндсэн шалгуур нь “Ковид-19” цар тахлаас шалтгаалан 2019 онтой харьцуулахад орлого нь 30% унасан байх юм. Дэмжлэгийн хамгийн дээд хэмжээ нь орлого нь 70% буурсан үед дэмжлэгт хамаарах тогтмол зардлын 90%-тай тэнцэх нөхөн олговор олгоно. Дэмжлэгт хамаарах тогтмол зардалд түрээсийн зардал, лизингийн төлбөр, зээлийн хүүгийн зардал, засварын өртөг, даатгал гэх мэт хамаарна.

Шинэ бизнесийн гараа эхлүүлэх хувийн аж ахуй эрхлэгч гэдэгт ХЭАА, нэг хүний ХХК-аас гадна дүрслэх урлагийн салбарын богино хугацааны ажилтан, бүх салбарын байнгын бус (түр) ажилтан, хөрөнгийн компани болон хоршоо хамаарна. “2022 оны 2 дугаар улирлын шинэ гарааны тусламж”-ийг урьдчилгаа байдлаар төлөх ба дэмжлэг үзүүлэх хугацааны туршид орлогын байдлаас хамааран тодорхой хувиар буцаан төлөх юм.³¹

³¹ “Ковид-19” цар тахлын үеийн аж ахуйн тусламжийг 2022 оны 6 дугаар сарыг дуустал сунгалаа – Шалгуур үзүүлэлтүүд нь хэвээрээ үргэлжилнэ-Corona-Wirtschaftshilfen werden als Absicherungsinstrument bis Ende

2.5 ЯПОН УЛС

Эдийн засгийн нөхцөл байдал

Япон Улс нь эдийн засгаараа дэлхийд гуравдугаарт ордог томоохон эдийн засагтай улс юм. Дэлхий даяар 2019 оны сүүлээс эхлэн тархаад байгаа “Ковид-19” цар тахлаас шалтгаалан улс орнуудын эдийн засаг удааширч, уналтад орох эрсдэл үүсээд байна. Дэлхийн эдийн засгийн хямрал Япон Улсад ихээхэн нөлөө үзүүлж 2020 онд тус улсын ДНБ 4.8% хүртэл буурчээ.³²

Олон улсын валютын сан Япон Улсын эдийн засгийн одоогийн нөхцөл байдал болон цаашдын хэтийн төлөвт дараах таамаг, дүгнэлтийг гаргасан байна.³³ Үүнд:

- Япон Улсын эдийн засаг 2021 онд гадаад худалдаа, олон нийтийн хэрэглээ (public consumption), хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр эргэн сэргэж 2.6 хувийн өсөлттэй болжээ. Түүнчлэн “Япон Улсын эдийн засаг 2022 онд 3.2 хувиар, 2023 онд 1.3 хувиар өсөх;
- “Ковид-19” цар тахлын улмаас эдийн засгийн өсөлт мэдэгдэхүйц буурч, тус улсын эдийн засаг суларснаар 2020 онд “Япон Улсын өр ДНБ-ний 256.2%-д, 2022 онд 252.3%-д, 2023 онд 250.8%-д хүрнэ хэмээн Олон Улсын Валютын Сан урьдчилан тооцоолсон байна.

“Ковид-19” цар тахлын улмаас үүссэн хямралыг дарах арга хэмжээ (2020-2021 онд ДНБ-ний 16 орчим хувь) нь хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт, ЖДҮ-д зориулсан мөнгөн тэтгэмж, хөнгөлөлттэй зээл олгох зэрэг арга хэмжээ хэрэгжүүлснээр улсын төсөвт хүндрэл учраад байгаа юм. Үүний үр дүнд улсын төсвийн алдагдал 2021 онд 8% (өнгөрсөн онтой харьцуулахад 9.2%) болсон.

Засгийн газраас иргэдийн бодит орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ, хөтөлбөр, төлөвлөгөө

Японы Засгийн газраас “Ковид-19” цар тахлын хямралыг даван туулах зорилгоор 1 их наяд орчим ам.доллартай тэнцэх санхүүгийн багц бүхий “Эдийн засгийг эрчимжүүлэх багц хууль”-ийг баталсан бөгөөд энэ нь тус улсын ДНБ-ний 20 гаруй хувьтай тэнцэж байгаа нь 2008 оны санхүүгийн хямралын үед авч хэрэгжүүлсэн хөшүүргийн багцаас хоёр дахин их байгаа юм.³⁴

Засгийн газраас 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр шинэ хэлбэрийн “Ковид-19”-ийн эсрэг хэрэгжүүлэх анхдугаар арга хэмжээг тогтоож, нийт 15,3 тэрбум иен зарцуулахаар шийдвэрлэж, эх орондоо буцаж ирэгсдэд 3 тэрбум иенийн тусламж үзүүлэх, дотоодод халдварлах эрсдэлийн эсрэг 6,5 тэрбум иен, хилийн хорио цээрийн шалгалтыг сайжруулахад 3,4 тэрбум иен зарцуулах зэрэг арга хэмжээ авсан.

Juni 2022 verlängert – Bewährte Programmbedingungen werden fortgesetzt-*гэрманаар*
<https://www.bmwk.de/Redaktion/DE/Pressemitteilungen/2022/02/20220216-corona-wirtschaftshilfen-werden-als-absicherungsinstrument-bis-ende-juni-2022-verlangert-bewahrte-programmbedingungen-werden-fortgesetzt.html>
³² <https://santandertrade.com/en/portal/analyse-markets/japan/economic-political-outline>

³³ Мөн тэнд.

³⁴ <https://www.hennessyfunds.com/insights/japan-japan-small-portpers-june-2020>

Хүснэгт 3. “Ковид-19” цар тахлын үед иргэдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээний мэдээлэл³⁵

Хувь хүн болон өрхийн амьжиргааг дэмжих		Арга хэмжээ	Төрөл	Хэмжээ, нөхцөл
Тэтгэмж		Бүх оршин суугчдад Хүүхэдтэй гэр бүлүүдэд	Онцгойлсон бэлэн мөнгөний төлбөр Хүүхдийн тэтгэмж	Хүн тус бүрд 100,000 иен Хүүхдийн нэмэлт тэтгэмж 10,000 иен
		Амьжиргааны зардлаа төлөх чадамжгүй өрх толгойлсон эцэг, эхүүдэд	Өрх толгойлсон эцэг, эхчүүдэд тусгайлсан дэмжлэг олгох	Өрх бүрд 50,000 иенийг олгох бөгөөд хэрвээ хүүхдийн тэтгэмж авч байгаа бол хоёр дахиаас хойших хүүхдэд 30,000 иен олгох. Өрхийн орлого буурсан тохиолдолд
Зээл		Ажлаас халагдсаны тэтгэмж	Ажлаас халагдсаны тэтгэмж	Сар бүр 330,000 иений тэтгэмж
		Орлогын хэмжээ буурснаас үүдэн орон сууцаа алдах эрсдэл	Эрсдэлийн сан үүсгэх	3-9 хүртэлх сарын түрээсийн төлбөрийг хойшлуулах
		Орлогын хэмжээ буурснаас шалтгаалж үргэлжлүүлэн сурах болгомжгүй болох эрсдэл	Оюутнуудад зориулсан эрсдэлийн сан	Бага орлоготой оюутнуудад 200,000 иен, бусад оюутнуудад 100,000 иен
Хөшгүүрлэх, хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх		Орлогын хэмжээ буурснаас шалтгаалж амьжиргааны чадамж доошлох	Бага үнийн дүн бүхий эрсдэлийн сан, дэмжлэгийн сан	Олон ам бүлтэй гэр бүлд олгох дэмжлэгийн дээд хэмжээ нь 800,000 иен Ганц бие өрхөд олгох дэмжлэгийн дээд хэмжээ нь 600,000 иен
		Орлого буурснаас шалтгаалж нийгмийн даатгалын шимтгэл төлөхөд хүндрэл үүсэх Татвар, нийтийн үйлчилгээний төлбөрийг төлөхөд хүндрэл үүсэх	Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, шимтгэлийн хэмжээг бууруулах Татвар, нийтийн үйлчилгээний төлбөрийг хойшлуулах	Үндэсний эрүүл мэндийн даатгал, урт хугацааны халамжийн даатгал, тэтгэвэр Үндэсний болон орон нутгийн татвар, нийтийн үйлчилгээний төлбөр (цахилгаан, газ, утас, цахилгаан холбооны төлбөр)

Эх сурвалж: <https://corona.go.jp/en/action/>



³⁵ <https://corona.go.jp/en/action/>

Татварын хөнгөлөлт³⁶

Засгийн газрын төсвийн урамшууллын зардал нь цар тахлын дэгдэлтийн эдийн засгийн нөлөөллийг багасгах гол хэрэгсэл юм. Эрүүл мэндийн хямралд өртсөн ажлын байрыг хадгалахын тулд татвар төлөх хугацаа, хэмжээг мэдэгдэхүйц хэмжээгээр өөрчилж байна.

Бүртгүүлэх/төлбөрийн эцсийн хугацааг сунгах

Автомат банкны шилжүүлэг ашигладаг татвар төлөгчдийн 2019 оны татварын тайланг төлөх хугацааг дараах байдлаар сунгана.

- Хувь хүний орлогын албан татвар, сэргээн босголтын орлогын албан татвар төлөх хугацааг 2020 оны 05 дугаар сарын 15-ныг хүртэл;
- Хувь хүний хэрэглээний татвар, орон нутгийн хэрэглээний татвар төлөх хугацааг 2020 оны 05 дугаар сарын 19-ныг хүртэл;
- Хэрэглээний татвар төлөгчдийн төлбөр төлөх хугацааг 2020 оны 05-р сарын 19-ныг хүртэл.

2020 оны 04-р сарын 30-ны өдөр “Ковид-19” цар тахлын эсрэг татвар, эдийн засгийн арга хэмжээг багтаасан хууль баталсан бөгөөд дараах татварын хөнгөлөлт үзүүлнэ. Үүнд:

- тухайн хугацаанд татвар төлөгчийн орлого 20 хувиар буурсан бол 2020 оны 02 дугаар сарын 01-нээс 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд хөнгөлөлт үзүүлэх;
- татварын алдагдлыг буцаах замаар татварын буцаан олголтыг 1 тэрбум иенээс бага хөрөнгөтэй компаниудад олгох (100 сая иенээс бага);
- жижиг, дунд компаниудын хөрөнгө оруулалтын татварыг бууруулах;
- цар тахлын улмаас цуцлагдсан соёл, урлаг, спортын арга хэмжээнд оролцохдоо төлсөн мөнгөө буцаан авах хүсэлтээ гаргасан тохиолдолд буцаан олгох;
- орон сууцны зээлд хамрагдах тусгай хөнгөлөлтийн шаардлагыг харгалзан үзэх;
- хэрэглээний татварын тусгай дүрмүүд тогтоох;
- төрийн болон хувийн санхүүгийн байгууллагуудтай байгуулсан гэрээг татвараас чөлөөлөх;
- орон нутгийн татварын хөнгөлөлтийн арга хэмжээнүүд (тухайлбал, татвар хураах хөнгөлөлтийн хугацаа, жижиг, дунд аж ахуйн нэгжийн өмчлөлд байгаа зарим эд хөрөнгийн үл хөдлөх хөрөнгийн татварыг бууруулах гэх мэт) арга хэмжээг авсан байна.

Нийгмийн халамж, тэтгэмж

Япон Улсын Засгийн газар “Ковид-19” цар тахлын үед эдийн засгийн хямралаас сэргийлэхийн тулд төрөл бүрийн арга хэмжээг стратегийн дагуу хэрэгжүүлэх хугацааг харгалзан үзэж, хоёр үе шаттайгаар буюу эхний үе шат “*Яаралтай тусламжийн үе*”, хоёр дахь үе шат “*V хэлбэрийн нөхөн сэргээх үе*” гэсэн шат дамжлагаар эдийн засгаа дахин сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Тодруулбал: эхний үе шат “Яаралтай тусламжийн үе шат” нь халдварын төгсгөл хүртэл үргэлжлэх бол хоёр дахь үе шат “V хэлбэрийн нөхөн сэргээх үе шат” нь халдварт өвчин дууссаны дараа эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, нийгмийн бүтцийн өөрчлөлтийг сайжруулах замаар эдийн засгаа идэвхтэй сэргээх үе шат юм.³⁷

³⁶ <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/japan-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

³⁷ https://www5.cao.go.jp/keizai1/keizaitaisaku/2020/20200420_economic_measures.pdf

Яаралтай тусламжийн үе шатны гол арга хэмжээ

- засгийн газар “Ковид-19”-ийн халдварын дараа эдийн засгаа сэргээх найдвартай суурийг бий болгохын тулд ажил эрхлэлт, бизнес, өдөр тутмын амьдралд нь тэтгэмж олгох;
- халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, эмчилгээний зориулалттай бүтцийг бий болгох, эм бэлдмэлийг нийтэд хүртээмжтэй болгох арга хэмжээ;
- ажил эрхлэлт, бизнесийг тогтвортой байлгах;
- өрхийн орлогыг дэмжих: Япон Улсад оршин сууж байгаа бүх иргэдэд бэлэн мөнгө олгох, Хүүхдийн тэтгэмж олгохдоо арван мянган иен нэмж олгох, санхүүгийн хүндрэлтэй айл, өрхүүдэд яаралтай бичил зээл олгох, бага орлоготой өрхийн түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах, чөлөөлөх гэх мэт;
- ЖДҮ эрхлэгчдэд үзүүлэх яаралтай тусламж: ЖДҮ эрхлэгчид болон хувиараа бизнес эрхлэгчдэд бэлэн мөнгө өгөх, барьцааны зээл өгөхгүй байх, орон нутгийн өмчийн татварыг бууруулах, чөлөөлөх гэх мэт.

“V” хэлбэрийн буюу эдийн засгийг нөхөн сэргээх үе шатны гол арга хэмжээ

Эдийн засгийн хямралд өртсөн салбаруудын хэрэглээ, түүнчлэн дижиталчлал, технологийг ашиглах зэрэг ирээдүйд хийх хөрөнгө оруулалтыг идэвхжүүлж хүчирхэг сэргэлтэд хүрэх үе шат юм.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар дамжуулан эдийн засгийн үйл ажиллагааг сэргээхдээ:

- аялал жуулчлал, тээвэр, хүнс гэх мэт хямралд өртсөн салбаруудыг дэмжих: холбогдох талбайн хэрэглээний зардлыг үнийн хөнгөлөлт, ваучер, онооны шагнал гэх мэт хэлбэрээр урамшуулах;
- бүс нутгийн эдийн засгийг идэвхжүүлэх: Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуйг дэмжих, дотоодын аялал жуулчлалыг бодлогоор, үе шаттай идэвхжүүлэх;
- эдийн засгийн бүтцийг илүү уян хатан болгох;
- нийлүүлэлтийн уян хатан байдлыг нэмэгдүүлэх;
- хилийн чанад дахь худалдааг хөнгөвчлөх, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас загасан бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний экспорт, дотоодын үйлдвэрлэлийн чадавхыг бэхжүүлэх;
- алсын зайн технологийг ашиглан дижитал хувиргалтыг хурдасгах;
- төсвийн хөрөнгө оруулалт хийх гэх мэт хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2.6 БНКаЗУ**Эдийн засгийн нөхцөл байдал**

Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сангийн мэргэжилтэн нар БНКаЗУ-ын эдийн засаг, нийгмийн төлөв байдал, хөдөлмөрийн зах зээл дээрх ажлын байр, хүүхэд, гэр бүлийн асуудлаар санал солилцжээ. БНКаЗУ-ын өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зорилгод бүлгийнхэнд төрөөс дэмжлэг үзүүлэх, шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх, олон нийтийн саналыг авах, тэтгэмж, үйлчилгээ шаардлагатай байгааг тодорхойлжээ.

Тус улсын эдийн засаг 2021 оны гуравдугаар улирлаас аажим аажмаар сэргэж, тогтвортой өсөж эхэлсэн байна. ДНБ-ний хэмжээ 2021 оны мөн үеэс 3%-аар өссөн нь Засгийн газар

эдийн засгийг эрчимжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, түүхий эдийн үнийн өсөлт, дотоодын эрэлт сэргэсэнтэй холбоотой гэж үзсэн байна.

Эдийн засгийг сэргээх цогц төлөвлөгөөнд хөрөнгө оруулалт болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлд ажлын байрыг нэмэгдүүлэх, цахимжуулах, төсвийн орлого, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг 160 гаруй арга хэмжээнүүдийг багтаасан байна. Засгийн газар нь эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, үйлдвэрлэлийн үр дүнтэй бодлогын тогтолцоог бий болгох, дижиталчлал болон ногоон эдийн засагт шилжих үйл ажиллагааг дэмжиж байна.

Газрын тос, байгалийн хий, металлын үнийн огцом өсөлт нь БНКаЗУ-ын экспортод эерэг нөлөө үзүүлж, худалдааны тэнцэл сайжирч, урсгал зардал 2022 оны 1 дүгээр улиралд 6.6 тэрбум ам.долларын ашигтай гарчээ.

Хэрэглээний үнийн инфляц 08 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 16.1%-д хүрсэн. Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалж өмнөх жилийнхээс бараг хоёр дахин өссөн байна. Эрх баригчид мөнгөний бодлогоо чангатгаж, гол нэрийн бүтээгдэхүүнд үнийн дээд хязгаар тогтоож, шатахуун, хэрэглээний үнийн өсөлтийг хязгаарласан.

Энэ оны 01 дүгээр сараас хойш тенгений ам.доллартой харьцах ханш 10%-иар суларсан байна. Инфляц өндөр байгаа ч ажилгүйдлийн түвшин мөн оны 2 дугаар улиралд 4.9%-аас буураагүй, бодит цалин 8.9%-аар өссөн байна. Цар тахлын үед ажиглагдаж байсан ядуурлын түвшин 2022 онд 25.6% байсан бол цаашид 15.5% хүртэл буурах төлөвтэй болж байна.³⁸

Засгийн газраас иргэдийн бодит орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр авч буй зарим арга хэмжээ

БНКаЗУ-ын Засгийн газраас иргэдийн орлогыг хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр дараах хөтөлбөр, тогтоолыг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 ны 1060 дугаар тогтоолоор “Төрөөс хувираа бизнес эрхлэгчдийг дэмжих тухай” хөтөлбөр;
- Засгийн газрын 2021 оны 728 дугаар тогтоолоор “Үндэсний үйлдвэрлэлийг 2021-2025 онд хөгжүүлэх” төсөл;
- Засгийн газрын 2022 оны 43 дугаар тогтоолоор “Засгийн газрын 2018 оны 820 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” болон “Мөнгөн хөрөнгийг шийдвэрлэхийн тулд урт хугацааны зээл, мөнгөний хөрвөх чадварыг хангах тухай” тогтоолууд;
- БНКаЗУ-ын Засгийн газрын 2022 оны хөтөлбөр;
- “Үндэсний үйлдвэрлэлийг 2021-2025 он хүртэл хөгжүүлэх төсөл” хөтөлбөр;
- “Даму” бизнес хөгжлийн сангийн хөтөлбөр;
- “Бизнесийн замын зураг-2025” болон “Энгийн юмсын эдийн засаг”, “Енбек” хөтөлбөрүүдээр төрийн хөнгөлөлттэй зээл олгох;
- “Эдийн засгийг сэргээх цогц төлөвлөгөө”-д хөрөнгө оруулалт, ЖДҮ, хөдөлмөрийн зах зээлд ажлын байрыг нэмэгдүүлэх, цахимжуулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг 160 гаруй арга хэмжээ;
- “Нийгмийн зорилтот бүлгийн тусламж” хөтөлбөр нь бага орлоготой иргэдэд зориулсан байна.

³⁸ <https://www.worldbank.org/en/country/kazakhstan/overview#3>

БНКаЗУ нь “Ковид-19” цар тахлын үед иргэдийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд шинэ ажлын байрыг бий болгох, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд жижиг бизнесийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Татварын хөнгөлөлт

Аж ахуй эрхлэгчдийн тухай хууль (*Based on the Entrepreneurial Code*)-аар Засгийн газраас эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг тогтоожээ. Тэргүүлэх салбарын Засгийн газар болон компаниудын хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний дагуу татварын хөнгөлөлтийг үзүүлдэг. Шаардлага хангасан хөрөнгө оруулалтын төсөлд дараах татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ. Үүнд:

гаалийн татварыг чөлөөлөх;

- импортын НӨАТ-аас чөлөөлөх;
- төрийн буцалтгүй тусламжид татварын хөнгөлөлт үзүүлэх;
- хөрөнгө оруулалтын татааст хөнгөлөлт үзүүлэх;
- тусгай хөрөнгө оруулалтыг гаалийн татвараас чөлөөлөх;
- бусад бараанд татварын хөнгөлөлт үзүүлэх.

Татварын хуульд тодорхой ангиллын татвар төлөгчдийн төлөх хугацааг өөрчлөх, татвар төлөгчийн тодорхой шалгуур хангасан татварын төлөлтийг 100%-аар чөлөөлөх, татварыг хэсэгчлэн төлөх боломжийг олгох зэрэг нэмэлт, өөрчлөлтүүд тусгажээ. “Хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт”-ийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж байна.

БНКаЗУ-ын эдийн засгийн тусгай бүсийг 11 мужуудад байгуулж, татварын хөнгөлөлт эдлэхийн тулд тухайн нутаг дэвсгэрийн харьяат, татварын албанд бүртгүүлсэн, тэргүүлэх чиглэлд хамрагдсан зэрэг шаардлагуудыг хангасан байх ёстой байдаг байна. 2022 оны 08 дугаар сарын 01-ний байдлаар эдийн засгийн тусгай бүс дэх хуулийн этгээдэд үзүүлэх татварын хөнгөлөлтөд:³⁹

- ААНОАТ 100% чөлөөлөх (тодорхой нөхцөлөөр);
- НӨАТ чөлөөлөх 0% (ЗГ-аас тогтоосон жагсаалтаар);
- газрын татвар, газар ашигласны төлбөр 0%;
- үл хөдлөх хөрөнгийн татвар 0% гэсэн үзүүлэлттэй байна.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн олон хөтөлбөрүүд хэрэгжиж байдаг. Үүнд, нэг хүртэлх насны хүүхэд асарч буй эхчүүд, дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон түүнийг асран халамжлагч зэрэг зорилтот өрхийн иргэдэд зориулсан хөтөлбөр юм. Төрөөс олон хүүхэдтэй, амьжиргааны түвшингээс доогуур амьдралтай гэр бүлд зориулж эрх зүйн болон сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх төвүүдийг нээж өгсөн байна. Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд зориулж тус төвүүд массаж, үсчин, гар болон хөлний хумс арчилгаа, оёдлын чиглэлээр гэрчилгээ олгох сургалтыг үнэ төлбөргүйгээр явуулдаг байна.

“Нийгмийн зорилтот бүлгийн тусламж” хөтөлбөрийг 2001 онд батлагдсан Төрийн зорилтот нийгмийн тусламжийн тухай хууль (*On state targeted social assistance*)-аар зохицуулдаг. Уг хуульд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд хамгийн сүүлд 2020 онд томоохон өөрчлөлтийг оруулжээ.

Тус хуульд зааснаар иргэдийг 2 төрөлд хуваан авч үздэг байна. Эхний төрөлд хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадваргүй иргэд, 3 хүртэлх насны хүүхдээ асран хүмүүжүүлж

³⁹ <https://taxsummaries.pwc.com/kazakhstan/corporate/tax-credits-and-incentives>

байгаа эхчүүд зэрэг онц анхаарал халамж шаардагдсан, мөнгөн тусламж хэрэгцээтэй иргэдийг хамруулсан байна. Хоёрт: гэр бүлийн нэг гишүүнээс бусад нь хөдөлмөрийн чадвартай, Засгийн газраас “нийгмийн гэрээ”-г гурван сарын хугацаатай байгуулж, биелүүлэх чадвартай иргэдийг хамруулж, нийгмийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.

Мөнгөн тусламжаас гадна хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сургалтын үйл ажиллагаа явуулах, нийгмийн ажилд шилжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн нөхөн сэргээлт, хуулийн зөвлөгөө өгөх, орон сууцны тусламж үзүүлэх, амьжиргааны түвшинээс доогуур өрхүүдэд хүнсний тусламж, гэр ахуйн цэвэрлэгээний бодис, сурагчийн үнэ төлбөргүй хоол, хичээлийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэгслээр хангах, нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих зэрэг нийгмийн багц баталгаа хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна.⁴⁰

Санхүүгийн дэмжлэг болон хөнгөлөлттэй зээл

БНКаазУ-ын Үндэсний эдийн засгийн яам нь (*Ministry of National Economy*) “Даму”⁴¹ (*Damu*) бизнесийн хөгжлийн сангаар дамжуулан жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор “Бизнесийн замын зураг 2025” (*Business Road map 2025*)⁴², “Энгийн юмсын эдийн засаг” (*Economy of simple things*) “Енбек” (*Еңбек*) гэх мэт төрийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүдийг арилжааны банкууд ба банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтран БНКаазУ-ын Засгийн газраас баталсан тогтоол, журмын дагуу хэрэгжүүлдэг байна.

“Даму” сан нь БНКаазУ-ын жижиг дунд бизнесийг дэмжих чиглэлээр 20 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлдэг байна.

Санхүүгийн дэмжлэгийн төрлүүд:

- бус нутаг, салбар бүрийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд хоёрдугаар шатлалын банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох, бичил зээлийн байгууллагаар дамжуулан зээл олгох;
- татаас олгох - банкнаас олгосон зээлийн хүүг бууруулах;
- баталгаа – банкны зээлийн барьцаанд хэсэгчилсэн баталгаа гаргах.

БНКаазУ-ын Засгийн газрын 2019 оны 1060 дугаар тогтоолоор “Үндэсний үйлдвэрлэлийг 2021-2025 онд хөгжүүлэх төслийн хүрээнд жижиг аж ахуйн нэгж, тэр дундаа бичил бизнес эрхлэгчдийн зээл болон бичил зээлийн хүүгийн тодорхой хэсэгт багцын татаас, хэсэгчлэн баталгаа гаргах журмыг баталжээ.

Дээрх хөтөлбөрөөс “Бизнесийн замын зураг 2025”, “Енбек” хөтөлбөрүүд нь бичил бизнесийг дэмжих чиглэлээр бага хүүтэй, төрийн баталгаатай, барьцаагүй зээл, зарим тохиолдолд төрийн грант буюу төрөөс тэтгэлэг олгодог байна.

Жижиг бизнесийг дэмжих санхүүгийн гол хэрэгсэлд бизнес эрхлэгчдэд олгох зээлийн хүүгийн татаас, баталгаа гаргах, төрөөс буцалтгүй тусламж олгох хэрэгслүүд хамаарч байгаа ба зээлийн хүүгийн хэмжээ жилийн 6% байна.

- эргэлтийн хөрөнгөд 5 сая тенгений хэмжээтэй 2 хүртэл жилийн хугацаатай зээл;
- хөрөнгө оруулалтын зориулалтаар 20 сая хүртэл тенгений 5 хүртэл жилийн хугацаатай зээл.

⁴⁰ [https://www.hrw.org/news/2022/10/05/kazakhstan-families-struggle-enjoy-basic-rights#:~:text=\(Berlin%2C%20October%205%2C%202022,Human%20Rights%20Watch%20said%20today.](https://www.hrw.org/news/2022/10/05/kazakhstan-families-struggle-enjoy-basic-rights#:~:text=(Berlin%2C%20October%205%2C%202022,Human%20Rights%20Watch%20said%20today.)

⁴¹ “Даму” сан нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, БНКаазУ-ын бизнес эрхлэгчид, жижиг, дунд бизнесийг дэмжихэд чиглэсэн улсын санхүүгийн эх үүсвэрийг ашиглах үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор байгуулагдсан төрийн сан юм.

⁴² Государственная программа поддержки и развития бизнеса «Дорожная карта бизнеса 2025», https://egov.kz/cms/ru/articles/road_business_map?ysclid=l2yi6e7vg6

- 5 сая хүртэлх тенгений хэмжээтэй 6%-ийн хүүтэй ихэнх зээлийг барьцаагүйгээр олгодог.

Төрөөс зээлийн баталгааг хөдөө орон нутаг, жижиг хотод салбарын хязгаарлалтгүйгээр өөрийн гэсэн үр дүнтэй төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бизнес эрхлэгчид, гарааны бизнес эрхлэгчид, залуу бизнес эрхлэгчдэд гаргаж өгдөг байна.

Үндэсний үйлдвэрлэлийг 2021-2025 онд хөгжүүлэх төслийн хүрээнд 995.3 мянган ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэл баримталж байна. Бизнес эрхлэгчдийн түрээсийн хөрөнгийн үнийн дүнгийн 30-70% хүртэл баталгаа гаргадаг байна.

Иргэдийн орлого нэмэгдүүлэх тусгайлсан арга хэмжээ

БНКаЗУ-ын Засгийн газар нь хүнсний үнийн өсөлттэй холбогдуулан зарим гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн дээд хязгаарыг тогтоож, үр тарианы экспортын квотыг нэвтрүүлж, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн орлогыг хамгаалах чиглэлээр хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээнүүдийг хамруулдаг байна.⁴³ Түүнчлэн хүнсний дотоодын үйлдвэрлэлийг өргөжүүлэх, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг мөн авсан байна.

“Ковид-19” цар тахлын үед эдийн засгийн хүндрэлийг багасгахын тулд ипотекийн зээлийн хүүнд санхүүжилт олгох замаар бага орлоготой айл өрхүүдэд орон сууцны урьдчилгаа төлбөрийг бууруулж, анх удаа орон сууц худалдан авагчдын зээлийн шалгуурыг сулруулж, зээлийн хүүг бууруулдаг байна.

БНКаЗУ-ын Засгийн газрын хөтөлбөрт тэтгэврийн санд хуримтлалтай, чинээлэг өрхүүдийн хоёр дахь орон сууцны худалдан авалтыг хурдасгах, мөнгөтэй иргэдэд орон сууцны үнийг багаар нэмэгдүүлэх гэсэн чиглэлийг баримталдаг байна.

ГУРАВ.ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дэлхийн улс орнууд цар тахлын хүндрэлээс бүрэн гарч амжаагүй байтал дараагийн хүндрэлтэй нүүр тулж байна. Дайны нөлөө зөвхөн хөрш орнуудад бус, хүчирхэг эдийн засагтай Евро бүс, АНУ-ын эдийн засагт нөлөөлж, дэлхий нийтээр нийлүүлэлтийн гаралтай инфляцыг дахин өдөөж байна. #Олон улсын валютын сан болон Дэлхийн банк 2022 онд нийлүүлэлтийн гинжин хэлхээний доголдол, эрчим хүчний үнийн өсөлтийн улмаас дэлхий нийтээр инфляц үргэлжлэн өсөх хандлагатай байна. Тэд 2022 онд инфляц өндөр хөгжилтэй орнуудад дунджаар 3.9 хувь, хөгжиж буй орнуудад 5.9 хувь байна гэж төсөөлсөн. Гэвч Орос-Украины дайны нөлөөгөөр барууны орнуудад газрын тос, эрчим хүчний нийлүүлэлтийн тасалдлаас үүдэн инфляц хурдацтай өсч байна. Жишээ нь, Евро бүсийн инфляц 2022 оны 3 дугаар сард 7.5 хувьд хүрч, түүхэн дээд хэмжээнд хүрэв. Жилийн өмнө тус бүсийн инфляц ердөө 1-1.5 хувьд хэлбэлзэж байсан юм.⁴⁴

АНУ

ОХУ-ын зүгээс Украин руу довтлон эзлэн түрэмгийлэх ажиллагаа явуулсан нь АНУ-ын эдийн засаг, улс төрийн төлөв байдалд сөрөг нөлөө үзүүлж буй талаар *Economist Intelligence Unit (EIU)*⁴⁵ олон улсын эдийн засгийн сэтгүүлээс дараах дүгнэлтүүдийг гаргасан байна.

⁴³ <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/36772/Winter-2021-2022.txt?sequence=2&isAllowed=y>

⁴⁴ Монголбанк, Глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарч буй өөрчлөлтийн тойм.

⁴⁵ <https://www.eiu.com/n/about/>

- ОХУ болон Украины мөргөлдөөний улмаас дэлхийн түүхий эдийн үнийг өсгөж, инфляцыг нэмэгдүүлж, АНУ-ын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.
- Үүний үр дүнд энэ онд ДНБ-ний бодит өсөлтийн төсөөллөө 3.4%-аас 3% болгон бууруулсан байна.
- АНУ эрчим хүчний томоохон экспортлогч орон болох байр сууриа бэхжүүлж чулуужсан түлш, цементийн үйлдвэрлэл тэр дундаа байгалийн шингэрүүлсэн хийн (LNG) үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, Европ дахь эрэлтийг нөхөхөөр ажиллаж байна.
- Барууны хамтын ажиллагаа ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээ авч анхаарал хандуулж байгаа боловч дайн үргэлжлэх хугацаанд НАТО-ийн эвсэлд зөрчилдөөн үүснэ хэмээн АНУ таамаглаж байна.
- ОХУ-ын санхүүгийн түнш болох Хятадтай хийх хамтын ажиллагаа улам нягтрах нь Америк, Хятадын харилцааг улам сулруулна хэмээн үзэж байна.⁴⁶

Эдийн засгийн хямрал, мөнгөний ханш унах эрсдэл: АНУ-ын ОХУ, Украинтай хийдэг худалдааны цар хүрээ хамгийн бага хэмжээндээ хүрээд байгаа нь эдийн засагт том нөлөө үзүүлж эхэлж байна. Энэ нь цаашлаад инфляцыг өдөөж, хэрэглээний зарцуулалтын (consumer spending)⁴⁷ өсөлтийг удаашруулах хандлагатай байгаа аж. Орос Украины дайнаас өмнө түүхий эдийн үнэ дэлхийн хэмжээнд дөрвөн хүчин зүйлийн улмаас өсөж байсан. Үүнд:

- нийлүүлэлтийн сүлжээ тасалдсан;
- цаг агаарын таагүй үзэгдэл;
- “Ковид-19”-ийн шинэ давалгаа;
- эдийн засгийн эрэлт ихэссэн.

Дэлхийн зах зээл дээрх дайнаас үүдэлтэй түүхий эдийн үнийн өсөлт нь АНУ-ын эдийн засагт нөлөөлж, инфляц сүүлийн 40 жилийн хугацаанд хамгийн өндөр түвшинд (2-р сард жилийн 7.9% байсан) хүрээд байна. Иймд **Economist Intelligence Unit** сэтгүүл АНУ-ын хэрэглээний зарцуулалт болон ДНБ-ний бодит өсөлтөд дайны нөхцөл байдал сөргөөр нөлөөлөх ба үүний үр дүнд энэ онд АНУ-ын бодит ДНБ-ний өсөлтийн таамаглалыг 3.4%-аас 3% болж буурна хэмээн дүгнэж байна.

АНУ-ын Төв банкны бодлого: Инфляцыг бууруулахын тулд АНУ-ын төв банкны Холбооны нөөцийн сан 3 дугаар сарын 16-ны өдөр үндсэн сангийн хүүгээ 25 суурь нэгжээр өсгөсөн нь 2018 оноос хойших анхны өсөлт болсон байна. Холбооны сан энэ онд нэмэлт хүү нэмэх төлөвлөгөөгөө зарласан бөгөөд хэрэв Украины дайны улмаас түүхий эдийн үнэ таамаглаж байснаас хурдан өсвөл энэ хэмжээг дахин хянаж магадгүй хэмээн мэдэгдсэн байна. Холбооны нөөцийн сангийн бодлого АНУ-ын эдийн засагт сайнаар нөлөөлнө хэмээн хүлээж байгаа ч дайны үр дагавар болон бусад гадаад хүчин зүйлс, тухайлбал, “Ковид-19”-ийн шинэ хувилбар гарч ирсэн зэрэг нь АНУ-д инфляц, мөнгөний ханш унах эрсдэлд хүргэх аюултай байна.

АНУ-ын эрчим хүчний салбар: Европын орнууд Оросын эрчим хүчний импортыг хязгаарлахын тулд өөр газрын тос, байгалийн хий нийлүүлэгч орныг хайж байгаа ба эрчим хүчний хомстлыг нөхөхийн тулд АНУ-д хандаж байна. ОХУ-ын эрчим хүчний импортоос татгалзсаны улмаас үүссэн хэрэгцээг АНУ дангаараа нөхөж чадахгүй ч дотоодын үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, одоогийнхоос ч илүү дэлхийн эрчим хүчний экспортлогч орон

⁴⁶ <https://www.eiu.com/n/what-does-the-ukraine-crisis-mean-for-the-us/>

⁴⁷ Consumer spending is the total money spent on final goods and services by individuals and households for personal use and enjoyment in an economy.

болох боломжтой болно.⁴⁸ Дотоодын болон олон улсын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангахын тулд АНУ, ялангуяа байгалийн шингэрүүлсэн хийн (LNG) салбарт үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх өмнөх төлөвлөгөөгөө түргэтгэх шаардлагатай тулгарч байна. Эдийн засагчдын тооцоолсноор 2022 оны эцэс гэхэд АНУ дэлхийн хамгийн том шингэрүүлсэн хийн экспортын хүчин чадалтай болж, 2023 онд экспортын хэмжээгээр Катар, Австралийг гүйцэж, эрчим хүчний томоохон экспортлогч болно гэж үзэж байна.

ОХУ

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Донбассын бүс нутагт цэргийн тусгай ажиллагааг эхлүүлсэн. Улс орнууд үүнийг эсэргүүцэн, тал бүрээр шахалт үзүүлж, тус улсад 2014 оноос хойш тавьж байсан хориг арга хэмжээг нэмэгдүүлж, мөн шинэ хоригуудыг тавьж байна. 2022 оны 08 дугаар сарын байдлаар дэлхийн 30 гаруй улс ОХУ-ын эсрэг 11 мянга гаруй хориг арга хэмжээ аваад байна. Үүнд:

- ОХУ-аас импортлох эрчим хүчний хэмжээг бууруулах;
- ОХУ-ын Төв банкны болон ихэнх санхүүгийн байгууллагуудын гадаад валютын нөөцийг царцаан, олон улсын санхүүгийн харилцааны SWIFT системээс хасан хязгаарлах;
- өндөр технологийн нийлүүлэлтийг хориглох зэрэг багтаж байна.

ОХУ-ын байгалийн хий, газрын тосны импортод тавьж буй хориг

ЕХ, АНУ тэргүүтэй улс орнууд ОХУ-ын эсрэг дараах хориг арга хэмжээ авахаар шийдвэрлээд байна. Үүнд:

Европын холбоо:

- 2022 оны 12 дугаар сараас эхлэн далайгаар тээвэрлэсэн ОХУ-ын газрын тосны импортыг хориглох;
- 2023 оны 02 дугаар сараас эхлэн ОХУ-д боловсруулсан газрын тосны бүх бүтээгдэхүүний импортыг хориглох.

АНУ: ОХУ-ын газрын тос, байгалийн хийн импортыг хориглох.

ИБУИНХУ: 2022 оны сүүл гэхэд ОХУ-ын газрын тосны импортыг үе шаттайгаар зогсоох, ОХУ-ын байгалийн хийн импортыг зогсоосон.

ХБНГУ: “Хойд урсгал 2” байгалийн хийн хоолойн төслийг түр хугацаагаар зогсоосон.

Европын холбоо: ОХУ-ын нүүрсний импортыг тус тус зогсоогоод байна.

Европын холбооны хувьд ОХУ-ын байгалийн хийн импортод хориг тавиагүй бөгөөд энэ нь Европын холбооны байгалийн хийн нийт хэрэглээний 40 гаруй хувийг ОХУ-аас хангадагтай холбоотой байна.

Хувь хүмүүсийн эсрэг чиглэсэн хориг

АНУ, Европын холбоо, ИБУИНХУ зэрэг улсууд ОХУ-ын төрийн өндөр албан тушаалтан, цэргийн албан хаагч болон бизнес эрхлэгчдийн эсрэг хориг арга хэмжээ авсаар байна. Үүнд, хориг арга хэмжээнд орсон хүмүүсийн хориг тогтоосон улс дахь активыг царцаах, хориг тавьсан улсад нэвтрэхийг хориглосон зэрэг орж байна.

Бусад хориг арга хэмжээ

Холбогдох улс орнууд дараах бараа, үйлчилгээнд хориг тавьсан байна. Үүнд:

⁴⁸ АНУ дэлхийн дөрөв дэх том түүхий нефть экспортлогч, хоёр дахь том байгалийн хий экспортлогч орон болоод байна.

АНУ, ЕХ, ИБУИНХУ: Тээврийн хэрэгслийн эд анги гэх мэт энгийн болон цэргийн зориулалтаар ашиглаж болох хосолмол хэрэглээ бүхий барааны экспортыг хориглосон;

АНУ, ЕХ, ИБУИНХУ, Канад Улс: агаарын орон зайдаа ОХУ-ын агаарын тээврийн компаниудыг нислэг үйлдэхийг хориглосон.

АНУ, ИБУИНХУ, Канад Улс, Япон Улс: ОХУ-аас алт импортлохыг хориглосон.

АНУ: ОХУ-д тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүн экспортлохыг хориглосон байна.

ИРЛАНД УЛС

Ирланд Улс нь Европын холбоо болон НҮБ-ын түвшинд Орос-Украины мөргөлдөөнийг зогсоохыг уриалсан улсын нэг төдийгүй Украиныг Европын холбооны гишүүнээр элсүүлэхийг дэмжсэн Европын холбооны гишүүн орнуудын тэргүүн эгнээнд байсан. Ирланд Улсын хувьд Украины бүрэн эрхт, энх тайван байдлыг дэмжиж олон улсын форумд өөрийн байр суурь, дуу хоолойгоо хүргэсээр байна.

ОХУ, Украин руу халдан довтолсны улмаас Украины 15.7 сая хүн буюу нийт хүн амын бараг тал хувь нь хүмүүнлэгийн тусламж авах шаардлагатай байна гэж НҮБ-аас мэдээлсэн байдаг. Ирланд Улс Украины хямралд хамгийн түрүүнд хариу арга хэмжээ авсан улсуудын нэг байсан бөгөөд Европын Зөвлөлийн Хөгжлийн банканд тусгайлан байгуулагдсан “Украинд хандивлагчийн санд” нэг сая еврогийн хандив өгсөн байна.⁴⁹

Ирланд Улсын төрийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншүүдтэй хамтран ажиллаж, Украинд 4.3 сая гаруй еврогийн үнэ бүхий түргэн тусламжийн машин болон биет бус эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн бөгөөд цаашид дуулга, эмнэлгийн хэрэгсэл, цус, түлш зэрэг тусламж үзүүлэхээ тус улсын Ерөнхий сайд илэрхийлсэн.

Европын холбоо Украинын иргэд болон Украинаас дүрвэгсдэд Европын холбооны нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхийг зөвшөөрөх түр хамгаалалтын удирдамж гаргасан. Үүний дагуу Ирланд Улсын Засгийн газраас нийгмийн хамгааллын дэмжлэг үзүүлж байна.⁵⁰ Дүрвэгсэд нь Дублин хотын Citywest Convention Center-т хандан холбогдох бичиг баримтыг бүртгүүлж, хүсэлт гаргаснаар дараах төрийн үйлчилгээг авах боломжтой байна.⁵¹

Үүнд:

- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- хүүхдийн тэтгэмж (16-аас доош насны хүүхэд бүрт сард 140 еврогийн тэтгэмжийг эцэг эх, асран хамгаалагчдад олгох);
- түр оршин суух байраар хангах.

Орос-Украины мөргөлдөөний улмаас Ирланд Улсын эдийн засгийн өсөлтөд нөлөөлж, инфляцын түвшин нэмэгдэж, иргэдийн худалдан авах чадвар буурч тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Газрын тос, байгалийн хийн үнэ өсөж зөвхөн Ирланд Улсад төдийгүй олон улсад бензин, дизель түлш, байгалийн хий, цахилгааны жижиглэнгийн үнэ өссөн байна.

⁴⁹ <https://www.gov.ie/en/campaigns/bc537-irelands-response-to-the-situation-in-ukraine/>

⁵⁰ <https://www.gov.ie/en/collection/acd7c-information-for-people-arriving-from-ukraine/>

⁵¹ <https://www.gov.ie/en/publication/abf3e-social-welfare-supports-for-ukrainian-citizens-arriving-in-ireland-under-the-temporary-protection-directive/>

Байгаль орчин, цаг уур, харилцаа холбооны газраас ОХУ-Украины мөргөлдөөний нөхцөлд Ирланд Улсын эрчим хүчний аюулгүй байдлын хэрэгцээг хангах зорилгоор Эрчим хүчний аюулгүй байдлын хамгаалах групп (*Energy Security Emergency Group*)-ыг байгуулсан. Тус газар нь эрчим хүчний аюулгүй байдалд дайны нөлөөлөлтэйгөөр үүсэх эрсдэл, үндэсний хэмжээний үйл ажиллагаа, хариу арга хэмжээг зохицуулж, хянан ажиллах юм. Үүнд:

- эрчим хүчний салбарт үзүүлэх нөлөөллийн эсрэг хариу арга хэмжээг тодорхойлж эрчим хүчний аюулгүй байдалд хяналт тавих;
- хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийг дэмжих хариу арга хэмжээг авах, зохицуулах (санхүүгийн хувьд эмзэг, эрчим хүчний асуудалд өртөх эрсдэлтэй өрхүүд);
- яаралтай тусламжийн төлөвлөгөөг шинэчлэн батлан ажиллах.

ХБНГУ

ОХУ-Украины дайн, мөн ОХУ байгалийн хийн нийлүүлэлтээ багасгасны улмаас эрчим хүчний үнэ огцом өсөөд байна. Энэ байдал хяналтаас гарч болзошгүй хэмээн Холбооны засгийн газар түгшиж байна.

ХБНГУ-ын Эрчим хүчний хангамжийн аюулгүй байдлыг хангах тухай хуульд⁵² 2022.07.08-ны өдөр өөрчлөлт оруулж, хийн хэрэглээг багасгах талаар доорх арга хэмжээнүүд авахаар тусгасан байна. Эдгээр өөрчлөлтүүдийг 6 сар, зарим заалтыг нь 2 жил мөрдөхөөр заасан байна. Үүнд:

- хэрэв техникийн аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөхгүй бол тогтмол ордоггүй өрөөг халаахгүй байх. Яамны зүгээс жишээ болгож, хонгил, том заал, техникийн өрөөг нэрлэж байна. Нийтийн үйлчилгээний газар болон конторын барилга байгууламжуудын дотоод журамд үүнийг тусгах;
- ажлын болон үйлдвэрийн байранд аль болох хэмнэлтийн боломжийг эрж хайх. Гэрээс ажиллах явдлыг хөхиүлэн дэмжих;
- түрээслэгч нь халаалтыг багасгахыг хориглодог байсан заалтыг түр хугацаагаар хүчингүй болгох;
- байшингийн эзэн хувийн усан сангаа хийгээр халаахыг үүнээс хойш бүрэн хориглох;
- хийн халаагуурын эзэд халаалтын төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлын шалгалт хийх. Гидравликийн тэнцлийг шалгаж халуун ус оптимал түгээгдэж буй эсэхийг тогтоох, төвлөрсөн халаалтын системд холбогдсон байшингийн дулаан солилцооны үр ашиггүй, автоматжаагүй халаалтын татуургыг илрүүлэх, солих;

2022.10.01-нээс эхлэн нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцуудыг сэргээн идэвхжүүлж, хийн станцуудыг орлуулна. Үүнтэй холбоотой Холбооны зам тээврийн яам нүүрсийг төмөр замаар тэргүүн ээлжид тээвэрлэх талаар холбогдох журамд өөрчлөлт оруулсан байна.

ОХУ-ын Газпромын ХБНГУ дахь хамгийн том түнш болох Дюссельдорфд байрлах Uniper хэрэглэгчдийн хийн үнийг өсгөхгүйн тулд Холбооны улс түүний 30%-ийн хувьцааг авсан

⁵²Эрчим хүчний хангамжийн аюулгүй байдлыг хангах тухай хууль-Gesetz zur Sicherung der Energieversorgung (Energiesicherungsgesetz - EnSiG)-*германаар*
https://www.gesetze-im-internet.de/ensig_1975/BJNR036810974.html

Хуульд орсон өөрчлөлтийн цөм асуудал нь хэрэв онцгой байдал болвол өндөр үнээр худалдан авсан зардлыг эргүүлэн тооцох аргаар хэрэглэгч ямар нийлэгчтэй гэрээ хийснээс үл хамааран бүх хий хэрэглэгчид хуваарилах зарчим юм.

Түүнээс гадна Засгийн газар үүнээс хойш Эрчим хүчний арга хэмжээнүүдийг зохицуулах журмын дагуу зохицуулалтыг хариуцах болсон байна. Ингэснээр хэрэглэгчдийг нийлүүлэлтийн тасалдал, хорогдлоос сэргийлэх ач холбогдолтой юм. Ханган нийлүүлэгч нь зөвхөн Холбооны сүлжээний агентлагийн зөвшөөрсний дагуу үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй болсон байна.⁵³

МегаВатт цаг тутам байгалийн хийн үнэ өмнө нь ОХУ-аас авдаг байхад 20-30 евро байсан бол Голландын ТТФ бирж дээр 2022 оны 07 дугаар сард 129 евро хүрч, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 83.40 евро болж буусан ч өнөөдрийн байдлаар дахин өссөн байна.

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалагчид Эрчим хүчний хангамжийн аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулахыг шаардаж байна. Эрчим хүчний үнийн өсөлтийг хуульд 7 хоногийн өмнө зарлана гэснийг 4 долоо хоногийн өмнө гэж өөрчлөх нь зүйтэй. Ингэснээр хэрэглэгчид онцгой нөхцөлт гэрээ цуцлах талаар шийдвэр гаргахад нь хангалттай хугацаа олгох нь зүйтэй. Хуульд мэдэгдэл хүлээн авсан даруйд гэрээг “хойшлуулалгүй” цуцална гэж тусгасан байдаг байна. Мөн төлбөрийн үлдэгдэлгүй байх ёстой гэж заасан байдаг. Хууль энэ хэвээрээ байвал ялангуяа ирэх халаалтын улиралд айл өрхүүдэд холбогдох хөнгөлөлт, чөлөөлөлтийн багц шаардлагатай болох нь ойлгомжтой байна. Түүнээс гадна хийн төлбөрөө барагдуулах чадамжгүй хэрэглэгчийн хийг хаахгүй байх болон орлого багатай өрхөд чиглэсэн нэмэлт хөнгөлөлт, чөлөөлөлтийн багц шайрдлагатай байна.⁵⁴

Холбооны Засгийн газар хийн эргүүлэн тооцох дээд үнийг 2 419цент/кВц гэж тогтоолоо. Есдүгээр сарын байдлаар, нэг загвар өрх (20 000кВц) жилд дунджаар 4371 евро хийн төлбөрт төлсөн тооцоо гарсан нь өмнөх онтой харьцуулахад даруй 3.2 дахин өссөн явдал юм. Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ыг бууруулснаар нэг өрх жилд 306 евро хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх тооцоо гарсан байна. Хийн үнийг барьсанаар нэмэлт хөнгөлөлт, чөлөөлөлт авчрах нь дамжиггүй юм.⁵⁵

ЯПОН УЛС

Япон Улс нь Их долоогийн гишүүн орнуудаас НАТО-д элсээгүй цорын ганц улс хэдий ч батлан хамгаалах салбарт анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Япон Улсын Либерал ардчилсан нам 2022 оны 04 дүгээр сард Засгийн газартаа улсын аюулгүй байдлыг хангах бодлого, түүний эсрэг авах арга хэмжээг нэмэгдүүлэх тухай санал хүргүүлсэн. Уг саналдаа Япон Улсын батлан хамгаалахын төсвийг ДНБ-ний 2 хувьтай тэнцэхүйц хэмжээний зардлыг батлуулах, ирэх 5 жилийн хугацаанд батлан хамгаалахын салбарын төсвийг нэмэгдүүлэхийг тусгасан байна. Харин сөрөг хүчний зүгээс Япон Улсын өрийн хэмжээ өндөр дүнтэй байгаа учир батлан хамгаалах салбарт ийм их хэмжээний төсвийг зарцуулах шаардлагагүй гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байна.

⁵³ Өвөлжилтийн талаар авах шинэ арга хэмжээний багцыг танилцуулав-Neues Maßnahmenpaket für den Winter vorgestellt-*германаар* <https://www.deutschlandfunk.de/energiesicherungsgesetz-gas-100.html>

⁵⁴ Герман дахь хийн хямрал: Шинэ хууль хэрэглэгчдийн уурыг хүргэхээр байна-Gaskrise in Deutschland: Neues Gesetz könnte Verbrauchern nun böse Überraschung bescheren-*германаар* <https://www.merkur.de/wirtschaft/habeck-preis-erhoehung-aktuell-gas-versorger-krise-verbraucher-notfall-plan-deutschland-zr-91625338.html>

⁵⁵ Германы хийн хямрал-Gaskrise in Deutschland-*германаар* <https://www.check24.de/gas/gaskrise/>

ОХУ, Украины хооронд үүссэн нөхцөл байдлаас үүдэн Япон Улсын үндэстэн дамнанас корпорацууд эдийн засгийн хувьд ихээхэн хохирол амссан бөгөөд маш олон корпорацууд үйлдвэрлэлийн процессоо өөрчлөх шаардлага тулгарсан. Тухайлбал, Тоёота компани бараа материалгүй байснаас бараагаа нөөцлөх үйл ажиллагааны горимд шилжих шаардлага үүссэн гэж мэдэгдсэн байна.

Хоёр орны хурцадмал байдлаас шалтгаалж Япон Улсын иений ханш огцом унах, ажиллах хүчин, хөдөлмөрийн үнэлэмж буурах зэрэг асуудлууд нь тус улсын эдийн засаг, аюулгүй байдалд онцгой асуудал үүсгэж байна.

БНКаЗУ

2022 оны эхний хагас жилийн байдлаар ОХУ-Украины дайн, олон улсын хориг арга хэмжээ, “Ковид-19” цар тахлаас шалтгаалсан үнийн огцом өсөлт зэрэг нь БНКаЗУ-ын нийгэм, эдийн засгийн төлөв байдалд нөлөөлж байна.

ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээний сөрөг нөлөөнд: инфляц өндөр, мөнгөний хатуу бодлого, газрын тосны үнэ өссөн, эдийн засаг суларсан, нийгмийн эмх замбараагүй байдал үүссэн зэрэг эрсдэлүүд гарсан байна.

ОХУ-ын эдийн засгийн уналтаас гарсан үр дагавар нь БНКаЗУ-д нийлүүлдэг сүлжээг тасалдуулж, эдийн засгийн өсөлтийг бууруулсан гэж үздэг. 2022 онд ДНБ-ний бодит өсөлт 1.5-2.0% болж буурах төлөвтэй байна.

БНКаЗУ нь импортынхоо 40%-ийг ОХУ-аас авдаг. Худалдааны эргэлтийн тасалдал, валютын ханш өсөлт зэрэг нь эдийн засгийн өсөлтийг бууруулсан гэж үздэг байна. Энэ оны 3 дугаар сард болсон шуурганы улмаас БНКаЗУ-ын газрын тосны гол хоолойд гэмтэл гарчээ. ОХУ-ын Хар тэнгисээр дамжуулан БНКаЗУ-ын газрын тосны 80%-ийг экспортолдог байна. Одоогийн байдлаар, гэмтэл гарсан газрын тосны хоолойн засварыг нэг сарын хугацаанд засварлана гэж тооцооноор газрын тосны экспортын хэмжээ 2022 онд 5-6%-аар буурах магадлалтай болоод байна.

Фокус Экономикс (*Focus Economics*)-ийн шинжээчид 2022 онд БНКаЗУ-ын ДНБ-ний 2.7%-аар, 2023 онд 3.8%-аар тус тус өснө гэж таамаглаж байна. Инфляцын түвшин 2022 оны байдлаар 12.6%-аар, 2023 онд инфляц дунджаар 9.5%-аар өснө гэж таамаглаж байна.⁵⁶

Урьдчилсан байдлаар, БНКаЗУ-ын ДНБ-ний өсөлт нэгдүгээр улиралд 4.6% хүрсэн бол хоёрдугаар улирлын байдлаар 3.4% болж буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь БНКаЗУ-ын эдийн засаг хоёрдугаар улиралд нэгдүгээр улиралтай харьцуулахад удааширсан нь Орос-Украины дайны үр дагавар нөлөөлсөн гэж үзэж байна.⁵⁷

БНКаЗУ-ын гол экспортын бүтээгдэхүүн болох газрын тос, байгалийн хийн үнэ нэмэгдсэн нь бизнесийн орчин доройтож, хөрөнгө оруулалтыг бууруулж, инфляц болон зээлийн хүүгийн хэмжээ өссөн зэрэг дотоодын эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлсөн байна.

Цаашид, валютын ханшийн уналт, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт зэрэг асуудлууд нь 2022 онд инфляцыг өндөр түвшинд байлгахад байна. Түүнчлэн мөнгөний бодлого хатуу хэвээр байх төлөвтэй байна. БНКаЗУ-ын төсөвт өрхийн аж амьдралыг сайжруулах, бизнесийн орчинг тогтвортой байлгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж байна.

⁵⁶ <https://www.focus-economics.com/countries/kazakhstan>

⁵⁷ <https://www.focus-economics.com/countries/kazakhstan>

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- A Statistical Analysis of Impact of COVID19 on the Global Economy and Stock Index Returns, 2021 <<https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC7796698/>> хандсан 2021.09.08
 - Baldwin R., Weder di Mauro B. Economics in the time of COVID-19 // VoxEU.org eBook, CEPR Press, 2020. <<https://voxeu.org/article/economics-time-covid-19-new-ebook.>>
 - BIS Working Papers No 959, Macroeconomic effects of Covid-19: a mid-term review, August 2021, <<https://www.bis.org/publ/work959.pdf>> хандсан 2021.09.08
 - Center for disease control and prevention, <<https://www.cdc.gov>> хандсан 2021.09.08
 - Davide Furceri, Prakash Loungani, Jonathan D. Ostry, How Pandemics Leave the Poor Even Farther Behind, MAY 11, 2020 <<https://blogs.imf.org/2020/05/11/how-pandemics-leave-the-poor-even-farther-behind/>> хандсан 2021.09.07
 - Global Economic Effects of COVID-19, Congressional research service, Updated July 9, 2021 <<https://sgp.fas.org/crs/row/R46270.pdf>> хандсан 2021.09.08
 - Government support and the COVID-19 pandemic, Version 14 April 2020, <<https://www.oecd.org/coronavirus/policy-responses/government-support-and-the-covid-19-pandemic-cb8ca170/>> хандсан 2021.09.07
 - OECD (2021), OECD Employment Outlook 2021. <<https://www.oecd.org/employment-outlook/>> хандсан 2021.09.08ww
 - Supporting people and companies to deal with the COVID-19 virus. OECD, 2020. <[http://www.oecd.org/coronavirus/policy-responses/supporting-people-and-companies-to-deal-with-the-covid-19-virus-options-for-an-immediate-employment-and-social-policy-response-d33dffe6/.](http://www.oecd.org/coronavirus/policy-responses/supporting-people-and-companies-to-deal-with-the-covid-19-virus-options-for-an-immediate-employment-and-social-policy-response-d33dffe6/)> хандсан 2021.09.08
 - Европын Комиссын цахим хуудас, <https://ec.europa.eu/info/business-economy-euro/recovery-coronavirus/recovery-and-resilience-facility_en> хандсан 2021.09.08
 - “Ковид-19”-ийн халдварт /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр эрх бүхий байгууллагуудаас гаргасан шийдвэрийн талаарх мэдээлэл лавлагаа, УИХ-ын ТГ-ын Парламентын судалгааны хүрээлэн, 2020
 - Mongolia-Economic-Update-From-Relief-to-Recovery (1).pdf
 - Монгол Улсын эдийн засгийн тойм “Тусламж дэмжлэгээс сэргэлт өөд”, дэлхийн банкны тайлан, 2021 оны 2-р сар <https://www.legalinfo.mn/annex/details/11611?Lawid=16094>
 - Монгол Улсын эдийн засгийн тойм, 2021, 2-р сар.
 - Сангийн яам (mof.gov.mn)
- АНУ
- AmericanRescuePlan<https://www.whitehouse.gov/briefing-room/legislation/2021/01/20/president-biden-announces-american-rescue-plan/>
 - American Jobs Plan summary <https://www.naco.org/resources/featured/naco-executive-summary-american-jobs-plan>
 - American Family Plan American-Families-Plan-Fact-Sheet-FINAL.pdf (whitehouse.gov)
 - Clean energy plan FACT SHEET: President Biden Sets 2030 Greenhouse Gas Pollution Reduction Target Aimed at Creating Good-Paying Union Jobs and Securing U.S. Leadership on Clean Energy Technologies | The White House
 - US Covid-19 Stimulus and Relief <https://www.investopedia.com/government-stimulus-efforts-to-fight-the-covid-19-crisis-4799723>
 - Economic Indicator <https://tradingeconomics.com/united-states/indicators>

- Covid-19 Economic Relief Bill <https://www.ncsl.org/ncsl-in-dc/publications-and-resources/covid-19-economic-relief-bill-stimulus.aspx>
- The Coronavirus Aid, Relief, and Economic Security Act (CARES) <https://www.ncsl.org/ncsl-in-dc/publications-and-resources/coronavirus-stimulus-bill-states.aspx>
- Families First Coronavirus Response Act https://www.ncsl.org/documents/statefed/Corona_Virus_FYI_032020.pdf

ХБНГУ

- <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19#G>
- <https://www.worldometers.info/world-population/germany-population/>
- <https://www.worldometers.info/coronavirus/country/germany/>
- <https://tradingeconomics.com/>
- <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2020-11-24/germany-amendments-to-infectious-diseases-protection-act-enter-into-force/>
- <https://www.jonesday.com/en/insights/2020/04/act-to-mitigate-the-consequences-of-the-covid-19-pandemic-under-germanys-civil-insolvency-and-criminal-procedure-law-of-2>
- <https://perma.cc/L4S4-N7MB>
- <https://www.ibanet.org/article/6AC928DD-58FB-4A55-822B-F0FE5F277F2F>
- <https://www.ibanet.org/article/6AC928DD-58FB-4A55-822B-F0FE5F277F2F>
- <https://www.jonesday.com/en/insights/2020/04/act-to-mitigate-the-consequences-of-the-covid-19-pandemic-under-germanys-civil-insolvency-and-criminal-procedure-law-of-2>
- https://ec.europa.eu/info/system/files/germany-recovery-resilience-factsheet_en.pdf
- <https://www.imf.org/en/News/Articles/2021/07/13/na071521-beyond-the-pandemic-five-charts-on-germanys-economic-recovery-plan>

ОХУ

- Правительство Российской Федерации. (n.d.-a). Меры Правительства по повышению устойчивости экономики и поддержке граждан в условиях санкций. Government.ru. Retrieved October 19, 2022, from http://government.ru/sanctions_measures/
- Правительство Российской Федерации. (n.d.-b). Меры Правительства РФ по борьбе с коронавирусной инфекцией и поддержке экономики. Government.ru. Retrieved October 19, 2022, from http://government.ru/support_measures/
- Мартин, Н., & Неверова, А. (2022, September 7). Как влияют на российскую экономику санкции Запада? – DW – 07.09.2022. Dw.com. <https://www.dw.com/ru/naskolko-silno-rossijskaa-ekonomika-stradaet-izza-sankcij-zapada/a-63034838>
- BBC News. (2022, February 25). Ukraine: What sanctions are being imposed on Russia? BBC News. <https://www.bbc.com/news/world-europe-60125659>
- Tbilisi, U. S. E. (2022, August 16). International sanctions are working: Russia feels economic pressure. U.S. Embassy in Georgia. <https://ge.usembassy.gov/international-sanctions-are-working-russia-feels-economic-pressure/>

Ирланд Улс

- The Health (Preservation and Protection and other Emergency Measures in the Public Interest) Act 2020 <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/1/enacted/en/html>
- The Emergency Measures in the Public Interest (Covid-19) Act 2020 <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/2/enacted/en/html>
- The Microenterprise Loan Fund (Amendment) Act 2020 <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/3/enacted/en/html>

- The Financial Provisions (Covid-19) Act 2020
<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/4/enacted/en/html>
- The Credit Guarantee (Amendment) Act 2020
<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/5/enacted/en/html>
- The Residential Tenancies and Valuation Act 2020
<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/7/enacted/en/html>
- The Companies (Miscellaneous Provisions) (Covid-19) Act 2020
<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/9/enacted/en/html>
- The Social Welfare (Covid-19) (Amendment) Act 2020
<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/12/enacted/en/html>
- National Development Plan
<https://www.gov.ie/en/policy-information/07e507-national-development-plan-2018-2027/>
- Economic Recovery Plan file:///Users/uurtsaikh/Downloads/136523_03f31f12-10eb-4912-86b2-5b9af6aed667.pdf
- Ensuring Sustainable Public Finance <https://www.gov.ie/en/publication/d4dcc-sustainable-public-finances/>
- Pathways to Work 2021-2025 <https://www.gov.ie/en/publication/90e59-pillar-2-helping-people-back-into-work/>
- Rebuilding Sustainable Enterprises <https://www.gov.ie/ga/foilsuichan/d28d9-pillar-3-rebuilding-sustainable-enterprises/>

БНКаЗУ

- <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/36772/Winter-2021-2022.txt?sequence=2&isAllowed=y>
- <https://www.focus-economics.com/countries/kazakhstan>
- <https://www.worldbank.org/en/news/press-release/2022/09/29/listening-to-kazakhstan-survey-spotlights-challenges-along-with-optimism-on-economic-prospects>
- <https://www.worldbank.org/en/news/press-release/2022/09/29/listening-to-kazakhstan-survey-spotlights-challenges-along-with-optimism-on-economic-prospects>
- Государственная программа поддержки и развития бизнеса «Дорожная карта бизнеса 2025». https://egov.kz/cms/ru/articles/road_business_map?ysclid=l2yi6e7vg6

Япон Улс

- <https://santandertrade.com/en/portal/analyse-markets/japan/economic-political-outline>
- <https://santandertrade.com/en/portal/analyse-markets/japan/economic-political-outline>
- <https://www.hennessyfund.com/insights/japan-japan-small-portpers-june-2020https://corona.go.jp/en/action/>
- <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/japan-government-and-institution-measures-in-response-to-covid.html>
- https://www5.cao.go.jp/keizai1/keizaitaisaku/2020/20200420_economic_measures.pdf

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮЛЭГ II

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ТӨРИЙН СҮЛДНИЙ БЭЛГЭДЭЛ БА ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ:
МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ,
О.Нарантуяа, Б.Туул, Б.Мөнгөнсүвд*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

- 1.Соёмбо тэмдгийн үүсэл, утга санаа
- 2.Монголын төрийн бэлгэ тэмдгийн түүхэн уламжлал
- 3.1992 оны Үндсэн хуулийг хэлэлцэх үед төрийн сүлдний талаар иргэд, АИХ-ын депутатуудаас гарч байсан саналын тойм
- 4.Гадаадын зарим улсын төрийн сүлдний бэлгэдэл
- 5.Гадаадын зарим улс орнуудын төрийн сүлдээ сольсон давтамж, шалтгаан
- 6.Хуучин ЗХУ, түүний бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсуудын төрийн сүлдний нийтлэг ба ялгаатай талууд, сольсон давтамж, шалтгаан

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. СОЁМБО ТЭМДЭГ БА МОНГОЛЫН ТӨРТ УЛСУУДЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТАЛААРХ ТОЙМ

- 1.1.Соёмбо тэмдгийн үүсэл, утга санаа
- 1.2.Монголын төрийн бэлгэ тэмдгийн түүхэн уламжлал
 - 1.2.1.Хүннү гүрний төрийн бэлгэ тэмдэг
 - 1.2.2.Их Монгол улсын төрийн бэлгэ тэмдэг
 - 1.2.3.Юань гүрний төрийн бэлгэ тэмдэг
 - 1.2.4.Эл хаант улсын төрийн бэлгэ тэмдэг
 - 1.2.5.Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын төрийн сүлд
 - 1.2.6.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн сүлднүүд
 - 1.2.7.Монгол Улсын Төрийн сүлд
- 1.3.1992 оны Үндсэн хуулийг хэлэлцэх үед төрийн сүлдний талаар иргэд, АИХ-ын депутатуудаас гарч байсан саналын тойм.

- 1.3.1.Иргэдээс ирүүлсэн саналын талаар
- 1.3.2.АИХ-ын депутатуудаас гарсан саналын талаар

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТӨРИЙН СҮЛДНҮҮД

- 2.1.Азийн орнууд
 - 2.1.1.Вьетнам Улс
 - 2.1.2.Өмнөд Солонгос Улс
 - 2.1.3.Хятад Улс
 - 2.1.4.Шри Ланка Улс
 - 2.1.5.Энэтхэг Улс
- 2.2.Европын орнууд
 - 2.2.1.Австри Улс
 - 2.2.2.Герман Улс
 - 2.2.3.Грек Улс
 - 2.2.4.Испани Улс
 - 2.2.5.Чех Улс
- 2.3.Латин Америкийн орнууд



- 2.3.1.Бразил Улс
- 2.3.2.Коста-Рика Улс
- 2.3.3.Мексик Улс
- 3.3.4.Чили Улс
- 2.3.5.Перу Улс

ГУРАВ. ХУУЧИН ЗХУ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН БҮГД НАЙРАМДАХ УЛСУУДЫН ТӨРИЙН СҮЛДНҮҮД

3.1.Хуучин ЗХУ

3.2.Орос Улс

3.3.Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсууд

- 3.3.1.Азербайжан Улс
- 3.3.2.Армени Улс
- 3.3.3.Беларусь Улс
- 3.3.4.Гүрж Улс
- 3.3.5.Казахстан Улс
- 3.3.6.Киргиз Улс
- 3.3.7.Латви Улс
- 3.3.8.Литва Улс
- 3.3.9.Молдова Улс
- 3.3.10.Тажикистан Улс
- 3.3.11.Туркменистан Улс
- 3.3.12.Узбекистан Улс
- 3.3.13.Украин Улс
- 3.3.14.Эстони Улс

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Төрийн сүлдний бэлгэдэл ба түүхэн уламжлал, шинэчлэл: Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны захиалгын даалгавар:

- Хүннү гүрний үеэс Монголын төрт ёсны бэлгэдлийн түүхэн уламжлалын талаар;
- Соёмбо тэмдгийн талаар;
- 1992 оны шинэ Үндсэн хуулийг хэлэлцэн батлах үед төрийн сүлдэнд Соёмбо үсгийг тусгах талаар иргэд, депутатуудаас санал гаргаж байсан эсэх талаар;
- Ази, Европ, Латин Америкийн 20 хүртэлх орны төрийн сүлдээ солих давтамж, түүний шалтгаан, төрийн сүлдний бүтэц, агуулга, бэлгэдлийн талаар;
- хуучин социалист системийн болон ЗХУ-ын бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсуудын төрийн сүлдний нийтлэг болон ялгаатай талууд.

Судалгааны зорилго:

Хүннү гүрний үеэс Монголын төрт ёсны бэлгэдлийн түүхэн уламжлал, түүний дотор Соёмбо тэмдгийн талаар, мөн Ази, Европ, Латин Америкийн болон хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсуудад төрийн сүлдээ сольсон давтамж, түүний шалтгаан, төрийн сүлдний бүтэц, агуулга, бэлгэдлийн талаар харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд Монгол Улсын төрийн сүлдний түүхэн уламжлалын талаарх тойм, гадаадын зарим оронд төрийн сүлдээ сольсон давтамж, түүний шалтгаан, төрийн сүлдний агуулга, бэлгэдлийн талаар харьцуулан судаллаа. Судалгаанд:

- Азийн – Вьетнам, Өмнөд Солонгос, Хятад, Шри Ланка, Энэтхэг зэрэг улсуудыг;
- Европийн – Австри, Герман, Грек, Испани, Чех зэрэг улсуудыг;
- Латин Америкийн – Коста-Рика, Мексик, Чили, Перу зэрэг улсуудыг;
- хуучин ЗХУ, түүний бүрэлдэхүүн 15 Бүгд найрамдах улсыг хамруулсан болно.

Судалгааны бүтэц:

Судалгааны тайлан нь судалгааны хураангуй болон дэлгэрэнгүй хэсгээс бүрдэнэ. Судалгааны дэлгэрэнгүй хэсгийн нэгдүгээр бүлэгт Соёмбо тэмдэг ба Хүннү гүрний үеэс хойших Монголын төрт улсуудын төрийн бэлгэ тэмдгийн тухай болон 1992 оны Үндсэн хуулийг хэлэлцэх үед төрийн сүлдний талаар иргэд, АИХ-ын депутатуудаас гарч байсан саналын тойм, хоёрдугаар бүлэгт Ази, Европ, Латин Америкийн нийт 15 улсын тусгаар тогтнолоо зарласнаас хойших төрийн сүлдний хувьсал, тэдгээрийн бэлгэдэл, гурвдугаар бүлэгт хуучин ЗХУ болон түүний бүрэлдэхүүн 15 Бүгд найрамдах улсын ЗХУ-ын үеийн болон орчин үеийн төрийн сүлд, тэдгээрийн хувьсал өөрчлөлт, бэлгэдлийн талаар судаллаа.

Түлхүүр үг: *төрийн сүлд, соёмбо, төрийн бэлгэ тэмдэг.*

Keyword: *coat of arm, national symbol, national emblem, heraldry.*

Ключивые слова: *герб, государственный герб, государственный символ.*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Дэлхийн 230 гаруй улс орнууд өлмий бат, эрхэмсэг оршихуйг бэлгэдэж өөрсдийн үндэсний онцлогийг илэрхийлсэн бэлгэ тэмдгүүдийг бүтээж, Үндсэн хууль болон түүнтэй дүйцэхүйц хууль тогтоомжоор баталдаг байна.⁵⁸ Төрийн сүлд нь тухайн улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэгт тооцогддог. Соёмбо бол Монгол төрийн бэлгэ тэмдэг юм.

1. Соёмбо тэмдгийн үүсэл, утга санаа

1686 онд Анхдугаар богд Өндөр гэгээн Занабазар монгол, санскрит, түвд үг бичихэд зориулан 90 үсэг бүхий Соёмбо үсгийг зохиожээ. Бүх үсгийнхээ шинжийг багтаасан гүн утга, бэлгэдэл бүхий титэм үсэг нь монголчуудын сүлд бэлгэ тэмдэг болсоор иржээ. Соёмбо хэмээх санскрит үг нь “Өөрөө тодорсон гэгээн” гэдэг утгыг хадгалдаг бөгөөд улс төр, гүн ухаан, шашны олон бэлгэдлийг агуулсан байдаг.

Соёмбыг Хүннүчүүдийн сүлдний нар, сар, гал гуравт үндэслэн зохиосон гэж судлаачид тайлбарладаг.

Соёмбын дүрслэл, түүний гүн гүнзгий утга, агуулгыг авч үзвэл, соёмбоны оройн хэсэгт нар сар хоёрын дээр галын дөлийг дүрсэлж нийлүүлсэн нь Монголын ард түмэн үүрд бадран цэцэглэж байхыг, дээр орших галын дөл нь үргэлжид өөдлөн бадрах үйлсийг, жад буюу сумны хошууг төлөөлсөн гурвалжин хоёр тэмдэг нь халдаж ирэх дайсныг эсэргүүцэн дарахыг, хөндлөн шугам дахь тэгш өнцөгт хоёр зураас нь дээдэс, доодос цөм шударга байж, ард түмэндээ цэх шулуун зүтгэхийг, хэзээ ч нүдээ аньдаггүй эр, эм хоёр загас буюу арга билгээр эрэгтэй, эмэгтэй бүх ард ямагт сонор соргог, сэцэн цэлмэг байж, өсөн үржихийг, хоёр хажуугийн босоо шугам нь бат бэх хэрэм, хаалтыг илэрхийлэн бэлгэдсэн утгатай ажээ.

Ийнхүү Соёмбо тэмдэг нь “Монголын ард түмэн гал мэт мандан бадарч, наран саран мэт гэрэлтэн мөнхжиж, сум мэт эгц шулуун, хуяг мэт бат бэх байж, загас мэт сонор соргог, өнөр өтгөн явж, арга билгээ хослон төмөр хэрэм лугаа адил төр улсаа хамгаалъя” гэсэн гүн утгыг илэрхийлдэг байна.

Соёмбо нь Монголын ард түмэн эв нэгдэлтэй байж, өнөд бат оршихыг бэлгэддэг бөгөөд сүүлийн 100 гаруй жилийн хугацаанд манай улсын Үндсэн хуулиудад тусгагдаж ирсэн.

2. Монголын төрийн бэлгэ тэмдгийн түүхэн уламжлал

Тулгар төр байгуулагдсан 2230-аад жилийн өмнө буюу **Хүннү гүрний үед** далбаа, туг, төрийн сүлдийг сүр хүч, цог хийморийг илэрхийлсэн төрийн бэлгэ тэмдэг болгон хэрэглэдэг байжээ. Хаан хүний төрийн есөн бэлгэ тэмдэг гэж үздэг хаш тамга, исэр, шүхэр зэргийг Хүннү гүрний шаньюй нар хэрэглэж байсан. Төмөр, алтаар хийсэн нар, сарны дүрстэй Хүннү гүрний сүлд Хэнтий, Ховд аймгийн хэд хэдэн газраас олдож байв. Хүннү гүрний төрт ёсны энэ мэт олон уламжлал Сяньби, Жужан зэрэг дараа дараагийн улсуудаар дамжин XIII зууны монголчуудад уламжлагдсан байдаг.

810 гаруй жилийн өмнөх **Их Монгол улс** нь хаан төрийн эрх ёс, сүр хүчийг илтгэсэн төрийн хаш тамга, есөн хөлт цагаан сүлд, дөрвөн хөлт их хар сүлд, гэрэгэ зэрэг төрийн бэлгэ тэмдэгтэй байжээ. Чингис хаан Их Монгол улсыг байгуулаад төрийн есөн хөлт Цагаан тугийг бүтээлгэн тахин шүтэж, улс орныхоо ирээдүй хойчийг даатгадаг болсон гэдэг. Энэхүү туганд Монгол төрийн үйл хэрэг цэвэр ариун, шударгаар мандан бадрахын бэлгэдэл шингэсэн байдаг. Туг нь мянган цагаан, шарга азарганы дэл, сүүлний хялгасаар шүншиглэн хийсэн гөхөлтэй, түүний дор гурван үзүүрт ган сэрээ бүхий дүгрэг цараас доош алтан шармал хүрээ

⁵⁸ Товуусүрэн Ц. Үндсэн хуулиа ойлгохуй. Хоёр дахь хэвлэл. УБ., 2020 он. 45 дахь тал.

байх ба түүний доторх цагаан хялгасан хөхлийг нарийн зүссэн ямааны арьсан сураар бэхэлж, тугийн иш модонд бэхэлсэн байдаг.

Чингис хааны дөрвөн хөлт Хар сүлдийг хар, хээр азарганы дэлээр зуулгаж мянган олноо базааж түмэн өртгөөр тахидаг байжээ. Хар сүлд нь Их Монгол улсын цэргийн сүр хүч, цог хийморийг илэрхийлэх гол сүлд болж, сүлдийг Цагаан тугийн нэгэн адил тахидаг байв.

Юань гүрний үед туг сүлд бол төрийн чухал бэлгэ тэмдэг байжээ. Чингис хааны үеэс уламжлан ирсэн “хар туг”-ийг “..дан өнгийн ширдсэн ишинд залаа гаргаж үйлдэнэ. Мордохдоо урьдаар туг байгуулна. Хөөрөгт мориор бараа болгоно. Цэрэг буудалласан бол тугаа Юүэ хуан-мэн хаалганы баруун өнцгийн гэрт саатуулна.” гэж сурвалжид тэмдэглэсэн байдаг.

Мөн хар туг нь монголчуудын цэрэг дайны сүлд туг бөгөөд дайсан этгээдийн омог зоригийг дарж, цэрэг дайчдынхаа сүр жавхааг хөгжөөдөг “бусдыг айлгахын бэлгэ” байжээ.

Эл хаант улсын хааны бэлгэ тэмдэг нь төрийн далбаа, туг, төрийн хэнгэрэг байв. Төрийн далбаа, цэргийн туг нь хааны өргөөнд мандаж байжээ. Энэ үед тугчин гэх албат байсан бөгөөд түүний хажууд ордны найрал хөгжимчид төрийн их хэнгэргийн хамт дагалддаг байжээ.

Манж Чин улсаас тусгаар тогтнолоо сэргээсэн **Богд хаант Монгол Улсын** төрийн сүлдээр Соёмбо үсгийг залж, төрийн далбаа, төрийн тамганы голд байрлуулан дээдлэх болсон. Соёмбын “Э, бам” үсэг нь арга, билиг хослохыг, бадам язгуурын төр шашнаа ариунаар мандуулахыг бэлгэдсэн утгатай аж.

Тухайн үед төрийн бэлгэ тэмдэг нь төр, шашныг хослон илтгэсэн эрхэмсэг оршихуйн бэлгэдэл байв.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын үед гурван удаа төрийн сүлдийг баталж байсан. 1921 онд байгуулагдсан БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулиар (1924 онд) Соёмбо үсэг бүхий анхны “улсын сүлд тэмдэг”-ийг анх удаа хуульчилжээ.

1940 оны шинэ Үндсэн хуулиар БНМАУ “хөдөлмөрчдийн тусгаар тогтносон улс” болж, “сүлд тэмдэг”-ээ шинэчилсэн. Сүлд тэмдэг нь тухайн үеийн бодлого, үзэл суртлаас ангид байгаагүй ч эх орон, эдийн засаг, хүн ардаа төлөөлүүлэн дүрсэлж, улсаа богино хугацаанд хөгжүүлэх, үргэлжид оршихыг бэлгэдэж байв. Манай улс шинэ үсэгт шилжиж, сүлд тэмдэгт хуучин үсгээр бичсэн улсын нэрийг 1945 онд шинэ үсгээр болгон өөрчилжээ.

1960 оны Үндсэн хуулиар БНМАУ “социалист улс” болох чиг баримжааны дагуу төрийн сүлдээ дахин шинэчилсэн. Төрийн сүлд нь тариан түрүүгээр хөвөөлсөн дугуй хэлбэртэй болсон нь тухайн үеийн социалист орнуудын төрийн сүлдэнд түгээмэл дүрслэгдэж байв. Магнайдаа алтан Соёмбо үсэг бүхий таван хошуутай төрийн сүлд нь тухайн үеийн төрийн мөн чанар, улс түмний найрамдлын үзлийг илэрхийлэн, манай орны үндэсний болон эдийн засгийн онцлогийг үзүүлжээ.

Монгол Улсад нэг нам дангаар ноёрхсон улс төрийн дэглэмийг халж, олон намын тогтолцоо, олон ургалч үзлийг хүлээн зөвшөөрсөн зарчмын цоо шинэ өөрчлөлтийг авчирсан ардчилсан хувьсгалын үр дүнд 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсан. Үндсэн хуулийн дагуу Монголын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг болох Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь манай ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ. Төрийн сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг

хослуулан дүрсэлсэн байдаг. Мөн шинэ Үндсэн хуулиар төрт ёсны эртний уламжлалаас Есөн хөлт Цагаан туг, Төрийн тамга хоёрыг дахин сэргээн залсан билээ.

3.1992 оны Үндсэн хуулийг хэлэлцэх үед төрийн сүлдний талаар иргэд, АИХ-ын депутатуудаас гарч байсан саналын тойм

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг боловсруулах, хэлэлцэх явцад төрийн сүлдийг өөрчлөх эсэх талаар ард иргэд, Ардын Их Хурал (АИХ)-ын депутатууд, уран бүтээлчид хамтын оюун ухаанаар сайтар хэлэлцэж шийдвэрлэсэн бөгөөд улсынхаа зан заншил, түүх, соёл, бэлгэ дэмбэрэл, одоо ба ирээдүй энэ цагаа харьцуулан авч үзэж байв.

Энэ үеэр АИХ-аас төрийн бэлгэ тэмдгийн асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллуулж, 200 орчим зураач, уран бүтээлчид янз бүрийн мэргэжлийн хүмүүс оролцож, мэргэжлийн урлагийн байгууллагуудын дунд төрийн сүлдний загвар зохиох уралдаан зарлаж, шилдэг бүтээлүүдээр нь Төрийн ордонд үзэсгэлэн гаргаж байжээ. Төрийн сүлдний загварыг бүтээхэд олон уран бүтээлчид ухаанаа заран оролцсоны дотроос зураач Ц.Ойдовын бүтээл шалгарчээ.

Иргэдээс ирүүлсэн саналын талаар: Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн үеэр зөвхөн төрийн бэлгэ тэмдэгтэй холбоотой асуудлаар иргэдээс давхардсан тоогоор 1000 гаруй захидал, бичиг, зөвлөмж, санал, хүсэлт, шүүмжлэл иржээ. Эдгээрийг АИХ-ын хуралдаанд багцлан танилцуулж байснаас үзэхэд, улсын нэр, үндсэн хуулийн нэр, төрийн сүлд, далбаа, дууллыг хэвээр нь үлдээх санал нэлээдгүй гарч байжээ.

Иргэдийн зүгээс 1960 оны Төрийн сүлд нь Монгол Улсыг болон монголчуудын ахуй, хүсэл зоригийг илэрхийлж чадсан, олон нийтийн санаа сэтгэлд нийцсэн, олон улсад танигдсан бөгөөд шинэ төрийн сүлд баталсан тохиолдолд улсын хилийн бүх шонг өөрчлөхөөс эхлээд их хэмжээний зардал гарна гэж үзэж байжээ. Үүнээс гадна Төрийн сүлдийг хэвээр үлдээж, Үндсэн хууль дахь зөвхөн түүний тайлбарыг өөрчлөх санал иргэдээс гарч байсан байна.

АИХ-ын депутатуудаас гарсан саналын талаар: АИХ-ын депутатуудын дунд ч төрийн сүлдээ өөрчлөх эсэх талаар олон санал гарч, нэлээдгүй хугацаанд хэлэлцэж байж нэгдсэн саналд хүрч байжээ. АИХ-ын депутатуудын дунд явуулсан асуулгад 400 орчим депутат оролцож, 270 депутат саналаа өгч байжээ. Депутатын 63 хувь нь төрийн сүлдний шинэ төсөл боловсруулахад санал өгсөн байна. Сүлдэнд багтах элементүүдийн хувьд депутатуудын 80 хувь нь *соёмбыг*, 75 хувь нь *морийг*, 70 хувь нь *галыг*, 52 хувь нь *нар, галыг* оруулах саналтай байжээ.

4.Гадаадын зарим улсын төрийн сүлдний бэлгэдэл

Судалгаанд хамрагдсан орнуудын одоо хэрэглэж байгаа төрийн сүлднүүдийн үндсэн элементүүд нь ихэвчлэн эртнээс уламжлан ирсэн бэлгэдлүүд байна. Эндээс төрийн сүлдээрээ дамжуулан өвөг дээдсийнхээ уламжлалыг хадгалах, дээдлэн хүндэтгэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх гэсэн өнгөрсөн, одоо, ирээдүйн холбоос бүхий бэлгэдлийг харж болно.

Ази, Европ, Латин Америкийн болон хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн байсан, нийт 30 улсын одоо хэрэглэж байгаа төрийн сүлдийг авч үзвэл, дараах бэлгэдэл, агуулгатай байгаа нь ажиглагдаж байна:

- *өмнө нь хэрэглэж байсан төрийн сүлдний элементийг уламжилж авсан* –
 - судалгаанд хамрагдсан Европын улсуудын ихэнх нь өмнө нь хэрэглэж байсан төрийн сүлдээ уламжилж авсан: **Грек** 1822 оны цагаан загалмайтай цэнхэр

- бамбайг, **Испани** 1868 оны хоёр баганатай бамбайг, **Чех** 1920 оны мөнгөн арслантай бамбайг, **Герман, Австри** 1919 оны нэг толгойтой бүргэдийг;
- эргэн нэгдсэн **Вьетнам** Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам Улсын төрийн сүлдийг;
 - **Чили** 1834 оны, **Перу** 1825 оны бамбайг;
 - хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсууд тусгаар тогтнолоо зарлаж, социалист төрхтэй төрийн сүлдээ дараах байдлаар эрс өөрчилсөн: **Азербайжан** 1930 оны галын дөлийг, **Армени** 1918 оны, **Гүрж** XIV зууны, **Латви** 1921 оны бамбайг, **Литва** XX зууны морьтныг, **Орос** XIII зууны хоёр толгойтой бүргэдийг, **Украин** эртний Киевийн Оросын “гурван шүдтэй жад”-ыг, **Эстони** 1700-аад оны гурван арсланг;
 - харин **Беларусь** нь хуучин ЗХУ-ын үед хэрэглэж байсан улаан таван хошуутай төрийн сүлдийг, **Тажикистан** өөрчлөлт оруулсан хуучин төрийн сүлдийг;
 - *буддын шашны агуулгатай* – **Шри Ланкад** буддын шашны тэргүүн байр суурь, шударга ёсыг бэлгэддэг төрийн сүлдийг, **Энэтхэгт** нийтийн тооллын өмнөх III зуунд Будда Гаутама анх бурхны ном заасан, буддын томоохон санг байгуулсан газарт босгосон Ашока баганыг;
 - *эртний бэлгэдлийг төрийн сүлдэндээ тусгасан* – **Өмнөд Солонгос** соёлын бэлгэ тэмдэг болох “Мугунхва” цэцгийг, **Мексик** домогт гардаг эртний ацтекүүд могой идэж буй бүргэдийг, **Узбекистан** домогт гардаг хөгжил цэцэглэлтийн Хумо шувууг;
 - *улс төрийн агуулгатай* – 1919 онд Тяньаньмэний талбайд **Хятадын** шинэ ардчилсан хувьсгалыг эхлүүлсэн хөдөлгөөнийг төлөөлүүлэн Тяньаньмэний хаалгыг;
 - *газар нутгийн онцлогийг харуулсан* – **Коста-Рика** хиллэдэг Номхон далай, Карибын тэнгисийг болон бахархал болсон гурван уулыг;
 - *шинэ төрийн сүлд бүтээсэн* – **Казахстан** уралдаанд шалгарсан гэрийн тооныг, **Киргиз** уран бүтээлчдийн санаачилгаар шонхор шувууг, **Туркменистан** Ерөнхийлөгч асан С.Н.Туркменбашийн санаачилгаар найман өнцөгтийг.

Дээрх улсуудын одоо хэрэглэж байгаа төрийн сүлдний элементүүдийн бэлгэдлийг үзвэл:

- **амьтан** –
 - *арслан* нь хүч чадал, эр зоригийн бэлгэ тэмдэг болохоос гадна улсуудын төрийн сүлдэнд өөрийн гэсэн бэлгэдлийг давхар илэрхийлж байдаг: **Арменид** эрх мэдэл, тэвчээр хатуужлыг, **Энэтхэгт** энх тайван, шударга ёс, хүлээцтэй байдлын төлөө тууштай байхыг, **Гүрж, Эстонид** өгөөмөр сэтгэлийг, **Чехэд** тус улсыг бүрдүүлсэн түүхэн 3 үндэстний нэгийг, **Шри Ланкад** нутгийн оршин суугчдыг;
 - *арслан, гриффин* хамтдаа **Латвийн** Баруун болон Зүүн Латвийн нэгдлийг; *бух* нь **Энэтхэгт** хөдөлмөрч, тууштай байдлыг; *лам гэрөөс* нь **Перугийн** байгалийн баялгийг; *луу* нь **Орост** улс орны хувь заяаны хүнд сорилтуудыг;
 - *морь* нь **Энэтхэгт** үнэнч, хурд, эрч хүчийг, “Янардаг” ахалтек морь нь **туркменчуудын** бахархлыг, **Казахстанд** цэвэр ариун бодол санаа, нийгэм, байгалийг, дэлхийн соёл иргэншилтэй зохицох хүсэл эрмэлзлийг, мөн морьд гэрийн тооны хоёр талд байгаа нь эх орноо нүдний цөцгий мэт хамгаалж, эх орондоо үнэнчээр зүтгэхийг, морьдын далавч нь хүчирхэг, улсын хөгжлийг;

- **архитектурын байгууламж** –
 - *Ашока баганыг* нийтийн тооллын өмнөх III зуунд Будда Гаутама анх бурхны ном заасан, буддын томоохон санг байгуулсан газрыг тэмдэглэснийг (**Энэтхэг**);
 - *Геркулесийн баганууд* нь Гибралтарын хоолой болон эзэнт гүрний хилийн чанад дахь эзэмшил газрыг (**Испани**);
 - *Тяньаньмэний хаалга* нь Хятадын ард түмний империализм ба феодализмын эсрэг тэмцлийн няцашгүй сэтгэлийг (**Хятад**);
- **байгаль, байгалийн баялаг** –
 - *Арарат* уул нь **Гүржид** эртний үндэсний бэлгэдлийг;
 - *уулс, ногоон хөндий, Амударья, Сырдарья голууд* нь нарлаг **Узбекистаныг**, харин Амударья, Сырдарья голууд нь мөнх амьдралыг;
 - *далай* нь **Коста-Рикатай** хиллэдэг Номхон далай, Карибын тэнгисийг;
 - *зоос* нь **Перугийн** байгалийн баялгийг;
- **бамбай** –
 - эртний элементүүдийн нэг болох бамбай нь **Азербайжан, Армени, Герман, Грек, Испани, Коста-Рика, Латви, Литва, Молдова, Орос, Чех, Чили, Перу** зэрэг улсуудын төрийн сүлдэнд байдаг;
- **бичвэр** –
 - **Беларусь, Вьетнам, Казахстан, Киргиз, Өмнөд Солонгос, Коста-Рикагийн** төрийн сүлдэнд улсын нэрийг бичсэн нь тухайн улсын засаглалын дэглэмийг;
 - **Испани** “Хязгаараас цааш”, **Гүрж** “Эв нэгдэл дэх хүч чадал”, **Чили** “Шалтгаан, эсхүл хүч чадал”, **Энэтхэг** “Зөвхөн үнэн л ялна” гэсэн уриаг;
 - **Бразил** – улсын нэрээс гадна анх Бразилын Нэгдсэн Улсыг тунхагласан “1889 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр”-ийг бичсэн байна;
- **жигүүртэн** –
 - бүргэд нь Европт эртнээс түгээмэл тархсан бэлгэ тэмдэг бөгөөд олон дүр төрхтэй байдаг: *нэг толгойтой бүргэд* нь **Австрийн** бүрэн эрхт байдлыг, **Арменид** эрх мэдэл, хүч чадал, тэвчээр хатуужлыг, **Германд** эрх чөлөөт ардчилсан уламжлалыг, ард түмэн ба төрийг, **Чехийг** бүрдүүлсэн түүхэн 3 үндэстний хоёрыг;
 - *хоёр толгойтой бүргэд* нь **Оросын** газар нутаг Европ, Ази тивд байдгийг;
 - *нарны хоёр талд байгаа хоёр бүргэд* нь **Арменийн** өргөн уудам газар нутгийг;
 - *шонхор шувуу* нь **Киргизэд** цэвэр ариун сэтгэлгээг, эрхэмсэг байдлыг, ард түмний амьдралын хэв маяг, уламжлалт соёлыг, мөн тус улсын газар нутгийг;
 - *хумо шувуу* нь **Узбекистанд** аз жаргал, аз хийморь, агуу байдал, сайн сайхныг;
- **морьтон** –
 - **Гүржид** *морь унасан Гэгээн Георгий* нь дайчин, ялагч гэгээнтнийг, мөн үнэн алдартны шашныг, **Орост** *лууг жадаар хөнөөж байгаа Гэгээн Георгий* нь сайн ба муу, гэрэл ба харанхуйн тэмцэл, эх орноо хамгаалахыг, **“Витис”** нь **Литвагийн** хилийг манаж буй хуягт баатрыг;
- **нар, сар, од** –
 - *ургах нар* нь **Беларусь, Коста-Рика, Латвид, Тажикистан, Туркменистан, Узбекистанд** хөгжил цэцэглэлтийг;

- *ургах нарны алтан туяа* нь **Киргизэд** ариун дагшин газар нутгийг гэрэлтүүлж байхыг, төр улсыг;
- *хавиргаан сар, од* нь **Узбекистаны** ард түмний ариун нандин итгэл үнэмшлийг буюу исламын шашныг;
- *цагаан таван хошуу од* нь **Чилийн** үндэсний бэлгэ тэмдэг болдог;
- *таван хошуу од* нь **Бразилын** 27 мужийг, **Коста-Рикагийн** 7 мужийг, **Вьетнамд** социалист дэглэм, эв санааны нэгдэл, улсын гэрэлт ирээдүйг, **Хятадын** ард түмний агуу эв нэгдлийг, **Латви** болж нэгдсэн түүхэн нутгуудыг, **Казахстаны** нүүдэлчин ард түмний чиглүүлэгч од, Казахстаны өөрийн гэсэн хөгжлийн замналыг;
- *найман хошуу од* нь **Азербайжанд** нарыг; **Узбекистанд** Бүгд найрамдах улсыг, улс орны эв нэгдлийг;
- **титэм –**
 - хана хэрэм мэт титэм нь **Австрид** хөрөнгөтөн иргэдийг;
 - **Арменид** эрх мэдлийг, **Испанид** бүрэн эрхт байдлыг, тус улсын түүхийг, **Орост** ОХУ болон түүний субъектүүдийн бүрэн эрхт байдлыг, **Чилийн** тэнгисийн цэргийг болон Номхон далайн баатарлаг үйлсийг;
- **үр тариа, ургамал –**
 - *будаа* нь **Вьетнамд** хөдөө аж ахуйг, **Шри Ланкад** цэцэглэн хөгжихийг;
 - *кофе* нь **Бразил, Коста-Рикагийн** хөдөө аж ахуйн буюу экспортын гол бүтээгдэхүүнийг;
 - *лаерын навч* нь **Грект** алдар нэрийг;
 - *“мугунгхва” цэцэг* нь **Өмнөд Солонгост** “хэзээ ч ганддаггүй мөнхийн цэцэг” гэсэн утгатай;
 - *тамхины мод* нь **Бразилын** хөдөө аж ахуйн чухал бүтээгдэхүүнийг;
 - *тариан түрүү* нь **арменчуудын** хөдөлмөрч занг, **Беларусь, Тажикистан, Туркменистан, Узбекистанд** хөдөө аж ахуйн гол бүтээгдэхүүнийг, **Хятадад** тариачдыг;
 - *хөөвөнгийн мөчрийг* цэцэглэсэн байдлаар дүрсэлсэн нь **Тажикистан, Туркменистан, Узбекистаны** хөдөө аж ахуйн гол бүтээгдэхүүнийг, мөн **Узбекистанд** ард түмний цэвэр ариун зүрх сэтгэл, хүсэл зориг, баялгийг;
 - *царс модны мөчир* нь **Латвид** хүч чадал, тогтвортой байдлыг, **Эстонид** эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх хүсэл эрмэлзлийг;
 - *чидун жимсний мөчир* нь **арменчуудын** оюун ухаан, соёлын баялаг өвийг, **Молдовад** энх тайвныг;
 - *“сипчона” мод* нь **Перугийн** байгалийн баялгийг;
- **хөдөлмөрийн багаж, зэвсэг –**
 - *алх* нь **Австрид** ажилчин ангийг;
 - *араа хүрд* нь **Вьетнамд** аж үйлдвэрийг, **Хятадад** ажилчин ангийг;
 - **Украины** гурван шүдтэй жад нь Киевийн Оросын захирагчийн бэлгэ тэмдгийг;
 - *сэлэм* нь **Шри Ланка, Арменид** эр зоригийг;
 - *хадуур* нь **Австрид** тариаланчдыг;

- **бусад –**
 - *галын дөл* нь **Азербайжанд** “галын орон”-ыг;
 - *гэрийн тоон* нь **Казахстанд** бат бөх байдлыг, *тооно* нь эцгийн гэр, орчлон ертөнцийг, тоононд байгаа *гурван нум* нь тус улсын гурван муж улсын эв нэгдлийг;
 - *загалмай* нь **Арменийг** Христийн шашинтай улс гэдгийг, **Молдовын** эртний Ромын гарал үүслийг, *загалмай*, *бөмбөрцөг* хоёр нь **Гүржийн** бүрэн эрхт байдал эргэн ирснийг, мөн үнэн алдартны шашныг, *очирт таяг*, *бөмбөрцөг* нь **Оросын** бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, эв нэгдэл, тус улсын хүчийг;
 - *Ноагийн хөвөөг авдар* нь **Арменид** их үерийн дараа хамгийн түрүүнд Арарат уулан дээр буусныг; *худалдааны хөлөг онгоцнууд* нь **Кост-Рикагийн** далайн түүхийг;
 - *тасарсан гинж* нь **Австри, Арменид** эрх чөлөө, тусгаар тогтнолыг;
 - *хивс* буюу “салыр гель” нь **Туркменистан** улсын найрамдал, эв нэгдлийг;
- **хэлбэр дүрс –**
 - *дугуй хэлбэр* нь **Казахстанд** ертөнц, мөнх амьдрал, эв нэгдэл, тусгаар тогтнол болон нүүдэлчин амьдралын хэв маягийг;
 - *найман өнцөгт* нь **Туркменистаны** энх тайван, хөгжил цэцэглэлтийг;
- **өнгө нь мөн гүн гүнзгий агуулгыг бэлгэдэж байдаг –**
 - *алтан өнгө* нь **Орос, Гүржид** эрх мэдэл, эд баялгийг, **Казахстанд** амьдрал, хөгжил цэцэглэлтийг;
 - *алтан шар, улаан өнгө* нь **Хятадад** аз жаргал, сайн сайхныг;
 - *алтан, мөнгөн, хөх, ногоон өнгө* нь **Узбекистанд** энх тайван, бүтээн байгуулалт, амар амгаланг.
 - *мөнгөн өнгө* нь **Орос, Гүржид** өгөөмөр сэтгэл, цэвэр ариун бодол, санаа зорилго, шударга үнэний төлөөх тэмцлийг;
 - *ногоон өнгө* нь **Азербайжанд** эд баялаг, үржил шимийг;
 - *улаан өнгө* нь **Азербайжан, Гүржид** хүч чадал, эр зоригийг, **Латвид** тусгаар тогтнолын төлөөх тэмцлийг, **Орост** эр зориг, эх орноо хайрлахыг, мөн эх орноо хамгаалагчдын урссан цус, олон үндэстний улсын эв нэгдлийг;
 - *хар өнгийн луу* нь **Оросын** түүхэнд гэм зэмгүй амиа алдсан хүмүүсийн уй гашуу, тэднийг үүрд санан дурсаж байхыг;
 - *цагаан өнгө* нь **Азербайжанд** тайван, амар амгаланг, **Латвид** эрх чөлөө, үндэсний нэр төр, шударга төрийг;
 - *цэнхэр өнгө* нь **Казахстанд** энх тайван, амар амгалан, хөгжил цэцэглэлт, цэвэр ариун байдлыг, мөн Казахстаны хязгааргүй тэнгэрийг;
 - *шар өнгө* **Вьетнамд** нийгмийн төлөөллийг тус тус илэрхийлж байна.

5.Гадаадын зарим улс орнуудын төрийн сүлдээ сольсон давтамж, шалтгаан

Судалгаанд хамрагдсан **Азийн орнууд** нь бусад улсын колони, эсхүл эзлэн түрэмгийллээс чөлөөлөгдөж, тусгаар тогтнолоо тунхагласныхаа дараа төрийн сүлдээ баталсан байдаг. Ийнхүү тусгаар улсынхаа анхны төрийн сүлдээ баталснаас хойш Хятад (1915 онд), Өмнөд Солонгос (1919 онд), Вьетнам (1955 онд) зэрэг улсууд 4 дэх төрийн сүлдээ, Шри Ланка (1954

онд) 2 дахь төрийн сүлдээ хэрэглэж байна. Энд төрийн сүлдээ шинэчилсэн болон өөрчилсөн тохиолдлуудыг хамт нь авч үзсэн болно. Харин Энэтхэг 1950 онд баталсан төрийн сүлдээ өөрчлөөгүй байна.

Европын орнуудын хувьд Испани 1230 оноос хойш 15 дахь, Грек 1833 оноос хойш 5 дахь, Австри 1848 оноос хойш 6 дахь, Чех 1920 оноос хойш 4 дэх, Герман 1962 оноос хойш 9 дэх төрийн сүлдээ хэрэглэж байна. **Латин Америкийн орнуудын** хувьд Чили 1813 оноос хойш 5 дахь, Мексик 1821 оноос хойш 8 дахь, Перу 1821 оноос хойш 4 дэх, Бразил 1889 оноос хойш 3 дахь, Коста-Рика 1940 оноос хойш 5 дахь төрийн сүлдээ хэрэглэж байна.

Эдгээр улсуудын төрийн сүлдээ өөрчилсөн шалтгааныг багцалж үзвэл:

- *төрийн байгуулал, эсхүл төрийн удирдлагын хэлбэр солигдсон* –
 - Гоминдан намын удирдлагад байсан **Хятад** 1934 оноос Коммунист намын удирдлагад орж, улмаар 1949 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсыг тунхагласан;
 - Бүгд Найрамдах **Шри Ланка** Улс 1972 онд, Бүгд Найрамдах Социалист **Чехословак** Улс 1960 онд, Бүгд Найрамдах **Мексик** Улс 1867 онд, хоёр дахь **Өмнөд Солонгос** 1960 онд тус тус байгуулагдсан;
 - **Германы** газар нутагт 1871 онд Германы эзэнт гүрэн, 1919 онд Ваймерын Бүгд Найрамдах Улс, 1933 онд нацист Герман байгуулагдаж байв;
 - **Грек** – 1924 онд Хоёрдугаар Бүгд Найрамдах Грек Улс байгуулагдсан боловч 1936 онд дахин хаант засаглал тогтжээ. Харин одоогийн Гуравдугаар Бүгд Найрамдах Грек Улс 1975 онд байгуулагдсан;
 - **Испани** – 1868 онд Анхдугаар Бүгд Найрамдах Улс, 1931 онд Хоёрдугаар Бүгд Найрамдах Улс байгуулагдаж байсан;
 - **Бразилын** Нэгдсэн Улс 1971 онд Холбооны Бүгд Найрамдах Улс болсон;
- *нэг улс хоёр задарсан, эсхүл (эргэн) нэгдсэн* –
 - **Австри** – Австри-Унгарын төрийн сүлдийг 1915 онд, Бүгд Найрамдах Герман-Австрийн төрийн сүлдийг 1919 онд баталж байсан;
 - 1954 онд хоёр хуваагдсан **Вьетнам** 1976 онд эргэн нэгдсэн;
 - **Герман** – Ром мөхсөний дараа 1806 оноос хоёр толгойтой бүргэдийг төрийн сүлдэндээ дүрслэхээ больсон. Мөн дэлхийн II дайнд ялагдсан Герман хоёр хуваагдаж, 1990 онд эргэн нэгдсэн байна;
 - 1469 онд **Испанийн** хоёр хаант улс нэгдэж, Гранадаг тус улсад 1492 онд нэгтгэв;
 - **Чех** – 1993 онд Чехословакийн холбоо задран Чех ба Словак гэж хуваагдсан;
 - **Перу** 1836 онд хоёр хуваагдсан ч 1839 онд эргэн нэгдсэн байна.
- *хаан ширээнд шинэ хаан суусан / шинэ ерөнхийлөгч сонгогдсон* –
 - **Грек** (1863 онд), **Испани** (1516, 1580, 1700, 1759, 1808, 1813, 1870 онуудад), **Мексик** (1863, 1865 онд) зэрэг улсуудын шинэ хаад төрийн сүлдээ улам бүр сүр жавхлантай болгон өөрчилж байв;
 - **Мексикийн** үе үеийн ерөнхийлөгчид төрийн сүлдээ өөрчилж байв (1893, 1916, 1934, 1968 онд);
- *улсынхаа онцлогыг тодруулах үүднээс төрийн сүлдний уран сайхны дүрслэлийг сайжруулсан* –

- **Герман** 1953, 1955 онд, **Чили** 1819, 1834, 1920 онуудад, **Перу** 1950 онд төрийн сүлдний элементүүдийг өөрчлөн сайжруулжээ;
- **Өмнөд Солонгос** 1997 онд, **Бразил** 1968 онд өнгийг нь тодруулж байсан;
- **Коста-Рика** 1848 онд батлагдсан төрийн сүлдэнд засаг захиргааны нэгжид өөрчлөлт орох, эсхүл төрийн сүлдний элементүүдийг илүү тодруулах үүднээс 1906, 1964, 1998 онд өөрчлөлт оруулсан;
- **Мексик** 1823 онд тусгаар тогтнолын ойгоо тохиолдуулан төрийн сүлдээ шинэчилсэн.

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудын хувьд 1990-ээд оны эхэн үед тусгаар тогтнолоо зарласныхаа дараа шинэ төрийн сүлдээ залж байжээ. Эдгээр улсуудын төрийн сүлдээ өөрчилсөн давтамж, солих шалтгааныг авч үзэхэд:

- **Гүрж** 1990 онд эхлээд 1918 оны зүүн тийш харсан гэгээн Георгийг сэргээсэн боловч 2004 онд XIV зууны баруун тийш харсан гэгээн Георгийг залсан байна;
- **Тажикистан** 1992 оны шинэ төрийн сүлдээ 1993 онд дахин шинэчлэхдээ хуучин ЗХУ-ын үед хэрэглэж байсан төрийн сүлдээ өөрчлөн баталсан байна;
- **Беларусь** 1991 оны төрийн сүлдний зарим элементийн дүрс, өнгийг 2012, 2021 онд өөрчилжээ. 2021 онд дэлхийн бөмбөрцгийг бага зэрэг эргүүлснээр Европ тив “илүү их”, Орос Улсын нутаг дэвсгэр “илүү бага” дүрслэгдэх болсон;
- **Туркменистан** 1992 оны төрийн сүлдний элементүүдийн дүрслэл, өнгийг 2000 онд, бамбайны хэлбэрийг 2003 онд тус тус өөрчилсөн;
- латин үсэгт шилжихтэй холбогдуулан кирилл үсгээр бичсэн байсан улсынхаа нэрийг **Казахстан** 2018 онд, **Узбекистан** 2010 онд латин үсгээр өөрчилсөн.

Харин Азербайжан, Армени, Киргиз, Латви, Литва, Молдова зэрэг улсууд 1990-ээд орны эхэн үед баталсан төрийн сүлдэндээ өөрчлөлт оруулаагүй байна.

6.Хуучин ЗХУ, түүний бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсуудын төрийн сүлдний нийтлэг ба ялгаатай талууд, сольсон давтамж, шалтгаан

Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-ын 1924 онд бүтээгдсэн анхны социалист төрхтэй төрийн сүлд нь эвлэлдэн нэгдсэн ажилчин, тариачид болон Бүгд найрамдах улсууд ЗХУ-д сайн дурын үндсэн дээр нэгдэж, бүх үндэстний тэгш эрхийг бэлгэдэж, тус улсын ард түмэн дэлхийн бүх улсын хөдөлмөрчидтэй интернационал эв нэгдлийн үзэл санааг илэрхийлж байв.

ЗХУ-ын төрийн сүлдний элементүүдийн бэлгэдлийг авч үзвэл:

- *таван хошуу*, эсхүл таван хошуу од нь үүрд мөнх, эрх мэдэл, гэрэл гэгээг, мөн дэлхийн таван тивийн пролетариудын эв нэгдлийг;
- *алх, хадуур* нь хөдөлмөрийн урам зоригийг, мөн ажилчин, тариачдын хүчтэй улсыг цогцлоон байгуулах хүсэл эрмэлзлийг;

- *дэлхийн бөмбөрцөг* нь тус улс хүн төрөлхтөнтэй нягт хамт байхыг, өөрөөр хэлбэл, олон улсын энх тайванч зарчимтай, дэлхийн бүх ард түмэн “хөдөлмөр”-ийг удирдлагаа болгох шинэ нийгмийг;
- *ургах нар* нь коммунист үзэл санаа, түүний гэрэлт ирээдүйг;
- *тариан түрүү* нь хөгжил цэцэглэлтийг;
- *улаан болон алтан шар* өнгө нь хувьсгалт уламжлал, хувьсгалт агуу үйл хэрэгт үнэнч байхыг, мөн ЗХУ-ын бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсуудын эв нэгдлийн коммунист үзэл санааны гэрэлт ирээдүйг, тэр тусмаа улаан өнгө нь эртнээс боолууд эзэдтэйгээ, хамжлагууд ноёдтойгоо, пролетариуд хөрөнгөтөн эзэдтэйгээ тэмцэх тэмцлийн дүрэлзсэн галыг, урссан цусыг илэрхийлж байв.

“Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” хувьсгалт уриаг бүх улсын ажилчдын нөхцөл байдал, тэдний сонирхол болон тэдний дайсан нэг учраас бүх үндэстний ажилчдын холбоод ахан дүү мэт хамтран бүх үндэстний хөрөнгөтний холбоог эсэргүүцэх гэсэн утга санаагаар анх К.Маркс, Ф.Энгельс нар гаргаж иржээ.

ЗХУ-ын төрийн сүлдний уриаг эхлээд 1924 онд 6 хэлээр бичсэн байв. Хожим нь Бүгд найрамдах улс болж, ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсон улсын хэлээр бичсэн уриа бүхий туузыг төрийн сүлдэнд нэмжээ. 1929 онд уриаг турк хэлээр нэмсэн ба энэ үед орос хэл дээрх уриа бүхий туузыг төрийн сүлдний төв хэсэг рүү шилжүүлсэн. Уриаг 1936, 1946, 1956 онуудад нэмж, эсхүл хасаж, эцэст нь 15 уриатай болжээ.

ЗХУ-ын бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсуудын төрийн сүлдний түүхэн хөгжил социализмын материаллаг, техник болон соёлын хөгжилд тулгуурлаж байжээ. Энэ нь төрийн сүлдний дүрслэл, уран сайхны найруулга болон улсуудын аж байдал, үндэстний онцлогийг илэрхийлэх бэлгэдлийг улам сайжруулж байв. Ингэхдээ тухайн үндэстний онцлогийг хадгалагдахын зэрэгцээ ЗХУ-ын бүх ард түмний эв нэгдэл, нөхөрлөлийг илэрхийлэхийг зорьж байв. Тийм учраас таван хошуу, алх, хадуур, ургах нар, тариан түрүү, хувьсгалт уриа зэрэг ЗХУ-ын төрийн сүлдний үндсэн элементүүд Бүгд найрамдах улсуудын төрийн сүлдэнд “заавал” оруулдаг байжээ.

Орос, Казахстан, Украин улсын төрийн сүлднүүд нь улаан өнгөтэй бамбай байсан. Бусад улсын төрийн сүлд нь тариан түрүү болон модны мөчрөөр хөвөөлсөн дугуй хэлбэрээрээ ЗХУ-ын төрийн сүлдтэй төстэй байв. Харин **Армени, Гүржийн** төрийн сүлд нь 1922-1936 онд оршин тогтнож байсан Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Өвөр Кавказ Улсын төрийн сүлдний дугуй хэлбэрийг уламжлан авчээ.

ЗХУ-ын бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсууд төрийн сүлдээ сайжруулахын тулд нэлээд өөрчилж байсан. Эдгээрээс хамгийн олон удаа их өөрчлөгдөж байсныг үзвэл, **Тажикистан** 1919 онд батлагдсан төрийн сүлдээ 2 удаа шинэчилж, түүнд 4 удаа өөрчлөлт оруулж байсан бол **Азербайжан** 1921 онд, Беларусь 1919 онд батлагдсан төрийн сүлдээ 1 удаа шинэчилж, түүнд 4 удаа өөрчлөлт оруулжээ. **Узбекистан** 1925 оны төрийн сүлдэндээ 2 удаа, 1937 оны шинэ төрийн сүлдэндээ 4 удаа өөрчлөлт оруулж байжээ.

Төрийн сүлд шинэчлэгдсэн, өөрчлөгдсөн нийтлэг шалтгаануудыг багцлан танилцуулбал:

- улсын статус өөрчлөгдсөн –
 - 1922 онд 3 улс нэгдэн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Өвөр Кавказ Улс байгуулсан боловч 1936 онд задран Азербайжан, Армени, Гүрж зэрэг Бүгд найрамдах улсууд болж, ЗХУ-ын бүрэлдэхүүнд оржээ;

- Автономит Бүгд Найрамдах Тажик Улс 1929 онд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Узбекистан Улсын бүрэлдэхүүнээс гарснаар төрийн сүлдний тажик хэл дээрх уриаг хасжээ;
- латин үсгээс кирилл үсэг рүү шилжсэн / зөв бичих шинэ дүрэм батлагдсан –
 - ЗХУ-ын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1939 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн шийдвэрээр Бүгд найрамдах улсууд кирилл үсэг рүү шилжихтэй холбогдуулан төрийн сүлдэн дээрх улсын нэр, уриаг засжээ;
 - 1956 оноос шинэ дүрмийн дагуу улсын нэрийн товчлол цэгийг авчээ;
- хувьсгалт уриаг зөв болгож залруулсан –
 - 1937 онд ЗХУ-ын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн дэргэд байгуулагдсан мэргэшсэн орчуулагчдаас бүрдсэн тусгай хороо нь Бүгд найрамдах улсуудын төрийн сүлдний бичээсүүдийг нягталж, алдааг залруулах санал боловсруулж байжээ. Уриаг “Бүх дэлхийн пролетариуд нэгдэгтүн!” гэж буруу бичсэн байсан Киргиз (1937 онд), Казахстан (1940 онд), Тажикистан (1940 онд), Туркменистан (1946 онд) зэрэг улсууд төрийн сүлдэндээ залруулга хийжээ;
- төрийн сүлдний дүрслэл, уран сайхны найруулгыг сайжруулсан –
 - Азербайжан (1956 онд), Беларусь (1981 онд), Казахстан (1978 онд), Беларусь (1981 онд) зэрэг улсууд төрийн сүлдний үндэсний онцлогоо тодруулах үүднээс сайжруулж байжээ;
- ЗХУ-ын бүх ард түмний нэгдлийг илэрхийлэх үүднээс төрийн сүлднүүдийг жигдэлсэн –
 - таван хошууг Казахстан (1950 онд), Орос (1978 онд) улсууд төрийн сүлдэндээ хожуу нэмж оруулжээ.

Бүгд найрамдах улсуудын төрийн сүлдэнд тухайн үндэсний онцлог хадгалагдаж байсан. Тухайлбал, тариан түрүүг дангаар нь Орос, Казахстан, Латви, Украины төрийн сүлдэнд дүрсэлсэн байв. Харин бусад улсын төрийн сүлдэнд тариан түрүүтэй хамт тухайн улсын хөдөө аж ахуйн гол бүтээгдэхүүн болох хөвөнгийн мод (*Азербайжан, Киргиз, Тажикистан, Туркменистан, Узбекистан*), усан үзмийн мод (*Армени, Молдовь, Туркменистан*), царс мод (*Литва*), шилмүүст мод (*Эстони*), эрдэнэ шиш (*Молдовь*) болон маалингийн цэцгийг (*Беларусь*) дүрсэлсэн байв. Мөн шүтээн уул (*Армени* - Арарат уул, *Киргиз* – Алатау уул), үндэсний хээ угалз (*Гүрж, Киргиз*), үндэстний хивсийг (*Туркменистан*) дүрсэлсэн байв.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. СОЁМБО ҮСЭГ БА МОНГОЛЫН ТӨРТ УЛСУУДЫН ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТАЛААРХ ТОЙМ

Анх хүннүүд нар, сартай сүлд хэрэглэж байсан ба хожим нь гал нэмэгдсэнээр монголчуудын гол сүлд болсон нар, сар, галтай сүлд бий болжээ. Нар, сар, гал гурав нь ухааны гэрлийг, хорвоогийн гэгээг, үүрд мөнхийн оршихуйг илэрхийлдэг. Одоогийн бидний хэрэглэж буй Соёмбо тэмдэгт эдгээр бэлгэдэл бүрэн орсон байдаг онцлогтой.

1.1.Соёмбо тэмдгийн үүсэл, утга санаа

Соёмбо нь одоогоос 300 гаруй жилийн өмнө буюу XVII зууны үед анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазарын зохиосон Соёмбо үсгээс үүсэлтэй. Монголчуудын бичиг үсэг, үндэсний

соёл, сэтгэлгээний онцгой чухал өв болсон Соёмбо үсгийг Өндөр гэгээн Занабазар тэртээ түүхэн цаг үед Монгол Улсын тусгаар тогтнол, оюун санааны эв нэгдэл, улс үндэстэн, хүн ардын амар амгалан, төр улсаа батжин бэхжихийг бэлгэдэн бүтээсэн бөгөөд уг үсгийн эхэн дэх титэм нь монголчуудын төрийн бэлгэ тэмдэг болон хэрэглэгдсээр иржээ.

Соёмбо үсгээс гаралтай Соёмбо титмээрээ Өндөр гэгээн Занабазар Монгол Улс тайван амгалан оршиж, хөгжин цэцэглэж, монгол хүн ард амар түвшин (“хөл хөсөр, гар ганзагад”-хэрүүл маргаангүй) жаргал, буян дүүрэн амьдрахыг бэлгэдсэн гэдэг.⁵⁹

Соёмбо үсэгт хүний танин мэдэхүйн задлан шинжилж нэгтгэн ухаарах зарчим төгс хэрэглэгдсэн⁶⁰ гэж үздэг.

Эрдэмтэн Б.Ринчин гуайн бичсэнээр Соёмбын оройд байгаа галын дөлийг илэрхийлсэн тэмдэг нь үргэлжид өөдлөн бадрах үйлсийг бэлгэдсэн байна. Соёмбод монголчуудын эртний нар, сар хоёрын дээр галын дөлийг дүрсэлж нийлүүлсэн нь Монголын ард түмэн үүрд дэлгэрэн цэцэглэж байхын ерөөлийг агуулсан. Соёмбо үсгийн дотор буй гурвалжин хоёр тэмдэг нь жад буюу сумны хошууг төлөөлсөн бөгөөд энэ нь халдаж ирэх дайсныг эсэргүүцэн няцаах утга санааг илэрхийлжээ. Хөндлөн шугам дахь тэгш өнцөгт хоёр зураас нь дээдэс, доодос цөм шударга байж, ард түмэндээ цэх шулуун зүтгэхийн санааг илтгэдэг. Үсгийн голд хэзээ ч нүдээ аньдаггүй эр, эм хоёр загас буюу арга, билгээр эрэгтэй, эмэгтэй бүх ард ямагт сонор соргог, сэцэн цэлмэг байж, өсөн үржихийг билэгдсэн. Хоёр хажуугийн босоо шугам нь бат бэх хэрэм, хаалтыг томьёолжээ. “Хоёр хүн эвтэй бол төмөр хүрээнээс бат” гэсэн ардын сэцэн үгийн агуулгыг үүгээр илэрхийлжээ. Соёмбо үсэг нь бүхэлдээ Монголын ард түмэн эв нэгдэлтэй байж, өнө бат оршихыг илэрхийлдэг.⁶¹

Галын дөлийг Соёмбод гурван салаагаар дүрсэлсний учир гэвэл, энэ гурваар ертөнцийн цагаар бол өнгөрсөн, одоо, ирээдүй, хүмүүний амьдралаар бол өвгөд хөгшид, идэр залуу, өсвөр багачуудыг төлөөлүүлдэг. Гал бол нар, сарыг орлохоос ч илүү ач тус, хүч чадалтай, өөрөөр хэлбэл, гал гаргаж чадсанаараа хүмүүс байгалийн догшин ширүүнээс өөрийгөө хамгаалах, оюун санаа, биологийн хувьд хөгжих нэгэн чухал нөхцөлөө бүрдүүлжээ. Соёмбод нар, сарыг галын дараа байрлуулж дүрсэлсний учир гэвэл, хүмүүс галыг өдөр ч, шөнө ч хэрэглэдэг бөгөөд нар, сар, гал гурав бол ухааны гэрлийг, хорвоогийн гэгээг, үүрд мөнхийн оршихуйг тэмдэглэдэг. Монголчуудын домог ёсоор, сар бол эцэг, нар бол эх хэмээн сүсэглэн биширдэг байсан. Байгалийн энэхүү эцэг, эх хоёр нь мөн хүн төрөлхтний эцэг, эх гэж зүйрлэж болно.⁶²

Монголын түүхийн салшгүй нэг хэсэг болсон төрийн бэлгэ тэмдэг, түүний үүсэл, хөгжил нь сүүлийн 100 гаруй жилийн хугацаанд манай улсын Үндсэн хуулиудад тусгагдаж, тухайн үеийн улс төр, нийгмийн байдлыг илтгэсэн утга агуулгыг өөртөө багтааж байжээ.

1.2. Монголын төрийн бэлгэ тэмдгийн түүхэн уламжлал

Монгол нутагт оршин байсан эртний нүүдэлчдийн дунд нар, сар, тэнгэр эрхсийг шүтэх шүтлэг өргөн дэлгэрсэн байсан нь археологийн олдвороор батлагддаг. Энеолитийн үеэс эхлээд хүрэл, төмрийн үеийн хадны зурагт нар, сар, од эрхсийг дүрсэлсэн, наран шүтлэгийг илэрхийлсэн дүрс нэлээд байдаг.

⁵⁹ Даш-Ёндон Б, Мөнхбаатар Л. Соёмбо сүлд: Монгол ухаан. УБ., 2015 он. 67 дахь тал.

⁶⁰ Мөн тэнд. 80 дахь тал.

⁶¹ Сэндэнхорол Б. Төрийн бэлгэ тэмдгийн уламжлал, шинэчлэл, хэрэглэх журам, түүний эрх зүйн зарим асуудал. УБ., 2012 он. 7-8 дахь талууд.

⁶² Даш-Ёндон Б, Мөнхбаатар Л. Соёмбо сүлд: Монгол ухаан. УБ., 2015 он. 81 дэх тал.

1.2.1. Хүннү гүрний төрийн бэлгэ тэмдэг

Эрт цагт монголчууд төр улс, ялгуулсан цэргийнхээ сүр хүчин, сүлд хийморийн бэлгэдлийг хүлэг морьдынхоо хур дэлээс дээжлэн авсан туг үсээр цогцлоон үйлдэж байсан учраас туг хэмээн нэрлэх болжээ. Монголын нутгаас одоогоор олдоод байгаа хамгийн эртний тугийн дурсгал нь Баянхонгор аймгийн Баянлиг сумын Бичигтийн хаданд “нэг гартаа туг барьсан морьтныг” дүрсэлсэн хадны зураг юм. Энэхүү хадны зургаас үзэхэд, эртний монголчууд бүр хүрэл зэвсгийн үеэс адуу малынхаа дэл сүүлээр туг хийж, түүнийгээ эрхэмлэн хүндэтгэж иржээ. Өөрөөр хэлбэл, адууны дэл сүүлээр хийсэн Монгол Улсын төрийн ба цэргийн туг нь хүрэл зэвсгийн үеэс уламжлалтай гэж үзэх бүрэн үндэс байна.

Умард Хүннүгийн Жижи шаньюй таван өнгийн тугтай байсан тухай сурвалжийн мэдээ байдаг. Иймд Хүннү болон эртний улсуудын үед далбаа, тугийг төрийн бэлгэдэл, цэргийн сүр хүч, цог хийморийг илэрхийлэгч хэмээн үзэн өргөн дэлгэр хэрэглэж байжээ.

Нийтийн тооллын 90 онд Умард Хүннүгийн шаньюйд төрийн хаш тамга байсан талаар сурвалж бичигт үлджээ. Модунь болон түүний дараагийн шаньюй нар Хан улсын хуандитай харилцаж байсан бичиг захидлуудын тухай хятад сурвалж бичигт тэмдэглэгдэн үлджээ. Хүннүгийн шаньюй эдгээр бичиг захидалдаа төрийн тамгаа дарж баталгаажуулдаг байжээ.

Тулгар төр байгуулагдсан 2230-аад жилийн өмнөх Хүннү гүрний үед далбаа, туг, төрийн сүлд зэрэг сүр хүч, цог хийморийг илэрхийлсэн төрийн бэлгэ тэмдгүүдийг хэрэглэдэг байжээ. Эдгээр нь монголчуудын Хаан хүний төрийн есөн бэлгэ тэмдэг гэж үздэг хаш тамга, исэр, шүхэр зэргийг Хүннү гүрний шаньюй нар хэрэглэж байсан.



Төмөр, алтаар хийсэн нар, сарны дүрстэй Хүннү гүрний сүлд Хэнтий, Ховд аймгийн хэд хэдэн газраас олдсон нь Монголын үндэсний түүхийн музейд хадгалагдаж байдаг.⁶³

Хүннү гүрний төр ёсны энэ мэт олон уламжлал Сяньби, Жужан зэрэг дараа дараагийн улсуудаар дамжин XIII зууны монголчуудад уламжлагдсан байдаг.⁶⁴

1.2.2. Их Монгол улсын төрийн бэлгэ тэмдэг⁶⁵

Их Монгол улсын төрийн ёс, ёслол нь хоорондоо нарийн шүтэлцээтэй байсан. Монголчууд аливаа ёсчлох ажиллагааг “нэр төртэй” хийхийг чухалчилж, нэрийг төртэй хамтруулан холбоо үг хэрэглэж ирсэн нь санамсаргүй хэрэг биш юм. Төр, иргэн хоёрын харилцан шүтэлцээг давхар илэрхийлсэн утгатай ажээ.

Их Монгол улсын үед хаан төрийн эрх ёс, сүр хүчийг илтгэсэн төрийн хаш тамга, есөн хөлт цагаан сүлд, дөрвөн хөлт их хар сүлд, гэрэгэ зэрэг төрийн бэлгэ тэмдэгтэй байсан.

Сүлд, туг

Их Монгол улсад есөн хөлт цагаан туг, сүлд нь төрийн эрхэм бэлгэ тэмдэг болж байжээ. Туг, сүлд хоёр нь үндсэндээ нэг ойлголт бөгөөд улс орон, цэргийн хүчийг бадруулах цог хийморийн бэлгэ тэмдэг гэж судлаачид үздэг. “Сүлд” гэдэг нь “Сүнэсү”, “Сүнс” гэдэг үгтэй

⁶³ Bryan Miller. Elite Xiongnu Burials at the Periphery: Tomb Complexes at Takhiltyn Khotgor, Mongolian Altai (Miller et al. 2009). <https://www.academia.edu>

⁶⁴ Гантулга Ц., Бямбасүрэн Г. Монгол төрийн үүсэл, ёс ёслол, бэлгэдэл, хүндэтгэл, уламжлал. УБ., 2011 он. 23 дахь тал.

⁶⁵ Мөн тэнд. 54, 66, 70 дахь талууд.

язгуур нэг, амин гол гэсэн утгыг агуулдаг ажээ. Хүн амьтны амин гол сүнс байдагчлан улс гүрний эрхэмлэх гол шүтээн нь сүлд болж байжээ. Харин “туг” гэдэг үг нь туг үс, түүдэг туг, туг сүүл гэхчлэн бөөн үс гэсэн утгатай. Түүхэн сурвалж бичгүүдийг үзвэл, “Монголын нууц товчоо”-нд “Есөн хөлт цагаан туг”, “Судрын чуулган”-д “Есөн хөхөлт цагаан туг”, “Гангийн урсгал”-д мөн “Есөн хөхөлт” гэж тус тус тэмдэглэжээ.

Есөн хөлт Цагаан туг

Чингис хаан Их Монгол улсыг байгуулаад төрийн есөн хөлт Цагаан тугийг бүтээлгэн тахин шүтэж, улс орныхоо ирээдүй хойчийг даатгадаг болсон гэдэг.

Монгол төрийн үйл ариун цэвэр, шударгаар мандан бадрахын бэлгэдэл нь есөн хөлт Цагаан туганд шингэсэн байдаг. Тугийг мянган цагаан, шарга азарганы дэл, сүүлний хялгасаар шүншиглэн хөхөл хийдэг бөгөөд доор нь гурван үзүүрт ган сэрээ бүхий дүгрэг цараас доош алтан шармал хүрээ байх ба түүний доторх цагаан хялгасан хөхлийг нарийн зүссэн ямааны арьсан сураар бэхэлж, тугийн иш модонд бэхэлсэн байдаг. Тугийн иш модыг ойн тэгш ургасан хуш модоор хийх ба уг модыг авахдаа газар усаа аргадан гуйж авдаг байна.⁶⁶

Дөрвөн хөлт Хар сүлд

Чингис хааны Хар сүлд нь уг гарлын хувьд “Чингис хаан дайнд нэг удаа ялагдах болсонд хурмаст тэнгэрээс хар сүлдийг саглагар модны дээр буулгасан тул Чингис Мухулайг томилж, хар сүлдийг хээр азарганы мундаан дээр залан буулгаснаар дайнд ялж, тус тугийг хар, хээр азарганы дэлээр зуулгаж мянган олноо базааж түмэн өртгөөр тахидаг болсон байна” гэх домгийн шинжтэй эх сурвалж байдаг. Хар сүлд нь Их Монгол улсын цэргийн сүр хүч, цог хийморийг илэрхийлэх гол сүлд болж байжээ.

Хар сүлдийг Цагаан тугийн нэгэн адил тахидаг байв. Тухайн үед дайн байлдаанд мордох бүртээ ялалтыг урин дуудаж хар сүлдийг догшруулан тахих нарийн дэг ёстой байжээ. Хар сүлдийг тахихдаа 4 элч буюу хөл сүлдийг 4 зүгт тусгай хүмүүст даалган явуулдаг ба тэд тус тусын зүгээс азарганы дэл, тахилгын идээ шүүс, сүлдний дээл зэргийг авчирдаг байв. Үүний дараа гол тугийн хөхлийг 4 элч сүлдэнд хувь тэнцүү хуваан зүүж, шинэ авчирсан хөхлийг гол сүлдэндээ зооглуулдаг байжээ.⁶⁷

1.2.3.Юань гүрний төрийн бэлгэ тэмдэг

Юань гүрний үед Чингис хааны үеэс уламжлан хар туг, цагаан туг, алаг туг гэх гурван туг сүлд нь монголчуудын эрх чөлөө, тусгаар тогтнол, эрэлхэг дайчин баатрын хүчний бэлгэдэл болж байжээ.

Тухайн үед цагаан туг байсан эсэх тухай сурвалжийн тодорхой мэдээ баримт байхгүй байна. Харин хар туг буюу хар сүлдний тухай “Арван буянт номын цагаан түүх” болон “Юань гүрний судар” зэрэг сурвалжид тодорхой тэмдэглэгдсэн байдаг. Тухайлбал, “Хар туг – дан өнгийн ширдсэн ишинд залаа гаргаж үйлдэнэ. Мордохдоо урьдаар туг байгуулна. Хөөрөгт мориор бараа болгоно. Цэрэг буудалласан бол тугаа Юүэ хуан-мэн хаалганы баруун өнцгийн гэрт саатуулна.” гэсэн тэмдэглэл байдаг.

Хар туг бол монголчуудын цэрэг дайны сүлд туг юм. Сурвалжид хар тугийг “бусдыг айлгахын бэлгэ” гэж тэмдэглэснээс үзэхэд, дайсан этгээдийн омог зоригийг дарж, цэрэг дайчдынхаа сүр жавхааг хөгжөөдөг гэдгийг мэдэж болно. Эртний монголчууд дайнд мордохоос өмнө цэрэг дайчдынхаа омог зоригийг хөгжөөхдөө туг сүлдээ тахиж, тэнгэр газарт өргөл цацал өргөж байжээ. Юань гүрний үед энэхүү уламжлал хэвээр хадгалагдаж,

⁶⁶ Болортуяа Б. Төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ., 2013 он. ¹⁷ дахь тал.

⁶⁷ Мөн тэнд. 18 дахь тал.

хар тугийг хан хүний есөн их бэлгэ тэмдгийн хамгийн тэргүүнд залж, дайсан этгээдийн дарлага болон мандаж, улаан бүрээтэй хамт төрийн эрх хүндийн нэгэн илэрхийлэл болдог байжээ.⁶⁸

Юань гүрний үед ч Их Монгол улсын төрийн есөн их бэлгэдэл нь ийнхүү уламжлал хэвээр байсныг “Дөрвөн арван буянт номын цагаан түүх” гэх сурвалжид хан хүний харьяанд байх “есөн их бэлгэ буй” гэснээс үзэж болно. Тухайлбал:⁶⁹

Хан хүний харьяанд байх есөн их бэлгэ буй

<i>Хараа ихт хар туг</i>	<i>Явдлын бэлгэ</i>
<i>Бусдыг айлгахын бэлгэ</i>	<i>Ээл ихт хүнд бүс</i>
<i>Хашгираа ихт улаан бүрээ</i>	<i>Төр тогтохын бэлгэ</i>
<i>Хамгаа хүндэтгэхийн бэлгэ</i>	<i>Өндөр талбигт сэнтий</i>
<i>Хүчин их хар хор (сум)</i>	<i>Хүнд суудлын бэлгэ</i>
<i>Бие сахихын бэлгэ</i>	<i>Түшиг сайн өрлөгүүд</i>
<i>Цог ихт шар хэнгэрэг</i>	<i>Найз нар арга бэлгийн бэлгэ</i>
<i>Олноо өргөгдөхийн бэлгэ</i>	<i>Түшиг сайн өрлөгүүд</i>
<i>Зангарга ихт алмаас илд</i>	<i>Найз нар арга бэлгийн бэлгэ</i>
<i>Засаг явуулахын бэлгэ</i>	<i>Есөн их бэлгийг</i>
<i>Чийрэг сайн алтан эмээл</i>	<i>Есөн өрлөгүүд мэд.</i>

1.2.4.Эл хаант улсын төрийн бэлгэ тэмдэг

Эл хаант улсын хааны нэгэн гол бэлгэ тэмдэг нь төрийн далбаа, туг ба төрийн хэнгэрэг байв. Хааны өргөөнд төрийн далбаа, цэргийн туг мандаж байсан ба хааны хажууд залрах урт иштэй тугийг хариуцсан тугчин гэх албат байжээ. Тугчны хажууд ордны найрал хөгжимчид байнга дагалдан явах ба төрийн их хэнгэргийг тэд мөн дэлдэж байжээ. Далбаа, туг болон хэнгэргийг хамгаалах, зөөвөрлөх ажлыг хариуцсан цэргийн тусгай анги мөн байжээ.⁷⁰

Төрийн бэлгэ тэмдэг болсон төрийн далбаа, туг, хэнгэрэг нь зөвхөн хааны мэдэлд байгаагүй. Эл хааны зүгээс төрийн, эсхүл шашны албан тушаалд томилогдсон түшмэлд тухайн үеийн төрийн хүндэтгэлийн ёс журмын дагуу албанд томилогдсон тухай хааны зарлигийн хамт туг, бөмбөрийг илгээдэг байжээ. Мөн Эл хаант улсын хааны зараалаар гадаад орон руу явж байсан элч нар мөн энэ эрхийг эдэлдэг байжээ.

1.2.5.Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын төрийн сүлд

1911 оны эцсээр Манж Чин улсаас тусгаар тогтнолоо сэргээсэн Монгол Улс байгуулагдсаны дараа төрийн ёс, ёслолыг цэгцэлж журамлахдаа үндэсний уламжлалт соёлыг тусгасан төрийн бэлгэ тэмдэг хэрэглэх болсон. Тусгаар Монгол Улсын төрийн албан ёсны бэлгэ тэмдэг нь Өндөр гэгээн Занабазарын зохиосон Соёмбо үсгийн эхэнд байрлах титэм үсгийг төрийн сүлд болгож, түүнийг улсын туг, төрийн тамганы голд байрлуулан дээдлэх болсон.⁷¹



⁶⁸ Гантулга Ц., Бямбасүрэн Г. Монгол төрийн үүсэл, ёс ёслол, бэлгэдэл, хүндэтгэл, уламжлал. УБ., 2011 он. 93 дахь тал

⁶⁹ Мөн тэнд. 72 дахь тал.

⁷⁰ Мөн тэнд. 136 дахь тал.

⁷¹ Сэндэнхорол Б. Төрийн бэлгэ тэмдгийн уламжлал, шинэчлэл, хэрэглэх журам, түүний эрх зүйн зарим асуудал. УБ., 2012 он. 5, 6 дахь талууд.

Соёмбын дүрслэлд Монголын эртний сүлд болох нар, сар, галын дүрс хийгээд сав шим ертөнц, орон, цаг, хүн амьтан, төр улс, арга билгийн гүн утга бэлгэдэл шингэсэн байдаг.

Тухайлбал, Соёмбын хамгийн дээд хэсэгт байгаа гал нь айл өрх, улс хотлоороо өнгөрсөн, одоо, ирээдүйд үүрд мандан бадрахыг, нар, сар нь Монголын ард түмэн мөнхөд цэцэглэн хөгжих, гурвалжин нь сум мэт хурц, эрэмгий байхыг, загас нь өнөр өтгөн, сонор соргогийг, хажуугийн босоо шугам нь хэрэм мэт бат байхыг бэлгэджээ. Соёмбын “Э, бам” үсэг нь арга, билиг хослохыг, бадам язгуурын төр шашнаа ариунаар мандуулахыг бэлгэдсэн утгатай. Энэ мэтчилэн төрийн сүлд нь Монгол Улс өнөд эрх чөлөөт, тусгаар улс байхыг бэлгэдсэн улс төрийн гүн агуулгатай аж. Шашин, төрийг хослон барьсан хаант төртэй Монгол Улсын төрийн бэлгэ тэмдэг нь төрийн болон шашны зан заншлыг хослон илтгэсэн эрхэмсэг оршихуйн бэлгэдэл байв.⁷²

1.2.6. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн сүлднүүд

1924 оны сүлд тэмдэг

1921 оны Ардын хувьсгалын үр дүнд байгуулагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улс нь (БНМАУ) 1924 онд Өндөр гэгээн Занабазарын зохиосон Соёмбо үсгийг “улсын сүлд тэмдэг”-ээ болгосон. Улсын сүлд тэмдгийг БНМАУ-ын далбаа, төрийн тамганы голд байрлуулж, тусгаар улсын бэлгэ тэмдэг болгон дээдэлсэн байна.

1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Их Хурлаас баталсан анхдугаар Үндсэн хуулийн 6 дугаар бүлэгт БНМАУ-ын төрийн шинэ бэлгэ тэмдэг болох улсын сүлд тэмдэг, далбаа, төрийн тамга гурвыг анх удаа хуульчилсан байв.

Үндсэн хуулийн 48 дугаар зүйлд “Улсын сүлд тэмдэгт дээр дурдсан соёмбо үсэг, түүний доод этгээдэд бадамлянхуа цэцгийн зураг бүхий сүлд тэмдэг хэрэглэн явуулбал зохино.” гэж заасан байна.

БНМАУ 1924-1940 оны хооронд 16 жил уламжлалт Соёмбо тэмдгийг сүлдээ болгон хэрэглэж байсан.



1940 оны сүлд тэмдэг

1940 оны 06 дугаар сарын 30-ны өдөр БНМАУ-ын VIII Их хурлаас баталсан шинэ Үндсэн хуулиараа “Хөдөлмөрчдийн тусгаар тогтносон улс” болж, “сүлд тэмдэг”-ээ шинэчилсэн байна.

Шинэ сүлд тэмдэг нь тухайн үеийн бодлого, үзэл суртлын нөлөөнөөс ангид байгаагүй ч эх орон, эдийн засаг, хүн ардаа төлөөлүүлэн дүрсэлж, улс орноо богино хугацаанд хөгжүүлэх, үргэлжид оршихын бэлгэдлийг илэрхийлсэн байв. Ийнхүү Соёмбо үсэг өөрчлөгдөж, социализм, коммунизмын зүг тэмүүлсэн үзэл санаа бүхий шинэ сүлд тэмдэгтэй болсон юм.⁷³

⁷² Гантулга Ц., Бямбасүрэн Г. Монгол төрийн үүсэл, ёс ёслол, бэлгэдэл, хүндэтгэл, уламжлал. УБ., 2011 он. 192, 195 дахь талууд.

⁷³ Мөн тэнд. 232 дахь тал.

БНМАУ-ЫН ҮНДСЭН ХУУЛЬ
(1940 оны 06 дугаар сарын 30-ны өдөр)

Ерэн хоёрдугаар зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын сүлд тэмдэг бол дугуй хэлбэртэй, дунд нь Монгол Улсын хангай, тал, говь нутаг дээр нарны зүг уурга бариад давхиж яваа морьтой ард байх ба дугуйн хөвөөгөөр өвс ногооны дээр хонь, үхэр, тэмээ, ямааны толгойг хоёр талд зурж, дугуйн дээд талыг дан алхан хээгээр хүрээлэн, дунд таван хошуу тэмдэг байна. Өвс ногооны доод уулзварт улаан лент дээр “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” хэмээсэн байна.

Эх сурвалж: Амарсанаа Ж., Энхжин Ц. Монгол Улсын төрийн бэлгэ тэмдэг. УБ., 2014 он. 14 дэх тал.

Энэхүү сүлд тэмдгийг тухайн үеийн нам, засгийн бодлогын дагуу хийсэн аж. Өөрөөр хэлбэл, сүлд тэмдгийн илэрхийлэх гол санаа нь Монгол Улсын малын тоо толгойг 200 саяд хүргэх зорилго, төлөвлөгөөний дагуу хийгдэж байжээ. (Ардын зураач Н.Цүлтэмийн АИХ-ын хуралдаанд хэлсэн үгнээс)




1940 оны БНМАУ-ын сүлд тэмдэг



1945 оны БНМАУ-ын төрийн сүлд

Тус сүлд тэмдгийг 20 жил хэрэглэхдээ түүнд нэг удаа өөрчлөлт орсон байна. Энэ нь манай улс монгол бичгээс шинэ буюу кирилл үсэгт шилжсэнтэй холбоотойгоор БНМАУ-ын Ардын Их Хурал (АИХ)-ын Тэргүүлэгчдийн 1945 оны 79 дүгээр зарлигаар хуучин үсгээр “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” гэж бичсэн байсныг шинэ үсгээр товчлон “БНМАУ” гэж өөрчилжээ.

Нэр томъёоны хувьд 1940 онд батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуульд “сүлд тэмдэг” гэж томъёолсон бол 1945 онд батлагдсан АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигт “Төрийн сүлд” гэж өөрчилсөн байна.



БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРЛИГ1945 оны 08 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 79

Улаанбаатар
хот**БНМАУ-ын Төрийн сүлдний доод талын лент дээр
манай улсын нэр монгол хуучин үсгээр
бичигдсэнийг шинэ үсэг болгон өөрчлөх тухай**

Б.Н.М.А.Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Төрийн сүлдний доод талын лент дээр манай улсын нэр монгол хуучин үсгээр бичигдсэнийг шинэ үсгээр товчлон “БНМАУ” гэж өөрчилсүгэй.

Б.Н.М.А.УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА

САМБУУ

Б.Н.М.А.УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ШАРАВ

*Эх сурвалж: Амарсанаа Ж., Энхжин Ц. Монгол
Улсын төрийн бэлэг тэмдэг. УБ., 2014 он. 38 дахь
тал.***1960 оны төрийн сүлд**

БНМАУ 1960 онд батлагдсан Үндсэн хуулиараа “социалист улс” болж, энэхүү чиг баримжааныхаа дагуу Төрийн сүлдээ дахин шинэчилжээ. Төрийн сүлд нь тариан түрүүгээр хөвөөлсөн дугуй хэлбэртэй болсон нь тухайн үеийн социалист орнуудын төрийн сүлдэнд түгээмэл дүрслэгдэж байв.

Шинэ төрийн сүлдний магнайд алтан Соёмбо үсэг бүхий таван хошууг байрлуулсан нь онцлогтой.

Энэхүү сүлдийг 1992 он хүртэл 32 жил хэрэглэсэн байна.



Үндсэн хуульд заасны дагуу БНМАУ-ын төрийн сүлд бол тухайн үеийн төрийн мөн чанар, улс түмний найрамдлын үзлийг илэрхийлэн, манай орны үндэсний болон эдийн засгийн онцлогийг үзүүлжээ.

БНМАУ-ЫН ҮНДСЭН ХУУЛЬ
(1960 оны 07 дугаар сарын 06-ны өдөр)

Ер дүгээр зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн сүлд бол төрийн мөн чанар, улс түмний найрамдлын үзлийг илэрхийлэн, тус орны үндэсний болон эдийн засгийн онцлогийг үзүүлсэн байна.

БНМАУ-ын сүлд бол тариан түрүүгээр хөвөөлсөн дугуй хэлбэртэй байна. Тарианы ишийг хүрд араагаар холбож, эдгээрийг “БНМАУ” гэсэн үсэг бүхий улаан, цэнхэр өнгийн туузаар ороож зангидсан байна.

Сүлдний төвд БНМАУ-ын хангай, говь, тал хосолсон нутгаар мандах коммунизмын наран өөд хурдалж яваа морь унасан хөдөлмөрчин хүн зурсан байна.

Сүлдний магнайд тариан түрүүний хоёр үзүүрийн хооронд дундаа алтан соёмбо үсэг бүхий таван хошуу байна.

*Эх сурвалж: Амарсанаа Ж., Энхжин Ц. Монгол
Улсын төрийн бэлэг тэмдэг. УБ., 2014 он. 20 дахь
тал.*

Энэхүү сүлд тэмдгийн илэрхийлэх гол санаа нь тухайн үед Монгол орныг хөдөө аж ахуй-үйлдвэрлэлийн орон болгох гэсэн нам, засгийн бодлогын дагуу хийгдэж байжээ. (Ардын зураач Н.Цүлтэмийн АИХ-ын хуралдаанд хэлсэн үгнээс)

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1988 оны 107 дугаар зарлигаар БНМАУ-ын Төрийн бэлгэ тэмдгийн тухай дүрмийг баталжээ. Уг дүрмийн дагуу Төрийн сүлд нь “БНМАУ-ын социалист төрийн мөн чанар тусгаар тогтносон бүрэн эрхт байдал, тухайн үеийн Монгол ардын хувьсгалт нам (МАХН)-ын удирдан чиглүүлэх роль, ажилчин анги, хоршоолсон ард/малчид, тариаланчид/хөдөлмөрч сэхээтний бат холбоо, социалист нийгэм цогцлон байгуулж байгаа Монголын ард түмний эрхэм дээд хүсэл эрмэлзэл, улс түмний энх тайван, найрамдлын үзэл санааг илэрхийлнэ.”

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРЛИГ

1988 оны 07 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 107

Улаанбаатар
хот

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Төрийн бэлгэ тэмдгийн тухай дүрэм

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.БНМАУ-ын Төрийн сүлд, Төрийн далбаа, Төрийн дуулал нь БНМАУ-ын Төрийн бэлгэ тэмдэг юм.

БНМАУ-ын Төрийн сүлд, Төрийн далбаа, Төрийн дуулал нь БНМАУ-ын социалист төрийн мөн чанар тусгаар тогтносон бүрэн эрхт байдал, МАХН-ын удирдан чиглүүлэх роль, ажилчин анги, хоршоолсон ард/малчид, тариаланчид/хөдөлмөрч сэхээтний бат холбоо, социалист нийгэм цогцлон байгуулж байгаа Монголын ард түмний эрхэм дээд хүсэл эрмэлзэл, улс түмний энхтайван, найрамдлын үзэл санааг илэрхийлнэ.

2.БНМАУ-ын Төрийн сүлдийг дүрслэх, байрлуулах, Төрийн далбааг дүрслэх, мандуулах, Төрийн дууллыг эгшиглүүлэх журмыг энэ дүрмээр тогтооно.

3.Улс, хоршоолол, олон нийтийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан БНМАУ-ын Төрийн сүлдийг дүрслэх, мандуулах, Төрийн дууллыг эгшиглүүлэхэд энэ дүрмийн заалтыг нарийн чанд сахин биелүүлбэл зохино.

4.БНМАУ-ын Төрийн бэлгэ тэмдгүүдийг нандигнан эрхэмлэж гүнээ хүндэтгэх нь БНМАУ-ын иргэн бүрийн эх оронч журамт үүрэг мөн.

ХОЁР. БНМАУ-ын Төрийн сүлд

5.БНМАУ-ын Үндсэн хуульд заасан ёсоор БНМАУ-ын Төрийн сүлд бол төрийн мөн чанар, улс, түмний найрамдлын үзэл санааг илэрхийлэн, тус үндэсний болон эдийн засгийн онцлогийг үзүүлсэн байна.

БНМАУ-ын Төрийн сүлд нь тариан түрүүгээр хөвөөлсөн дугуй хэлбэртэй байх бөгөөд тарианы ишийг хүрд араагаар холбож, эдгээрийг “БНМАУ” гэсэн үсэг бүхий улаан, цэнхэр өнгийн туузаар ороож зангидсан байна.

Төрийн сүлдний төвд БНМАУ-ын хангай, говь, тал хосолсон нутгаар мандах коммунизмын наран өөд хурдалж яваа морь унасан хөдөлмөрчин хүн зурсан байна.

Төрийн сүлдний магнайд тариан түрүүний хоёр үзүүрийн хооронд дундаа алтан соёмбо үсэг бүхий таван хошуу байна.

6.Төрийн сүлдийг өнгө ялгах буюу ялгахгүйгээр дүрсэлж болно. БНМАУ-ын Төрийн сүлдний өнгө ялгасан дүрслэлд морь унасан хөдөлмөрчин хүн, хүрд араа, уулын мөнх цас цагаан, нар, түүний цацраг, тариан түрүү, соёмбо болон “БНМАУ” гэсэн үсэг, таван хошууны хүрээ алтан шар, таван хошуу улаан, тэнгэр цэнхэр, уул хөх, мод хар ногоон, тал ногоон, говь шар, тууз нь БНМАУ-ын Төрийн далбааны өнгөтэй байна.

Эх сурвалж: Амарсанаа Ж., Энхжин Ц. Монгол Улсын төрийн бэлгэ тэмдэг. УБ., 2014 он. 51 дэх тал.

1.2.7. Монгол Улсын Төрийн сүлд

Нэг нам дангаар ноёрхсон улс төрийн дэглэмийг халж, олон намын тогтолцоо, олон ургалч үзлийг хүлээн зөвшөөрсөн зарчмын цоо шинэ өөрчлөлтийг⁷⁴ авчирсан ардчилсан хувьсгалын үр дүнд 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийг баталсан.

Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдгийн талаар тусгасан.



Үндсэн хуульд Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлэхийг заасан.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ
(1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр)

Арван хоёрдугаар зүйл.

1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.

2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.

3. Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

7. Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар бататгана.

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
– <https://legalinfo.mn/mn/detail/367>

Шинэ Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн үеэр АИХ-ын 396 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурал (УБХ)-ын нарийн бичгийн дарга Б.Чимид Төрийн сүлдний талаар ийнхүү ярьж байсан нь АИХ-ын хуралдааны тэмдэглэлд үлдсэн байна: “...ард түмний элчийн хувьд тангараг өргөнө гэдэг бол төрд биш Төрийн сүлдэнд өргөж байгаа юм. Төрийнхөө бэлгэ тэмдэг гэж хэлж байгаа энэ үед хоёр янзаар авч үзэж байна. Төрийн шүтээн гэдэг маягаар үзэж байгаа. Тийм учраас тэр утгаар Төрийн сүлдэндээ өргөхөөр хийсэн. Өөрөөр хэлбэл, төр ёсыг хүндэтгэсэнээ үзүүлж байна...”

Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх талаар бие даасан хууль 1994 онд батлагдсан. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн зорилт нь Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэгжүүлэх журам болон Төрийн дууллыг хуульчлан бататгахад оршино. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал байна.

⁷⁴ Чимид Б. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008 он. 38 дахь тал.

ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

(1994 оны 5 дугаар сарын 20-ны өдөр)

4 дүгээр зүйл. Төрийн сүлд

Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугираг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

5 дугаар зүйл. Төрийн сүлдийг үйлдэх, дүрслэх

1.Төрийн сүлдийг өнгө ялгах буюу ялгахгүйгээр үйлдэж дүрсэлж болно.

2.Төрийн сүлдийг өнгө ялган үйлдэх буюу дүрслэхэд соёмбо, эрдэнийн хүлэг, түмэн насан хээ, хүрд нь алтан шар, тэнгэр нь хөх, уулан хээ нь тодоос шингэрээж гурваар дагнасан ногоон, бадам цэцэг нь алтан шар өнгийн хүрээтэй цагаан, хадаг нь алтан шар утсаар хүрээлсэн цэнхэр, чандмань эрдэнэ нь ногоон, улаан, хөх өнгийг дөрвөөр дагнаж алтан шар өнгийн зураасаар хүрээлсэн байна. Төрийн сүлдний чандмань эрдэнэ, түмэн насан хээ, бадам цэцэг нь элгэн хүрэн дэвсгэр дээр байрлана.

3.Төрийн сүлдийг үйлдэх, дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран Үндсэн хуульд хавсаргасан эх загварт заасан тэг, харьцааг чанд баримтална.

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
– <https://legalinfo.mn/mn/detail/367>

1.3.1992 оны Үндсэн хуулийг хэлэлцэх үед төрийн сүлдний талаар иргэд, АИХ-ын депутатуудаас гарч байсан саналын тойм

Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийг боловсруулах, хэлэлцэх явцад манай улсын тусгаар тогтнол, бүрэн эрхийн бэлгэ тэмдэг болсон төрийн сүлдийг өөрчлөх эсэх талаар ард иргэд, АИХ-ын депутатууд, уран бүтээлчид “хамтынхаа оюун ухаанаар улсынхаа зан заншил, түүх, соёл, бэлгэ дэмбэрлийг нь бодож одоо, ирээдүй энэ цагаа харьцуулан үзэж” (АИХ-ын 71 дүгээр тойргийн депутат Т.Ядамсүрэнгийн АИХ-ын хуралдаанд хэлсэн үгнээс) сайтар хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Энэ үеэр АИХ-д төрийн бэлгэ тэмдгийн асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллуулж, үүнд 200 орчим зураач, уран бүтээлчид янз бүрийн мэргэжлийн хүмүүс албан ёсоор оролцож, мэргэжлийн урлагийн байгууллагуудаас төрийн сүлдний загвар зохиох уралдаан зарлаж, шилдэг бүтээлүүдээр нь Төрийн ордонд үзэсгэлэн гаргаж байжээ.

Төрийн сүлдний загварыг бүтээх гэж олон уран бүтээлчид ухаанаа зарсны дотроос зураач Ц.Ойдовын бүтээл шалгарчээ.⁷⁵

1.3.1.Иргэдээс ирүүлсэн саналын талаар

Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн үеэр зөвхөн төрийн бэлгэ тэмдэгтэй холбоотой асуудлаар иргэдээс давхардсан тоогоор 1000 гаруй захидал, бичиг, зөвлөмж, санал, хүсэлт, шүүмжлэл иржээ. Иргэд өөрсдийн зохиосон төрийн сүлд, тамга, туг, далбааны зургийг болон төрийн дууллын үгийг ирүүлэх, биеэрээ авчрах, мөн утас, цахилгаанаар зөвлөх, саналаа илэрхийлэх, шүүмжлэн сайжруулах, амжилт ерөөж хүсэх зэрэг олон хэлбэрээр идэвхтэй оролцжээ.

⁷⁵ Болортуяа Б. Төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ., 2013 он. 9 дэх тал.

Иргэдийн зөвлөмж, санал, хүсэлт, шүүмжлэлийг АИХ-ын хуралдаанд багцлан танилцуулж байснаас үзэхэд, улсын нэр, үндсэн хуулийн нэр, төрийн сүлд, далбаа, дууллыг хэвээр нь үлдээх санал нэлээдгүй гарч байжээ. Ийм саналтай иргэдийн үзэж байгаагаар 1960 оны Төрийн сүлд нь Монгол Улсыг болон монголчуудын ахуй, хүсэл зоригийг илэрхийлж чадсан, олон нийтийн санаа сэтгэлд нийцсэн, олон улсад танигдсан бөгөөд шинэ төрийн сүлд баталсан тохиолдолд улсын хилийн бүх шонг өөрчлөхөөс эхлээд их хэмжээний зардал гарна гэж байжээ. Үүнээс гадна Төрийн сүлдийг хэвээр үлдээж, Үндсэн хууль дахь зөвхөн түүний тайлбарыг өөрчлөх саналыг иргэдээс гаргаж байжээ.

Төрийн сүлдийг өөрчлөх саналтай иргэдийн зүгээс дараах өөрчлөлтүүдийг санал болгож байв. Үүнд:

- гал, нар, сар гурваа дээдэлсэн алтан соёмбыг дүрслэх;
- 1960 оны төрийн сүлдний морийг үлдээж, бусад элементүүдийг өөрчлөх;
- 1960 оны төрийн сүлдний таван хошуу малыг үлдээх;
- моринд хоёр жигүүр нэмэх;
- хүн, морь, гал, нар, сарыг оруулах;
- соёмбо үсэг, морио хийсвэр маягаар өөрчлөн дүрслэх;
- Чингисийн цагаан шонхор шувууг цэлмэг тэнгэрт мандуулах;
- шувууг дүрслэх;
- арсланг дүрслэх;
- монгол хоточ нохойг дүрслэх;
- Монголын байгалийг дүрслэх зэрэг санал гарчээ.

Үүний зэрэгцээ Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс “Улс орны амьдрал, олон түмний санаа бодолд” сэдэвт тухайн үеийн нийгмийн санаа бодлын төлөв байдлын судалгааг 1991 оны 04, 09 дүгээр саруудад хийсэн байна. Эхний судалгаанд Улаанбаатар, Дархан, Говь-Алтай, Хэнтий, Өмнөговь, Өвөрхангай аймгийн 12 сум, 100 гаруй байгууллагын 1300 хүн⁷⁶, хоёр дахь судалгаанд Улаанбаатар, Архангай, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар аймгийн 11 сум, 100 гаруй байгууллагын 1118 хүн⁷⁷ тус тус хамрагджээ.

Энэхүү социологийн судалгаанд оролцогчдын 55-72 хувь нь улсын нэр, төрийн сүлд, далбааг хуучин хэвээр нь байлгах, 12-29 хувь нь өөрчлөх саналтай байжээ.

Хүснэгт. Улсын нэр, төрийн сүлд, далбааг өөрчлөх эсэх талаарх санал, хувиар

№	Үзүүлэлт	1991.04 сард			1991.09 сард		
		Өөрчлөх хэрэгтэй	Өөрчлөх хэрэггүй	Мэдэхгүй	Өөрчлөх хэрэгтэй	Өөрчлөх хэрэггүй	Мэдэхгүй
1	Улсын нэр	16.6	72.5	9.6	12.8	72.0	14.8
2	Төрийн сүлд	29.5	55.1	14.2	16.5	63.9	19.3
3	Төрийн далбаа	21.8	60.4	16.5	13.6	66.0	20.0

Эх сурвалж: Уртнасан Ц., Сарантуяа О. Улс орны амьдрал олон түмний санаа бодолд. Социологийн цуврал судалгааны тайлангийн эмхэтгэл. УБ., 2007 он. 48 дахь тал.

⁷⁶ Уртнасан Ц., Сарантуяа О. Улс орны амьдрал олон түмний санаа бодолд. Социологийн цуврал судалгааны тайлангийн эмхэтгэл. УБ., 2007 он. 7 дахь тал.

⁷⁷ Мөн тэнд. 31 дэх тал.

АИХ-ын 1991 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд БНМАУ-ын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлын зохион байгуулах комиссын дарга П.Очирбат “Монгол Улсын Их цааз (Үндсэн хууль)-ын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай” илтгэлийг тавьсан байна. Уг илтгэлийн “Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн”-гийн төрийн сүлдтэй холбоотой асуудлыг энд эшлэн авлаа:

“...Монгол Улсын Их цааз (Үндсэн хууль)-ын төслийг 1991 оны 06 дугаар сарын 10-наас 1991 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд ард нийтээр хэлэлцүүлж дүгнэсэн бөгөөд төслийн талаар манай иргэд өөрсдийн санал бодлоо одоо ч хүртэл ирүүлсээр байна... Бүхэлд нь үзвэл, төслийг нийт 7 мянга гаруй байгууллага, хамт олон хурлаараа хэлэлцэж, түүнд 900 мянга гаруй хүн оролцож, давхардсан тоогоор 200 мянга гаруй санал гарсан байна. Эдгээр саналыг яам, тусгай газар, нам олон нийтийн болон эрдэм шинжилгээний байгууллагууд, аймаг, хотын гүйцэтгэх захиргаанд шүүж үзээд, яам, газар байгууллага, орон нутгийн хэмжээнд шийдвэрлэх асуудлыг түүгээрээ ярилцаж, төсөлтэй шууд холбогдох 8000 гаруй саналыг түүвэрлэж комисст ирүүлсэн... Түүнчлэн комисст 1200-гаад хүн саналаа бичиж ирүүлсэн. Комисс хөдөлмөрчдөөс ирүүлсэн саналыг судлан боловсруулж, төсөлд тусгах, төслийг найруулан засах үүрэг бүхий эрдэмтэн, мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын 11 хэсэг байгуулан ажиллууллаа...”

Хэлэлцүүлгийн явцад гарсан саналыг төслийн бүлэг, тус бүрээр авч үзвэл, 1,5 хувь нь удиртгал хэсгийн талаар, **26.4 хувь Нэгдүгээр бүлгийн талаар**, 21.1 хувь нь Хоёрдугаар бүлгийн талаар, 40.8 хувь нь Гуравдугаар бүлгийн талаар, 8.8 хувь нь Дөрөвдүгээр бүлгийн талаар, 1.4 хувь нь Тавдугаар бүлэгтэй холбогдсон санал байна. Эдгээр бүх саналыг цахим тоолуурт оруулж, бусад хуультай эрх зүй, улс төр судлалын үүднээс харьцуулан дүгнэлт хийж үзээд, 44.3 хувийг төсөлд ямар нэгэн хэлбэрээр тусгалаа.

...төрийн бэлгэ тэмдгийн талаар олон санал ирсэн байна. Тэдгээрийн нэлээд хэсэг нь одоогийн сүлд, далбааг хэвээр үлдээх, нөгөө нь сүлдийг соёмбо болгож, далбааг хөх өнгөтэй болгож өөрчлөх, гурав дахь нь 1960 оноос өмнөх уламжлалыг сэргээхийг санал болгожээ.” гэсэн байна.

1.3.2. АИХ-ын депутатуудаас гарсан саналын талаар

АИХ-ын депутатуудын дунд ч төрийн сүлдээ өөрчлөх эсэх талаар олон санал гарч, нэлээдгүй хэлэлцэж байж нэгдсэн саналд хүрч байжээ. Гарсан саналуудыг тоймлон үзье.

- *Төрийн сүлдээ өөрчлөх шаардлагагүй гэсэн саналтай зарим депутатуудын АИХ-ын хуралдаанд хэлсэн үгнээс:*

Н.Төмөртогоо (422 дугаар тойргийн депутат): “...Манай хөдөө орон нутгийн ард түмэн, манай хөдөлмөрчид бол төрийнхөө сүлдэнд залбирч байдаг...”

Д.Жагварал (104-р тойргийн депутат): “...Монголчууд бурхнаасаа салангуут төрийнхөө сүлдийг түшиж авсан нь үнэн юмаа. Түмэн олны минь амьдралаа даатгасан байгаа ийм сүлд ээ. Өдрийн од шиг ганц сансрын нисэгч минь эх орон дээгүүрээ явахад ээж, аавтай нь цуг алтан соёмбот туг нь даллаж байсныг бодоход, үүнд үнэхээр хайр нь шингэсэн байгаа юм. Өнөөдөр үүнийгээ солино гэхэд эд нөхөд ч гэсэн нэгийг бодож суугаа байх аа гэж бодож байна. Ийм учраас төрийн минь сүлд рүү хамаагүй дайрвал амиа хорлоно гэж 10 хүн мэдэгдсэн явдал ч бидэнд бас нэгийг бодогдуулж байгаа юм. Их цаазын төсөлд Монгол Улсад засгийн бүх эрхийг ард түмэн мэднэ гэж заасан байна. Үнэхээр түүний баталгаа энэ сүлдэнд байж байгаа нь харагдаж байгаа юм. Иймд ардаа хүндэлсэн төрийн минь сүлд бат оршихын үндэс энэ болох болов уу гэж бодож байна. Сүлдэндээ мөнхөрсөн ард түмэн минь

төрийнхөө хуулийг дээдлэн сахихын тулд төрийн минь өлмий бат оршиж, мэлмий тунгалаг байхын өлзий хутаг орших болов уу гэж бодож байна...”

С.Рэнцэнбал (58 дугаар тойргийн депутат): “...Улсын нэр, хуулийн нэр, сүлд гурвыг хуучнаар нь үлдээх саналтай байна. Улс орны хэмжээнд улс нийгмийн маань гол баялаг мал сүрэг маань байсан, одоо ч байгаа, цаашдаа ч байх ийм нөхцөлд улс орон даяар бэлгэдэл болгон сүлдэндээ дээдэлсэн халуун хошуут молор эрдэнэ морьт сүлдээ монголчууд малаа бараагүй цагт солих ёсгүй гэдэг үзэл баримтлал дээр үнэхээр малчин ард маань бол хатуу зогсож санал бодлоо илэрхийлсээр байгааг өнөөдрийн Их Хурал анхаарахгүй өнгөрч болохгүй байхаа гэж үзэж байна...”

Д.Шагдар (398 дугаар тойргийн депутат): “...Манай улсын хэмжээн дээр гарах энэ төрийн сүлд, далбаа, соёмботой холбоотой ийм зардлууд миллиардаар яригдах байх гэж бодож байна...”

- *Төрийн сүлдээ өөрчлөх шаардлагатай гэсэн саналтай зарим депутатуудын АИХ-ын хуралдаанд хэлсэн үгнээс:*

Г.Баасанжав (57 дугаар тойргийн депутат) “...Сүлд, далбаа, тэмдгийг өөрчлөх шаардлага байна гэж үзэж байна. Энэ нь төрийн хуучин тогтолцооны үеэс шинэ тогтолцоонд шилжиж, нэг үгээр хэлбэл, бид хувьсгал хийж байна...”

Л.Лантуу (145 дугаар тойргийн депутат): “...Нэгэнт нийгмийн харилцаа үндсээрээ өөрчлөгдөж байгаа учраас бидний батлах гээд байгаа, хэлэлцэж байгаа энэ Үндсэн хууль бол ихээхэн хэмжээний өөрчлөлт орох нь зүй ёсны зүйл болов уу гэж бодож байна. Энд юуны өмнө эхлээд бидний анхаарах ёстой асуудал бол 4 асуудал байгаа гэж бодож байна: БНМАУ-ын нэр, сүлд, далбаа, үндсэн хуулийн нэр. Нэгэнт нийгмийн шинэ харилцаа бий болж байгаа учраас энэ дөрөвт ямар нэгэн өөрчлөлт орохгүйгээр бид энэ Үндсэн хуулийг баталж болохгүй гэж бодож байна...”

Д.Тангад (297 дугаар тойргийн депутат): “...Үндсэн хуулийн нэр, сүлдийг өөрчлөх бодит шаардлага л байна. Яагаад гэвэл нийгмийн тогтолцоо, нийгмийн чиглэл маань өөрчлөгдчихлөө...”

Ч.Хишигдалай (320 дугаар тойргийн депутат): “...Монгол Улсын сүлд, далбаа ямар ч байсан Монголын ард түмний түүхэн уламжлалыг нэг талаар тусгасан, нөгөө талаар монголчуудын хүсэл эрмэлзлийн бэлгэдлийг тусгасан байх гэж бодож байна. Үүнийг тусгаж чадвал сүлд, далбааны загвар үндсэн үүргээ биелүүлэх байхаа гэж бодож байна...”

- *Төрийн сүлдийг хэрхэн өөрчлөх тухай зарим депутатуудын АИХ-ын хуралдаанд хэлсэн үгнээс:*

Д.Маам (Улсын Бага Хурлын гишүүн): “...сүлдийг өөрчлөх бол чухам ямар учраас өөрчлөх, сүлдэнд Хүннүгийн үеэс юу тусгагдах, Чингисийн үеэс юу байх, соёмбо нь байх уу, үгүй юу, соёмбо байвал түүнийг эвдлэх үү, хэсэглэх үү, эсхүл бүтнээр нь авах уу зэрэг нарийн асуудлууд бий. Ийм учраас бид та бүхний дунд жижиг асуулга явуулна. Энэ бол тэр Академийн авсан асуулгаас өөр бөгөөд бас ач холбогдолтой. Баярлалаа.”

Г.Зуунай (143 дугаар тойргийн депутат): “...миний ярих юм бол төрийн бэлгэдлийн асуудлаар явуулсан социологийн судалгааны товч дүн... Социологийн асуулгад 400 орчим депутат орж, 270 хүн саналаа өгснийг нэгтгэсэн. Энэ дүнгээс үзвэл, депутатын 63 хувь нь төрийн сүлдний шинэ төсөл боловсруулах санал өгсөн байна. Одоо ирсэн материал дээр үндэслээд шинэ төсөл боловсруул гэсэн байна... Сүлдэнд багтах элементүүдийн тухайд бол депутатуудын 80 хувь нь **соёмбыг**, 75 хувь нь **морийг**, 70 хувь нь **галыг**, 52 хувь нь

нар, галыг оруулъя гэсэн байна. Сүлдэнд шувуу оруулахыг депутатуудын 1,4 хувь нь дэмжсэн байна... Төрийн далбааны тухайд бол цэнхэр өнгийг, цэнхэр өнгөтэй далбааг сонгож авах, голдоо соёмботой байх саналыг депутатуудын 95,5 хувь нь оруулсан байна... Өнгөний хувьд улаан өнгийг 51 хувь нь, цагаан өнгийг 35 хувь нь оруулах нь зүйтэй гэж санал хэлжээ. Төрийн дууллын тухайд бол түүнийг хуучин хэвээр байлгах санал илт давамгайлж байна, 68,9 хувь нь хамаарсан байна...”

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТӨРИЙН СҮЛДНҮҮД

2.1. Азийн орнууд

2.1.1. Вьетнам Улс

1955-1976 онд

XIX зуунд Вьетнам Улс нь Францын колони улс болсон, Японы эзлэн түрэмгийлэлд болон Энэтхэг-Хятадын дайнд өртсөн, хоёр хуваагдсан зэрэг ээдрээтэй түүхийг туулж байжээ. Иймээс тус улс нь төрийн сүлдийг 1955 оноос хойш албан ёсоор хэрэглэж эхэлсэн бөгөөд одоо 4 дэх төрийн сүлдээ хэрэглэж байна.

1954 оны 07 дугаар сарын 20-ны өдөр Вьетнамын тухай Женевийн конвенц батлагдсанаар тус улсын хойд хэсэгт Вьетнамын коммунист хувьсгалч Хо Ши Мин тэргүүтэй Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам Улсыг байгуулж, өмнөд хэсэгт Бүгд Найрамдах Вьетнам Улс (Өмнөд Вьетнам)-ыг тунхаглажээ. Энэ хоёр улс нь тус бүрдээ төрийн сүлдтэй байв.

*Бүгд Найрамдах Ардчилсан
Вьетнам Улсын төрийн сүлд*



1955-1976 он

Бүгд Найрамдах Вьетнам Улсын төрийн сүлднүүд



1957-1963 он



1967-1975 он

Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам Улсын хувьд 1955-1976 онд нэг төрийн сүлдтэй байсан бол Бүгд Найрамдах Вьетнам Улсын хувьд 1957, 1967 онд баталсан хоёр өөр төрийн сүлдтэй байв.

1976 оноос хойш

Хоёр Вьетнам дахин нэгдсэний дараа буюу 1976 оноос Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам Улсын төрийн сүлдийг уламжлуулан одоог хүртэл хэрэглэж байна.

1992 онд батлагдсан Вьетнам Улсын Үндсэн хуулийн 13.2-т⁷⁸ “Төрийн сүлд нь дугуй хэлбэртэй, улаан дэвсгэрийн голд цагаан будааны түрүүгээр хөвөөлсөн алтан таван хошуу, доор нь тал араа хүрд, “Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс” гэсэн бичээс байна.” гэж заасан байна.



⁷⁸ <https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/94490/114946/F114201808/VNM94490%20Eng.pdf>

Төрийн сүлдний төв хэсэгт дүрсэлсэн таван хошуу нь Вьетнамын Коммунист намаар удирдуулсан социалист дэглэм болон тус улсын ард түмний эв санааны нэгдэл, улс орны баатарлаг түүхийг дурсан санахын зэрэгцээ намын удирдлага дор нийгмийн гэрэлт ирээдүйг илэрхийлдэг.

Мөн хөдөө аж ахуйг бэлгэддэг цагаан будааны түрүүгээр хөвөөлсөн, аж үйлдвэрийг бэлгэддэг араа хүрд байрлуулсан нь Вьетнам Улсын хөгжлийн үйл явц дахь чухал хослолыг онцолжээ. Төрийн сүлдний доод хэсэгт “Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс” гэж вьетнам хэлээр бичсэн нь энэ үндэстний нэр, улс төрийн дэглэм юм. Шар өнгө нь Вьетнамын нийгмийн төлөөллийн өнгө аж.⁷⁹

2.1.2.Өмнөд Солонгос Улс

XX зуунд Өмнөд Солонгос Улс нь төр засгаа төвхнүүлэх, төрийн сүлдэнд өөрийн улсын онцлогийг тодруулах зэрэг шалтгаанаар төрийн сүлдээ өөрчилж байсан бөгөөд 1919 оноос хойш 4 лэх төрийн сүлд хэрэглэж байна.

1919-1948 онд

Японы эзлэн түрэмгийллийг эсэргүүцсэн тусгаар тогтнолын хөдөлгөөний үр дүнд 1919 онд Бүгд Найрамдах Солонгосын Түр засгийн газар байгуулагдсан байна.

Түр засгийн газрын албан ёсны баримт бичигт ашиглаж байсан төрийн сүлдийг энд харуулав.



1948-1963 онд

Анхны Бүгд Найрамдах Солонгос Улс 1948 оны 08 дугаар сарын 15-ний өдөр батлагдсан Үндсэн хуулиар төрийн сүлдээ шинэчилсэн байна.



1963-1997 онд

1960 оны 04 дүгээр сард тус улсын 1, 2, 3 дахь Ерөнхийлөгч Сингман Ри огцорч, Ардчилсан намын Хэо Жөнг шилжилтийн Засгийн газрыг байгуулсан байна.

Шилжилтийн Засгийн газар 1960 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газрын тэргүүн нь Ерөнхийлөгч, Парламент нь хоёр танхимтай Үндэсний Ассамблей байхаар тогтсон ба энэ нь хоёр дахь Солонгос Улс байгуулагдсан гэж үздэг байна.

1997 оноос хойш

1997 онд төрийн сүлдний зөвхөн өнгийг өөрчилжээ.

Тус улсын төрийн сүлдийг Нарамунжанг буюу Гукжан гэж нэрлэдэг. Төрийн сүлдний асуудлыг 1963 онд баталсан Төрийн сүлдний журам (Regulations on the National Emblem)-аар зохицуулдаг.



⁷⁹ <https://www.vietnamonline.com/culture/national-emblem.html>

Үндэсний бэлгэ тэмдэг болох төрийн сүлдний “Тэгеукги” бэлгэдэл “Мугунхва” цэцгийн таван дэлбээгээр хүрээлсэн бөгөөд бүхэлд нь БНСУ (대한민국) гэсэн бичигтэй туузаар хүрээлсэн байна.

Олон зууны турш Солонгосын соёлын бэлгэдэл “Мугунхва” цэцэг нь “хэзээ ч ганддаггүй мөнхийн цэцэг” гэсэн утгатай. Солонгосын ард түмний “Мугунхва” цэцгийг шүтэх сэтгэл Японы эзлэн түрэмгийллийн үед ч бүдгэрээгүй. Тийм ч учраас тусгаар тогтнолоо сэргээсний дараа тус улсын Засгийн газар энэхүү цэцгийг “үндэсний цэцэг” болгож, төрийн дуулалдаа энэхүү цэцгийн гоо сайхныг магтан дуулсан байдаг.

2.1.3.Хятад Улс

XX зуунд Хятад Улс нь улс төрийн нөхцөл байдлаас үүдэлтэйгээр төрийн сүлдээ өөрчилж байсан бөгөөд 1915 оноос хойш 4 дэх төрийн сүлдээ хэрэглэж байна. Энд хамрагдаагүй цаг хугацаанд тус улсад улс төрийн эмх замбараагүй байдал, Японы эзлэн түрэмгийлэл, иргэний дайн болж байжээ.

1915-1916 онд

1911 онд Үндэсний хувьсгал гарч, Манж Чин улсын ноёрхол дууссаны дараа Бүгд Найрамдах Хятад Улсын удирдагчид улсынхаа өөрчлөгдсөн нөхцөл байдлыг илэрхийлэх үндэсний шинэ бэлгэ тэмдэгтэй болох шаардлагатай гэж үзэн шинэ төрийн сүлд баталжээ. Энэхүү төрийн сүлдийг эзэн хаан Юан Шикайны хаанчлалын үед буюу 1915-1916 онд хэрэглэж байжээ.



1928 онд

Нанжингийн 10 жил гэгддэг Гоминданы үед Бүгд Найрамдах Хятад Улс нэг намын удирдлагад байсан. Тиймээс төрийн сүлдний цагаан нарыг намын бэлгэдэл бүхий Гоминданы хөх тэнгэрээр сольжээ.



1934 онд

Хятадын иргэний дайны эхэн үед 1931 оны 11 дүгээр сарын 07-ний өдөр Хятадын Коммунист намын ирээдүйн удирдагч Мао Зедун, генерал Жу Дэ нар Зөвлөлт Бүгд Найрамдах Хятад Улс (Chinese Soviet Republic)-ыг тунхаглаж, 1934 онд төрийн сүлдээ шинэчилжээ.



1950 оноос хойш

1949 онд тунхагласан Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын одоогийн төрийн сүлдийг 1950 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Ардын төв Засгийн газрын зөвлөлийн VIII хурлаар баталжээ.

Төрийн сүлдийг 1991 онд баталсан БНХАУ-ын төрийн сүлдний тухай хуулиар⁸⁰ зохицуулдаг. Хуулийн 2 дугаар зүйлд “БНХАУ-ын төрийн сүлд нь төв хэсэгтээ таван одоор гэрэлтэж, тарианы түрүү, араа хүрдээр хүрээлэгдсэн Тяньаньмэний хаалга дүрстэй байна.” гэж заажээ. Энэ хуулиар төрийн сүлдийг хэрэглэх, хориглох зүйлийн талаар болон төрийн сүлдний хэрэглээнд хяналт тавих асуудлыг зохицуулсан. Хуулийн хавсралтаар БНХАУ-ын төрийн сүлдний загварыг баталсан байна.



БНХАУ-ын төрийн сүлдний 5 ширхэг таван хошууны доор Тяньаньмэний хаалга байх бөгөөд тариан түрүүгээр хөвөөлсөн, доод талд нь араа хүрд (сogwheel) байдаг. Тариан түрүү, таван од, Тяньаньмэний хаалга болон араа хүрд нь алтан өнгөтэй, тойрог доторх талбай болон тойргийн доод хэсгийг чимэглэсэн тууз нь нь улаан өнгөтэй. Алтан шар болон улаан өнгө нь уламжлал ёсоор аз жаргал, сайн сайхныг бэлгэддэг.

1919 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Тяньаньмэний талбайд Хятадын шинэ ардчилсан хувьсгалын эхлэлийг тавьсан хөдөлгөөн эхэлсэн тул Тяньаньмэний хаалгыг орчин үеийн Хятадын бэлгэдэл гэж үздэг. Тяньаньмэний хаалга нь Хятадын ард түмний империализм ба феодализмын эсрэг тэмцлийн няцашгүй сэтгэлийг, араа хүрд, тариан түрүү нь ажилчин анги, тариачдыг төлөөлж, таван од нь Хятадын Коммунист намын удирдлага дор Хятадын ард түмний агуу эв нэгдлийг илэрхийлдэг.⁸¹

2.1.4. Шри Ланка Улс

XVI зуунаас эхлээд Цейлон буюу Шри Ланка Улс нь бусад орны колоничлолд байх хугацаанд зааныг, 1948 онд тусгаар тогтнолоо зарласнаас хойш буддын шашны уламжлалыг голчлон төрийн сүлдэндээ тусгаж байжээ.

XVI зуунд

Португалын далайчин Лоуренчо де Алмейда Цейлон арал (одоогийн Шри Ланка)-ыг нээсний дараа XVI зуунд португалчууд тус арлын эргийг эзэлжээ.

Тухайн үед тус улсын төрийн сүлдэнд урд талд нь заан, түүний эргэн тойронд нь далдуу мод, ард нь өндөр уулсыг дүрсэлсэн байв.



XVII зуунд

XVII зуунд португалчуудын оронд голландчууд Цейлон арлын эргийг эзэлсэн ч арлын ар тал нь тусгаар тогтнолоо хадгалж байжээ.

Энэ үеийн төрийн сүлд нь уул, далдуу мод, заан, шанцайн боодол болон хоёр жижиг бамбай бүхий арлын газарзүйн байршлыг дүрсэлсэн байв. Зааны урд дүрсэлсэн гурван боодол шанцай нь тэр үеийн экспортын гол бүтээгдэхүүн байсныг илэрхийлсэн. Заан нь арлын ажилд ашигладаг амьтан бөгөөд хүч чадлын бэлгэдэл юм.



⁸⁰ <http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/he122/>

⁸¹ http://english.www.gov.cn/archive/chinaabc/202012/31/content_WS5fede0a6c6d0f72576943057.html

1875-1948 онд

1796-1948 он хүртэл Британийн колони байсан бөгөөд энэ үед Их Британийн төрийн сүлдийг хамт ашигладаг байсан.

Британичууд 1795 оноос Цейлон арал дээр эрх мэдлээ тэлж эхэлсэн бөгөөд 1796 онд голландчууд эзэмшил газрыг бүрэн эзлэн авчээ. 1802 онд Британийн Цейлоныг Британийн эзэнт гүрний колони хэмээн зарласан байна. Харин 1815 онд тус арал дээрх сүүлчийн хаант улсыг эзлэн авснаар Цейлон арлын бүх нутаг дэвсгэр Британийн колони болжээ.

1954–1972 онд

1948 онд тусгаар тогтнолоо зарласны дараа буддын шашны уламжлалыг голчлон тусгасан шинэ төрийн сүлдтэй болжээ. Төрийн сүлдэнд тус улсын үндэсний цэцэг болох цэнхэр бадамлянхуа цэцгийн алтан дэлбээгээр хөвөөлсөн улаан хүрэн дэвсгэр дээр баруун урд сарвуудаа сэлэм барьсан эр зоригийг бэлгэдсэн алтан арслан дүрслэгдсэн, орой хэсэгт нь Цейлоны титмийг байрлуулсан байв.

**1972 оноос хойш**

1972 онд баталсан Үндсэн хуулиар тус улсыг “Бүгд Найрамдах Шри Ланка Улс” гэж нэрлэж, төрийн сүлдэнд өөрчлөлт оруулжээ. Өмнөх төрийн сүлдний гадуур нь цэцэглэн хөгжиж буйг илтгэх хилийг тойрсон будааны үр тариаг тойруулж дүрсэлсэн ба энэ бүгдийг үр тарианы уламжлалт вааран дээр байршуулсан байна. Ваарны хоёр талд нар, сарыг дүрсэлсэн байна. Төрийн сүлд нь буддын шашны тэргүүн байр суурь, шударга ёсыг бэлгэддэг.⁸²



Төрийн сүлдний төвд байрласан алтан арслан нь арлын уугуул оршин суугчдыг бэлгэддэг, мөн арслан “кастане” хэмээх сэлэм барьсан ба хоёулаа эр зоригийн бэлгэдэл аж.⁸³

1978 оны Үндсэн хуулиар тус улсын нэр “Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улс” болж өөрчлөгдсөн.

2.1.5. Энэтхэг Улс

Энэтхэг Улс нь XX зууны дунд үе хүртэл Британи, Португал болон Францын колони, хилийн чанад дахь нутаг дэвсгэр байсан. Урт удаан хугацааны эрх чөлөөний төлөөх тайван тэмцлийн үр дүнд 1945 онд Энэтхэг Улс тусгаар тогтнолоо олсон боловч шашны үзэл суртлын хагаралдаанаас үүдэн Энэтхэг болон Пакистан улс болж хоёр хэсэг хуваагджээ.

1950 онд хүчин төгөлдөр болсон Энэтхэг Улсын Үндсэн хуулиар тус улс нь парламентын засаглалтай улс болж, өнөөдрийг хүртэл төрийн сүлдэнд эртний Ашокагийн баганын дөрвөн арслан байдаг.

⁸² https://www.srilanka.org.tr/tourism_1-1975

⁸³ <https://tournavigator.pro>

Нийтийн тооллын өмнөх III зууны дунд үед эзэн хаан Ашока нь Будда Гаутама анх бурхны ном зааж байсан, буддын томоохон санг байгуулсан газрыг тэмдэглэхийн тулд Ашока баганыг босгожээ. Энэхүү баганын дөрвөн арсланг бие биедээ ойртсон бөгөөд титэмлэн “abacus” хавтан дээр зогсож байгаагаар дүрсэлсэн байдаг ба Энэтхэг Улсын төрийн сүлдэнд тэрхүү байдлаар нь оруулсан байна.



सत्यमेव जयते

Төрийн сүлдэнд ердөө гурван арслан харагдах бөгөөд дөрөв дэх арслан харагддаггүй. Дугуй нь “abacus” дээр үндэсний бэлгэ тэмдэг болох “chakras” буюу дугуй хүрдний хооронд морь, бухыг дүрсэлсэн байдаг (зураг дээр заан, арслан нь харагддаггүй). Төрийн сүлдний доод хэсэгт “Зөвхөн үнэн л ялна” гэж деванагари үсгээр бичсэн байна.⁸⁴

Бэлгэдлийн хувьд арслангууд нь улс орныхоо энх тайван, шударга ёс, хүлээцтэй байдлын төлөө тууштай байхыг, бух нь хөдөлмөрч, тууштай байдлыг, морь нь үнэнч, хурд, эрч хүчийг илэрхийлдэг байна.

Төрийн сүлдтэй холбоотой харилцааг Энэтхэг Улсын төрийн сүлдний тухай 2005 оны хуулиар⁸⁵ зохицуулдаг. Энэ хуулийн дагуу төрийн сүлдийг тус улсын Засгийн газар болон төрийн байгууллагууд ашиглах ба аливаа хувь хүн, хувийн байгууллага албан ёсны захидал харилцаанд ашиглахыг хориглодог байна.

2.2.Европын орнууд

2.2.1.Австри Улс⁸⁶

Австри Улсын одоогийн төрийн сүлдний бүргэд нь эртнээс уламжлагдаж ирсэн бөгөөд түүний дүр тэрх олон удаа өөрчлөгдөж байжээ.

1866-1915 онд

1848 онд хаан ширээнд суусан I Франц Иосиф нь хөрөнгөтний хувьсгалаар задран унахын ирмэгт байсан Австрийн эзэнт гүрнийг аварчээ. Тэрээр 68 жил хаан ширээнд суух хугацаандаа Австрийн эзэнт гүрнийг нэгтгэхийн зэрэгцээ Унгарын бослогыг даран Австри-Унгарын анхны эзэн хаан болжээ.

1866 онд I Франц Иосифийн баталсан Австрийн эзэнт гүрний төрийн сүлднүүд нь хоёр толгойтой, гурван титэмтэй бүргэд, хоёр сарвуунд илд, очирт таяг, бөмбөрцгийг, цээжинд Хабсбург, Бабенберг, Лоррейн сүлдийг дүрсэлсэн байв. Харин эзэнт гүрний төрийн дунд сүлдэнд түүний харьяа улсуудын сүлдийг нэмж дүрсэлжээ.



Төрийн бага сүлд



Төрийн дунд сүлд

⁸⁴ <https://www.indembhelsinki.gov.in/national-emblem.php>

⁸⁵ <https://legislative.gov.in/sites/default/files/A2005-50.pdf>

⁸⁶ https://austria-forum.org/af/Wissenssammlungen/Symbole/Ständestaat_Staatswappen

1915-1918 онд

Австри-Унгарын эзэнт гүрэн задрахын өмнө буюу 1915 онд шинэчилсэн эзэнт гүрний төрийн сүлд нь давхар тогтолцоог илэрхийлсэн, эв нэгдэл, тэнцвэртэй байдлыг бэлгэдсэн байв.

Төрийн сүлдний Хабсбург-Лоррейн сүлд нь уриа үг бүхий тууз болон алтан туузаар холбогдсон байгаа нь нэгэн цагт хоёр төрийг захирч байгааг илэрхийлжээ.

**1919-1934 онд**

Австри-Унгарын эзэнт гүрэн задарсны дараа буюу 1919 оны 05 дугаар сард Бүгд Найрамдах Герман-Австри Улсын төрийн сүлд, төрийн тамганы тухай хуулийг Үндэсний түр ассамблейгаас баталсан.

Төрийн сүлдээр нэг толгойтой хар бүргэдийг сонгосон ба түүний цээжин хэсэгт улаан, цагаан, улаан өнгийн бамбай байрлуулжээ. Бүргэдийн цээжин дээрх 2 өнгө бүхий бамбай нь нийгмийн хамгийн чухал анги болох ажилчин ангийн давхарга бүрийн хамтын ажиллагааг бэлгэдсэн юм. Бүргэдийн сарвуунд байгаа алх нь ажилчин ангийг, хадуур нь тариачин ангийг бэлгэддэг бөгөөд эдгээр нь коммунист нийгмийн алх, хадууртай ямар ч холбоо хамааралгүй хэмээн тэмдэглэсэн байдаг.



Харин бүргэдийн толгой дээрх титмийг хөрөнгөтний ангийг бэлгэдсэн гэдэг боловч 1924-1929 онд Австри Улсын 7 дахь канцлер байсан Рудолф Рамек “Энэ титэм нь хөрөнгөтнийг илэрхийлж байгаа тэмдэг бус үнэн хэрэгтээ Ардчиллын бэлгэ тэмдэг юм.” гэж тайлбарлаж байв.

1934-1938 онд

1930-аад оны эхээр дэлхийн эдийн засаг хямарч, Европт фашист хөдөлгөөнүүд гарч ирснээс үүдэн Австри Улсад улс төрийн ерөнхий байдал тогтворгүй болсон байв. 1933 онд канцлер Дольфус тус улсын Парламент, Засгийн газар өөрөө тарсныг зарлаж байжээ.

Анхдугаар Бүгд Найрамдах Улсын парламентын ардчилал ийнхүү төгсөж, 1933 оноос авторитар улс болсон байна. Энэхүү шинэ агуулгыг төрийн шинэ сүлдэнд илэрхийлэх болов.

Холбооны улсын үед (corporate statism, state corporatism) хар өнгийн хоёр толгойтой бүргэдийг төрийн сүлдэнд дахин залжээ. Ингэхдээ алх, хадуур, титмийг хассан байв.



1945-1984 онд

Нацист Германы эзлэн түрэмгийллээс чөлөөлөгдсөний дараа 1945 оны 05 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Хоёрдугаар Бүгд Найрамдах Австри Улс (БНАУ)-ын төрийн сүлд, өнгө, тамганы тухай хуульд зааснаар “төрийн сүлдэнд ажилчин ангийг бэлгэдэн алх, тариаланч түмнийг бэлгэдэн хадуур, хөрөнгөтөн иргэдийг бэлгэдэн бүргэдийн толгой дээр хана хэрэм мэт титмийг дүрсэлнэ” гэжээ.



1945 онд Австри Улс тусгаар тогтнол, төрөө сэргээн босгосны дурсгалд зориулан 1919 оны төрийн сүлдийг дахин залахдаа бүргэдийн хоёр сарвуунд тасарсан төмөр гинжийг нэмж оруулжээ.

1984 оноос хойш

1984 онд батлагдсан БНАУ-ын төрийн бэлгэ тэмдэг, төрийн сүлдний тухай холбооны хуулиар төрийн бэлгэ тэмдгүүд, тэр дундаа төрийн сүлдний дүрслэл, тэдгээрийг хэрэглэх эрх зүйн харилцаа илүү тодорхой болсон байна.

Тус улсын төрийн сүлдэн дээр дүрсэлсэн нэг толгойтой, улаан хэлтэй, хар өнгөтэй дүүлэн нисэх мэт бүргэд нь Австри Улсын бүрэн эрхт байдлыг бэлгэднэ. Бүргэд нь цээжинд нь мөнгөн болон улаан өнгийн бамбайтай, толгойд нь хана хэрэм мэт гурван үзүүрт титэмтэй, хоёр сарвуундаа тасарсан гинжтэй. Бүргэдийн баруун сарвуунд дотогш эргэсэн хадуурыг, зүүн сарвуунд алхыг дүрсэлсэн байдаг.⁸⁷

**2.2.2.Герман Улс⁸⁸**

Герман Улс нь төрийн сүлдээ тухайн цаг үеийн улс төрийн нөхцөл байдал, засаглал, нийгмийн байдлын өөрчлөлтөөс улбаалан хэд хэдэн удаа сольж байжээ.

962-1806 онд

Германы эзэнт гүрний хаад нь Герман, Ромыг хамтад нь захирдаг байсан учраас төрийн сүлдэндээ баруун, зүүн тийш харсан хоёр толгойтой бүргэдийг дүрсэлдэг байжээ. Харин Ром мөхсөний дараа буюу 1806 оноос тус улсын төрийн сүлдэнд хоёр толгойтой бүргэдийг дүрслэхээ болжээ.



УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

⁸⁷ <https://austria-forum.org/af/AEIOU/Wappen>

⁸⁸ <https://www.bpb.de/kurz-knapp/lexika/handwoerterbuch-politisches-system/202134/staatssymbole/>

1888-1918 онд

1848, 1849 оны Франкфуртын Үндэсний Ассамблей (Frankfurt National Assembly)-гаар Германы анхны Парламентыг байгуулсан бөгөөд хөрөнгөтний нийгэмгүй эзэнт гүрэн байгуулахыг эрмэлзэх болжээ. 1871 онд Германы эзэнт гүрнийг тунхаглаж, тус улсын төрийн сүлдэнд баруун тийш харсан бүргэдийг дүрсэлсэн байна.⁸⁹

1919-1928 онд⁹⁰

Ваймерын Бүгд Найрамдах Улсын үед ч нэг толгойтой бүргэдийг төрийн сүлдээр залж байжээ. Тухайн үеийн Ерөнхийлөгч Фридрих Райх 1919 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр тус улсын Засгийн газрын шийдвэрээр төрийн сүлдийг ийн өөрчилжээ.

Баруун тийш харсан, хэл, хошуу, хоёр хөл нь улаан өнгөтэй, далавчаа дэлгэсэн бүргэдийг төрийн сүлдээр тодруулсан байна.

**1933-1935 онд**

1933 онд байгуулагдсан Герман Улсын төрийн эрхэнд байсан нацистууд нэг толгойтой бүргэдийг өөрчилсөн ч өмнөх бүргэдийн хуучин дүр төрхийг хадгалсаар байсан. Төрийн сүлдний бүргэдийн далавчны өдийг 5, эсхүл 6 ширхэгтэйгээр, бүргэдийн толгойг баруун тийш харуулан дүрсэлж байв. Харин улс төрийн нам, эвслийн бэлгэ тэмдэг дээрх бүргэдийн толгойг зүүн тийш харуулан дүрсэлдэг байжээ.

**1935-1945 онд**

Герман Улсын Ерөнхийлөгч Паул фон Хиндбург нас барсны дараа Адолф Хитлер улсыг захирч эхэлсэн. Тэрээр засгийн эрхийг авснаас хойш 8 сарын дараа буюу 1935 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Германы ажилчдын үндэсний социалист намын бэлгэ тэмдгийг төрийн сүлд болгон ашиглах болжээ.



Тухайн үед төрийн сүлд болох бүргэдийн ерөнхий хэлбэр нь дайн, тулааныг илэрхийлсэн хэв маягтай байсан нь өмнөх үеийн төрийн сүлднээс ялгаатай байжээ.

1950 оноос хойш

Дэлхийн II дайнд ялагдсан Герман Улс нь хоёр хуваагдаж, баруун зүгт Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс (БНАГУ), зүүн зүгт Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ) байгуулагдсан.

УИ.МН
СУДАЛГААНЫ САН

⁸⁹ <https://www.bmi.bund.de/DE/themen/verfassung/staatliche-symbole/staatssymbole/staatssymbole-node.html>

⁹⁰ <https://www.bundestag.de/parlament/symbole/adler/>

Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс (БНАГУ)

1950-1953 оны БНАГУ буюу баруун Германы төрийн сүлдэнд ажилчид, тариачдыг илэрхийлдэг алх, тариан түрүүгээр хөвөөлсөн байв.

1953-1955 оны тус улсын төрийн сүлдэнд сэхээтнүүдийг илэрхийлдэг алтан луужин, төрийн далбааны гурван өнгөтэй туузыг нэмж оруулжээ.

1953 онд БНАГУ-ын сүлдэнд өөрчлөлт орсон ч ажилчин анги, социалист сэхээтнүүд, тариачдын эв нэгдлийг илэрхийлсэн хэвээр байв. Улаан буудайн алтан хэлхээгээр улаан дэвсгэрийг хөвөөлж, түүний дотор төв хэсэгт алтан алх, луужин хоёрыг байрлуулжээ. Улаан буудайн хэлхээг хар-улаан-алтан гэсэн үндэсний өнгөт туузаар ороосон байв. БНАГУ энэхүү сүлдийг хоёр Герман нэгдэх хүртэл буюу 1990 онд хүртэл хэрэглэжээ.



1950-1953 онд



1953-1955 онд



1955-1990 онд

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

ХБНГУ буюу зүүн Германы Ерөнхийлөгч асан Теодор Хойс 1950 онд Холбооны Засгийн газрын шийдвэрээр Ваймарын Бүгд Найрамдах Улсын төрийн сүлдийг Герман Улсын төрийн сүлдээр дахин залжээ.

Тус улсын одоогийн төрийн сүлд төдийгүй далбаа, дуулал хүртэл XIX зуунаас эхлэлтэй хэмээн “Германчуудын дуун 1841” (“Lied der Deutschen”) номонд дурдсан байна.



Тус улсын төрийн сүлд нь алтан шаргал өнгийн бамбайн дээр далавчаа дэлгэсэн, битүү өдтэй, баруун тийш харсан хар өнгийн бүргэдийг дүрсэлсэн байдаг. Бүргэдийн хошуу, хэл, сарвуу улаан өнгөтэй байдаг.

ХБНГУ-ын төрийн бэлгэ тэмдэг нь эрх чөлөөт ардчилсан уламжлалыг илэрхийлдэг бөгөөд ард түмэн болон төрийг нэгэн ижил хэмээн үздэг байна.

2.2.3. Грек Улс

Дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил Грек Улс ч тухайн цаг үеийн нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан төрийн сүлдээ хэд хэдэн удаа сольсон байдаг. Тус улсын төрийн сүлдэнд эртний домгийн амьтад, эртний грекийн бурхдын дүрийг дүрсэлсэн байдаг. Тухайлбал, үнс нурмаас дүүлэн нисэх галт шувуугаар Грек Улсын тусгаар тогтнол, сэргэн мандахыг бэлгэдсэн байдаг.

1833-1862 онд

I Отто хааны үеийн төрийн их сүлд нь 1822 онд батлагдсан цэнхэр бамбай дээр цагаан загалмайг уламжлан авсан байна.

Төрийн сүлдний энэхүү элемент нь өнөөг хүртэл Грек Улсын төрийн сүлдэнд үндсэн элемент болсоор байна.⁹¹

**1863-1936 онд**

1863 онд Глюксбургийн эзэнт гүрний шинэ хаанд зориулан төрийн шинэ их, бага сүлдийг бүтээжээ. Төв хэсэгт усан цэнхэр өнгийн бамбайн дээр цагаан загалмайг, бамбайн хоёр талд арслангийн арьсан өмсгөлтэй, гартаа модон муна барьсан эртний Грекийн домогт баатар Геркулесийг, орой дээр дээдсийн алтан титмийг, доод хэсэгт “Ард түмний хайр, миний хүчирхэг сүлд” гэж бичсэн хааны зарлигийг тус тус дүрсэлсэн байдаг.⁹²



Бамбайн төвд эртний Грекийг бэлгэдэж Афинагийн толгой, Эллинистийн үеийг бэлгэдэж дуулга, жад, Византын үеийг бэлгэдэж хоёр толгойтой бүргэд, орчин цагийн Грекийг бэлгэдэж галт шувууг тус тус дүрсэлжээ. Мөн нэр, суу алдрыг бэлгэдэж лаврын цэцгийн хэлхээгээр төрийн сүлд хүрээлсэн байдаг.

1924-1935 онд

Эллинистийн арми нуран унасны дараа Грект төрийн хувьсгал гарсан бөгөөд хувьсгалыг эллинистийн армийг захирч байсан хүмүүс санаачилсан бөгөөд хаант засаглалыг устгаж Бүгд Найрамдах Грек Улс байгуулах тухай санал асуулга явуулахад нийт ард түмний 69.95 хувь дэмжсэн байна. Ингэснээр 1924 онд Хоёрдугаар Бүгд Найрамдах Грек Улс болсон бөгөөд энэ үед төрийн сүлдийг өөрчилж, цагаан загалмайтай цэнхэр бамбайг дангаар дүрсэлсэн байна.

**1936-1973 онд**

Хаант засаглалаа эргүүлэн тогтоосны дараа төрийн сүлдээ өөрчилж, өмнөх төрийн сүлдийг бага зэрэг өөрчилж уламжлуулан 1975 он хүртэл хэрэглэсэн байна.



⁹¹ <https://auswandern-info.com/griechenland/flagge-wappen>
⁹² “Flaggen, Wappen, Hymnen”, Battenberg Verlag, 1991, von Derkwillem Visser.

1975 оноос хойш

Эллинистийн үе буюу 1973-1974 онд цэргийн Хунтагийн засгийг унагаасны дараа галт шувууг төрийн сүлдээр баталсан бөгөөд зоос, гадаад паспорт зэрэгт галт шувууг дүрсэлж байжээ. Төрийн сүлд дээр галт шувууг ашиглаж байгаад 1974 онд цэргийн дэглэм нуран унасны дараа хэсэг хугацаанд төрийн сүлд тэмдгийг тодорхойлоогүй байсан.


Үүний дараа бүх ард түмний санал хураалтаар Бүгд Найрамдах засаглалыг хэвээр үлдээж, төрийн сүлдийг 1975 онд одоогийн загвараар буюу цэнхэр өнгийн бамбай дээр цагаан загалмайг алдар нэрийн бэлгэдэл болох лаврын навчны сүлжээсээр хөвөөлсөн бэлгэ тэмдгийг Гуравдугаар Бүгд Найрамдах Грек Улсын төрийн сүлдээр залсан байна.

**2.2.4. Испани Улс**

Испани Улсын төрийн сүлдний түүх XIII зуунаас эхэлдэг бөгөөд өнөөг хүртэл тухайн үеийн хаад, эсхүл Засгийн газрын шийдвэрээр олон удаа солигдож байсан. Төрийн сүлд нь тус улсыг, испани үндэстнийг, үндэсний бүрэн эрхт байдлыг, засаглалын хэлбэрийг, үндсэн хуульт хаант засаглалыг илэрхийлж байдаг.⁹³

1230 онд⁹⁴

Кастилийн III Фернандо Испанийн хэд хэдэн газар нутаг (Кастиль, Леон, Галиси)-ийг нэгтгэж авсны дараа Испанийн нэгдсэн Кастиль ба Леоны хаант улсыг тунхаглажээ. 1230 онд III Фернандо шинэ хаант улс болох Кастиль ба Леоны төрийн сүлдийг баталжээ.




Төрийн сүлд нь бамбай байх ба бамбайг 4 хэсэгт хуваажээ. Ийнхүү III Фернандо нь бамбайг 4 хуваахыг сүлдний урлагт анх нэвтрүүлсэн хүн болсон юм. Хожим нь Европын бусад хаад энэхүү загварыг түгээмэл хэрэглэх болсон.

1492-1516 онд⁹⁵

1469 онд Кастилийн хатан хаан I Изабелла болон Арагоны хаан II Фердинанд нар гэрлэсний дараа Иберийн хойгт Испанийн хоёр хаант улсын нэгдэл үүссэн байна: Арагон болон Кастиль ба Леон. Үүний үр дүнд шинэ улс үүссэн бөгөөд түүний нутаг дэвсгэр нь орчин үеийн Испани Улсын нутаг дэвсгэртэй бараг дүйцэж байв.

Ийнхүү шинэ хаант улс байгуулагдсантай холбогдуулан 1475 онд II Фердинанд, I Изабелла нар шинэ төрийн сүлдийг батлав. Энэхүү сүлд нь Испанийн олон хаант улсын түүхэн сүлднүүдийг дүрсэлжээ. “Католик хаадын сүлд” нэртэй энэхүү төрийн сүлдний төвд дөрвөн хэсэгт хуваагдсан бамбай байв.



⁹³ <https://web.archive.org/web/20060317162511/http://www.la-moncloa.es/IDIOMAS/en-GB/Espana/EIEstado/Simbolos/EIescudo.htm>

⁹⁴ <https://www.promotour.info/spain/symbole/emblem2.php>

⁹⁵ <https://www.promotour.info/spain/symbole/emblem2.php>

Бамбайны зүүн дээд ба баруун доод хэсэгт Кастиль ба Леоны сүлдийг дүрсэлжээ. Энэхүү сүлдэнд Кастилийн сүлд (улаан дэвсгэр дээр алтан цайз) болон Леоны сүлд (цагаан дэвсгэр дээр алтан титэм зүүсэн нил ягаан арслан)-ний зургуудыг ээлжлэн байрлуулсан байна.



Харин баруун дээд ба зүүн доод хэсэгт Арагоны сүлд дүрсэлжээ. Энэхүү сүлд нь Арагоны сүлд (алтан дэвсгэр дээр дөрвөн босоо улаан судал) болон Сицилийн сүлд (алтан дэвсгэр дээр дөрвөн улаан судал болон 2 бүргэдийн дүрс) байв.

1492 онд Гранадаг эзлэн авсны дараа Гранадагийн бэлгэдлийг Испанийн “Католик хаадын сүлд”-нд нэмж оруулжээ. Бамбайн доод хэсэгт мөнгөн дэвсгэр дээр 2 ногоон навчтай анарын дүрсийг дүрсэлсэн нь Гранадагийн бэлгэ тэмдэг юм.

Бамбайны баруун доод талд олон тооны сум, дээр нь Изабеллагийн нэрийн эхний “Y” үсэг байв. Харин зүүн доод талд гордиан зангилаа нь эхнэр, нөхөр хоёрын хооронд байгуулсан гэрээний уриа “Tanto monta”, дээр нь Фернандогийн нэрийн эхний “F” үсэг байв. Мөн Испанийн энэхүү төрийн сүлдэнд анх удаа Сан Хуан бүргэд бамбайг барьсан дүрээр гарч иржээ.

1516-1556 онд⁹⁶

Түүнээс хойших Испанийн хаад “Католик хаадын сүлд”-нд байнга өөрчлөлт оруулж байжээ. Тухайлбал, 1516 онд I Карлос бамбайн дээрх сүлднүүдийг сольж, Геркулесийн 2 баганыг нэмжээ.



Геркулесийн баганууд нь Гибралтарын хоолой болон эзэнт гүрний хилийн чанад дахь эзэмшил газрыг бэлгэдсэн “Plus Ultra” (латин хэлнээс “Хязгаараас цааш”) гэсэн бичээстэй байв.



1580-1668 онд



1700-1759 онд



1759-1808, 1813-1868 онд



1808-1813 онд

⁹⁶ <https://www.promotour.info/spain/symbole/emblem2.php>

1868-1870 онд

1868 онд байгуулагдсан түр Засгийн газрын үеийн төрийн сүлдний төв хэсэгт Бурбон-Анжоугийн ордныг дүрсэлсэн бамбай дээр ордон, арслан, Наварре болон Гранада зэргийг дүрсэлсэн бөгөөд бамбайн дээр ханын дүрстэй титмийг дүрсэлсэн байдаг. Бамбайн хоёр талаар Геркулесийн баганыг титэмгүйгээр дүрсэлжээ.



1870-1873 онд

1870 онд Испанийн хаан Савой Улсын I Амадейг тунхагласны дараа Испанийн төрийн сүлд дахин өөрчлөгдөв. Титмийг дахин хааны титмээр сольсон. Мөн Савойн ордны сүлд бүхий бамбайг улаан галбай дээр мөнгөн загалмай хэлбэрээр Испанийн төрийн сүлдний бамбайн дээр байрлуулсан байв.



1874-1931 онд

1873 оны 02 дугаар сард Савой Улсын I Амадей нийгмийн хямралтай тулгарч, Карлистын II дайн эхэлж, хаан ширээнээсээ бууж, 1873-1874 онд Испанийн түр Бүгд Найрамдах Улсыг тунхаглажээ. Ийнхүү Анхдугаар Бүгд Найрамдах Улсыг бэлгэдэн 1868-1870 оны төрийн сүлдийг дахин сэргээсэн байна.



1931-1939 онд



1939-1945 онд



1945-1977 онд




1977-1981 онд

1939-1945 онд

Генерал Франкогийн дарангуйллын үе (1938-1975 онд)-д эртний “Католик хаадын сүлд”-тэй төстэй төрийн сүлдийг хэрэглэсэн байна. Ингэхдээ төрийн сүлдний дээрх сүлднүүдийг сольж, Геркулесийн багана болон “Нэг, агуу, эрх чөлөөт” гэсэн уриаг нэмж оруулсан.

1977-1981 онд

Шилжилтийн үед буюу 1977 онд Испани Улсын хааны 1511/77 дугаар зарлигаар төрийн далбаа, бэлгэ тэмдгийн журмыг болон төрийн сүлдний загварыг баталсан байна. Төрийн сүлдэнд орсон гол өөрчлөлт нь Гэгээн Иоханы нисэж буй бүргэд юм.



1981 оноос хойш⁹⁷

1981 оны Төрийн сүлдний тухай хуулиар төрийн сүлдийг дахин шинэчилжээ. Дараа нь төрийн сүлдний загвар, хэмжээ, өнгөний схем, хэрэглээг тодорхой болгож, Испани Улсын хааны 1981 оны 2964/1981 дугаар, 1982 оны 2267/1982 дугаар зарлигаар баталжээ.



Төрийн сүлдний бамбай нь Испанийн таван хаант улсын сүлд болон Бурбон-Анжоу гүрний сүлднээс бүрддэг. Бамбайн хоёр талд байрлах Геркулесийн баганууд нь Гибралтарын хоолой болон эзэнт гүрний хилийн чанад дахь эзэмшил газрыг бэлгэдсэн “Plus Ultra” (латин хэлнээс “Хязгаараас цааш”) гэсэн бичээстэй. Мөн баганууд нь Ромын эзэнт гүрний хааны болон Испанийн хааны титэмтэй бөгөөд энэ нь тус улсын эзэнт гүрэн, хаант улс болох түүхийг илэрхийлдэг. Харин үндэсний бүрэн эрхт байдлыг бэлгэддэг хааны титэм нь төрийн сүлдний дээд талд байрладаг.

2.2.5.Чех Улс⁹⁸

1918-1990 онд Бүгд Найрамдах Чехословак Улс оршин тогтнох 72 жилийн түүхэн хугацаандаа төрийн сүлдээ хэд хэдэн удаа өөрчилж байсан хэдий ч хоёр сүүлтэй мөнгөн арсланг уламжлан хэрэглэсээр ирсэн байна. Тус улс нь 1990 онд энх тайвнаар Бүгд Найрамдах Чех Улс ба Бүгд Найрамдах Словак Улс гэх тусгаар улсууд болж, хоёр улс өөр өөрсдийн төрийн сүлдийг ашиглах болсон байна.

Чехословак Улс**1920-1960 онд**

Австри-Унгарын эзэнт улс нуран унасны дараа Анхдугаар Чехословакийн Бүгд Найрамдах Улс байгуулагдсан эхний хоёр жилийн хугацаанд түр зохицуулалт хийж, 1920 онд Үндсэн хуулиараа төрийн бага, дунд, их сүлдийг баталжээ.

Хамгийн өргөн хэрэглэгддэг төрийн бага сүлд нь Францын улаан өнгийн бамбай дээр хоёр сүүлтэй мөнгөн арслан, түүний цээжин хэсэгт патриархийн загалмайг дүрсэлсэн байдаг.

**1960-1990 онд**

1960 онд Үндсэн хуульд өөрчлөлт оруулан Бүгд Найрамдах Социалист Чехословак Улс хэмээн улсын нэрийг өөрчилж, мөн төрийн сүлдээ шинэчилжээ. Хаант засаглалыг бэлгэдсэн титмийн оронд арслангийн толгой дээр таван хошуу тэмдгийг дүрсэлсэн ба цээжин дээр Словакийн шинэ төрийн сүлдийг нэмж оруулсан байна.

Шинэ төрийн сүлд нь Криван уулыг, галын дөл нь 1944 оны Словакийн үндэсний бослогыг бэлгэдсэн. Социалист улсаа байгуулсан тул Христийн патриархийн загалмайг төрийн сүлд дээрээс авсан нь төрийн сүлдээ өөрчлөх бас нэгэн шалтгаан байсан.



⁹⁷ <https://web.archive.org/web/20060317162511/http://www.la-moncloa.es/IDIOMAS/en-GB/Espana/EIEstado/Simbolos/EIescudo.htm>

⁹⁸ https://web.archive.org/web/20110726013739/http://www.senat.cz/zajimavosti/znaky_a_vlajky/index-eng.php?ke_dni=09.04.2010&O=7

Чех Улс

1990-1992 онд

“Хилэн хувьсгал” (Velvet Revolution)-ын дараа буюу 1990 оны 04 дүгээр сард Бүгд Найрамдах Чех Улс (БНЧУ) болж тусгаар улс болж, төрийн сүлдээ шинэчилсэн.

1990 онд коммунист дэглэм нуран унаснаар БНЧУ нь төрийн сүлдэнд эртнээс уламжлан ирсэн хоёр сүүлтэй, алтан титэмтэй, мөнгөн сарвуутай арсланг дахин залсан байна. Мөн Словакийн патриархийн загалмайг дүрсэлсэн байдаг.



1993 оноос хойш

1993 онд Чехословакийн холбоо задран Бүгд Найрамдах Чех Улс болон Бүгд Найрамдах Словак Улс гэж тусгаар тогтносон хоёр улс болжээ.

БНЧУ төрийн бага, дунд, их сүлдийг баталсан. **Төрийн их сүлд** нь тус улсыг бүрдүүлсэн түүхэн 3 үндэстнийг дүрсэлдэг бол **төрийн бага сүлд** нь улаан бамбай дээрх хоёр сүүлт арсланг дүрсэлсэн байдаг.

БНЧУ-ын төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд төрийн их сүлдний талаар *“Дөрөв хуваасан бамбайны эхлэл болон төгсгөл хэсэг нь улаан өнгөтэй байх бөгөөд титэм зүүж, хэлээ унжуулж, зэвсэглэсэн арслан, хоёр дахь хэсэгт цэнхэр өнгийн бамбай дээр улаан өнгийн, зэвсэглэсэн, хэлээ унжуулсан бүргэд, гурав дахь хэсэгт хэлээ унжуулж, титэм зүүсэн, булган дээл нөмөрсөн, цээжин дээрээ хавирган сарыг дүрсэлсэн бүргэд байна гэж дүрсэлсэн байна”* гэж заасан байна.



Харин төрийн бага сүлдний талаар *“төрийн бага сүлдэн дээр улаан өнгийн бамбай дээр хоёр сүүлт, алтан титэмтэй мөнгөн арсланг дүрсэлнэ”* гэж заасан байна.

2.3. Латин Америкийн орнууд

2.3.1. Бразил Улс

1889 онд Бразилын Нэгдсэн Улсыг тунхагласны дараа тус улсын улс төрийн нөхцөл байдал, засаг захиргааны өөрчлөлт зэргээс үүдэн 1968, 1971 онд төрийн сүлдэнд өөрчлөлт оруулж байжээ.

1889-1968 онд

1889 онд II Педро хаан ширээнээс бууж, Бразилын Нэгдсэн Улсыг тунхагласны дараа хааны сүлдний оронд төрийн сүлдийг залжээ.

Төрийн сүлдний хоёр талаар тамхины болон кофены мөчрөөр хөвөөлж, төв хэсэгт нь бөмбөрцөг, түүний доор загалмайг дүрсэлжээ. Бөмбөрцгийн эргэн тойронд тус улсын тухайн үеийн мужийн тоог төлөөлүүлэн 20 ширхэг одыг байрлуулжээ. Доод хэсэгт туузын эхний мөрөнд “Бразилын Нэгдсэн Улс” гэж улсын нэрийг, хоёр дахь мөрөнд тус улсыг тунхагласан огноог бичжээ.



1968-1971 онд

1968 онд Бразил Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад төрийн сүлдний зөвхөн өнгийг өөрчилжээ.



1971 оноос хойш

Тус улс 1971 онд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс болж, үүнийгээ төрийн сүлдэндээ тусгаж байжээ. Мөн бөмбөрцгийн эргэн тойронд мужийн тоог төлөөлүүлсэн одны тоог 27 болгож нэмжээ. Тус улс нь 26 муж болон Холбооны 1 тойрогтой юм.

Сүлд тэмдгийн гол элемент нь алтлаг (шар) хүрээтэй, тэнгэрийн цэнхэр өнгөтэй дугуй байна. Дугуй дотор өөр өөр хэмжээтэй 5 ширхэг таван хошууг дүрсэлсэн ба тэдгээрийн байршил нь Өмнөд загалмай одны контуртай тохирч байдаг. Алтан туяа цацруулсан том таван хошууны доор улаан дэвсгэр дээр алтан одоор чимэглэгдсэн цэнхэр бариултай сэлмийг дүрсэлсэн байдаг.



Энэ бүхэн нь цэнхэр туузаар холбосон мөчрүүдээр хөвөөлсөн: баруун талд нь цэцэглэж буй тамхины мөчрийг, зүүн талд нь боловсорч гүйцсэн кофены жимстэй мөчрийг дүрсэлсэн нь тус улсын хөдөө аж ахуйн чухал үр тариа юм. Сүлдний доод хэсэгт байгаа туузны эхний мөрөнд “Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс” гэж, хоёр дахь мөрөнд Бразилын Нэгдсэн Улсыг анх тунхагласан өдрийг “1889 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр” гэж бичжээ.

2.3.2.Коста-Рика Улс

Коста-Рика Улс 1821 онд Испаниас тусгаар тогтнолоо олж авсныхаа дараа 1824 оны 03 дугаар сард Төв Америкийн Холбоонд элссэн бөгөөд энэ үед Коста-Рика Улс тус холбооны төрийн сүлдийг хэрэглэж байжээ. Харин мөн оныхоо 11 дүгээр сард Коста-Рика Улс нь Төв Америкийн Холбооны муж улсын хувьд өөрийн сүлдтэй болжээ.

Төв Америкийн Холбооны төрийн сүлд



1824-1840 онд

Төв Америкийн Холбооны Коста-Рикагийн муж улсын сүлд



1824-1840 онд



1840 онд

Төв Америкийн Холбоо задран унасны дараа 1840 онд Коста-Рика Улс тусгаар тогтнолоо тунхаглаж, тусгаар тогтносон улсын хувьд анхны төрийн сүлдээ баталжээ. Энэхүү төрийн сүлдний голд найман хошуутай мөнгөн одыг лавр, миртийн мөчрөөр чимэглэж, “Коста-Рика Улс” гэсэн бичсэн байв.



1848-1906 онд

1848 онд Ерөнхийлөгч Хосе Мария Кастро Мадриз шинэ төрийн сүлд баталсан нь одоогийн төрийн сүлдний үндсэн загвар болсон аж. Энэхүү төрийн сүлдэнд галт уул, хөлөг онгоц, оддыг дүрсэлсэн байв.



Тус улсын засаг захиргааны нэгжид өөрчлөлт орох, эсхүл төрийн сүлдний элементүүдийг илүү тодруулах үүднээс 1906, 1964, 1998 онд төрийн сүлдэнд өөрчлөлт оруулжээ.

1906-1964 онд

Төрийн сүлдийг 1906 оны 11 дүгээр сард өөрчлөн төрийн сүлдэнд байсан цэргийн бэлгэ тэмдэг, төрийн далбаа, эрдэнэ шишийн түрүү зэргийг хассан байна.



1964-1998 онд

Төрийн сүлдний таван ширхэг одыг долоон мужийнхаа тоогоор долоон ширхэг болгон нэмсэн байна.



1998 оноос хойш

Коста-Рика Улсын одоогийн төрийн сүлдний бамбай дээр дүрсэлсэн усны мандал нь тус улстай хиллэдэг Номхон далай, Карибын тэнгисийг төлөөлдөг. Мөн худалдааны хөлөг онгоцнууд нь тус улсын далайн түүхийг илэрхийлдэг бол гурван галт уул нь тус улсын гол уулсыг төлөөлдөг байна. Ургах нар нь улс орны хөгжил цэцэглэлтийг, хоёр талд байрлах “алтан буурцаг” нь эртнээс тус улсын экспортын гол бараа болох кофег бэлгэддэг. Харин тэнгэрт байгаа долоон ширхэг од нь тус улсын долоон мужийг төлөөлдөг.



Далдуу модны хоёр мөчрийн доор цагаан туг дээр “Бүгд Найрамдах Коста-Рика Улс” гэж бичсэн байна. Төрийн сүлдний хамгийн дээд хэсэгт “Төв Америк” гэсэн бичээс бүхий цэнхэр туузаар ороосон титэм байна.

1998 онд төрийн сүлдэнд оруулсан өөрчлөлт нь гурван галт уулыг ялгахын тулд тэдгээрийн оройгоос нь утаа гарч байгаагаар дүрсэлсэн байна.

2.3.3. Мексик Улс

Мексик Улс анхны төрийн сүлдээ 1821 онд бүтээснээс хойш нэлээдгүй өөрчилсний дараа 1916 онд эртний ацтекүүд (aztecs)-ийн бэлгэдлийг сэргээсэн төрийн сүлдийг баталжээ. Ацтекүүд (aztecs)-ийн бэлгэдэлтэй төрийн сүлдэнд хоёр удаа өөрчлөлт оруулжээ. Ийнхүү өөрчлөлт оруулахдаа төрийн сүлдэнд тус улсын үнэт зүйлийг илэрхийлсэн түүхэн уламжлалыг хадгалсаар байв.

1821-1823 онд

Испаниас тусгаар тогтносны дараа 1821 онд Мексикийн эзэнт гүрний анхны хаан Агустин де Итурбидег анхны төрийн сүлдийг баталжээ. Тэрээр төрийн сүлдэндээ эзэнт гүрний бэлгэ тэмдэг болсон хааны титэмтэй бүргэдийг сонгосон байна.



1823-1864 онд

1823 онд тусгаар тогтнолын ойг тохиолдуулан төрийн сүлдийг шинэчилсэн байна. Шинэчилсэн төрийн сүлдэнд эзэн хаантай холбоотой элементүүдийг бүрэн авчээ. Энэ үеэс төрийн сүлдийг зоос, марк, тамга, албан бичигт ашиглаж эхэлжээ.



1863-1867 онд

Мексикийн хоёр дахь хаан болох I Максимилиан төрийн сүлдийг сүр жавхлантай болгохын тулд хааны титмийг эргэн сэргээхдээ домгийн шувуу болон “Шашин ба тусгаар тогтнол” гэж бичээсийг нэмж оруулжээ.



1865 онд I Максимилиан хаан төрийн сүлдийг дахин өөрчилсөн нь төрийн сүлдний хааны титмийг авч, домгийн хоёр глиф (glyph)-ийг нэмж, бичээсийг “Шударга ёсны тэгш байдал” гэж өөрчилжээ.

1867-1893 онд

1867 онд Мексикийн 2 хоёр дахь эзэнт гүрэн нуран унасны дараа Бүгд Найрамдах Улсаа тунхаглаж, 1823 оны төрийн сүлдийг сэргээжээ.

1893-1916 онд

1893 онд Ерөнхийлөгч Хосе де ла Крус Порфирио Диас төрийн сүлдний бүргэдийн дүр төрхийг өөрчилжээ.



1916-1934 онд

1916 онд Ерөнхийлөгч Венустиано Карранса Гарса төрийн сүлдэнд эртний ацтекүүд (aztecs)-ийн зарим бэлгэдлийг сэргээн оруулжээ. Энэ үеэр бүргэдийн зуусан усан могойг хоржин могойгоор сольж, бүргэдийг урд талаас нь биш хажуу талаас нь харуулжээ.



1934-1968 онд

1934 онд Ерөнхийлөгч Абелардо Родригес Лухан мөн төрийн сүлдийг өөрчилжээ.

**1968 оноос хойш**

1968 онд Ерөнхийлөгч Густаво Диаз Ордазын өөрчилсөн төрийн сүлдийг өнөөг хүртэл ашиглаж байна.

Мексик Улсын одоогийн төрийн сүлд нь өргөст лийр кактус дээр сууж, хоржигнуурт могой зууж буй мексик (алтан) бүргэдийг дүрсэлсэн байдаг. Энэ нь эртний ацтекчүүд могой идэж буй бүргэдийг харсан даруйдаа хотоо хаана барихаа мэддэг гэсэн эртний домогт үндэслэжээ. Энэхүү дүрслэл нь олон зууны турш Мексикийн улс төр, соёлын чухал бэлгэдэл байсаар ирсэн.



Теночтитланчууд (Tenochtitlan)-ын хувьд ч энэ нь шашны утгатай байсан бөгөөд европчуудын хувьд энэ нь сайн сайхан мууг ялахыг бэлгэддэг байжээ.

1984 онд батлагдсан Төрийн сүлд, төрийн далбаа, төрийн дууллын тухай хуулиар төрийн сүлдний дүрслэл болон хэрэглэх журмыг зохицуулсан байдаг.⁹⁹

3.3.4. Чили Улс

Чили Улсын анхны төрийн сүлд 1813 онд бүтээгдсэнээс хойш дүр төрхөө хэд хэдэн удаа өөрчилжээ. Тухайлбал, тус улсын 1834 оны төрийн сүлдийг английн зураач Чарльз Вуд Тейлор бүтээж байсан бөгөөд тэрхүү төрийн сүлдэнд нэг удаа өөрчлөлт оруулж (1920 онд) өнөөг хүртэл хэрэглэж байна.

1813-1814 онд

Анхны төрийн сүлд нь бөмбөрцөг бүхий дорик маягийн баганатай, эрх чөлөөний модыг дүрсэлсэн бөгөөд нутгийн уугуул эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэлхээ холбоо болон одыг дүрсэлсэн байжээ.

**1819-1834 онд**

1819 онд Сенатаас баталсан шинэ төрийн сүлд нь хөх өнгийн бамбайны голд дүрслэх цагаан гантиг баганын орой дээр “Эрх чөлөө” гэж бичсэн бөмбөрцөг байв. Таван хошууны хувьд оройн хэсэгт байгаа нь Сантьяго мужийг, баганын хоёр талд байгаа нь Концепсион, Кокимбо мужуудыг төлөөлжээ. Бамбайг тойроод гурван өнгийн туузаар холбосон лаврын навчин хоёр мөчрөөр хөвөөлжээ. Бамбайн эргэн тойронд зэвсгүүдийг дүрсэлжээ.



Мөн ондоо төрийн сүлдэнд бамбайн эргэн тойронд тугуудыг нэмж оруулжээ.

⁹⁹ <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2008-03-02/mexico-law-on-national-symbols-amended/>

1834-1920 онд

1834 онд Жоакин Приетогийн Засгийн Газрын захиалгаар Английн зураач Чарльз Вудийн бүтээсэн шинэ төрийн сүлдийг баталжээ. Энэхүү төрийн сүлдэнд үндэсний цэцэг болох сорihue-г дүрслэн харуулсан. Мөн кондор, хуэмулын ард нь Чили Улсын төрийн далбааг байрлуулжээ.



1920 оноос хойш

1920 онд баталсан Чили Улсын төрийн сүлд нь хөх, улаан өнгийн бамбай байх ба түүн дээр үндэсний бэлгэ тэмдэг болох цагаан таван хошууг дүрсэлсэн байдаг. Бамбайны хоёр талд Андын нурууны махчин шувуу болох кондор, Чилийн эндемик хөхтөн амьтан болох хуэмул байдаг. Энэхүү хоёр амьтан нь Чилийн тэнгисийн цэргийн болон Номхон далайн баатарлаг үйлсийг бэлгэдсэн алтан титэмтэй байдаг.



Бамбайн дээд хэсэгт байрлах цэнхэр, цагаан, улаан өнгийн өд нь Бүгд Найрамдах Улсын үе үеийн ерөнхийлөгчдийн хүндэтгэлийн малгайны өнгөөр төлөөлүүлэн оруулжээ. Мөн “Шалтгаан, эсхүл хүч чадал” гэсэн уриаг бичжээ.

2.3.5.Перу Улс

Генерал Хосе де Сан Мартин бүтээсэн тус улсын анхны төрийн сүлдийг 1820 оны 10 дугаар сарын 21-ний өдөр баталжээ. Түүний дараа 1825 онд баталсан төрийн сүлдийг нэг удаагийн өөрчлөлттэйгөөр өнөөг хүртэл хэрэглэж байна.

1821-1825 онд

Төрийн сүлдний голд байрлах бамбай дээр далайн зүгээс харахад Андын нуруунаас ургах нарыг дүрслэн, түүний ард Өмнөд Америкийн улсуудын туг, гадил жимсний модыг дүрсэлжээ. Зүүн талд нь кондор шувууг, баруун талд нь лам гөрөөсийг дүрсэлжээ. Доод хэсэгт нь “Перугийн нар дахин мандаж байна” гэж бичсэн байна.



1825-1839 онд

1825 онд тус улсын Конгрессоос шинэ төрийн бэлгэ тэмдгийг тодорхойлсон хууль баталжээ. Төрийн сүлдний гурав хуваасан бамбай дээр лам гөрөөс, “cinchona” мод болон асгарч буй зоосыг дүрсэлжээ. Бамбай нь титэмтэй бөгөөд хоёр талдаа төрийн далбааны өнгөтэй туг байна.



1836-1839 онд

1836 онд Перу Улс хоёр хуваагдсан байна: Өмнөд Перугийн Бүгд Найрамдах Улс болон Хойд Перу Боливитой нэгдэж Перу-Боливийн Холбоо байгуулагджээ.

Өмнөд Перугийн Бүгд Найрамдах Улсын шинэ төрийн сүлдний дээр нь дөрвөн жижиг одтой (Арекипа, Аякучо, Кузко болон Пуно мужуудыг төлөөлүүлэн) алтан нарыг дүрсэлжээ.

Харин Хойд Перу хуучин төрийн сүлдээ авч үлджээ.



1839-1950 онд

1839 оны Перу-Боливийн Холбоо задарсны дараа хоёр Перу Улс нэгдэж, 1825 оны төрийн сүлдээ сэргээсэн байна.

1950 оноос хойш

Генерал Мануэль А.Одриагийн засаглалын үед 1950 онд төрийн сүлдний элементүүдийн дүрсийг өөрчилжээ.

Төрийн сүлдний бамбай нь Польш хэлбэрээр гурван хэсэгт хуваагдсан: зүүн талд лам гөрөөсийг, баруун талд “cinchona” модыг, доод талд асгарч буй зоосыг дүрсэлсэн нь тус улсын байгалийн гурван баялгийг бэлгэднэ. Бамбай нь титэмтэй бөгөөд хоёр талдаа төрийн далбааны өнгөтэй туг байна.



ГУРАВ. ХУУЧИН ЗХУ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН БҮГД НАЙРАМДАХ УЛСУУДЫН ТӨРИЙН СҮЛДНҮҮД

3.1.Хуучин ЗХУ

Хуучин Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ) буюу бүтэн нэрээрээ Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс (ЗСБНХУ) (Союз Советских Социалистических Республик, СССР) нь 1922 онд Орос, Украин, Беларусь, Өвөр Кавказ (хожим нь Азербайжан, Армени, Гүрж болж задарсан) зэрэг 4 улсын гэрээгээр байгуулагдаж байжээ.

ЗХУ-ын анхны төрийн сүлдийг **1924 онд** баталсан Үндсэн хуулиар бататган хуульчилсан байна. Төрийн сүлд нь тариан түрүүгээр хөвөөлсөн дугуй хэлбэртэй байна. Эхлээд хоёр талд тарианы ишийг улаан туузаар 3 удаа ороож, туузан дээр “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг орос, украин, беларусь, гүрж, армени, турк-татар гэсэн 6 хэлээр бичсэн байв.

Хожим нь ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсон Бүгд найрамдах улсын хэлээр уриа бүхий туузыг төрийн сүлдэнд нэмж байв.

Тухайлбал, **1925 онд** хамгийн түрүүнд Узбекистан, Туркменистан, **1929 онд** Тажикистан нэгдэж, уриаг турк хэлээр нэмж оруулсан, энэ үед орос хэл дээрх уриа бүхий туузыг төрийн сүлдний төв хэсэг рүү шилжүүлсэн. **1936 онд** ЗХУ-ын Үндсэн хуулийг шинэчлэн баталсан хэдий ч төрийн сүлдэнд өөрчлөлт ороогүй, гагцхүү туузны тоо нэмэгджээ. Учир нь мөн онд Казахстан, Киргиз, Азербайжан, Армени, Гүрж зэрэг улсууд ЗХУ-д нэгдсэн байв. 1940 онд Латви, Литва, Молдова, Эстони зэрэг улсууд нэгдэн орсон боловч уриаг дэлхийн II дайны дараа буюу **1946 онд** ЗХУ-ын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн газрын шийдвэр (1940 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн)-ээр нэмж оруулжээ. Харин **1956 онд** Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Карел-Финландын Улс нь автономит улсын статустай болсноор финланд хэл дээрх уриа хасагдаж нийт 15 уриатай болсон түүхтэй. Уриаг 1936 онд батлагдсан Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд тусгасан дарааллын дагуу байрлуулсан байв.



1923–1929 онд



1929-1936 онд



1936-1946 онд



1946-1956 онд

1977 онд батлагдсан ЗХУ-ын Үндсэн хуульд зааснаар тус улсын төрийн сүлд нь нарны туяанд дэлхийн бөмбөрцөг дээр тариан түрүүгээр хөвөөлсөн алтан шар өнгийн алх, хадуурыг хөндлөн байрлуулсан байв. Тариан түрүүг улаан туузаар 14 удаа ороож, туузан дээр “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг ЗХУ-ын бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсуудын хэлээр, харин төв хэсгийн туузан дээр орос хэлээр бичсэн байв. Төрийн сүлдний дээд хэсэгт таван хошууг байрлуулжээ.¹⁰⁰



1956-1993 онд

¹⁰⁰ <http://statesymbol.ru/>

ЗХУ-ын төрийн сүлд нь эвлэлдэн нэгдсэн ажилчин, тариачид болон холбооны улсууд ЗХУ-д сайн дурын үндсэн дээр нэгдэж, бүх үндэстний тэгш эрхийг бэлгэдэж, ЗХУ-ын ард түмэн дэлхийн бүх улсын хөдөлмөрчидтэй интернационал эв нэгдлийн үзэл санааг илэрхийлж байв. Төрийн сүлдний элементүүд нь дараах утга санааг илэрхийлж байжээ¹⁰¹:

- таван хошуу, эсхүл таван хошуу од (пятиконечная звезда) нь үүрд мөнх, эрх мэдэл, гэрэл гэгээг, мөн дэлхийн таван тивийн пролетариудын нэгдлийг;
- алх, хадуур нь хөдөлмөрийн урам зоригийг, мөн ажилчин, тариачдын хүчтэй улсыг цогцлоон байгуулах хүсэл эрмэлзлийг;
- дэлхийн бөмбөрцөг нь тус улс хүн төрөлхтөнтэй нягт хамт байхыг, өөрөөр хэлбэл, олон улсын энх тайванч зарчимтай, дэлхийн бүх ард түмэн “хөдөлмөр”-ийг удирдлагаа болгох шинэ нийгмийг;
- ургах нар нь коммунист үзэл санаа, түүний гэрэлт ирээдүйг;
- тариан түрүү нь хөгжил цэцэглэлтийг;
- улаан болон алтан шар өнгө нь хувьсгалт уламжлал, хувьсгалт агуу үйл хэрэгт үнэнч байхыг, мөн ЗХУ-ын бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсуудын эв нэгдлийн коммунист үзэл санааны гэрэлт ирээдүйг, тэр тусмаа улаан өнгө нь эртнээс боолууд эзэдтэйгээ, хамжлагууд ноёдтойгоо, пролетариуд хөрөнгөтөн эзэдтэйгээ тэмцэх тэмцлийн дүрэлзсэн галыг, урссан цусыг илэрхийлж байв.

“Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” хувьсгалт уриаг анх К.Маркс, Ф.Энгельс нар гаргаж иржээ. Түүхийн хуудсыг сөхөж үзвэл, 1847 оны 01 дүгээр сард пролетари хувьсгалчдыг нэгтгэсэн “Шударга хүмүүсийн холбоо”-ны Лондонгийн хороо нь өөрийн холбооны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэ хөтөлбөр боловсруулахад К.Маркс, Ф.Энгельс нарыг урьсан байв. Энэ үеэр тус холбооны нэрийг “Коммунистуудын холбоо” болгож өөрчилжээ. Мөн холбооны “Бүх хүмүүс бол ахан дүүс” уриаг “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” гэж өөрчлөх саналыг К.Маркс, Ф.Энгельс нар гаргажээ. 1847 оны 06 дугаар сард Лондон хотод болсон Коммунистуудын их хурал дээр Ф.Энгельс энэхүү урианы талаар ийнхүү тайлбарлажээ: “Бүх улсын ажилчдын нөхцөл байдал ижил, тэдний сонирхол нэг, тэдний дайсан нэг учраас бүх үндэстний ажилчдын холбоод ахан дүү мэт хамтран бүх үндэстний хөрөнгөтний холбоог эсэргүүцэх ёстой.”¹⁰²

3.2.Орос Улс

ЗХУ задарсны дараа Оросын Холбооны Улс (ОХУ) нь хоёр толгойтой бүргэдийг төрийн сүлд болгон сэргээсэн. Тус улсын төрийн сүлдний түүхэн уламжлалаас үзэхэд, XIV зуунаас хойш таван зууны турш Орос Улсын төрийн бэлгэ тэмдэг болж байх хугацаандаа¹⁰³ хоёр толгойтой бүргэдийн дүр төрх олон удаа өөрчлөгдөж байжээ. Эдгээрээс ОХУ-ын одоогийн төрийн сүлдэнд байгаа элементүүд хэзээ нэмэгдэж, хэрхэн хувирч байсныг он цагийн дарааллаар авч үзье.

¹⁰¹ Поцелуев Владимир. Гербы Союза ССР. Москва, Политиздат, 1987 г. Стр. 14, 19, 26-27, 45-46, 85, 97.

¹⁰² Мөн тэнд.

¹⁰³ <http://statesymbol.ru/>

Москвагийн их гүнт улс

XIV зуунд

Хоёр толгойтой бүргэдийн дүрсийг Оросын бэлгэ тэмдэг болгон ашигласан анхны нотлох баримт бол Москвагийн их гүн Иван III Васильевич буюу Их Иваны тамга юм.

Их Иван нь 1462-1505 онд Орос (Русь)-ын газар нутгийг захирч байсан. Тухайн үед гадаадын улсуудын олон удаагийн дайралтын дараа Орос дахин нэгдэж, түүний төв нь одоогийн Москва хот болж байжээ.

Их Иваны тамганы урд талд нь **морьтныг**, ар талд нь **хоёр толгойтой бүргэдийг** дүрсэлсэн байв. Жадаар могой хөнөөж байгаа морьтон бол сайн нь мууг (дайснаа) ялан дийлж байгааг, хоёр толгойтой бүргэд бол эзэн хааны хүчийг бэлгэддэг байв.¹⁰⁴



Өвөг дээдсээс өвлөсөн “морьтон”

Их Иван нь тамган дээр байгаа морьтныг өөрийн гэр бүлийн сүлднээс авсан бөгөөд морьтныг нөмрөгтэй болгож, жадаар могой хөнөөж байгаагаар дүрсийг баяжуулжээ.

Их Иваны өвөө буюу I Василий Дмитриевич (1371-1425 онд амьдарч байсан) нь гэр бүлийн сүлд бүхий тамган дээрээ өөрийгөө дүрсэлсэн байжээ.¹⁰⁵

I Василий Дмитриевичийн тамга (1389 он)



Византаас ирсэн “хоёр толгойтой бүргэд”

1453 онд Туркийн османчууд эртний Византын эзэнт гүрний (395-1453 онд оршин тогтнож байсан) нийслэл Константинополийг (одоогийн Истанбул) эзлэн авч байсан. Энэ үйл явдлаас хойш Византын сүүлийн эзэн хааны авга үеэл Софья нь Их Ивантай гэрлэсэн бөгөөд тэрээр Византын бэлгэ тэмдэг болох хоёр толгойтой алтан бүргэдийг Орост анх авч иржээ.

Византын хоёр толгойтой бүргэд нь эзэнт гүрний тусгаар тогтнолыг, харин түүний хоёр толгой нь эзэнт гүрний баруун, зүүн хэсэг дэх эрх мэдлийг нь бэлгэддэг байжээ.¹⁰⁶

Византын сүүлийн эзэн хааны тамга



Оросын хаант улс¹⁰⁷

XVI зуунд

1547-1584 онд бүх Оросын анхны хаан байсан “Догшин” хэмээх IV Иван Васильевич хоёр толгойтой бүргэдэд томоохон өөрчлөлт оруулсан нь **морьтныг бүргэдийн цээжин дээр шилжүүлсэн** явдал байв. Морьтон бол Москвагийн ноёдын бэлгэ тэмдэг болсон гэгээн Георгий байв.

Ийнхүү Оросын хаант улсын төрийн сүлдийг сүрлэг болгохын тулд хоёр толгойтой бүргэдийн цээжинд морьт унасан гэгээн Георгий жадаар могой хөнөөж байгаагаар дүрсэлжээ.



¹⁰⁴ <http://kursk-museum.ru/gallery/simvolika/index.html>

¹⁰⁵ Президентская библиотека имени Б.Н.Ельцина. <https://www.priib.ru/>

¹⁰⁶ <http://statesymbol.ru/>

¹⁰⁷ Думин С.В. Гербы дома Романовых. <https://runivers.ru/doc/historical-journal/article/?ID=478649&JOURNAL=>, <http://statesymbol.ru/>

XVII зуунд¹⁰⁸

1613 онд Михаил Федорович Романов хаан ширээнд сууснаар 400 гаруй жил үргэлжилсэн Романовынхны хаанчлалын эрин эхэлжээ.

1646 онд Романовын удмын Оросын хоёр дахь хаан Алексей Михайлович хаан ширээнд суусан байна. Тэрээр бүргэдийн сарвуунд хүч чадлын бэлгэдэл болох **очирт таяг, бөмбөрцгийг** нэмж дүрсэлжээ.

Мөн бүргэдийн **далавчнууд бүрэн нээгдэн өндөрт өргөгдөв.**



Алексей Михайловичийн үед бүргэд нь христийн шашны Эцэг Бурхан, Хүү Бурхан, Ариун Сүнс гэсэн **ариун гурвалыг бэлгэдсэн гурван титэмтэй** болжээ.

Оросын эзэнт гүрэн¹⁰⁹**XVIII зуунд**

Түүхэнд “Их” хэмээн тэмдэглэгдсэн I Петр Алексеевич Романов нь бүх Оросын сүүлчийн хаан (царь) (1682-1721 онд), Оросын эзэнт гүрний анхны эзэн хаан (император) (1721-1725 онд) байв. Тухайн үед Балтын тэнгис рүү гарцтай төдийгүй флоттой болж, Нева мөрний эхэнд Санкт-Петербург хотыг байгуулсан хүчирхэг эзэнт гүрэн болсон байв.

Энэ үед хоёр толгойтой бүргэд нь Оросын эзэнт гүрний өргөжин тэлсэн газар нутгийг бэлгэдэх болжээ. Тодруулбал, Сибирь, Алс Дорнодын өргөн уудам нутгийг өөртөө нэгтгэсний дараа төвийн том титмийн доор хоёр тийш харж байгаа бүргэд нь нэг эзэнт гүрний Европ болон Азийн Орос орныг бэлгэдэх болов.

Мөн титмийн гурвалыг **эгзээн Андреевскийн тугийг бэлгэдсэн цэнхэр туузаар**, бүргэдийн цээжийг Оросын дээд шагнал болох гэгээн Андрейн одонгоор чимэглэжээ.



Ийнхүү I Петрийн үед ОХУ-ын одоогийн төрийн сүлдний үндсэн загвар бий болжээ.

XIX зуунд

I Николай эзэн хааны үед төрийн сүлдний шинэчлэл хийгджээ. 1856 онд баталсан төрийн бага сүлдний бүргэдийн баруун далавчинд Казань, Польш, Таврикс, Их Гүнт (Киев, Владимир, Новгород)-ийн, зүүн далавчинд Астрахань, Сибирь, Гүрж, Финландын бэлгэ тэмдэг болсон бамбайнуудыг дүрсэлжээ. 1857 онд баталсан төрийн их, дунд, бага сүлднүүдийг 1917 оныг хүртэл хэрэглэжээ.

¹⁰⁸ <https://www.vokrugsveta.ru/article/260555/>, <http://kursk-museum.ru/gallery/simvolika/index.html>

¹⁰⁹ <http://kursk-museum.ru/gallery/simvolika/index.html>



Төрийн бага сүлд



Төрийн дунд сүлд



Төрийн их сүлд

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улс¹¹⁰

Октябрийн социалист хувьсгал ялсан 1917 онд Бүх Оросын Зөвлөлүүдийн II их хурлаар Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улсыг тунхаглажээ. **1918 онд** батлагдсан анхдугаар Үндсэн хуульд зааснаар төрийн сүлд нь нарны туяанд улаан дэвсгэр дээр алтан алх, хадуурыг хөндлөн байрлуулж, тариан түрүүгээр хөвөөлсөн байв. Гадна талаар нь “Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улс” гэж, доод хэсэгт “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг орос хэлээр бичсэн байв.

Гүйцэтгэх төв хороо төрийн сүлдний уран сайхны хэлбэрийг сайжруулахаар шийдвэрлэж, 1920 онд сард зураач Н.А.Андреевын бүтээсэн төрийн сүлдний шинэ хувилбарыг баталжээ. Шинэ хувилбарт уриаг төрийн сүлдний доод хэсэгт улаан туузан дээр, улсын нэрийн “Р.С.Ф.С.Р” товчлолыг дээд хэсэг рүү шилжүүлжээ. Улаан дэвсгэрийг тариан түрүүгээр хөвөөлсөн байв.

Энэхүү сүлдийг **1925 онд** шинэ Үндсэн хуулиар бататгаж, 1993 оныг хүртэл хэрэглэсэн байна. Энэхүү 70 гаруй жилийн хугацаанд төрийн сүлдэнд хэд хэдэн өөрчлөлт орж байжээ. Тухайлбал, **1956 онд** батлагдсан “Оросын үсэг, цэг таслалын дүрэм”-ийн дагуу улсын нэрийн “Р.С.Ф.С.Р.” товчлолоос цэгүүдийг авсан бол **1978 онд** батлагдсан шинэ Үндсэн хуулиар төрийн сүлдэнд таван хошууг нэмж оруулжээ.



ОИН.МН
СУДАЛГААНЫ САН

¹¹⁰ <http://www.heraldicum.ru/russia/rsfsr.htm>

Оросын Холбооны Улс (ОХУ)¹¹¹

ОХУ-ын орчин үеийн төрийн сүлдийг тус улсын Ерөнхийлөгчийн **1993 оны** 11 дүгээр сарын 30-ны өдрийн зарлигаар батлахдаа Орос Улсын түүхийн залгамж чанар, салшгүй байдлын илэрхийлэл болсон хоёр толгойтой бүргэдийг төрийн сүлд болгон сэргээсэн байна.

2000 онд төрийн сүлдийг ОХУ-ын төрийн сүлдний тухай үндсэн хуулийн хууль (конституционный закон)-иар¹¹² зохицуулах болсон. Энэ хуулиар ОХУ-ын төрийн сүлд, түүний тодорхойлолт, албан ёсны ашиглах журмыг тогтооходоо түүний дүрс, өнгийг тодруулж өгчээ.

Төрийн сүлд нь улаан өнгийн франц маягийн бамбайн дээр хүч чадлыг бэлгэдсэн далавчаа өргөсөн хоёр толгойтой алтан бүргэд байна. Хоёр толгойтой бүргэд нь тус улсын газар нутаг Европ, Ази тивийг дамнасан байдгийг илэрхийлдэг. Бүргэдийн гурван эгнээнд байрладаг өд нь сайн сайхан, шударга үнэн, гоо сайхныг илэрхийлдэг.



Бүргэд нь туузаар холбосон I Петрийн үеийн гурван титэмтэй бөгөөд энэ нь ОХУ болон түүний бүрэлдэхүүн улсуудын бүрэн эрхт байдлыг бэлгэддэг.

Бүргэд нь сарвуундаа төрийн эрх мэдэл, улсын эв нэгдлийг илэрхийлсэн очирт таяг, бөмбөрцөг барьсан байдаг. Орчин үед очирт таяг нь улсын бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнол, эв нэгдэл, түүний хүчийг илэрхийлдэг.

Бүргэдийн цээжин дээр лууг жадаар хөнөөж буй морьтон буюу гэгээн Георгийг дүрсэлсэн франц маягийн бамбай нь хамгаалалтыг илэрхийлж байдаг. Гэгээн Георгий лууг жадаар хөнөөж байгаа нь сайн ба муу, гэрэл ба харанхуйн тэмцэл, эх орноо хамгаалах эртний бэлгэдэл юм. Харин хар луу нь улс орны хувь заяаны хүнд сорилтуудыг илэрхийлдэг.

ОХУ-ын төрийн сүлдний өнгөний хувьд, улаан өнгө нь эр зориг, эх орноо хайрлахын бэлгэдлийг, мөн эх орноо хамгаалагчдын урссан цус, олон үндэстний улсын эв нэгдлийг, алтан өнгө нь эрх мэдэл, эд баялгийг, мөнгөн өнгө нь өгөөмөр сэтгэл, цэвэр ариун бодол, санаа зорилго, шударга үнэний төлөөх тэмцлийг, лууг хар өнгөөр дүрсэлсэн нь тус улсын түүхэнд гэм зэмгүй амиа алдсан хүмүүсийн уй гашуу, тэднийг үүрд санан дурсаж байхыг илэрхийлдэг.

3.3.Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсууд

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн Бүгд найрамдах улсуудын тухайн үед болон холбооноос тусгаар болсноос хойш хэрэглэж байсан, хэрэглэж байгаа төрийн сүлднүүдийн талаар үзье:

- | | |
|----------------|-------------------|
| 1) Азербайжан; | 8) Литва; |
| 2) Армени; | 9) Молдова; |
| 3) Беларусь; | 10) Тажикистан; |
| 4) Гүрж; | 11) Туркменистан; |
| 5) Казахстан; | 12) Узбекистан; |
| 6) Киргиз; | 13) Украин; |
| 7) Латви; | 14) Эстони. |

¹¹¹ <http://statesymbol.ru/>, <https://blazon.ru/strany/gerb-rossii.html>

¹¹² Федеральный конституционный закон от 25.12.2000 № 2-ФКЗ «О Государственном гербе Российской Федерации». pravo.gov.ru.

3.3.1. Азербайжан Улс

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Азербайжан Улс (ЗСБНАЗУ)¹¹³

1920 онд байгуулагдсан ЗСБНАЗУ-ын анхдугаар Үндсэн хууль **1921 онд** батлагджээ. Үндсэн хуульд бататгасан төрийн сүлд нь дэлхийн бөмбөрцгийн цаанаас гарч буй нарны туяанд алтан алх, хадуур, улаан хавирган сар, таван хошуу байх ба эдгээрийг тариан түрүүгээр хөвөөлсөн байв. Төрийн сүлдний дээд талын туузан дээр улсын нэрийг, доод талын туузан дээр “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг азербайжан хэлээр бичсэн байв.



1922 онд Азербайжан, Армени, Гүрж зэрэг Өмнөд Кавказын улсууд нэгдэн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Өвөр Кавказ Улс байгуулагдсан боловч 1936 онд задарчээ.

Азербайжан Улс нь Бүгд найрамдах улс болж, ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсны дараа буюу **1937 онд** батлагдсан шинэ Үндсэн хуулиар төрийн сүлдээ шинэчилжээ. Шинэ төрийн сүлд нь тариан түрүү болон хөвөнгийн мөчрөөр хөвөөлсөн дугуй хэлбэртэй болжээ. Эдгээрийг туузаар ороож, дээр нь “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг азербайжан, орос хэлээр бичсэн байв. Дотор нь мандах нарны туяанд алх, хадуур, газрын тосны цооног зэргийг дүрсэлжээ. Төрийн сүлдний оройн хэсэгт таван хошуу, түүний доод талд нь улаан туузан дээр улсын нэрийг азербайжан, орос хэлээр бичжээ.



1993 он хүртэл хэрэглэсэн энэхүү сүлдэнд хэд хэдэн өөрчлөлт орсон байна: **1937 онд** азербайжан хэл дээрх улсын нэрийг зассан, **1940 онд** Азербайжан Улс латин үсгээс кирилл үсэг рүү шилжихтэй холбогдуулан төрийн сүлдний азербайжан хэл дээрх бичгүүдийг сольсон, **1956 онд** тус улсын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар “Төрийн сүлдний журам” батлагдаж, төрийн сүлдний элементүүдийн өнгийг өөрчилсөн байна.

Мөн **1958 онд** төрийн сүлдэн дээрх улсын нэрийг засжээ. Анх кирилл үсэгт шилжихдээ “Азербайжан” гэсэн үгэнд “Й” үсгийг, “Социалист” гэсэн үгэнд “Я” үсгийг бичдэг байв: АЗЭРБАЙЧАН СОВЕТ СОСЯЛИСТ РЕСПУБЛИКАСЫ.

Хийсэн засвар нь “Й” үсгийг “J” үсгээр, “Я” үсгийг цагаан толгойн үсгээс хассан тул “И” үсгээр сольжээ: РЕСПУБЛИКАН СОЦИАЛИСТ АЗЭРБАЖЧАН СОВЕТИ.

1978 онд батлагдсан шинэ Үндсэн хуулиар, мөн 1981 онд Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн баталсан “Төрийн сүлдний журам”-аар төрийн сүлдэнд өөрчлөлт ороогүй.

¹¹³ <http://www.heraldicum.ru/azerbaij/index.htm>

2) Бүгд Найрамдах Азербайжан Улс (БНАЗУ)¹¹⁴

1993 онд батлагдсан БНАЗУ-ын Үндсэн хуулиар төрийн сүлдний өнгөт болон хар, цагаан зургийг баталж, тус улсын Ерөнхийлөгчийн баталсан “БНАЗУ-ын төрийн сүлдний тухай журам”-аар төрийн сүлдтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байна.

2018 онд БНАЗУ-ын төрийн сүлдний дүрсийг батлах тухай үндсэн хуулийн хууль (конституционный закон)-ийг баталжээ. Энэ хуульд зааснаар БНАЗУ-ын төрийн сүлд нь царс модны мөчир, тариан түрүүн дээр байрлуулсан дорнын бамбай байна. Энэ нь тус улс дорнын соёл иргэншилд харьяалагддагийг илэрхийлнэ.

Төрийн далбааны өнгө бүхий дэвсгэртэй бамбайн дээр нарны бэлгэдэл найман хошуу цагаан од байх ба одны төвд “галын орон”-ыг бэлгэддэг галын дөл байна. Од нь “тайван, амар амгалан” гэсэн утгатай цагаан өнгөтэй, дөл нь хүч чадал, эр зоригийг бэлгэдсэн улаан өнгөтэй, царс модны мөчир нь эд баялаг, үржил шимийг бэлгэдсэн ногоон өнгөтэй, тариан түрүү нь шар, бамбай болон одны хүрээ, бамбайн 8 ширхэг тав, царс модны 5 ширхэг самар нь алтан өнгөтэй байх бөгөөд тэдгээрийн өнгөний кодыг дээрх хуульд тодорхой зааж өгчээ.



Энэхүү төрийн сүлдний анхны өнгөт зураг Турк улсад хэвлэгдсэн “Одлу юрд” (“Галын улс”) сэтгүүлийн 1930 оны 04 дүгээр сарын дугаарт хэвлэгджээ. Оросоос цагаачлан ирсэн М.Е.Расулзаде уг зургийг Абхазын хунтайж Шервашидзегийн бүтээсэн азербайжаны төрийн сүлд бөгөөд 1920 оны 04 дүгээр сард Азербайжаны Парламентын танхимд байсан гэж мэдээлжээ.

3.3.2.Армени Улс

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Армени Улс (ЗСБНАРУ)¹¹⁵

1920 онд байгуулагдсан ЗСБНАРУ-ын анхдугаар Үндсэн хууль **1922 онд** батлагджээ. Үндсэн хуулиар бататгасан төрийн сүлдэнд Армени үндэстний эртнээс бэлгэдэж ирсэн Арарат уулын их, бага оргилыг, уулын цаанаас ургах нарны туяанд алх, хадуурыг, уулын бэлд усан үзмийн мод, тариан түрүү, чидун жимсний мөчрийг дүрсэлжээ. Төрийн сүлдний эргэн тойронд улсын нэр болон “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг армени хэлээр бичжээ.



1922 онд Өмнөд Кавказын гурван улс болох Азербайжан, Армени, Гүрж нэгдэн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Өвөр Кавказ Улс байгуулагдсан боловч 1936 онд задарчээ.

Армени Улс нь Бүгд найрамдах улс болж, ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсны дараа буюу **1937 онд** шинэ Үндсэн хууль батлагджээ. Шинэ Үндсэн хуульд заасан төрийн сүлд нь 1922 оныхоос бага зэрэг өөрчлөгдсөн байна: чидун жимсний мөчрийг тариан түрүүгээр, нарыг таван хошуугаар сольж, дээр нь алх, хадуурыг байрлуулжээ. Мөн улаан туузан дээр уриаг орос хэлээр нэмж оруулжээ.



¹¹⁴ <https://president.az/ru/pages/view/azerbaijan/symbols> , <https://blazon.ru/strany/gerb-armenii.html>

¹¹⁵ Поцелуев Владимир. Гербы Союза ССР. Москва, Политиздат, 1987 г. Стр. 110-111, <http://www.heraldicum.ru/armenia/soviet.htm>

Төрийн сүлдэн дээрх улсын нэрийг хэд хэдэн удаа засжээ: армени хэлээр “hАйастани Социалистакан Хорhрдайн hАнрапетутюн” гэж байсныг **1940 онд** “hАйкакан Советакан Социалистакан Республика” гэж, **1966 онд** “hАйкакан Советакан Социалистакан hАнрапетутюн” гэж тус тус зассан байна.

2) Бүгд Найрамдах Армени Улс (БНАРУ)¹¹⁶

1992 онд батлагдсан БНАРУ-ын төрийн сүлдний тухай хуулийн дагуу тус улсын анхны буюу 1918 оны төрийн сүлдийг сэргээжээ. 2005 онд шинэ Үндсэн хууль батлагдсаны дараа 2006 онд БНАРУ-ын төрийн сүлдний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан ч төрийн сүлдэнд өөрчлөлт ороогүй байна.

Төрийн сүлдний төв хэсэгт байгаа бамбайг 4 хэсэгт хувааж, нийтийн тооллоос өмнөх II зуунаас нийтийн тооллын XIV зууныг хүртэлх хугацаанд тус улсын түүхэнд тусгаар байсан 4 хаант улсын бэлгэ тэмдгийг дүрсэлсэн байдаг. Бамбайн дээрх арслан загалмайтай байгаа нь тус улсыг Христийн шашинтай улс гэдгийг, нарны хоёр талын 2 бүргэд нь тус улсын өргөн уудам нутаг дэвсгэрийг илэрхийлж байдаг.



Бамбайн төвд эртний үндэсний бэлгэдэл болох Арарат уул, түүний орой дээр Библи дээр гардаг Ноагийн хөвөгч авдар (Ноев ковчег) байдаг. Их үерийн дараа Ноагийн хөлөг авдар хамгийн түрүүнд Арарат уулан дээр буусан хэмээн эртний домогт өгүүлдэг.

Бамбайн хоёр талаас нь эрх мэдэл, хүч чадал, тэвчээр хатуужлыг илэрхийлдэг арслан, бүргэд хамгаалж байдаг. Бамбайг доод хэсэгт таван элементийг дүрсэлсэн байдаг: сэлэм нь дайчин мөн чанарыг, гинж нь эрх чөлөө, тусгаар тогтнолыг, чидун жимсний мөчир нь арменчуудын оюун ухаан, соёлын баялаг өвийг, тариан түрүү нь арменчуудын хөдөлмөрч зан чанарыг, гурван өнгийн тууз нь Армени Улсын тугийг илэрхийлдэг. Төрийн сүлд нь үндсэн алтан өнгөнөөс гадна тус улсын төрийн далбааны улаан, цэнхэр, улбар шар өнгөтэй байна.

3.3.3. Беларусь Улс

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Беларусь Улс (ЗСБНБУ)¹¹⁷

ЗСБНБУ 1919 онд байгуулагдаж, 1922 онд Орос, Украин, Өвөр Кавказ болон тус улсын гэрээгээр байгуулагдсан ЗХУ-д орсон байна.

1919 онд батлагдсан тус улсын анхдугаар Үндсэн хуульд зааснаар төрийн сүлд нь нарны туяанд улаан дэвсгэр дээр алтан алх, хадуурыг хөндлөн байрлуулсан, тариан түрүүгээр хөвөөлсөн байв. Түүний дээд хэсэгт улсын нэрийн “Б.С.С.Р.” товчлол, төрийн сүлдний доод хэсэгт “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг беларусь хэлээр бичжээ. Энэхүү төрийн сүлд нь тухайн үеийн Орос Улсын төрийн сүлдний загвартай төстэй болжээ.



¹¹⁶ <https://www.president.am/ru/state-symbols/> , <https://geraldika.ru/>

¹¹⁷ Поцелуев Владимир. Гербы Союза ССР. Москва, Политиздат, 1987 г. Стр. 108-109, <http://www.heraldicum.ru/belarus/index.htm>

1927 онд тус улсын Зөвлөлүүдийн VIII их хурлаар шинэ төрийн сүлдийг тодорхойлж, Үндсэн хуульд бататган тусгажээ. Шинэ төрийн сүлд нь зүүн талдаа тариан түрүү, хошоонгор цэцгээр, баруун талдаа царс модны мөчрөөр хөвөөлсөн дугуй хэлбэртэй болов. Түүний доод хэсэгт дэлхийн дүрсэлсэн бөмбөрцгийн цаанаас мандаж байгаа нарны туяанд алх, хадуурыг дүрсэлжээ. Оройн хэсэгт таван хошууг нэмсэн бөгөөд ургамлын хэмжээг улаан туузаар ороож, уриаг беларусь, еврей, орос, польш хэлээр бичжээ. Харин хэлхээг холбосон доод талын туузан дээр тус улсын нэрийн товчлолыг бичсэн байв.



1937 онд батлагдсан шинэ Үндсэн хуульд төрийн сүлдийг хэвээр нь үлдээжээ. Мөн тус улсын Гүйцэтгэх төв хорооны Тэргүүлэгчдийн “ЗСБНБУ-ын төрийн сүлд, төрийн тугны тухай” зарлигаар төрийн сүлдний албан ёсны загварыг тогтоосон байна.

1958 онд улсын нэрийн товчлолын цэгийг авсан байна.

Энэ хугацаанд 1919 онд беларусь хэл дээр “Пролетарыі усіх краеу, злучайцеся!” гэж батлагдаж байсан уриа дараах байдлаар өөрчлөгджээ:

- 1927 онд “Пролетары усіх краін, злучайцеся!”;
- 1938 онд “Пролетарыі усіх краін, злучайцеся!”;
- 1958 онд “Пролетарыі усіх краін, яднайцеся!”.

1978 онд төрийн сүлдний баруун талд байсан царс модны мөчрийг тариан түрүү, маалингаар сольж, уриаг беларусь, орос хэлээр болгон сольжээ.

1981 онд төрийн сүлдний элементүүдийн хэлбэр, өнгийг илүү тодруулсан ба түүний төвд байх алх, хадуур болон бичээсүүдийг алтан өнгөтэй болгон өөрчилжээ.



2) Бүгд Найрамдах Беларусь Улс (БНБУ)¹¹⁸

1991 онд БНБУ “Погоня” нэртэй шинэ төрийн сүлдийг баталжээ. Энэ нь 1918 оны Бүгд Найрамдах Беларусь Ард Улс болон Литвийн их гүнт улсын төрийн сүлдийг тусгаар тогтносон БНБУ-ын төрийн сүлд болгон сэргээв.

1995 оны 05 дугаар сард явуулсан бүх нийтийн санал асуулгын дүнг үндэслэн БНБУ-ын Ерөнхийлөгчийн **1995 оны** 213 дугаар зарлигаар “БНБУ-ын төрийн сүлдний стандарт, журам”-ыг баталж, тус улс ЗХУ-ын үед хэрэглэж байсан төрийн сүлдээ уламжлан хэрэглэхээр тогтжээ. 2004 онд батлагдсан Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар төрийн сүлдний тодорхойлолт, түүнийг хэрэглэх журмыг зохицуулсан байна.



¹¹⁸ <https://rus.azattyq.org/a/ussr-ex-soviet-state-symbols-national-emblems-gallery/31045608.html>

Төрийн сүлдний доод хэсэгт бөмбөрцгийн цаанаас ургах нарны туяан дээр улсын хилийн хүрээг ногоон өнгөөр зурсан байна. Төрийн сүлдний дээд хэсэгт улаан таван хошууг байна. Төрийн сүлд нь хошоонгор болон маалингын цэцэгстэй алтан тариан түрүүгээр хөвөөлсөн дугуй хэлбэртэй. Энэхүү хэлхээ нь хоёр талдаа улаан, ногоон туузаар гурван удаа ороож, төв хэсэгт нь тус улсын нэрийг бичсэн байна.



Тус улс нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн бусад Бүгд найрамдах улсуудаас төрийн сүлдэндээ “улаан од” буюу улаан таван хошууг хэвээр авч үлдсэн цорын ганц улс юм. Энэхүү улаан таван хошуу нь “Улаан од” хэмээх коммунизмын тухай роман 1908 онд хэвлэгдсэний дараа коммунист системтэй холбоотой болсон гэж үздэг.

2012 онд Беларусь Улсын төрийн сүлдний зарим элементийн дүрс, өнгө өөрчлөгджээ.

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн бусад Бүгд найрамдах улсуудаас Беларусь Улс нь хамгийн сүүлд буюу **2021 оны** 01 дүгээр сард төрийн сүлдэндээ өөрчлөлт оруулсан. Энэ үед төрийн сүлдний зарим элементийг хэлбэр, өнгөний хувьд өөрчилжээ. Тухайлбал, дэлхийн бөмбөрцгийг бага зэрэг эргүүлснээр Европ тив “илүү их”, Орос Улсын нутаг дэвсгэр “илүү бага” дүрслэгдэх болсон. Мөн улсын хилийн хүрээг ногоон өнгөтэй байсныг алтан шар болгож өөрчилсөн.



3.3.4. Гүрж Улс¹¹⁹

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Гүрж Улс (ЗСБНГУ)

1921 онд ЗСБНГУ-ыг тунхагласны дараа тус улсын Хувьсгалт хороо (Ревком)-ноос шинэ төрийн сүлдийг баталжээ. Тус улсын төрийн сүлдэнд дугуй улаан дэвсгэрийн дээд хэсэгт – туяа цацруулсан таван хошууг, доод хэсэгт – цасан уулыг, баруун талд – тариан түрүүг, зүүн талд – усан үзмийн модыг, дунд хэсэгт – алтан алх, хадуурыг дүрсэлсэн байна. Эдгээрийн эргэн тойронд “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг гүрж, орос, франц хэлээр бичиж, гадна талаар үндэсний хээ угалзаар хүрээлсэн байна.

1922 онд Азербайжан, Армени, Гүрж зэрэг Өмнөд Кавказын улсууд нэгдэн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Өвөр Кавказ Улс байгуулагдсан боловч 1936 онд задарчээ.

1922, 1927 онд тус улсын Үндсэн хуулийг шинэчлэн баталсан бөгөөд ингэхдээ төрийн сүлдийг хэвээр үлдээсэн байна.

1937 онд шинэ Үндсэн хууль батлагдсан ба энэ үед ЗХУ-ын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн дэргэд байгуулагдсан комиссын саналаар төрийн сүлднээс франц хэл дээрх уриаг хасаж Үндсэн хуульд тусгажээ.

1978 онд дахин шинэ Үндсэн хууль баталсан ба энэ үед төрийн сүлдэнд улсын нэрийн товчлолыг гүрж хэлээр нэмж оруулсан.



¹¹⁹ <http://www.heraldicum.ru/gruzia/soviet.htm>

2) Бүгд Найрамдах Гүрж Улс (БНГУ)

1990 онд тус улсын Дээд зөвлөлөөс БНГУ-д шилжих шилжилтийн үеийг тунхаглах тухай хууль баталсан. Энэ хуулийн дагуу тус улсын нэрийг БНГУ гэж өөрчилж, үүний дагуу Үндсэн хууль болон төрийн сүлдийг өөрчлөхөөр тогтжээ. Энэ үед 1918-1921 онд оршин тогтнож байсан Гүржийн Ардчилсан Бүгд Найрамдах Улсын төрийн сүлдний загвар дээр шинэ төрийн сүлдийг бүтээжээ.



2004 онд БНГУ-ын төрийн их, дунд, бага сүлдийг баталсан байна. Төрийн сүлдийг дундад зууны үеийн Гүржийн сүлдний загвар дээр тулгуурласан байна.



Төрийн их сүлд



Төрийн дунд сүлд



Төрийн бага сүлд

Тус улсын төрийн их сүлд нь гэгээн Георгий морин дээр жадаар лууг хөнөөж буй мөнгөн дүрсийг дүрсэлсэн франц маягийн улаан бамбай юм. Гэгээн Георгий бол тус улсын ивээн тэтгэгч гэгээнтэн бөгөөд төрийн сүлдэн дээрх түүний дүрс нь гүржүүдийн үнэн алдартны шашныг илтгэдэг. Мөн дайчин, ялагч гэгээн Георгий нь Гүржийн ард түмний дайчин, зоригтой дүр төрхийг илэрхийлдэг.

Алтан титэм (Иверийская корона)-ийн оройд бөмбөрцөг, загалмай байгаа нь Гүржийн бүрэн эрхт байдал эргэн ирснийг бэлгэдэх ба мөн үнэн алдартны шашныг төлөөлдөг байна. Энэхүү бамбайг хоёр талаас нь хүч чадал, эр зориг, өгөөмөр сэтгэлийн бэлгэ тэмдэг болсон хоёр алтан арслан хамгаалж барьдаг. Бамбайн доор “Эв нэгдэл дэх хүч чадал” гэсэн уриа бүхий туузыг дүрсэлсэн байна.

БНГУ-ын төрийн сүлдний өнгө нь мөн л уламжлалт утгыг илэрхийлж байдаг: улаан өнгө нь эр зоригийг, алтан өнгө нь эд баялаг, эрх мэдлийг, мөнгөн өнгө нь өгөөмөр сэтгэл, цэвэр ариун бодлыг тус тус илэрхийлдэг.

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН

3.3.5. Казахстан Улс¹²⁰**1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Казахстан Улс (ЗСБНКаУ)**

ЗСБНКаУ 1936 онд тухайн үеийн Орос Улсын автономит улсын статусаас гарч, Бүгд найрамдах улс болон ЗХУ-ын бүрэлдэхүүнд оржээ.

1937 онд батлагдсан Үндсэн хуульд зааснаар төрийн сүлдний дээд талд нь таван хошуу байрлаж, хоёр талаар нь тариан түрүүгээр хөвөөлсөн, төв хэсэгт нь улаан дэвсгэр дээр алх, хадуур байна. Улсын нэрийн товчлол, “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг казах, орос хэлээр бичжээ. Энэхүү төрийн сүлд нь тухайн үеийн Орос Улсын төрийн сүлдний загварт үндэслэж бүтээгдэж байв.



1940 онд тус улс латин үсгээс кирилл үсэг рүү шилжсэний дараа бүх казах бичвэрийг засаж, мөн алхыг хадуурын дээр байрлуулж, **1950 онд** төрийн сүлдний оройн хэсэгт таван хошуу нэмжээ.

Харин **1978 онд** төрийн сүлдний элементүүдийн дүрс, өнгийг өөрчилжээ. Тухайлбал, хурц улаан өнгийг бүдгэрүүлж, нарны туяаны тоог багасгаж, хадуурыг дахин алхны дээр байрлуулжээ.

2) Бүгд Найрамдах Казахстан Улс (БНКаЗУ)

1992 онд БНКаЗУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан тус улсын төрийн сүлдний төвд “юрта” буюу гэрийн тооныг дүрсэлсэн. Нарны туяа нь гэрийн унь хэлбэрээр тусдаг. Хоёр хажуу талаар дүрсэлсэн домгийн далавчтай морьд нь тооныг хамгаалдаг аж. Морьдын далавчийг улаан буудайн түрүүтэй төстэй байдлаар дүрсэлсэн байна. Төрийн сүлд нь алтан болон тэнгэрийн хөх өнгөтэй.



Төрийн сүлдний “шанырак” буюу гэрийн тооны бат бөх байдал нь уринаас хамаарч байдаг шиг аз жаргал нь хүн бүрийн сайн сайхан байдлаас хамаарна гэдгийг илэрхийлдэг. Тооно нь эцгийн гэр, өргөн утгаараа орчлон ертөнцийг бэлгэддэг. Мөн тоонд байгаа хөндлөн гурван нум нь гурван муж улсын эв нэгдлийг илэрхийлдэг.

Домгийн далавчтай морьд болох “тулпар”-уудыг иссыкийн Алтан хүн (иссыкский Золотой человек)-ий дуулгаар чимэх бөгөөд морьдын далавч нь хүчирхэг, цэцэглэн хөгжсөн улсыг бий болгох мөрөөдлийг бэлгэддэг. Мөн морьд нь цэвэр ариун бодол санаа, нийгэм, байгаль, дэлхийн соёл иргэншилтэй зохицох хүсэл эрмэлзлийг гэрчилдэг. Тооныг хоёр талаас нь хамгаалж байгаа морьд бол эх орноо нүдний цөцгий мэт хамгаалж, эх орондоо үнэнчээр зүтгэхийг илэрхийлдэг.

Таван хошууг БНКаЗУ-ын анхны Ерөнхийлөгч Н.А.Назарбаевын саналаар нүүдэлчин ард түмний чиглүүлэгч од, Казахстаны өөрийн гэсэн хөгжлийн замналыг бэлгэдэн оруулжээ. Төрийн сүлдний дугуй хэлбэр бол ертөнц, мөнх амьдрал, эв нэгдэл, тусгаарлагдмал байдлын дүр төрх бөгөөд казахуудын нүүдэлчин амьдралын хэв маягийн бэлгэдэл юм.

¹²⁰ <http://www.heraldicum.ru/kazakstn/index.htm>

БНКаЗУ-ын төрийн хоёр бэлгэ тэмдэг болох төрийн сүлд, далбааг ижил өнгөөр хийсэн бөгөөд дараах агуулгатай: цэнхэр өнгө нь казахуудын энх тайван, амар амгалан, хөгжил цэцэглэлт, цэвэр ариун байдлын бэлгэдэл төдийгүй мөн Казахстаны хязгааргүй тэнгэрийг, алтан өнгө нь амьдрал, хөгжил цэцэглэлтийн бэлгэ тэмдэг аж.¹²¹

2025 онд тус улс латин үсэгт шилжихтэй холбогдуулан **2018 онд** кирилл үсгээр “Казахстан” гэж бичсэнийг латин үсгээр сольжээ.

3.3.6. Киргиз Улс

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Киргиз Улс (ЗСБНКиУ)¹²²

ЗСБНКиУ 1936 онд автономит улсын статусаас гарч, Бүгд найрамдах улс болон ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсон байна. **1937 онд** батлагдсан шинэ Үндсэн хуулийн дагуу тус улсын төрийн сүлдний доод хэсэгт алх, хадуур, түүний дээд талд үндэсний хээ угалз бүхий цэнхэр нуман хаалга байна. Уг хаалгаар Алатау уулсын цаанаас ургах нарыг дүрсэлжээ. Нуман хаалганы гадна талаар хөвөнгийн мөчир, тариан түрүүгээр хөвөөлсөн бөгөөд түүнийг улаан туузаар ороож, “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг киргиз, орос хэлээр бичсэн байв. Доод талын туузан дээр улсын нэрийг киргиз хэлээр бичжээ.

1937 онд киргиз хэл дээрх уриа “Бүх дэлхийн пролетариуд нэгдэгтүн!” гэж байсныг залруулсан бол **1940 онд** тус улс шинэ үсэгт шилжсэнтэй холбогдуулан тус улсын нэр болон уриаг мөн өөрчилжээ.

1948 онд Үндсэн хуулийн 115 дугаар зүйлд “Төрийн сүлдний дээд талд таван хошуу”-г нэмсэн бол **1956 онд** зөв бичгийн дүрмийн дагуу улсын нэрийн товчлолын цэгүүдийг хасжээ.



2) Бүгд Найрамдах Киргиз Улс (БНКиУ)¹²³

1994 онд тус улсын Дээд зөвлөлөөс баталсан “Төрийн сүлдний тухай” 1429-XII дугаар тогтоолд тус улсын шинэ төрийн сүлдийг тодорхойлсон байна. Төрийн сүлдийг 2004 оноос БНКиУ-ын төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар зохицуулж байна.

БНКиУ-ын төрийн сүлд бол тус улсын ард түмний сэтгэлгээ, байгаль, соёл, засаглалын онцлогийг бэлгэдлийн уламжлалт дүрсээр илэрхийлсэн тойрог байдаг.

Төрийн сүлд нь цагаан хүрээтэй цэнхэр дугуй дүрсний төвд далавчаа дэлгэсэн цагаан шонхор шувуу байна. Түүний цаана Иссyk-Куль нуур, Ала-Тоо цаст уулын оргилуудыг, цаанаас нь ургах нарны туяаг, хоёр талаар нь тус улсын газар тариалангийн гол үр тариа болох хөвөнгийн мөчир, тариан түрүүг дүрсэлсэн байна. Дээд хэсэгт киргиз хэлээр “Киргиз” гэсэн, доод хэсэгт “Бүгд Найрамдах Улс” гэсэн бичээснүүдтэй.

Шонхор шувуу нь сэтгэлгээний цэвэр ариун байдал, эрхэмсэг байдлын бэлгэдэл бөгөөд киргизүүдийн амьдралын хэв маяг, уламжлалт соёлыг илэрхийлж, Киргизийн нутаг



¹²¹ <https://blazon.ru/strany/gerb-kazahstana.html>

¹²² <http://www.heraldicum.ru/kyrgyz/index.htm>

¹²³ https://grs.gov.kg/ru/eid/state_symbols/

дэвсгэрийг хамгаалж байхыг бэлгэддэг. Ургах нарны алтан туяа нь Киргиз Улсын ариун дагшин газар нутгийг гэрэлтүүлж байхыг бэлгэддэг.

3.3.7. Латви Улс¹²⁴

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Латви Улс (ЗСБНЛаУ)¹²⁵

ЗСБНЛаУ Бүгд найрамдах улс болж ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсны дараа буюу **1940 онд** батлагдсан Үндсэн хуулийн дагуу төрийн сүлдэнд далайгаас мандах нарны туяанд тариан түрүүгээр хөвөөлсөн алх, хадуур, дээд хэсэгт таван хошууг дүрсэлж, доод хэсэгт улаан туузан дээр улсын нэрийг латви хэлээр, түүний хоёр талд “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг латви, орос хэлээр бичжээ.



1978 оны Үндсэн хуульд төрийн сүлдний тодорхойлолтыг өөрчлөн найруулжээ.

2) Бүгд Найрамдах Латви Улс (БНЛатУ)¹²⁶

1990 онд БНЛатУ хуучин төрийн сүлдийг дахин залжээ. Уг төрийн сүлдийг БНЛатУ-ын тусгаар тогтнолыг тунхагласны дараа буюу 1921 онд Парламентаас баталж байжээ.

БНЛатУ нь төрийн их, дунд, бага сүлдтэй. Төрийн их сүлд нь гурав хуваасан испани маягийн бамбай байна: дээд хэсэгт ургах нар, зүүн доод хэсэгт улаан арслан, баруун доод хэсэгт баруун сарвуундаа илд барьж байгаа мөнгөн гриффин байна. Бамбайны дээр 3 ширхэг таван хошууг байрлуулсан. Төрийн далбааны улаан-мөнгөн-улаан өнгөтэй туузаар ороосон царс модны мөчир дээр зогссон арслан, гриффин хоёр нь бамбайг хамгаалж байдаг.



Төрийн их сүлд



Төрийн дунд сүлд



Төрийн бага сүлд

Төрийн сүлд нь тусгаар тогтносон БНЛатУ-ын төрийн бэлгэ тэмдэг төдийгүй түүх, соёлын бэлгэдэл болдог. Тухайлбал, арслан, гриффин бол XVI зуунаас уламжлагдан ирсэн бүс нутгийн түүхэн бэлгэ тэмдэг юм. Тэд хамтдаа Баруун болон Зүүн Латвийн нэгдлийг төлөөлдөг.

Алтан нар нь төр улсыг, гурван ширхэг таван хошуу од нь Латви Улс болж нэгдсэн түүхэн нутгууд (Курземе-Земгале, Видземе болон Латгале)-ыг илэрхийлдэг. Царс модны мөчир нь хүч чадал, тогтвортой байдлыг илэрхийлдэг. Модны дүр төрх нь Балтын орнуудын үндэсний бэлгэдэлтэй холбоотой байдаг.

¹²⁴ <https://rus.azattyq.org/a/ussr-ex-soviet-state-symbols-national-emblems-gallery/31045608.html>

¹²⁵ <https://web.archive.org/web/20110814035414/> , <http://www.heraldicum.ru/latvija/latssr.htm>

¹²⁶ http://latvia-spb.com/9_2_2_1.html

Туузны улаан зураас нь улс орны тусгаар тогтнолын төлөөх тэмцлийг, голын цагаан зураас нь эрх чөлөө, үндэсний нэр төр, шударга төрийн илэрхийлэл юм.

БНЛатУ-д төрийн сүлдийг хэрэглэх нарийн зохицуулалттай. Тухайлбал, төрийн их сүлдийг тус улсын Ерөнхийлөгч, Сейм (Парламент), түүний хороод, гишүүд, Сайд нарын зөвлөлийн дарга, яамд, тусгай үүрэг бүхий сайд нар, Төрийн аудитын газар, Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, Прокурорын ерөнхий газар, Латви Улсын банк, тус улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газар зэрэг субъектүүд хэрэглэнэ.

Төрийн дунд сүлдийг дээрх субъектүүдийн ажлын албад болон Парламентаас сонгосон, эсхүл баталсан байгууллагууд, албан тушаалтнууд, Засгийн газрын шууд харьяанд, эсхүл хяналтад байдаг байгууллагууд хэрэглэнэ. Мөн тойргийн болон дүүрэг (хот)-ийн шүүх, Иргэний бүртгэлийн газар, Сонгуулийн хороо, нийтийн эрх зүйн өөрөө удирдах байгууллагууд, тангараг өргөсөн нотариатчид зэрэг субъектүүд хэрэглэнэ. Мөн дээд боловсролын байгууллагын, магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрт хамрагдсан боловсрол, мэргэшлийг баталгаажуулсан диплом, гэрчилгээнд төрийн дунд сүлдийг тавьж болно.

Харин төрийн бага сүлдийг төрийн бусад байгууллагууд, өөрийн гэсэн албан ёсны сүлдгүй орон нутгийн засаг захиргааны байгууллагууд зэрэг субъектүүд хэрэглэнэ.

3.3.8.Литва Улс¹²⁷

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Литва Улс (ЗСБНЛиУ)¹²⁸

1940 онд Бүгд найрамдах улс болон ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсон ЗСБНЛиУ-ын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн “ЗСБНЛиУ-ны төрийн тэмдэг (сүлд)-ийн тухай” зарлигаар төрийн сүлдийг баталжээ.

Төрийн сүлд нь ургах нарны туяанд алтан алх, хадуур, царс мод, тариан түүгээр хөвөөлсөн, түүнийг улаан туузаар ороосон ба зүүн талд нь “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг литва хэлээр, баруун талд нь орос хэлээр бичсэн байв. Дээд хэсэгт таван хошуу, доод хэсэгт тус улсын нэрийн товчлолыг литва хэлээр бичсэн байв.

Царс модны навч нь төрт ёс, хүч чадлыг бэлгэддэг байна. Литвийн ард түмэн эртнээс энэхүү хүчирхэг модыг дээдэлж иржээ.

Төрийн сүлдний талаар 1978 оны Үндсэн хуульд тусгажээ.



2) Бүгд Найрамдах Литва Улс (БНЛитУ)

1991 оны 07 дугаар сарын 29-ний өдөр Москва хотод ЗХУ ба БНЛитУ-ын хооронд “Улс хоорондын харилцааны үндэс суурь болох тухай” гэрээнд гарын үсэг зурсны дагуу талууд бие биеийхээ бүрэн эрх, тусгаар тогтнолын эрхийг хүлээн зөвшөөрөв.

1990 онд батлагдсан БНЛитУ-ын төрийн сүлдний тухай хуульд **1991 оны** 09 дүгээр сарын 04-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн сүлдийг шинэчилсэн байна.

¹²⁷ <https://f-gl.ru>, <http://www.heraldicum.ru/lietuva/index.htm>

¹²⁸ Поцелуев Владимир. Гербы Союза ССР. Москва, Политиздат, 1987 г. Стр. 143.

1992 оны 10 дугаар сарын 25-ны өдөр тус улсын Үндсэн хуулийг бүх нийтийн санал асуулгаар баталсан. Үндсэн хуулийн 15 дугаар зүйлд “Төрийн сүлд нь улаан дэвсгэр дээр цагаан Витис байна” хэмээн заажээ.

Литва Улсын төрийн сүлд болох “Витис” нь испани маягийн улаан бамбай байна. “Витис” нь улсын хилийг манаж буй хуягт баатар гэсэн утгатай. Бамбайн дээр баруун гартаа сэлэм өргөж барьсан хуягтай морьтон бөгөөд морьтон нь давхар загалмайг дүрсэлсэн цэнхэр бамбайтай байна.



Энэхүү төрийн сүлд нь Европын хамгийн эртний сүлднүүдийн нэг юм. Тус улсын оршин тогтносон түүхэнд “Витис” өөрчлөгдөөгүй. Зөвхөн хуучин ЗХУ-ын үед л тус улсын төрийн сүлдэнд морьтныг дүрслээгүй байв.

1990 онд батлагдсан БНЛитУ-ын төрийн сүлдний тухай хуульд **1991 онд** нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн сүлдийг шинэчилсэн байна.

3.3.9. Молдова Улс

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Молдова Улс (ЗСБНМОУ)¹²⁹

1940 онд батлагдсан тус улсын Үндсэн хуульд төрийн сүлдийг тодорхойлжээ. Төрийн сүлд нь ургах нарны туяанд алх, хадуур байна. Алх, хадуурыг эрдэнэ шиш, тариан түрүүгээр хөвөөлсөн ба ишийг нь усан үзэм, жимсээр холбосон байв. Хэлхээг улаан туузаар ороож, түүн дээр улсын нэрийн товчлолыг, хоёр талд нь “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг молдова, орос хэлээр бичжээ. Төрийн сүлдний оройн хэсэгт улаан таван хошууг байрлуулсан байв.



1952 онд тус улсын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар батлагдсан “ЗСБНМОУ-ын төрийн сүлдний тухай журам”-д төрийн сүлдний элементүүдийн өнгийг тодорхой заажээ.

1978 онд шинэчлэн батлагдсан Үндсэн хууль, 1981 онд Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар батлагдсан “Төрийн сүлдний тухай журам”-аар төрийн сүлдэнд өөрчлөлт ороогүй.

2) Бүгд Найрамдах Молдова Улс (БНМУ)¹³⁰

1990 онд батлагдсан БНМУ-ын төрийн сүлд нь тус улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, эв нэгдэл, хуваагдашгүй байдлын албан ёсны гол бэлгэ тэмдгийн нэг юм.

Төрийн сүлд нь бүргэдийн цээжинд байрласан улаан, цэнхэр өнгөтэй бамбай байна. Бамбайны голд бухын толгой, эвэр хооронд нь найман хошуутай од, толгойн баруун талд таван дэлбээтэй сарнай, зүүн талд нь хавирган сарыг дүрсэлсэн байна.

Хошуундаа загалмайтай бүргэд нь молдовачуудын эртний Ромын гарал үүслийг, түүний сарвуун дахь чидун жимсний мөчир нь энх тайвныг, очирт таяг нь бүрэн эрхт байдлыг илэрхийлдэг.



¹²⁹ <http://www.heraldicum.ru/moldova/mssr.htm>

¹³⁰ <https://www.presedinte.md/rus/emblem>

3.3.10.Тажикистан Улс¹³¹

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Тажикистан Улс (ЗСБНТаУ)

1924 оноос Узбекистан Улсын бүрэлдэхүүнд байсан Автономит Бүгд Найрамдах Тажик Улс нь 1929 онд Бүгд найрамдах улс болж, ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсон.

1931 онд батлагдсан Үндсэн хуульд зааснаар тус улсын төрийн сүлд нь таван хошуу байна: дээд хэсэгт – нарны туяанд алх, хадуурыг, доод хэсэгт – уулын энгэрт үйлдвэрийн барилга, төмөр зам, галт тэрэгний зүтгүүр, трактор, хонин сүрэг зэргийг дүрсэлжээ. Таван хошуу нь улаан буудайн түрүү, хөвөнгийн мөчрөөр хөвөөлж, доор нь усан үзмийг дүрсэлжээ. Төрийн сүлдний доод талд улсын нэрийг, дээд талд “Бүх дэлхийн пролетариуд нэгдэгтүн!” уриаг тажик, орос болон эртний араб хэлээр бичжээ.



Төрийн сүлдэнд дүрсэлсэн галт тэрэгний зүтгүүр нь зөвхөн техникийн хөгжлийг төдийгүй шинэ нийгмийн улс төр-нийгмийн үсрэнгүй хөгжлийг илэрхийлж байв.

1935 онд тус улсын Зөвлөлүүдийн V их хурлаар Үндсэн хуулиа шинэчлэн батлахдаа төрийн сүлд дээрх улсын нэрийг “ТаджСССР” гэж товчилсон хэлбэрээр оруулжээ.

1937 оны 01 дүгээр сард батлагдсан Үндсэн хуулиар баталгаажуулсан шинэ төрийн сүлд нь өмнөх загвараас ялгаатай нь алх, хадуурыг хүр хорхойтой усан үзмэн дээр байрлуулж, уриаг хэлхээг ороосон тууз руу шилжүүлжээ. Мөн хэлхээний дотор тариалангийн талбай, суваг, трактор, хоёр хонь, улаан туг бүхий усан цахилгаан станц, газрын тосны цооног, уулс, модыг, мөн уулсын цанаас ургах нарны туяанд тажик хэлээр тус улсын нэрийг бичиж, оройн хэсэгт улаан таван хошууг дүрсэлжээ. Хэлхээг ороосон туузан дээр уриаг тажик, орос бичжээ.



1937 оны 05 дугаар сард Гүйцэтгэх төв хорооны Тэргүүлэгчдийн шийдвэрээр төрийн сүлдний зарим элементүүдийн дүрс, өнгийг өөрчилжээ. Харин **1938 онд** төрийн сүлдний улсын нэрийн бичилтэд өөрчлөлт оруулжээ: “Ҷумһуријат” гэх үгний эхний “Ҷ” үсгийг “Respublika” гэх үгний эхний “R” үсгээр өөрчилснөөр улсын нэрийн товчлол “RSS Tadjikiston” гэж бичих болсон.

1940 онд шинэчлэн баталсан Үндсэн хуульд зааснаар шинэ төрийн сүлд нь таван хошуу дүрсээс бүрдэх бөгөөд түүний дээд хэсэгт ургах нарны туяанд алх, хадуурыг улаан таван хошуун дээр дүрсэлжээ. Таван хошууны хоёр талд хөвөнгийн мөчир, тариан түрүүгээр хөвөөлсөн байна. Улаан туузан дээр улсын нэрийг болон “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг тажик, орос хэлээр бичсэн байв.



¹³¹ <https://rus.azattyq.org/a/ussr-ex-soviet-state-symbols-national-emblems-gallery/31045608.html>

2) Бүгд Найрамдах Тажикистан Улс (БНТадУ)

1992 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр БНТадУ-ын Дээд зөвлөлийн “зохицуулах” XVI чуулганаар “Төрийн сүлдний тухай журам”-ыг баталжээ. Уг тогтоолд зааснаар төрийн сүлд нь уулсын цаанаас ургах нарны туяанд далавчтай арслан байна. Арсланг гурван өнгийн туузаар ороосон улаан буудайн түрүүгээр хөвөөлсөн байна. Дээд талд титэм болон хагас тойрог хэлбэрээр байрлуулсан долоон одыг дүрсэлсэн байв.



Шуудангийн марк дээрх төрийн сүлд (1994 он)

1993 онд батлагдсан БНТадУ-ын одоогийн төрийн сүлд нь цасан уулсын цаанаас мандаж буй нарны туяанд титэм болон хагас тойрог хэлбэрээр байрлуулсан долоон од байна. Түүний хоёр талд гурван өнгийн туузаар ороосон хөвөнгийн мөчир, тариан түрүүгээр хөвөөлжээ. Доод хэсэгт дэлгэсэн номыг тавиур дээр байрлуулсан байна.



3.3.11. Туркменистан Улс¹³²

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Туркменистан Улс (ЗСБНТуУ)¹³³

1924 онд ЗСБНТуУ байгуулагдан ЗХУ-д нэгдэн оржээ.

1927 онд батлагдсан тус улсын Үндсэн хуульд зааснаар төрийн сүлд нь тариан түрүүгээр хөвөөлсөн дугуй байна. Уг дугуйг дөрвөн хэсэгт хуваасан: Копетдаг уулсын хормойд хоньчин хонин сүрэгтэйгээ; тэмээ, трактор; хөвөнгийн мөчир; усан үзмийг дүрсэлсэн ба “салор гель” буюу хивсний зургийг төв хэсэгт нь байрлуулсан.



Тариан түрүүг улаан туузаар ороож, дээр нь “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг туркмен, орос хэлээр бичиж, доод хэсэгт нь ургах нарны туяанд алх, хадуурыг, оройн хэсэгт нь таван хошууг дүрсэлжээ.

Тус улсын төрийн сүлдний нэг онцлог элемент бол туркмен үндэстний “салыр гель” буюу хивс юм. Туркменистан Улс эртнээс уламжлалт хээгээр нэхсэн хивсээрээ алдартай байсан. “Гель”-ийг салыр, йомут, эрсар гэсэн үндсэн 3 төрөлд хуваадаг. Туркменистаны олон угсаатнуудын нэг болох салырчуудын хийдэг “салыр гель” нь тус улсын хивс урлалын “өвөг” гэж үздэг байна.

¹³² <http://www.heraldicum.ru>

¹³³ Поцелуев Владимир. Гербы Союза ССР. Москва, Политиздат, 1987 г. Стр. 115-117.

1937 онд шинэчлэн батлагдсан Үндсэн хуулийн дагуу төрийн сүлд нь ургах нарны дэвсгэр дээр алх, хадуур, таван хошуу, үйлдвэрийн барилгуудыг дүрсэлсэн байв. Тариан түрүү, хөвөнгийн мөчрөөр хөвөөлсөн ба хэлхээг улаан туузаар ороож, дээр нь уриаг туркмен, орос хэлээр бичиж, доод талын төв хэсэгт нь хивс байрлуулжээ.



Тус улс хоцрогдсон улсаас үйлдвэржсэн улс болон хөгжиж байгаа илтгэж төрийн сүлдэнд үйлдвэрийн барилгуудыг ийнхүү оруулсан байв.

1940 онд тус улс кирилл үсэгт шилжсэнтэй холбогдуулан төрийн сүлд дээрх бичээсийг өөрчилжээ.

1946 онд туркмен хэл дээрх уриа “Бүх дэлхийн пролетариуд нэгдэгтүн!” гэж байсныг залруулжээ.



1977 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн дагуу төрийн сүлдэнд улсын нэрийн товчлолыг нэмсэн бөгөөд элементүүдийн дүрс, өнгийг өөрчилсөн байна.

2) Бүгд Найрамдах Туркменистан Улс (БНТурУ)

1992 онд батлагдсан БНТурУ-ын төрийн сүлдний тухай хуулиар төрийн сүлдний гадна талын улаан хүрэн тойрогт 7 ширхэг хөвөнгийн булцуу, тариан түрүүгээр хөвөөлж, тойргийн дээд хэсэгт хавирган сар болон 5 ширхэг таван хошуу од дүрсэлсэн байна. Уг дугуй тойргийн дотор байх алтан шаргал тойрогт үндэсний хээтэй 5 ширхэг хивсийг, голын цэнхэр тойрогт цагаан ахалтек морь (Гырат)-ийг тус тус дүрсэлжээ.



2000 онд БНТурУ-ын төрийн сүлдний тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр төрийн сүлдний элементүүдийн өнгө, хэмжээ өөрчлөгдөв.

Мөн төв хэсэгт байгаа ахалтек морь нь “Янардаг” болохыг тодорхой болгож хуульчилжээ.



2003 онд Халк Маслахат (Парламентын дээд танхим)-ын хуралдаанаар шинэ төрийн сүлдийг санал нэгтэй баталжээ. Энэ үеэр мөн Төрийн сүлдний тухай хуулийг шинэчлэн батлав.

Төрийн сүлд нь алтан шар хүрээтэй ногоон өнгийн найман өнцөгт байх ба түүн дотор улаан, цэнхэр өнгийн хоёр дугуй тойрог байна. Найман өнцөгт нь эртнээс уламжлагдан ирсэн бөгөөд энх тайван, хөгжил цэцэглэлтийг бэлгэддэг аж.



Ногоон өнгийн найман өнцөгтэй дүрсэнд 5 ширхэг таван хошуу одтой хавирган сар, тариан түрүү, хөвөнгийн мөчир зэрэг тус улсын үндэсний баялаг, төрийн бэлгэдлийн гол элементүүд байна.

Улаан дугуй тойрогт ахалтек, салыр, эрсар, човдур, йомут хивсийг дүрсэлсэн нь туркменчуудын найрамдал, эв нэгдлийг илэрхийлжээ. Цэнхэр дугуй тойрогт “Янардаг”

ахалтек морь байна. Төрийн сүлдний тухай хуульд зааснаар “Янардаг морь бол тусгаар тогтносон төвийг сахисан Туркменистан Улсын анхны бөгөөд насан туршийн Ерөнхийлөгч Сапармурад Ниязов Туркменбашигийн ахалтек морь бөгөөд туркменчуудын бахархал, өвөрмөц ахалтек үүлдрийн сонгодог дээжийн илэрхийлэл юм.” гэсэн байна. БНТурУ-ын тусгаар тогтнолтой чацуу (1991 он) энэ морийг мөн “Алтын-Даг” гэж нэрлэдэг байжээ.

3.3.12. Узбекистан Улс

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Узбекистан Улс (ЗСБНУЗУ)¹³⁴

1925 онд ЗСБНУЗУ байгуулагдсаны дараа тус улсын Гүйцэтгэх төв хорооноос баталсан “Төрийн сүлд, төрийн далбааны тухай” 67 дугаар тогтоолоор Үндсэн хууль батлах хүртэл түр хугацаанд хэрэглэх төрийн сүлдийг баталжээ.

Төрийн сүлд нь нарны туяанд алх, ураг хадуур (узбек хадуур) байх ба хөвөнгийн мөчир, тариан түрүүгээр хөвөөлсөн байв. Тэдгээрийн ишийг холбосон туузан дээр улсын нэрийн “УзССР” товчлолыг узбек, орос хэлээр бичжээ. Дээд хэсэгт таван хошуу, улаан туузыг дүрсэлжээ. Төрийн сүлдийг тойруулан “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг узбек, орос хэлээр бичжээ.

1927 онд батлагдсан анхдугаар Үндсэн хуулиар төрийн сүлдний зөвхөн улсын нэр, уриаг тажик хэлээр нэмж бичихээр тогтжээ.

Тус улс нь узбек үсгээс латин үсэг рүү шилжсэнтэй холбогдуулан **1929 оны** 02 дугаар сард гарсан Гүйцэтгэх төв хорооны шийдвэрийн дагуу 05 дугаар сард нь тус улсын Зөвлөлүүдийн III их хурлаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулжээ.

Мөн онд ЗСБНУЗУ-ын бүрэлдэхүүнд байсан Автономит Бүгд Найрамдах Тажик Улс (1924-1929 оны хооронд) нь ЗСБНТаУ болж ЗХУ-д нэгдэн оржээ. Энэ үйл явдлын дараа **1931 онд** Зөвлөлүүдийн IV их хурлаар Үндсэн хуульд өөрчлөлт орж, шинэ төрийн сүлдтэй болсон байна.

Төрийн сүлд нь дэлхийн бөмбөрцгийн цаанаас ургах нарны туяанд алх, хадуур, хөвөнгийн мөчир, тариан түрүүгээр хөвөөлсөн байна. Хэлхээсийг ороосон туузан дээр “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг узбек, орос хэлээр бичжээ. Хэлхээг холбосон туузан дээр улсын нэрийн товчлолыг узбек хэлээр бичсэн байв. Төрийн сүлдний орон хэсэгт улаан таван хошууг байрлуулжээ.

Тус улс латин үсэгт шилжсэнтэй холбогдуулан **1937 онд** Үндсэн хуульд тусгасан байна: тус улсын нэр “ӨЗ.б.Ş.Ç.” гэж байсныг “OzSSR.” гэж, уриа “BYTYN DUNJA PROLETARLARI, BIRLAŞIN;IZI!” гэж байсныг “BUTUN DUNJA PROLETARLARI, BIRLAŞIN;IZI!” гэж тус тус өөрчилжээ.



¹³⁴ <http://www.heraldicum.ru/uzbekstn/ussr.htm>

ЗСБНУзУ дахин кирилл үсэгт шилжсэнтэй холбогдуулан **1947 онд** Үндсэн хуульд өөрчлөлт орж төрийн сүлдний зарим элементүүд өөрчлөгджээ. Тухайлбал, хөвөнгийн мөчир дээр цэцэг нэмэгдэж, алтан алх, хадуурыг мөнгөн алх, узбек хадуураар сольж, узбек хэл дээрх уриаг “БУТУН ДУН’Ё ПРОЛЕТАРЛАРИ, БИРЛАШИНГИЗ!” гэж, улсын нэрийн товчлолыг “Уз.С.С.Р.” гэж өөрчлөгдсөн. Харин **1956 онд** зөв бичгийн шинэ дүрмийн дагуу улсын нэрийн товчлол цэггүй болжээ.



1978 онд Төрийн зөвлөлийн VI ээлжит бус чуулганаар батлагдсан шинэ Үндсэн хуулиар төрийн сүлдний зарим элементүүдийн дүрс, өнгө өөрчлөгджээ. Тухайлбал, мөнгөн алх, “урак” узбек хадуур алтан өнгөтэй болж, узбек, орос хэл дээрх урианы байр солигджээ.



2) Бүгд Найрамдах Узбекистан Улс (БНУзУ)

1991 онд БНУзУ тусгаар тогтнолоо зарлаж, “БНУзУ-ыг тунхаглах тухай” Дээд зөвлөлийн тогтоол батлагджээ.

1992 онд батлагдсан БНУзУ-ын төрийн сүлдний тухай хуулийн дагуу төрийн сүлд нь хөвөнгийн мөчир, тариан түүрүүгээр хөвөөлсөн, хэлхээний дотор Амударья, Сырдарья гэх томоохон голууд, ногоон хөндий тал, уулсын цаанаас ургах нар байна. Дээд хэсэгт найман өнцөгтэй од, түүн дотор хавирган сар ба од байна. Төрийн сүлдний голд далавчаа дэлгэсэн Хумо шувуу байна. Хэлхээг төрийн далбааны өнгөтэй туузаар холбож, туузан дээр улсын нэрийг бичсэн байна.



Төрийн сүлдэнд дээр дүрсэлсэн Амударья, Сырдарья гэх томоохон голууд нь мөнх амьдралыг, тариан түүрүү (улаан буудай) – баялгийг, хөвөнгийн мөчир – ард түмний зүрх сэтгэл, хүсэл зоригийн цэвэр ариун байдал, үндэсний арвин баялгийг бэлгэддэг. Найман өнцөгтэй од нь Бүгд найрамдах улсыг, эв нэгдлийг илэрхийлдэг бол хавирган сар ба од нь ард түмний ариун нандин итгэл үнэмшлийг буюу исламын шашныг бэлгэддэг аж. Эртний домогт гардаг хөгжил цэцэглэлтийн Хумо шувуу нь аз жаргал, аз, агуу байдал, сайн сайхныг бэлгэддэг.¹³⁵

2010 онд БНУзУ-ын төрийн сүлдний тухай хуульд “Узбекистон” гэж кирилл үсгээр бичсэн байсныг латин үсгээр “O‘zbekiston” болгон өөрчилсөн байна.

3.3.13.Украин Улс¹³⁶

1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Украин Улс (ЗСБНУкУ)¹³⁷

ЗСБНУкУ 1917 онд байгуулагдаж, 1922 онд Орос, Беларусь, Өвөр Кавказ болон тус улсын гэрээгээр байгуулагдсан ЗХУ-д нэгдэн орсон байна.

¹³⁵ <https://blazon.ru/strany/gerb-uzbekistana.html>

¹³⁶ <https://rus.azattyq.org/a/ussr-ex-soviet-state-symbols-national-emblems-gallery/31045608.html>

¹³⁷ Поцелуев Владимир. Гербы Союза ССР. Москва, Политиздат, 1987 г. Стр. 98-99.

<http://www.heraldicum.ru/ukraine/index.htm>

1923 онд тус улсын Гүйцэтгэх төв хорооноос баталсан “Төрийн далбаа, төрийн сүлд, төрийн тамгыг батлах тухай” тогтоолын дагуу төрийн сүлд нь тариан түрүүгээр хөвөөлсөн улаан бамбай байна. Бамбайн дээр ургах нарны туяанд алх, хадуур байна. Бамбайн дээд хэсэгт улсын нэрийн “У.С.С.Р.” товчлолыг, доод хэсэгт туузан дээр “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг украин, орос хэлээр тус тус бичсэн байв. Энэхүү төрийн сүлд нь ЗХУ-ын төрийн сүлдтэй тун төстэй болжээ.



1929 онд батлагдсан Үндсэн хуульд төрийн сүлд дээрх уриаг зөвхөн украин хэлээр бичихээр болсон бол **1937 онд** Үндсэн хуулиар төрийн сүлдэн дээрх улсын нэрийг “У.С.С.Р.” гэж товчилсон байсныг “У.Р.С.Р.” болгон өөрчилжээ.

1947 оны зун Украины коммунист намын Төв хороо төрийн сүлдийг ЗХУ-ын төрийн сүлдний нэгдсэн стандартад оруулах асуудлыг хэлэлцэж, оройн хэсэгт таван хошуу нэмэх, тус улсын нэрийг бамбайн доор шилжүүлэхээр тогтжээ. Энэхүү саналаа Москвад уламжлан батлуулсны эцэст **1950 онд** шинэ төрийн сүлд батлагдсан байна. Шинэ төрийн сүлдэнд уриаг украин, орос хэлээр оруулсан байна.



Энэхүү төрийн сүлд нь тухайн үеийн Орос Улсын төрийн сүлдний загварт үндэслэж бүтээгджээ. Тухайн үед Украин Улс нь Орос Улстай улс төр, эдийн засгийн хөгжлийн хувьд ч, угсаатны зүйн хувьд ч ЗХУ-ын бүрэлдэхүүн бусад Бүгд найрамдах улсуудаас илүү нягт холбоотой байжээ.

2) Бүгд Найрамдах Украин Улс (БНУКУ)

БНУКУ-ын Дээд Радын **1992 оны** 2137-XII дугаар тогтоолоор тус улсын төрийн сүлдээр Киевийн Орос (Киевской Руси)-ын захирагчийн бэлгэ тэмдэг болсон “гурван шүдтэй жад”-ыг баталжээ. Гэвч Дээд Радын зарим депутатууд эсэргүүцсэн тул БНУКУ-ын тухайн үеийн Ерөнхийлөгч Л.Кравчук буулт хийх үүднээс “гурван шүдтэй жад”-ыг “төрийн бага сүлд” болгож, хожим нь “их сүлд”-ийг хэлэлцэхийг санал болгожээ. Дээрх тогтоолд “гурван шүдтэй жад нь төрийн их сүлдний гол элемент гэж үзэж, гурван шүдтэй жадыг Украин Улсын төрийн бага сүлд болгон баталсугай.” гэж заасан байна.

1996 онд батлагдсан Үндсэн хуульд тус улсын төрийн бага сүлд, төрийн далбааг тогтоож, төрийн их сүлд нь гурван шүдтэй жад ба Запорожийн армийн бэлгэ тэмдгээс бүрдэхээр хуульчилжээ. Гэвч Үндсэн хууль батлах үед төрийн их сүлдийг бүтээж амжаагүй байв.

Мөн онд Дээд Радаас баталсан “БНУКУ-ын төрийн бэлгэ тэмдгийн тухай” тогтоолд төрийн их сүлдний загварыг бүтээх уралдаан зохион байгуулахаар тогтоосон байна. Үүний дагуу Дээд зөвлөл, Сайд нарын танхимаас хэд хэдэн удаа (1996, 2000, 2003, 2007, 2020 онуудад) төрийн их сүлдний загварын уралдаан зарласан боловч төрийн их сүлд өнөөг хүртэл батлагдаагүй байна.



3.3.14.Эстони Улс¹³⁸**1) Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Эстони Улс (ЗСБНЭУ)**

1940 онд ЗСБНЭУ байгуулагдан ЗХУ-д нэгдэн оржээ. **1940 онд** батлагдсан Үндсэн хуулиар тус улсын төрийн сүлдийг тодорхойлсон ба төрийн сүлд нь шилмүүст модны мөчир, тариан түрүүгээр хөвөөлсөн, ургах нарны туяанд алх, хадуур дүрсэлсэн байна. Хэлхээг ороосон улаан туузан дээр “Орон бүхний пролетариуд нэгдэгтүн!” уриаг эстони, орос хэлээр, хэлхээний ишийг холбосон улаан туузан дээр улсын нэрийн “Eesti NSV” товчлолыг эстони хэлээр тус тус бичжээ. Төрийн сүлдний оройн хэсэгт таван хошууг байрлуулжээ.

**2) Бүгд Найрамдах Эстони Улс (БНЭУ)**

ЗСБНЭУ-ын Дээд зөвлөлөөс 1990 оны 05 дугаар сарын 08-ний өдөр БНЭУ болох тухай тогтоолыг, 08 дугаар сарын 07-ны өдөр Төрийн далбаа, төрийн сүлдний тухай хуулийг тус тус баталжээ. Харин 1991 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр ЗХУ-ын Төрийн зөвлөл БНЭУ-ын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрчээ.

1990 оны хуульд зааснаар Эстони Улсын 1940 оны 08 дугаар сараас өмнө хэрэглэж байсан анхны төрийн далбаа, төрийн сүлдийг тус улсын төрийн далбаа, төрийн сүлд гэж үзнэ гэсэн байна.

1992 онд батлагдсан БНЭУ-ын төрийн далбаа, төрийн сүлдний жишиг зургийг батлах тухай хуульд тус улсын төрийн их, бага сүлдийг нарийвчлан хуульчилжээ.

2001 онд шинэчлэн батлагдсан Төрийн сүлдний тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар төрийн их сүлд нь үзэгч рүү харж яваа гурван хөх арсланг дүрсэлсэн алтан бамбай байна. Бамбайг алтан царс модны хоёр мөчрөөр хоёр хажуу талд нь хүрээлсэн байна.

Харин төрийн бага сүлд нь төрийн их сүлдтэй адил боловч царс модны мөчиргүй байна.



Төрийн сүлдний арслан нь хүч чадал, эр зориг болон өгөөмөр сэтгэлийг илэрхийлдэг бол царс мод нь Эстони Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх хүсэл эрмэлзлийг илэрхийлдэг ажээ.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

¹³⁸ <http://www.heraldicum.ru/estonia/index.htm>

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Ном:

- Амарсанаа Ж., Энхжин Ц. Монгол Улсын төрийн бэлгэ тэмдэг. УБ. 2014 он.
- Болортуяа Б. Төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ., 2013 он.
- Гантулга Ц., Бямбасүрэн Г. Монгол төрийн үүсэл, ёс ёслол, бэлгэдэл, хүндэтгэл, уламжлал. УБ., 2011 он.
- Даш-Ёндон Б. Соёмбо сүлд: Монгол ухаан. УБ., 2015 он.
- Сэндэнхорол Б. Төрийн бэлгэ тэмдгийн уламжлал, шинэчлэл, хэрэглэх журам, түүний эрх зүйн зарим асуудал. УБ., 2012 он.
- Товуусүрэн Ц. Үндсэн хуулиа ойлгохуй. Хоёр дахь хэвлэл. УБ., 2020 он.
- Уртнасан Ц., Сарантуяа О. Улс орны амьдрал олон түмний санаа бодолд. Социологийн цуврал судалгааны тайлангийн эмхэтгэл. УБ., 2007 он. 7 дахь тал.
- Чимид Б. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008 он. 38 дахь тал.
- Bryan Miller. Elite Xiongnu Burials at the Periphery: Tomb Complexes at Takhiltyn Khotgor, Mongolian Altai (Miller et al. 2009). <https://www.academia.edu>
- “Flaggen, Wappen, Hymnen”, Battenberg Verlag, 1991, von Derkwillem Visser.
- Поцелуев Владимир. Гербы Союза ССР. Москва, Политиздат, 1987 г.
- Думин С.В. Гербы дома Романовых.

Цахим хуудас:

- http://english.www.gov.cn/archive/chinaabc/202012/31/content_WS5fede0a6c6d0f72576943057.html
- <http://kursk-museum.ru/gallery/simvolika/index.html>
- http://latvia-spb.com/9_2_2_1.html
- <http://statesymbol.ru/>
- <http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/ne122/>
- <http://www.heraldicum.ru>
- <http://www.heraldicum.ru/lietuva/index.htm>
- <https://austria-forum.org>
- <https://auswandern-info.com/griechenland/flagge-wappen>
- <https://blazon.ru>
- <https://costarica.org/facts/flag/>
- <https://en-academic.com/dic.nsf/enwiki/256391>
- <https://f-gl.ru>
- https://grs.gov.kg/ru/eid/state_symbols/
- <https://law.go.kr/>
- <https://legislative.gov.in/sites/default/files/A2005-50.pdf>
- <https://president.az/ru/pages/view/azerbaijan/symbols> , <https://blazon.ru/strany/gerb-armenii.html>
- <https://projectperu.org.uk/about-peru/symbols-of-peru/>
- <https://rus.azattyq.org/a/ussr-ex-soviet-state-symbols-national-emblems-gallery/31045608.html>
- <https://theme.archives.go.kr/next/symbolKorea/nationEmblemHistory.do>
- <https://tournavigator.pro>



- <https://web.archive.org/web/20060317162511/http://www.la-moncloa.es/IDIOMAS/en-GB/Espana/EIEstado/Simbolos/EEscudo.htm>
- <https://web.archive.org/web/20060317162511/http://www.la-moncloa.es/IDIOMAS/en-GB/Espana/EIEstado/Simbolos/EEscudo.htm>
- https://web.archive.org/web/20110726013739/http://www.senat.cz/zajimavosti/znaky_a_vlajky/index-eng.php?ke_dni=09.04.2010&O=7
- <https://web.archive.org/web/20110814035414/> , <http://www.heraldicum.ru/latvija/latsr.htm>
- <https://www.bmi.bund.de/DE/themen/verfassung/staatliche-symbole/staatssymbole/staatssymbole-node.html>
- <https://www.bpb.de/kurz-knapp/lexika/handwoerterbuch-politisches-system/202134/staatssymbole/>
- <https://www.bundestag.de/parlament/symbole/adler/>
- <https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/94490/114946/F114201808/VNM94490%20Eng.pdf>
- <https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/94490/114946/F114201808/VNM94490%20Eng.pdf>
- <https://www.indembhelsinki.gov.in/national-emblem.php>
- <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2008-03-02/mexico-law-on-national-symbols-amended/>
- <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2008-03-02/mexico-law-on-national-symbols-amended/>
- <https://www.mois.go.kr/eng/>
- <https://www.presedinte.md/rus/emblem>
- <https://www.president.am/ru/state-symbols/> , <https://geraldika.ru/>
- <https://www.promotour.info/spain/symbole/emblem2.php>
- https://www.srilanka.org.tr/tourism_1-1975
- <https://www.symbols.com/symbol/flag-of-chile>
- <https://www.vietnamonline.com/culture/national-emblem.html>
- <https://www.vietnamonline.com/culture/national-emblem.html>
- <https://www.vokrugsveta.ru/article/260555/> , <http://kursk-museum.ru/gallery/simvolika/index.html>
- pravo.gov.ru.
- Президентская библиотека имени Б.Н.Ельцина. <https://www.prlib.ru/>

**БНСУ-ЫН ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ БА ТОМИЛГООНЫ
СОНСГОЛ БОЛОН АНУ-ЫН КОНГРЕССЫН НИЙТИЙН СОНСГОЛЫН
ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

(Мэдээлэл, лавлагаа)

*Г.Алтан-Оч (Ph.D),
И.Жаргалзаяабямба, О.Нарантуяа*

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

1.ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2.НИЙТИЙН СОНСГОЛ

Хавсралт 1.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

Хавсралт 2.

НИЙТИЙН АЛБАНД НЭР ДЭВШИГЧИЙГ ТОМИЛОХ СОНСГОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ



СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Улсын Их Хурлын даргын захиалгын дагуу “БНСУ-ын Үндэсний Ассамблейн хяналт, шалгалт ба томилгооны сонсгол, АНУ-ын Конгрессын нийтийн сонсголын талаарх эрх зүйн зохицуулалт” сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгаанд захиалгын дагуу Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын Төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтын тухай болон Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонсголын тухай хуулийг орчуулах, Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Конгрессын нийтийн сонсголын эрх зүйн зохицуулалтын талаар судаллаа.

Судалгааны хамрах хүрээ

БНСУ-ын Төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтын тухай болон Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонсголын тухай хуулийг орчуулах, АНУ-ын Конгрессын нийтийн сонсголын эрх зүйн зохицуулалтыг судлах.

Судалгааны үр дүнгийн тойм

Парламентын хяналт, шалгалтын хувьд, парламентын үндсэн чиг үүргүүдийн нэг болох хянан шалгах чиг үүрэг нь бусад чиг үүрэгтэй харилцан уялдаатай тасралтгүй хэрэгжих процесс юм. Дэлхийн улс орны парламентууд энэхүү чиг үүргээ олон арга хэлбэрээр хэрэгжүүлж байна. Тухайлбал, парламентын хяналтын тусгайлсан эрхтэй хороо байгуулах, нээлттэй сонсгол зохион байгуулах, хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, төсөвт хяналт тавих гэх мэт. Мөн нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтийн үр дүнгийн талаар нээлттэй хэлэлцэх, Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдэд асуулга, асуулт тавих, хариуг нь хэлэлцэх болон Засгийн газрын цаг зэрэг бусад аргуудыг ч хэрэглэж байна.

Эрх зүйн зохицуулалтын хувьд, парламентаас хяналт, шалгалт хийх асуудлыг Үндсэн хууль, Дэгийн тухай хуулиар түлхүү зохицуулсан байдаг бол зарим улс оронд бие даасан хуулиар зохицуулдаг байна. Тухайлбал, БНСУ-д парламентын хяналт, шалгалтын асуудлыг Үндсэн хууль, Үндэсний Ассамблейн тухай хууль болон Төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтын тухай хуулиар зохицуулж байна. Эдгээрээс Төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтын тухай хуулиар төрийн хяналтыг Үндэсний Ассамблейн холбогдох Байнгын хороо жил бүр явуулдаг бол төрийн шалгалтыг Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн 1/4-ээс доошгүй нь хүсэлт гаргавал тусгай хороо байгуулж, эсхүл Байнгын хорооноос явуулдаг. Үндэсний Ассамблейгаас хяналт хийх байгууллагуудыг уг хуульд тодорхой зааж өгсөн бөгөөд төрийн хяналт, шалгалтыг хийхдээ Үндэсний Ассамблейгаас баталсан төлөвлөгөөний дагуу явуулдаг.

Хяналт, шалгалт явуулсан хороо нь хяналт, шалгалтын үр дүнгийн тайлангаа Үндэсний Ассамблейн даргад хүргүүлэх бөгөөд тайланг хүлээн авсны дараа Үндэсний Ассамблейн дарга үр дүнг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлдэг байна.

Нийтийн сонсголын хувьд, иргэдийн ардчилалд хяналт тавих чухал хэлбэр төдийгүй олон нийтийн оролцоог хангах аргуудын нэг бөгөөд парламентын хороодоос хууль тогтоох, хяналт тавих, мөрдөн шалгах, нотлох болон томилгооны сонсголыг зохион байгуулдаг байна.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн тухай хуульд зааснаар Байнгын хорооны нийт гишүүний 1/3-ийн хүсэлтээр, эсхүл Байнгын хорооны тогтоолоор чухал шаардлагатай хуулийн төслийг хэлэлцэхэд болон бусад тусгай мэдлэг шаардсан асуудлаар нийтийн сонсгол

явуулахаар заасан. Мөн төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтын асуудал болон албан тушаалтныг томилох асуудлаар сонсгол зохион байгуулахаар заасан байна. Сонсголыг холбогдох Байнгын хороо болон Сонсголын тусгай хороо Үндэсний Ассамблейн тухай хууль болон Нийтийн албанд нэр дэвшигчийн томилох сонсголын тухай хуулийн дагуу зохион байгуулна. Сонсголыг нийтийн албанд нэр дэвшигчийг томилох саналыг хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор хийх бөгөөд сонсох хугацаа 3 хоногоос хэтрэхгүй. Сонсгол дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор сонсголын тайланг Үндэсний Ассамблейн даргад хүргүүлэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

АНУ-д Төлөөлөгчдийн танхим болон Сенатаас нийтийн сонсголыг түгээмэл зохион байгуулдаг. Нийтийн сонсголыг зохион байгуулж буй зорилгоос хамаарч хууль тогтоомжийн, хяналтын, мөрдөн шалгах, батлах сонсгол зохион байгуулдаг. Эдгээрээс батлах сонсголын хувьд Сенатын Байнгын хороод өөрийн эрх мэдлийн хүрээнд гүйцэтгэх засаглал болон шүүхийн албан тушаалд нэр дэвшүүлэх асуудлаар зохион байгуулдаг. Түүнчлэн сонсголыг парламентын сонсгол, албан бус сонсгол гэсэн хоёр төрөлд хуваадаг байна.

Албан бус сонсголыг олон нийтээс гэрчийн мэдүүлэг авах зорилгоор нэгдсэн улсын хэмжээнд, эсхүл муж улс буюу орон нутгийн парламентын гишүүн хийдэг бөгөөд парламентын аль нэг хороонд хамаардаггүй учир “албан бус” гэж үздэг байна. Парламентын сонсголыг хууль тогтоох үйл ажиллагааны эхэн шатанд мэдээлэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх зорилгоор хийдэг. АНУ-д Конгрессын нийтийн сонсголын тусгайлсан хуульгүй бөгөөд Сенатын дүрэм (Rules of Senate)-ээр зохицуулж байна. Тус дүрэмд зааснаар нийтийн сонсголыг оршил, сонсголд бэлтгэх, сонсгол явуулах, сонсголын дараах үйл ажиллагаа гэсэн 4 үе шатаар явуулах бөгөөд дүрэмд үе шат бүрд хийх ажилбаруудыг тодорхойлсон байна. Гэхдээ сонсгол зохион байгуулж буй хороо нь энэхүү дүрэмд нийцүүлэн сонсголын дэгийг баталж, хэрэглэх боломжийг олгосон байна.

Түлхүүр үг: төрийн хяналт, төрийн шалгалт, нийтийн сонсгол, томилгооны сонсгол

Keyword: state inspection, state investigation, hearing, public hearing, personnel hearing



СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

1.ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Олон улсад парламентын хууль тогтоох, хянан шалгах, төлөөлөл хэрэгжүүлэх үндсэн 3 чиг үүрэг нь харилцан уялдаатай тасралтгүй хэрэгжих процесс юм. Үүнээс парламентын хяналтыг үр нөлөөтэй явуулахад хууль ёсны бүрэн эрх, үүргээс гадна хяналтыг үр ашигтай хэрэгжүүлэх тогтолцоо, чадавх чухал юм.

Парламентын хяналт нь тасралтгүй, тууштай, нухацтай, баримт нотолгоонд суурилсан байдлаар явагддаг бөгөөд энэ нь парламент өөрөө хариуцлагатай байхыг шаарддаг. Мөн парламент болон парламентын гишүүд Засгийн газарт хэрхэн хяналт тавьсан талаараа иргэдэд тайлагнах нь тэдний төлөөллөө хариуцлагатай хэрэгжүүлж байгаагийн илрэл юм. Парламентын хяналтыг дараах арга хэлбэрүүдээр хэрэгжүүлж байна. Үүнд:


- **Парламентын хяналтын тусгайлсан эрхтэй хороод** нь баримтад тулгуурлан Засгийн газарт асуулга тавих, дүгнэлт, зөвлөмж гаргаж, парламент болон олон нийтэд танилцуулах үүрэгтэй байна.
- Парламентаас хяналт, шалгалт явуулж байгаа тодорхой асуудлыг Засгийн газрын төлөөлөл, олон нийт, экспертүүдийг оролцуулан хэлэлцэж **нээлттэй сонсгол** зохион байгуулах нь баримт нотолгоо цуглуулах, мөрдөн шалгах чухал арга хэлбэр юм.
- Парламентаас **хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх** зорилго нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавар, үр дүнг үнэлэх, цаашид авах арга хэмжээ, шаардагдах нэмэлт эх үүсвэр зэргийг шийдэхэд чиглэгдэнэ.
- Парламентад **Хянан шалгах тусгай хороог** байгуулах замаар зарим асуудлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж болох ба олон улсын парламентуудад нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлыг авч хэлэлцэхийн тулд ийм хороо байгуулах явдал түгээмэл байна.

Мөн хяналтын дараах арга хэлбэрүүдийг олон улсад хэрэгжүүлж байна. Үүнд:

- **нэгдсэн хуралдаанд парламентын хяналтыг хэрэгжүүлэх** – Парламентын гишүүд Засгийн газрын үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтийн үр дүнгийн талаар нээлттэй хэлэлцэж, санал шүүмж, асуулт хариулт, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар асуудалд олон нийтийн анхаарлыг татах боломжтой;
- **асуулга, асуулт тавих, түүний хариуг хэлэлцэх** - Засгийн газрын сайд нарт шахалт үзүүлж, бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах, Засгийн газар болон сайд нарт итгэл үзүүлэх эсэх болон бусад хариуцлагын асуудлыг ярих боломжтой;
- **“Засгийн газрын цаг”**- аар сөрөг хүчний хувьд илүү их асуулт асуух боломжтой;
- **төсвийн хяналт** - Парламентаас Засгийн газрын төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтыг хянах, тэргүүлэх салбарыг тодорхойлох, төсвийн хуваарилалт нь олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг хянах боломжтой.

Олон улсын парламентуудын хувьд хяналт тавих бүрэн эрхээ Үндсэн хууль, Дэгийн тухай хуулиар түлхүү зохицуулсан байна. Ялангуяа Европ, Африк, Америкийн парламентуудад дараах зохицуулалт хамгийн түгээмэл байна.¹³⁹

Зураг 1. Парламентын хяналтын эрх мэдлийн зохицуулалт



БНСУ-ын хувьд, парламентын хяналт, шалгалтын асуудлыг Үндсэн хууль, Үндэсний Ассамблейн тухай хууль болон Төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтын тухай хуулиар зохицуулж байна. **Үндсэн хууль** (61 дүгээр зүйл)-д¹⁴⁰ Үндэсний Ассамблей нь төрийн хэргийг хянан шалгах буюу төрийн тодорхой асуудлыг шалгаж, түүнтэй шууд холбоотой баримт бичгийг цуглуулах, гэрч дуудах, мэдүүлэг авах, дүгнэлт гаргуулахыг шаардаж болох бөгөөд төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтыг холбогдох хуульд зааснаар явуулна. Харин **Үндэсний Ассамблейн тухай хууль** (127 дугаар зүйл)-д төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтын тухай хуулийн дагуу явуулахаар заасан. **Төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтын тухай хуульд** зааснаар төрийн хяналтыг Үндэсний Ассамблейн холбогдох Байнгын хороо жил бүр явуулна.

Төрийн захиргааны байгууллагын шалгалтыг Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн 1/4-ээс доошгүй нь хүсэлт гаргавал тусгай хороо, эсхүл Байнгын хорооноос явуулна. Өөрөөр хэлбэл, хяналтыг жил бүр тогтмол зохион байгуулдаг бол шалгалтыг хүсэлт гаргасан тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга нэгдсэн хуралдаанд танилцуулж, бүлэг тус бүрийн төлөөлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр хяналт, шалгалтын хороо байгуулах, эсхүл холбогдох Байнгын хорооны аль нэг хийхээр шийдвэрлэдэг байна.

Үндэсний Ассамблей нь дараах байгууллагуудад хяналт, шалгалт явуулна. Үүнд:

- 1.Төрийн байгууллагын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан төрийн байгууллагууд;
- 2.орон нутгийн засаг захиргаанаас тусгай хот, нийслэл, аймаг (хяналтын хамрах хүрээ нь улсын төсвөөс санхүүжүүлж буй ажил, татаас болон төслүүдээр хязгаарлагдана);
- 3.Төрийн байгууллагын удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, Солонгосын (төв) банк, хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, загас агнуурын хоршоологчдын үндэсний холбоо;
- 4.дээр дурдсанаас бусад нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, Хяналт, шалгалтын тухай хуулийн дагуу хяналт, шалгалтын зөвлөлийн хяналт, шалгалтад хамрагдах байгууллага.


¹³⁹ Парламентын хяналт шалгалтын тогтолцоо ба эрх зүйн зохицуулалт: Бусад орнуудын туршлага, зөвлөмж, СТ-21/208, УИХТГ-ын ПССХ, 2021 он

¹⁴⁰ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=1&lang=KOR

Хувь хүний нууцад халдах, мөрдөн байцаалтын шатанд байгаа болон мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад хөндлөнгөөс оролцох зорилгоор аливаа хяналт, шалгалт явуулахыг хориглоно.

Үндэсний Ассамблейгаас хийх хяналт, шалгалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу явуулах бөгөөд хяналтын төлөвлөгөө (ажлын хэсгийн зохион байгуулалт, хуваарь, удирдамж, бусад), шалгалтын төлөвлөгөө (шалгалтын зорилго, хамрах хүрээ, шалгалтын хугацаа, шаардагдах төсөв) нь зорилго, хамрах хүрээ, хугацаа зэргээрээ ялгаатай байдаг.

Зураг 2. Үндэсний Ассамблейн хяналт, шалгалт явуулах процесс



Хяналт, шалгалтын хороо нь хяналт, шалгалтын үйл ажиллагааг явуулж дууссаны дараа үр дүнгийн тайланг Үндэсний Ассамблейн даргад хүргүүлэх бөгөөд тайланг хүлээн авсны дараа Үндэсний Ассамблейн дарга нэгдсэн хуралдаанд танилцуулж, үр дүнг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэдэг.

Үндэсний Ассамблей нь хяналт, шалгалтын үр дүнд хууль бус, шударга бус асуудал илрүүлсэн бол уг зөрчлийн байдлыг харгалзан Засгийн газар, эсхүл холбогдох байгууллагад нөхөн олговор олгох, сахилгын шийтгэл ногдуулах, тогтолцоог сайжруулах, төсвийн тодотгол хийх зэрэг арга хэмжээ авахыг Засгийн газар болон холбогдох байгууллагаас шаардаж болох бөгөөд холбогдох байгууллага шилжүүлсэн асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэж, үр дүнг Үндэсний Ассамблейд тайлагнана.

2.НИЙТИЙН СОНСГОЛ

Төрийн үйл хэрэгт иргэдийн оролцоог хангах ардчиллын хэд хэдэн хэлбэрүүд байдаг бөгөөд түүнийг дангаар нь бус төрийн тогтолцоо, үйл ажиллагааны үе шатаас хамаарч аль тохирохыг нь хэрэглэдэг байна. Дэлхийн улс орнуудын парламентаас иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулж байгаа бөгөөд хамгийн түгээмэл нь хууль тогтоох байгууллагын хорооноос олон нийтийг сонсох ажиллагаа зохион байгуулах юм. Мөн ард түмэн ардчилалдаа хяналт тавих чухал хэлбэр төдийгүй олон нийтийн оролцоог хангах аргын нэг нь нийтийн сонсгол юм. Олон улсад парламентын хороодоос нийтийн сонсгол зохион байгуулах хандлага түгээмэл бөгөөд хууль тогтоох, хяналтын, мөрдөн шалгах, нотлох болон томилгооны сонсголыг зохион байгуулж байна.

БНСУ-ын хувьд, Үндэсний Ассамблейн тухай хуулийн 64 дүгээр зүйлд зааснаар Байнгын хорооны нийт гишүүний 1/3-ийн хүсэлтээр, эсхүл Байнгын хорооны тогтоолоор чухал шаардлагатай хуулийн төслийг хэлэлцэхэд болон бусад тусгай мэдлэг шаардсан асуудлаар нийтийн сонсгол явуулахаар заасан. Мөн төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалт, албан тушаалтныг томилох асуудлаар сонсгол зохион байгуулахаар заасан байна.

Хуулийн төслийн сонсгол (58-4 дүгээр зүйл)-оор хууль хүчин төгөлдөр болох, хуульд бүхэлд нь болон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зохион байгуулна.

Хяналт, шалгалтын сонсгол (65 дугаар зүйл)-оор төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалттай холбоотойгоор нотлох баримтыг батлах зорилгоор гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлтийг сонсдог.

Томилгооны сонсгол (65-2 дугаар зүйл)-ыг нийтийн албанд нэр дэвшигчийг томилох зорилгоор Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонсголын тухай хуулийг баримтлан зохион байгуулна.

Сонсголыг холбогдох Байнгын хороо болон Сонсголын тусгай хороо зохион байгуулахаар заасан байна. Үндэсний Ассамблейн 46-3 дугаар зүйлд зааснаар Сонсголын тусгай хороо нь нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонсголыг зохион байгуулахаар заасан бөгөөд дараах албан тушаалтнуудыг нэрлэн заасан. Үүнд: Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Өргөн нэвтрүүлэг, харилцаа холбооны дарга, Үндэсний тагнуулын газрын дарга, Шударга өрсөлдөөний хорооны дарга, Санхүү, эдийн засгийн хорооны дарга, Хүний эрхийн үндэсний комиссын дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Үндэсний татварын албаны дарга, Ерөнхий прокурор, Солонгосын Үндэсний цагдаагийн газрын ерөнхий комиссар, Зэвсэгт хүчний

штабын ерөнхий командлагч, Солонгосын (төв) банкны Ерөнхийлөгч, Мэргэжлийн хяналтын газрын дарга зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд хамаарч байна.

Сонсголын тусгай хорооны гишүүдийг бүлгийн дарга тус бүрийн хүсэлтийн дагуу Үндэсний Ассамблейн дарга томилох бөгөөд 13 гишүүний бүрэлдэхүүнтэй, үйл ажиллагаагаа Үндэсний Ассамблейн нэгдсэн хуралдаанд тайлагнана. Хороо нь нийтийн албанд нэр дэвшигчийг томилох саналыг хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор сонсголыг дуусгах бөгөөд сонсох хугацаа гурван хоногоос хэтрэхгүй бөгөөд сонсгол дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор сонсголын тайланг Үндэсний Ассамблейн даргад хүргүүлнэ. Үндэсний Ассамблейн дарга нийтийн албанд нэр дэвшигчийн томилох сонсголын тайланг Ерөнхийлөгч, сонгогдсон Ерөнхийлөгч болон Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хүргүүлдэг.

Сонсголын тусгай хороо нь нийтийн албанд нэр дэвшигчийг томилох саналыг нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэх, эсхүл тус сонсголын явцыг нэгдсэн хуралдаанд танилцуулах хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлдэг.

АНУ-ын хувьд, төлөөлөгчдийн танхим болон сенатын танхим нь нийтийн сонсгол зохион байгуулах нь түгээмэл байдаг. Нийтийн сонсголыг зохион байгуулж буй зорилгоос хамаарч хууль тогтоомжийн, хяналтын, мөрдөн шалгах, батлах сонсгол гэсэн төрөлтэй. Эдгээрээс батлах сонсголын хувьд¹⁴¹ Сенатын Байнгын хороод өөрийн эрх мэдлийн хүрээнд гүйцэтгэх засаглал болон шүүхийн албан тушаалд нэр дэвшүүлэх асуудлаар зохион байгуулдаг. Энэхүү сонсгол нь нэр дэвшигчээс гадна тухайн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг олгодог байна. Түүнчлэн сонсголыг парламентын сонсгол, албан бус сонсгол гэсэн хоёр төрөлд хуваадаг байна.

Албан бус сонсголыг олон нийтээс гэрчийн мэдүүлэг авах зорилгоор нэгдсэн улс, муж улс буюу орон нутгийн парламентын нэг гишүүн хийдэг бөгөөд конгрессын аль нэг хороонд хамаардаггүй учир “албан бус” гэж үздэг байна. Тиймээс захирамж гарахгүй, түүнийг албадахгүй. Ерөнхийдөө сайн дурын үндсэн дээр түүнд оролцох эсэхийг шийддэг байна. Албан бус сонсголыг ихэнхдээ цөөнхийн бүлгийн гишүүн хийдэг байна.¹⁴²

АНУ-д конгрессын нийтийн сонсголын тусгайлсан хуульгүй, харин Сенатын дүрэм (Rules of Senate)-ээр зохицуулдаг байна.¹⁴³

Конгрессын сонсгол: АНУ-ын конгрессын сонсгол гэдэг нь хууль тогтоох үйл ажиллагааны эхэн шатанд мэдээлэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх зорилгоор хийдэг АНУ-ын Конгрессын хороодын албан ёсны, зарчмын арга хэрэгсэл юм. Сонсголыг зөвшөөрөх¹⁴⁴ (АНУ-ын Сенатын цор ганц, онцгой арга хэмжээ), хууль тогтоох, хянан шалгах, мөрдөн шалгах, батлах сонсголыг зохион байгуулдаг бөгөөд тухайн сэдвээр мэдээлэл цуглуулах зорилготой байдаг. Нийтийн сонсгол нь ирц, нээлтийн үг, гэрчүүдийг танилцуулах, гэрчийн аман мэдүүлэг, гэрчид асуулт тавих, хаалтын үг, сонсголын дараах гэсэн техникийн шинж чанартай удирдамжийг баримталдаг. George B. Galloway “Конгрессын сонсгол нь АНУ-ын бүхий л асуудлын талаарх мэдээллийн алтны уурхай юм.” гэж томьёолсон байдаг байна. АНУ-ын Засгийн газрын хэвлэн нийтлэлийн газар “Конгрессоос эрхлэн гаргадаг хамгийн чухал бүтээгдэхүүн бол сонсголын тайлан мэдээлэл” гэж үздэг бөгөөд Конгрессын номын сан ч мөн адил дүгнэсэн байдаг байна.

¹⁴¹ https://www.everycrsreport.com/reports/RL30548.html#_Toc256754267

¹⁴² Сонсгол-Hearing_(law)-англиар [https://en.wikipedia.org/wiki/Hearing_\(law\)](https://en.wikipedia.org/wiki/Hearing_(law))

¹⁴³ Ц.Болормаа, Г.Алтан-Оч “Парламентын нээлттэй сонсголд оролцогчдын үүрэг, хариуцлага” 2013 Судалгааны эмхэтгэл XIV боть, 539 дэх тал

¹⁴⁴ Confirmation hearings

Сенатын дүрэмд заасны дагуу хороодын сонгол нь олон нийтэд нээлттэй явагдах бөгөөд дараах тохиолдолд (Сенатын дүрмийн XXVI, 5-р зүйлийн (b)) хаалттай явуулна. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл багтсан;
- Хорооны боловсон хүчин, удирдлага буюу үйл ажиллагааны асуудал;
- Хүний хувийн нууцад халдах, хувь хүний нэр төр буюу мэргэшлийн байдалд хохирол учруулах, хувь хүнд эрүүгийн буюу албан тушаалын гэмт хэргээр хариуцлага тооцох;
- Хувь хүний онцлог шинж байдлыг илчлэх буюу хууль сахиулах үйл ажиллагаанд хохирол учруулах эрсдэлтэй;
- Санхүү буюу худалдааны нууцыг задруулах эрсдэлтэй;
- Бусад хууль, дүрмээр нууцлахаар заасан мэдээлэл.

Сенатын дүрэмд сонголыг хаалттай горимд шилжүүлэх тусгай зохицуулалт орсон байдаг байна. Дээр дурдсан аль нэг шалтгаанаар сенатор горимын санал гаргавал хорооны хуралдааныг хаалттай горимд шилжүүлж болдог байна. Ингэхдээ хорооны нээлттэй хуралдааны үеэр санал хураалт явуулж, олонх дэмжвэл сонголыг хаалттай горимд шилжүүлдэг байна. Харин тухайн асуудлаар хорооны сонголын хаалттай хуралдааныг календарийн 14 өдрөөс хэтрүүлж болдоггүй байна.¹⁴⁵

Сенатын дүрмээр доорх 3 зүйлд сонголын талаар тусгасан байна.¹⁴⁶ Үүнд:

- XVII-Хороодын референц (эрх мэдлийн хүрээ); Чөлөөлөх санал гаргах; Хороодын тайлагнал; Боломжит сонгол;
- XXVI-Хорооны үйл ажиллагаа;
- XXXVII-Ашиг сонирхлын зөрчил.

Сенатын дүрмийн XXVI зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хороо нь Сенат хуралдаантай байх, завсарлага авсан байх буюу хойшлогдсон байхаас үл хамааран сонгол явуулах эрхтэй. Хороо нь сонголыг Вашингтонд эсхүл аль нэг муж улсын нутаг дэвсгэр дээр¹⁴⁷ буюу гадаад улсад зохион байгуулж болно. Хороо нь Сенатын дүрэмд нийцүүлэн сонголын журам боловсруулж, журмыг хэвлэн нийтлэх бөгөөд энэхүү журам нь дэд хороонд мөн адил хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Дүрэмд зааснаар сонголыг 4 үе шаттай явуулна.

Оршил буюу 1 дэх үе шатанд хорооны үйл ажиллагаан дахь сонголын үүрэг роль, сонголын төрөл, хэлбэр, зохион байгуулалтын асуудал багтана.

“Сонголд бэлтгэх” буюу 2 дахь үе шат нь төлөвлөлт хэсэг. Үүнд:

- Сонгол явуулах эсэхийг шийдвэрлэх;
- Сонголтой холбоотой хороонд дэмжлэг үзүүлэх эх үүсвэр;
- Гэрээ байгуулж, нэмэлт хүн хүч дайчлах болон холбогдох асуудлууд;
- Хамтарсан сонгол хийх;
- Хорооны уулзалт (хуралдаан) дээр хориглох зүйлс;
- Сонголын цагийн хуваарь, олон нийтэд мэдээлэх;
- Гэрчүүдийг сонгох болон мэдүүлэг өгөх дараалал, хэлбэрийг тогтоох;
- Гэрчүүдээс мэдүүлгийг урьдчилан бичгээр авах;
- Шийдвэрийн төсөл, зарчмын зөрүүтэй санал гаргах журам;
- Хорооны гишүүдэд зориулсан товч танилцуулга бэлтгэх;

¹⁴⁵ АНУ-ын конгрессын сонгол-United States congressional hearing-англиар https://en.wikipedia.org/wiki/United_States_congressional_hearing

¹⁴⁶ Сенатын дүрэм-Rules of the Senate-англиар <https://www.rules.senate.gov/rules-of-the-senate>

¹⁴⁷ Field hearing-англиар

- Сонсголыг өргөн нэвтрүүлгээр цацах, медиаг татан оролцуулах, удирдах журам;
- Захиргааны арга хэмжээнүүд.

“Сонсгол явуулах” буюу 3 дахь үе шатанд сонсголыг хэрхэн явуулах тухай. Үүнд:

- Ирцийн шаардлага;
- Хаалттай сонсгол явуулах;
- Гэрчийн эрх;
- Гишүүдийн нээлтийн мэдэгдэл;
- Гэрчийг танилцуулах, тангараг өргүүлэх;
- Гэрчээс аман мэдүүлэг авах;
- Аман мэдүүлгийн дараах асуулт, хариултын үе.

“Сонсголын дараах үйл ажиллагаа” буюу 4 дэх үе шатанд хорооноос сонсголын дараа хийдэг ажилбаруудыг багтаана. Жишээ нь, хорооны ажилтан мэдүүлгүүдийг нэгтгэн дүгнэхэд бэлтгэх, гэрчээс авах нэмэлт асуулт бэлтгэх, сонсголын протоколыг хавсралт материалын хамтаар хэвлэх г.м.¹⁴⁸



¹⁴⁸ АНУ-ын Сенат дахь сонсгол: Бэлтгэх, явуулах гарын авлага-Hearings in the U.S. Senate: A Guide for Preparation and Procedure-*англиар*
https://www.everycrsreport.com/files/20100318_RL30548_28ce8e891f296875600ec1f5440b4382dd57b2e1.pdf

ХАВСРАЛТ 1.*Албан бус орчуулга***БНСУ-ЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ,
ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалттай холбоотой журам, бусад шаардлагатай асуудлыг тогтооход оршино.

2 дугаар зүйл.Төрийн захиргааны байгууллагын хяналт

1.Үндэсний Ассамблей нь ээлжит хуралдаан зарлан хуралдуулахаас өмнө төрийн захиргааны байгууллагын хяналт (цаашид "хяналт" гэх)-ыг 30-аас дээшгүй хоногийн хугацаатай холбогдох Байнгын хороодоор жил бүр явуулна. Тухайн хяналтыг Үндэсний Ассамблейн шийдвэрээр ээлжит хуралдааны хугацаанд хийж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хяналтыг Үндэсний Ассамблейн удирдах хороотой зөвшилцсөний үндсэн дээр холбогдох Байнгын хорооны даргын боловсруулсан төлөвлөгөөний дагуу явуулна. Хяналтад хамрагдах байгууллагууд давхцах, эсхүл Байнгын хороодын хяналтын хуваарь давхцах зэрэг онцгой нөхцөл байдал үүсэх тохиолдолд Үндэсний Ассамблейн удирдах хороо нь зохицуулалт хийж болно.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хяналтын төлөвлөгөө нь хяналтын ажлын хэсгийн зохион байгуулалт, хуваарь, удирдамж зэрэг хяналтад шаардлагатай асуудлыг багтаасан байна.

4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хяналтын төлөвлөгөөг жил бүрийн анхдугаар ээлжит бус хуралдаанаар боловсруулж, энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан хяналтад хамрагдах байгууллагад мэдэгдэнэ. Үндэсний Ассамблейн бүх нийтийн сонгуулийн жил дээр дурдсан төлөвлөгөөг боловсруулж, шинээр байгуулагдсан Үндэсний Ассамблейн ээлжит, эсхүл ээлжит бус хуралдаанд танилцуулж болно.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хяналтын төлөвлөгөөнд хяналтад хамрагдах байгууллага болон хуваарьт өөрчлөлт орсон бол энэ тухай хяналт эхлэхээс 7 хоногийн өмнө холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

3 дугаар зүйл.Төрийн захиргааны байгууллагын шалгалт

1.Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн ¼-ээс доошгүй нь хүсэлт гаргавал тусгай хороо, эсхүл Байнгын хорооноос төрийн тодорхой асуудлаар төрийн захиргааны байгууллагын шалгалт (цаашид "шалгалт" гэх) явуулж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шалгалт явуулах хүсэлтэд шалгалтын зорилго, хамрах хүрээ болон шалгалт хийх хороог зааж, хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд хүсэлт гаргаж буй гишүүд гарын үсэг (цаашид "шалгалт хийх хүсэлт" гэх) зурна.

3.Шалгалт хийх хүсэлтийг өргөн мэдүүлсэн тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга цаг алдалгүй нэгдсэн хуралдаанд танилцуулж, бүлэг тус бүрийн төлөөлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр шалгалтын тусгай хороо байгуулах, эсхүл холбогдох байнгын хороо (цаашид "шалгалтын хороо" гэх)-д шилжүүлж, шалгалт хийх хороог тогтооно. Энэ тохиолдолд Үндэсний Ассамблей ээлжит хуралдаан хаасан, эсхүл завсарласан бол

шалгалт хийх хүсэлтийг Үндэсний Ассамблейг хуралдуулах, шалгалтын хорооны үйл ажиллагааг үргэлжлүүлэх хүсэлт гаргасан гэж үзнэ.

4.Шалгалтын хороо нь шалгалтын зорилго, хамрах хүрээ, шалгалтын хугацаа болон шаардагдах төсвийг тусгасан шалгалтын төлөвлөгөөг нэгдсэн хуралдаанаар баталж, шалгалт явуулна.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан шалгалтын төлөвлөгөөг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж батлах, эсхүл буцаах тогтоол батална.

6.Нэгдсэн хуралдаанаас шалгалтын төлөвлөгөөг буцаасан тохиолдолд шалгалтын хороо нь өөрчлөлтийг оруулж дахин нэгдсэн хуралдаанд оруулна.

4 дүгээр зүйл.Шалгалтын хороо

1.Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан тусгай хороог бүлгийн гишүүдийн тоотой хувь тэнцүүлэн байгуулна. Гишүүд шалгалтад оролцохоос татгалзаж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тусгай хороо нь хорооны дарга, бүлэг тус бүрээс нэг нарийн бичгийн даргыг сонгож, нэгдсэн хуралдаанд танилцуулна.

3.Шалгалтын хорооны дарга осолд орсон, ажил үүргээ гүйцэтгэхээс татгалзсан, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаар шалгалтын хорооны үйл ажиллагаанд оролцох боломжгүй болсон тохиолдолд хяналтын хорооны даргын харьяалагддаггүй бүлгийн нарийн бичгийн дарга нараас хамгийн олон гишүүнтэй бүлгийн харьяалагддаг нарийн бичгийн дарга шалгалтын хорооны даргын үүргийг гүйцэтгэнэ.

4.Шалгалтын хороо нь Үндэсний Ассамблейн хуралдаан хаасан үед үйл ажиллагаагаа явуулж, шалгалттай холбоотой тайлан, баримт бичиг, холбогдох байгууллагын эзэмшиж буй зураг, видео материал (цаашид “баримт бичиг” гэх)-ыг ирүүлэхийг хүсэх, эсхүл шалгалтын ажиллагаанд гэрч, шинжээч, гэрчийн мэдүүлэг сонсох хүсэлт гаргах бол Үндэсний Ассамблейн даргын зөвшөөрөл шаардахгүй.

5 дугаар зүйл.Дэд хороо

1.Хяналт, шалгалт явуулах хороо (цаашид “хороо” гэх) нь шаардлагатай тохиолдолд хорооны тогтоолоор хоёр болон түүнээс дээш гишүүний бүрэлдэхүүнтэй дэд хороо, эсхүл ажлын хэсэг байгуулж, хяналт, шалгалт явуулж болно. Үндэсний Ассамблейн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хорооны харьяалах дэд хороо хяналт, шалгалтыг явуулж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан дэд хороо, эсхүл ажлын хэсэг нь нэг бүлгийн гишүүдээс бүрдэж болохгүй.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан дэд хороо, эсхүл ажлын хэсэг нь Үндэсний Ассамблейн тухай хуулийн хороотой холбоотой аливаа заалттай харшлахгүй бол энэ хуулийн заалтыг баримтална.

6 дугаар зүйл.Ажлын албаны туслах

1.Ажлын албаны туслах нь хяналт, шалгалт явуулахад дэмжлэг үзүүлж болно.

2.Ажлын албаны туслах нь Үндэсний Ассамблейн Тамгын газрын төрийн албан хаагчид, тухайлбал, тусгай зөвлөхүүд, Үндэсний Ассамблейн судалгааны алба болон төсвийн албаны төрийн албан хаагчид, бүлгийн бодлогын судлаачид байна. Онцгой

шаардлагатай тохиолдолд хяналт, шалгалтад хамрагдаж байгаа байгууллагад хамааралгүй шинжээчийг томилж болно.

7 дугаар зүйл.Хяналтын объект

Дараах байгууллагуудад хяналт, шалгалт явуулна:

1.Төрийн байгууллагын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан төрийн байгууллагууд;

2.Орон нутгийн засаг захиргаанаас тусгай хот, нийслэл, аймаг. (Хяналтын хамрах хүрээ нь улсын төсвөөс санхүүжүүлж буй ажил, татаас болон төслүүдээр хязгаарлагдана);

3.Төрийн байгууллагын удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, Солонгосын төв банк, хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, загас агнуурын хоршоологчдын үндэсний холбоо;

4.Энэ зүйлийн 1-3 дахь хэсэгт зааснаас бусад нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, Хяналт, шалгалтын тухай хуулийн дагуу хяналт, шалгалтын зөвлөлийн хяналт, шалгалтад хамрагдах байгууллага. Энэ нь нэгдсэн хуралдаанаар тусгайлан шаардлагатай гэж шийдвэрлэсэн тохиолдолд хязгаарлагдана.

7-2 дугаар зүйл.Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хяналт

Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хяналтыг хоёр болон түүнээс дээш хорооны хамтран байгуулсан ажын хэсэг хийж болно.

8 дугаар зүйл.Хяналт, шалгалтыг хязгаарлах

Хувь хүний нууцад халдах, мөрдөн байцаалтын шатанд байгаа болон мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад хөндлөнгөөс оролцох зорилгоор аливаа хяналт, шалгалт явуулахыг хориглоно.

9 дүгээр зүйл.Шалгалтын хорооны үйл ажиллагааны хугацаа

1.Шалгалтын хорооны ажиллах хугацааг нэгдсэн хуралдааны тогтоолоор сунгаж болно.

2.Шалгалтын хорооны явцын тайланг хүлээн авсны дараа шалгалтыг урт хугацаагаар үргэлжлүүлэх шаардлагагүй гэж үзвэл нэгдсэн хуралдаанаас шалгалтын хорооны ажиллах хугацааг тогтоолоор багасгаж болно.

3.Шалгалтын хорооны ажиллах хугацааг шалгалтын төлөвлөгөөнд тусгаагүй бол шалгалтын үр дүнгийн талаар нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэх хүртэл ажиллана.

9-2 дугаар зүйл.Урьдчилсан шалгалт

Хороо нь төрийн асуудлаар шалгалт явуулахын өмнө Үндэсний Ассамблейн Тамгын газрын шинжээч, ажилтан, эсхүл шалгалтад хамрагдаж буй байгууллагад хамааралгүй тусгай зөвлөхөөр урьдчилсан шалгалт явуулж болно.

10 дугаар зүйл.Хяналт, шалгалтын арга

1.Хороо, энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан дэд хороо болон ажлын хэсгийн шийдвэрээр хяналт, шалгалттай холбоотой тайлан, баримт бичгийг гаргаж өгөхийг холбогдох этгээд, бусад байгууллагаас шаардах, гэрч, шинжээч оролцуулах, гэрчийн мэдүүлэг авах хүсэлт гаргаж болно. Хороо хяналт, шалгалттай холбоотой баримт бичиг ирүүлэх хүсэлт гаргах бол нийт гишүүдийн 1/3-ээс доошгүй саналаар хүсэлт гаргана.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичгийг ирүүлэх хүсэлтийг бичгээр, цахимаар, компьютерийн соронзон хальс, соронзон диск болон түүнтэй адилтгах бусад зөвөөрлөгч хэрэгсэл, эсхүл компьютерийн сүлжээгээр гаргаж болно.

3.Хороо нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу нотлох баримтыг батлах, эсхүл шалгах зорилгоор сонсгол зохион байгуулж болно.

4.Үндэсний Ассамблейд мэдүүлэг өгөх, үнэлгээний тухай хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлт хүлээн авсан аливаа хүн, байгууллага нь биелүүлж, шалгалтын үйл ажиллагаанд хороотой хамтран ажиллана.

5.Хяналт, шалгалтын зорилгоор гэрч, шинжээч, гэрчийн мэдүүлэг, үнэлгээтэй холбоотой харилцаанд Үндэсний Ассамблейд мэдүүлэг өгөх, үнэлгээний тухай хуульд заасан журмыг баримтална.

11 дүгээр зүйл.Хяналт, шалгалтын газар

Хяналт, шалгалтыг Үндэсний Ассамблейд, эсхүл хяналт, шалгалтын газар болон хорооноос тогтоосон бусад газарт хийж болно.

12 дугаар зүйл.Олон нийтэд нээлттэй байх зарчим

Хяналт, шалгалтын ажиллагаа нь олон нийтэд нээлттэй байна. Хорооны тогтоолоор өөрөөр тогтоож болно.

12-2 дугаар зүйл.Төрийн захиргааны байгууллагын хяналтын мэдээллийн тогтолцоо

1.Үндэсний Ассамблей хяналтын үйл явц, үр дүн болон дэд зүйлд багтсан мэдээллийг олон нийтэд мэдээлнэ.

1.Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан хяналтын төлөвлөгөө;

2.Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан хяналтын тайлан;

3.Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан Засгийн газар болон холбогдох байгууллагын үр дүнгийн тайлан;

4.Үндэсний Ассамблейн дүрэмд заасан бусад асуудал.

2.Үндэсний Ассамблей энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хяналтын мэдээллийг нийтэд мэдээлэх, удирдах зорилгоор төрийн захиргааны байгууллагын хяналт мэдээллийн тогтолцоог байгуулж, ажиллуулж болно.

3.Төрийн захиргааны байгууллагын хяналт мэдээллийн тогтолцоог байгуулах, ажиллуулахад шаардлагатай асуудлыг Үндэсний Ассамблейн журмаар тогтооно.

13 дугаар зүйл.Хасах ба татгалзах

1.Үндэсний Ассамблейн гишүүн өөрт шууд хамааралтай, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл хяналт, шалгалтад оролцохоос татгалзаж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл байгаа бол Үндэсний Ассамблейн холбогдох гишүүнийг нэгдсэн хуралдаан болон хорооны гишүүдийн шийдвэрээр түдгэлзүүлж, өөр гишүүнийг томилно.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлыг Үндэсний Ассамблейн холбогдох гишүүн эсэргүүцсэн бол нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэнэ.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл байгаа бол Үндэсний Ассамблейн гишүүн эсхүл Үндэсний Ассамблейн тухай хуулийн 32-4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хорооны даргад татгалзах хүсэлт гаргана. Энэ тохиолдолд зөвхөн хорооны шийдвэрээр хасаж болно.

14 дүгээр зүйл.Хууль ёсны үүрэг

1.Хяналт, шалгалт хийхдээ тухайн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааг алдагдуулах, нууцыг задруулахыг хориглоно.

2.Хорооны гишүүн, түүний ажлын алба нь хяналт, шалгалт хийх явцад олж мэдсэн нууцыг үндэслэлгүйгээр задруулахыг хориглоно.

15 дугаар зүйл.Хяналт, шалгалтын үр дүнгийн тайлан

1.Хороо нь хяналт, шалгалтын үйл ажиллагаа дууссаны дараа хяналт, шалгалтын үр дүнгийн тайланг гаргаж, Үндэсний Ассамблейн даргад цаг алдалгүй хүргүүлнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тайланд гэрч сонгосон байдал, гэрчийн мэдүүлгийг шалгасны үр дүн зэрэг хяналт, шалгалтын явц, үр дүнгийн талаарх мэдээлэл, санал, зөвлөмжийг тусгаж, чухал шаардлагатай нотлох баримтыг хавсаргана.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн тайланг хүлээн авсан Үндэсний Ассамблейн дарга цаг алдалгүй нэгдсэн хуралдаанд танилцуулна.

4.Үндэсний Ассамблейн дарга хорооноос явцын тайлан шаардаж болно.

15-2 дугаар зүйл.Холбогдох захиргааны байгууллагаас дэмжлэг хүсэх

Шалгалтын хугацаа богино, баримт бичиг хангалтгүй зэрэг шалтгаанаар нэмэлт шалгалт явуулах шаардлагатай гэж үзвэл, нэгдсэн хуралдаан, хорооны тогтоолоор Хяналт, шалгалтын зөвлөл зэрэг холбогдох захиргааны байгууллагын даргад хүний нөөц, барилга байгууламж, техник хэрэгсэлийн дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаангүй бол холбогдох захиргааны байгууллагын дарга хүсэлтийг биелүүлнэ.

16 дугаар зүйл.Хяналт, шалгалтын үр дүнг шийдвэрлэх

1.Үндэсний Ассамблей хяналт, шалгалтын үр дүнг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.Үндэсний Ассамблей хяналт, шалгалтын үр дүнд хууль бус, шударга бус асуудал илрүүлсэн бол уг зөрчлийг харгалзан Засгийн газар, эсхүл холбогдох байгууллагад нөхөн олговор олгох, сахилгын шийтгэл ногдуулах, тогтолцоог сайжруулах, төсвийн тодотгол хийх зэрэг арга хэмжээ авахыг Засгийн газар болон холбогдох байгууллагаас шаардана. Засгийн газар, холбогдох байгууллага шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзсэн аливаа асуудлыг Засгийн газар, холбогдох байгууллагад шилжүүлнэ.

3.Засгийн газар болон холбогдох байгууллага энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ, эсхүл шилжүүлсэн асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэж, үр дүнг Үндэсний Ассамблейд тайлагнана.

4.Үндэсний Ассамблей энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан үр дүнгийн тайлангийн талаар зохих арга хэмжээ авч болно.

5.Эрх бүхий хорооны ажиллах хугацаа дууссан, эсхүл бусад шалтгааны улмаас энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан үр дүнгийн тайланг аль хороо явуулах нь тодорхойгүй бол

Үндэсний Ассамблейн дарга бүлэг тус бүрийн төлөөлөлтэй зөвлөлдсөний үндсэн дээр уг үүргийг хэрэгжүүлэх хороог томилно.

17 дугаар зүйл.Сахилгын арга хэмжээ

Хяналт, шалгалт хийж буй Үндэсний Ассамблейн гишүүн энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дэх хэсэгт заасан татгалзах үндэслэл байгааг мэдсэн хэдий ч татгалзах хүсэлт гаргаагүй, мөн 14 дүгээр зүйлд заасан хууль ёсны үүргийг биелүүлээгүй бол Үндэсний Ассамблейн тухай хуульд заасан сахилгын арга хэмжээ авч болно.

18 дугаар зүйл.Үндэсний Ассамблейн дүрэм

Энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай асуудлыг Үндэсний Ассамблейн журмаар тогтооно.

---ooOoo---

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТ 2.*Албан бус орчуулга***БНСУ-ЫН НИЙТИЙН АЛБАНД НЭР ДЭВШИГЧИЙГ ТОМИЛОХ
СОНСГОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь Үндэсний Ассамблейн тусгай хорооны бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагаа болон нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонсгол зохион байгуулах журмыг тогтооход оршино.

2 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.“Нийтийн албанд нэр дэвшигч” гэж Үндэсний Ассамблейн тухай хуулийн 46-3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу нийтийн албанд томилуулахаар санал болгосон хүн, сонгогдсон Ерөнхийлөгчөөс Ерөнхий сайдад нэр дэвшүүлсэн хүн, мөн хуулийн 65-2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгч, сонгогдсон Ерөнхийлөгч, эсхүл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс Үндэсний Ассамблейд нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонсгол явуулах хүсэлт гаргасан хүнийг;

2.“Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох санал” гэж Үндэсний Ассамблейн тухай хуулийн 46-3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу томилох тухай санал, сонгох тухай санал, сонгогдсон Ерөнхийлөгчийн хүсэлтээр Ерөнхий сайдад нэр дэвшигчийн талаар нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонсгол явуулах хүсэлт болон мөн хуулийн 65-2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний Ассамблейд нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонсгол явуулах саналыг ойлгоно.

3 дугаар зүйл.Сонсголын тусгай хороо

1.Үндэсний Ассамблейн тухай хуулийн 46-3 дугаар зүйлд заасан сонсголын тусгай хороо нь нийтийн албанд нэр дэвшигчийг томилох тухай саналыг Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлснээр байгуулагдсанд тооцно.

2.Сонсголын тусгай хороо нь нийт 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

3.Сонсголын тусгай хорооны гишүүдийг бүлгийн дарга тус бүрийн хүсэлтийн дагуу хувь тэнцүүлэх зарчмаар Үндэсний Ассамблейн дарга (цаашид “Дарга” гэх) томилж, өөрчилнө. Сонсголын тусгай хороо байгуулагдсан өдрөөс хойш хоёр хоногийн дотор гишүүнийг томилох хүсэлтийг даргад хүргүүлнэ. Энэ хугацаанд хүсэлт гаргаагүй бол дарга гишүүдийг шууд томилно.

4.Бүлэгт харьяалалгүй Үндэсний Ассамблейн гишүүнийг дарга шууд томилно.

5.Сонсголын тусгай хороо нь дарга, бүлэг тус бүрээс нэг нарийн бичгийн даргатай байх бөгөөд үйл ажиллагаагаа Үндэсний Ассамблейн нэгдсэн хуралдаанд тайлагнана.

6.Сонсголын тусгай хороо нь нийтийн албанд нэр дэвшигчийг томилох саналыг нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэх, эсхүл тус сонсголын явцыг нэгдсэн хуралдаанд танилцуулах хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

4 дүгээр зүйл.Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох тухай саналыг хянах, сонсгол зохион байгуулах

1. Үндэсний Ассамблейн тухай хуулийн 65-2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу сонсголын тусгай хороо (цаашид “Хороо” гэх) болон харьяалах Байнгын хороо нь нийтийн албанд нэр дэвшигчийг томилох саналыг хянаж, сонсголыг зохион байгуулна. Үндэсний Ассамблейн тухайн хуулийн 65-2 дугаар зүйлд заасны дагуу хороо нь нийтийн албанд нэр дэвшигчээс асуулт асуух, хариулт авах, саналыг нь сонсох эрхтэй.

2. Хороо нь шаардлагатай бол гэрч, шинжээч оролцуулах болон гэрчийн мэдүүлэг сонсох, нотлох баримтад шалгалт хийж болно.

5 дугаар зүйл. Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох тухай саналд хавсаргах баримт бичиг

1. Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлсэн нийтийн албан тушаалд нэр дэвшигчийг томилох тухай саналд хүсэлтийн тайлбар, даргын тодорхойлолт болон дараах баримт бичгийг хавсаргана:

1. Нэр дэвшигчийн намтар, ажлын туршлага болон боловсрол;

2. Төрийн албан хаагчийн цэргийн алба хаасан тухай мэдээлэл, Ил тод байдлын тухай хуулийн дагуу цэргийн алба хаасан талаарх лавлагаа;

3. Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн 10-2 дугаар зүйлийн 2-т заасны дагуу нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг;

4. Сүүлийн 5 жилийн орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, газрын иж бүрэн албан татвар төлсөн эсэх болон хугацаа хэтэрсэн өртэй эсэх талаарх лавлагаа;

5. Ял шийтгэлгүй эсэх тодорхойлолт.

2. Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох эрх бүхий этгээд, эсхүл нэр дэвшүүлэх эрх бүхий этгээд болон Үндэсний Ассамблейгаас сонгогдсон нийтийн албанд нэр дэвшигчид нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичгийг даргад хүргүүлнэ.

3. Үндэсний Ассамблейгаас сонгогдсон нийтийн албанд нэр дэвшигч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичгийг төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллагаас шаардаж болох бөгөөд хүсэлтийг хүлээн авсан байгууллагын дарга шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

6 дугаар зүйл. Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох тухай саналыг шилжүүлэх

1. Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох саналыг өргөн мэдүүлсэн тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга нэн даруй нэгдсэн хуралдаанд танилцуулж, харьяалагдах Байнгын хороонд шилжүүлж, сонсгол дууссаны дараа төслийг нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах, эсхүл хорооны дарга нэгдсэн хуралдаанд танилцуулна. Хэрэв нэгдсэн хуралдааны чөлөө цагт, эсхүл завсарласны улмаас чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах боломжгүй бол саналыг тайлангүйгээр оруулж болно.

2. Үндэсний Ассамблей нь томилгооны саналыг өргөн мэдүүлсэн өдрөөс хойш 20 хоногийн дотор сонсголыг зохион байгуулж дуусгана.

3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Өргөн нэвтрүүлэг, харилцаа холбооны дарга, Үндэсний тагнуулын газрын дарга, Шударга өрсөлдөөний хорооны дарга, Санхүү, эдийн засгийн хорооны дарга, Хүний эрхийн үндэсний комиссын дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Үндэсний татварын албаны дарга, Ерөнхий прокурор, Солонгосын Үндэсний цагдаагийн

газрын ерөнхий комиссар, Зэвсэгт хүчний штабын ерөнхий командлагч, Солонгосын банкны Ерөнхийлөгч, Мэргэжлийн хяналтын газрын дарга зэрэг албан тушаалд нэр дэвшигчдийн сонголыг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд зохион байгуулж чадаагүй тохиолдолд тухайн өдрөөс хойш 10 хүртэл хоногийн дотор Үндэсний Ассамблейн нэгдсэн хуралдаанд нийтийн сонголыг дахин хэлэлцэх хүсэлтийг Ерөнхийлөгч, сонгогдсон Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нар гаргаж болно.

4.Үндэсний Ассамблей нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд дээрх нэр дэвшигчдийг томилох сонголын тайланг хүргүүлээгүй тохиолдолд Ерөнхийлөгч болон Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч томилж болно.

7 дугаар зүйл.Гишүүдээс нэр дэвшигчдэд асуулт тавих

1.Хороо нь нийтийн албанд нэр дэвшигчийн тангаргийг сонссоны дараа 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх зөвшөөрөл өгнө.

2.Нийтийн албанд нэр дэвшигч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу дараах тангаргийг өргөнө:

"Би төрийн албанд нэр дэвшиж байгаа хүний хувьд ухамсартайгаар юу ч нуулгүй, юу ч нэмэлгүйгээр үнэнийг хэлэхээ тангараглаж байна."

3.Асуултын хугацааг нарийн бичгийн дарга нартай зөвшилцсөний үндсэн дээр хорооны дарга тогтооно.

4.Асуулт нь асуулт асуух, хариулах хэлбэрээр явагдана. Хороо нь өөрөөр шийдвэрлэсэн тохиолдолд асуултыг хамтын хэлбэрээр явуулж болно.

5.Хорооны гишүүн нь нийтийн албанд нэр дэвшигчээс асуулт асуух бол асуултын хураангуйг нарийвчлан бэлтгэж, сонгол хийхээс 24 цагийн өмнө хорооны даргад хүргүүлнэ. Энэ тохиолдолд хорооны дарга асуултын хураангуйг нэр дэвшигчид цаг алдалгүй уламжилна.

6.Хорооны гишүүн нь нэр дэвшигчээс бичгээр асуулт асууж болно. Энэ тохиолдолд тухайн гишүүн асуултын жагсаалтыг хорооны даргад бичгээр гаргана. Хорооны дарга нь тухайн асуултын жагсаалтыг сонсгол зохион байгуулахаас таваас доошгүй хоногийн өмнө нэр дэвшигчид хүргүүлнэ. Нэр дэвшигч нь тухайн асуултын хариуг сонсгол эхлэхээс 48 цагийн өмнө хорооны даргад бичгээр хүргүүлнэ.

7.Энэ хуулийн 14, 15 дугаар зүйлийн бичгээр өгсөн хариултад шаардлагатай өөрчлөлтийг оруулан дагаж мөрдөнө.

8 дугаар зүйл.Гэрчээр дуудах, гэрчээс мэдүүлэг авах

1.Хороо нь гэрч, шинжээчийг оролцуулж болох бөгөөд энэ тохиолдолд таваас доошгүй өдрийн өмнө хүсэлтийг бичгээр хүргүүлнэ.

9 дүгээр зүйл.Хорооны үйл ажиллагааны хугацаа

1.Хороо нь нийтийн албанд нэр дэвшигчийг томилох саналыг хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор сонголыг дуусгах бөгөөд сонсох хугацаа гурван хоногоос хэтрэхгүй байна. Сонсгол нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас дуусгавар болоогүй бол энэ хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хугацааг сунгаж болно.

2.Хороо нь нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонсгол дууссан өдрөөс хойш гурав хоногийн дотор сонголын тайланг даргад хүргүүлнэ.

3.Хэрэв хороо энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан хугацаанд сонголыг дуусгаагүй бол дарга саналыг нэгдсэн хуралдаанд шууд оруулж, хэлэлцүүлж болно.

10 дугаар зүйл. Үйл ажиллагааны тайлан

1.Хороо нь энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу даргад хүргүүлэх тайланд шалгалт болон сонголын үйл ажиллагааны явцыг тайлбарлаж, чухал шаардлагатай нотлох баримтыг хавсаргана.

2.Дарга хорооны тайланг хүргүүлсний дараа нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээс өмнө хэвлэж гишүүдэд тараана. Нэн яаралтай тохиолдолд тараахгүй байж болно.

3.Үндэсний Ассамблейн тухай хуулийн 46-3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдад нэр дэвшигчийн сонголын явцын талаарх тайланг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тайлангийн нэг гэж үзнэ.

11 дүгээр зүйл.Хорооны даргын үйл ажиллагааны тайлан

1.Хорооны дарга нь нийтийн сонгол дууссаны дараа тайланг нэгдсэн хуралдаанд тайлагнана.

2.Дарга нь Үндэсний Ассамблейн тухай хуулийн 65-2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нийтийн албанд нэр дэвшигчийн томилох сонголын тайланг Ерөнхийлөгч, сонгогдсон Ерөнхийлөгч болон Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид цаг алдалгүй уламжилна. Хэрэв тусгай хорооны дарга нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулаагүй тохиолдолд Үндэсний Ассамблейн даргад танилцуулах бөгөөд дарга тус тайланг Ерөнхийлөгч, сонгогдсон Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид уламжилна.

11-2 дугаар зүйл.Сонгогдсон ерөнхийлөгчийн хууль зүйн үр нөлөө

Ерөнхийлөгчийн шилжилтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу сонгогдсон Ерөнхийлөгч нь тангараг өргөөгүй байх үед Төрийн зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн талаар сонгол хийх хүсэлт гаргасан бол тус хүсэлт нь тухайн хүсэлт гаргасан Ерөнхийлөгчийн хийсэн үйлдэл гэж үзнэ.

12 дугаар зүйл.Баримт бичиг ирүүлэх хүсэлт

1.Хороо нь нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонголтой шууд холбоотой баримт бичгийг ирүүлэх хүсэлтийг хорооны шийдвэр, эсхүл нийт гишүүний 1/3-ээс доошгүй гишүүний хүсэлтээр төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон бусад байгууллагад гаргаж болно.

2.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичгийг тав хоногийн дотор ирүүлнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу баримт бичиг ирүүлэх хүсэлт хүлээн авсан байгууллага нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд үндэслэл бүхий тайлбар бичиг ирүүлнэ. Уг тайлбар бичгийг хорооны үйл ажиллагааны тайланд хавсаргана.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу баримт бичиг ирүүлэх хүсэлт хүлээн авсан байгууллага нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд хороо нь холбогдох байгууллагад сануулга өгч болно.

13 дугаар зүйл.Хянан шалгах

Шаардлагатай тохиолдолд хороо нь өөрийн шийдвэрээр шалгалт хийж болно.

14 дүгээр зүйл.Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонголыг нийтэд нээлттэй явуулах

Сонголыг дор дурдсанаас бусад тохиолдолд нээлттэй явуулна:

1.Төрийн нууц, үндэсний аюулгүй байдалтай холбоотой цэргийн асуудал, эсхүл дипломат харилцааны асуудлаар;

2. Хувь хүний нэр хүнд, хувийн нууцад халдах эрсдэлтэй тохиолдолд;

3.Аж ахуйн нэгж, хувь хүний хууль ёсны санхүүгийн болон арилжааны гүйлгээтэй холбоотой мэдээллийг задруулах эрсдэлтэй тохиолдолд;

4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл задрах эрсдэлтэй тохиолдолд;

5.Бусад хууль тогтоомжийн дагуу нууцыг хадгалах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд.

15 дугаар зүйл.Нийтийн албанд нэр дэвшигчийг хамгаалах

Нийтийн албанд нэр дэвшигч, гэрч, эсхүл шинжээч нь сонголыг хаалттай явуулах үндэслэл бүхий хүсэлт гаргавал хүсэлтийг хороо хэлэлцэн шийдвэрлэнэ. Хаалттай явуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд үндэслэлийг хаалттай хуралдаанд тайлбарлана.

15-2 дугаар зүйл.Нийтийн албан тушаалд нэр дэвшигчид дэмжлэг үзүүлэх

Төрийн байгууллага нь нийтийн албанд нэр дэвшигчид захиргааны дэмжлэг, туслалцаа үзүүлж болно.

16 дугаар зүйл.Хариулахаас татгалзах

1.Үндэсний Ассамблейд мэдүүлэг өгөх, үнэлгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигч нь хариулах, эсхүл баримт бичиг гаргаж өгөхөөс татгалзах эрхтэй.

2.Нийтийн албанд нэр дэвшигч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 148 болон 149 дүгээр зүйлд заасан асуудлаар хариулахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд хариулахаас татгалзсан шалтгаан нь нотлох баримтаар тогтоогдсон байх шаардлагатай.

17 дугаар зүйл.Татгалзах үндэслэл

1.Хорооны гишүүн нь нийтийн албанд нэр дэвшигчтэй шууд хамааралтай, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл хорооны гишүүнийг сонголд оролцуулахаас татгалзаж болно.

2.Хороо нь татгалзах үндэслэлтэй гэж үзвэл хорооны шийдвэрээр тухайн гишүүнийг хасаж өөр гишүүнийг сонголд оролцуулна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл байгаа бол гишүүн Үндэсний Ассамблейн тухай хуулийн 32-4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хорооны даргад татгалзах хүсэлт гаргана. Энэ тохиолдолд зөвхөн хорооны шийдвэрээр хасна.

18 дугаар зүйл.Хууль ёсны үүрэг

1.Хорооны гишүүн нь худал мэдээлэл тараах, заналхийлэх болон доромжилсон үг хэллэг хэрэглэхийг хориглоно.

2.Хорооны гишүүн, түүний ажлын алба нь тусгай хорооны сонсголоос олж мэдсэн нууцыг задруулахыг хориглоно.

19 дүгээр зүйл.Бусад зүйл

Хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагаа болон нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонсголын журамтай холбоотой энэ хуульд зааснаас бусад тохиолдолд Үндэсний Ассамблейн тухай хууль, Төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтын тухай хууль болон Үндэсний Ассамблейд мэдүүлэг өгөх, үнэлгээний тухай хуулийн заалтыг дагаж мөрдөнө.

---ooOoo---

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Монгол Улсын Их Хурлын түүхэн товчоон (2016-2020 он), УИХ-ын Тамгын газар, 2020.
- “Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд, байгууллага, олон нийтийн санал авах практикийн судалгаа” УИХТГ, НҮБХХ-ийн хамтран хэрэгжүүлж буй “иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл <https://mdskhanlex.com/wp-content/uploads/2019/07/хууль-боловсруулах-ажиллагаанд-оролцоог-хангах.pdf>
- Парламентын хяналт шалгалтын тогтолцоо ба эрх зүйн зохицуулалт: Бусад орнуудын туршлага, зөвлөмж, УИХТГ-ын ПССХ, 2021, Парламент судалгааны эмхэтгэл ХХХII боть.
- “Парламентын нээлттэй сонголд оролцогчдын үүрэг, хариуцлага” УИХТГ-ын Судалгааны төв, 2013, Судалгааны эмхэтгэл XIV боть.

БНСУ

- Үндэсний Ассамблейн тухай хууль https://korea.assembly.go.kr:447/res/low_06_read.jsp
- Төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын тухай хууль https://korea.assembly.go.kr:447/res/low_06_read.jsp
- Нийтийн албанд нэр дэвшигчийг томилох сонголын тухай хууль https://korea.assembly.go.kr:447/res/low_06_read.jsp

АНУ

- Hearing in the U.S.Senate: A guide for preparation and procedure https://www.everycrsreport.com/reports/RL30548.html#_Toc256754267



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ,
ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ БА ОЛОН УЛСЫН ЖИШИГ**

(Тойм судалгаа)

*Г.Билгээ, Д.Халиун, О.Нарантуяа,
П.Уранчимэг, Ц.Ариунаа*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

Нэг. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ БА ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ПРАКТИК ТУРШЛАГА

1.1.БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудад тусгагдсан нэмэлт, өөрчлөлт
оруулах зохицуулалт ба түүний хэрэгжилт

1.2.1992 оны Үндсэн хууль ба түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалт

1.3.1999, 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт

Хоёр. 2010 ОНД БАТЛАГДСАН МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ БА ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

2.1.Журмын тухай хууль батлах хэрэгцээ, шаардлага

2.2.Журмын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тойм

2.3.2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан үйл явц

2.3.2022 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан үйл явц

Гурав. ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ОЛОН
УЛСЫН НИЙТЛЭГ ЖИШИГ

3.1.Үндсэн хуулийн хэв шинж ба Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаар

3.2.Үндсэн хуулийн албан ёсны нэмэлт, өөрчлөлтөөс гадуурх өөрчлөлтийн талаар

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн лавлагаа (1999,
2000, 2019, 2022 онуудад)

Хавсралт 2. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай
хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн лавлагаа



УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам, түүний хэрэгжилт ба олон улсын жишиг” сэдэвт тойм судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Улсын Их Хурлаас 2010 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, хүчингүй болсон заалт тус бүрд дүн шинжилгээ хийх захиалагчийн зорилгод нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам, түүний хэрэгжилттэй холбоотой тойм судалгаа хийж, мэдээлэл лавлагаа бэлтгэх, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой олон улсын практик, нийтлэг жишгийг судлах.

Хамрах хүрээ:

- 1992 оноос өмнө Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн талаарх түүхчилсэн тойм судалгаа бэлтгэх: БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны Үндсэн хууль;
- Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиар зохицуулсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах харилцааны зохицуулалт, 1999, 2000 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан үйл явцын талаарх мэдээлэл лавлагаа бэлтгэх;
- 2010 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд ба хуулийн хэрэгжилттэй холбоотой тойм судалгаа гаргах: 2019, 2022 онд Улсын Их Хурлаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцсэн байдал;
- Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой олон улсын практик, нийтлэг жишгийг судлах.

Судалгааны бүтэц: Судалгаа нь удиртгал, судалгааны хураангуй болон дэлгэрэнгүй хэсэг, ашигласан материалын жагсаалт, хавсралтууд гэсэн бүтэцтэй.

Судалгааны дэлгэрэнгүй хэсэг нь дараах гурван бүлэгтэй:

1. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн зохицуулалт ба түүнийг хэрэгжүүлсэн практик туршлага;
2. 2010 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль ба түүний хэрэгжилт;
3. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой олон улсын нийтлэг жишиг.

Түлхүүр үг: үндсэн хууль; үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах; үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт; нэмэлт, өөрчлөлт оруулах журам; журмын тухай хууль.

Keywords: constitution; constitutional amendment; amendments; constitutional amendment rule.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Аливаа улсын Үндсэн хууль нь нийгмийн нийтлэг эрх ашигт үйлчлэх зорилгоор эрх зүйн дээд түвшинд улс төр, нийгмийн чухал ач холбогдол бүхий үнэт зүйлсийг баталгаажуулж, нийгмийн амьдралын бүх хүрээний суурь харилцааг зохицуулах бөгөөд улс орны тогтвортой хөгжлийн баталгаа болж байдаг. Үндсэн хууль удаан хугацаанд тогтвортой үйлчилснээр үндсэн хуульд байгууллын халдашгүй байдлын зайлшгүй урьдач нөхцөл нь болж, үндэсний эрх зүйн тогтолцооны хөгжил, хүний эрхийн баталгаа болох түүхэн үүргээ хэрэгжүүлж чадна. Үүний тулд Үндсэн хуулиа чандлан сахиж, түүний дархлааг алдагдуулахгүй байх нь юу юунаас чухал байдаг. Нөгөө талаас, Үндсэн хуулийг хэзээ ч хөндөшгүй баримт бичиг гэж туйлшруулан ойлгож болохгүй. Нийгэм байнга хөгжин урагшилж байдаг тул зайлшгүй тулгамдсан өөрчлөлтийг Үндсэн хуульд цаг тухайд нь тусгаж байх шаардлагатай байдаг.¹⁴⁹

Монгол Улсын үндсэн хуульд ёсны түүхэн хөгжлийн явцад улсын суурь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам тухайн цаг үеийнхээ шаардлагад нийцэн боловсронгуй болж иржээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын Үндсэн хуулиудад тусгагдсан нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалт ба тэдгээрийн хэрэгжилт: БНМАУ гурван удаа Үндсэн хуулиар түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн эрхийг төрийн эрх барих дээд байгууллагад олгожээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг 1924 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд товч байдлаар зохицуулсан¹⁵⁰ бол 1940 оны Үндсэн хуулийн 12 дугаар бүлэгт “БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлөх журам” хэмээн анх удаа тусгайлан журамлажээ¹⁵¹. Мөн түүнчлэн 1960 оны Үндсэн хуулийн “БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлөх ба халах тухай” 10 дугаар бүлэгт¹⁵², хожим 1981 онд Ардын Их Хурал (АИХ)-ын регламентаар¹⁵³ нэмэлт байдлаар бататган зохицуулж байжээ.

Эдгээр хуулийн хэрэгжилтийг авч үзвэл, 1940, 1960 оны Үндсэн хуулиудад тус бүр 16 удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан ч тэр бүр Үндсэн хуульд нэмэлт оруулах журмыг мөрдөөгүй байна. Тухайлбал, 1940 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн 9-ийг (56,3 хувь) нь, 1960 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн 6-г (31,6 хувь) нь АИХ-ын хуулиар бус тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Бага Хурлын тогтоолоор тус тус оруулсан байна.¹⁵⁴

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль ба түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалт: Манай улсад ардчилсан хөдөлгөөн өрнөж, улмаар АИХ-аар төрийн эрх барих дээд байгууллагын бүтцийг өөрчлөн шинэчлэх тухай асуудлыг хэлэлцэж, 1990 оны 05 дугаар сарын 10-ны өдөр БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг баталжээ. Энэхүү хууль нь 1960 оны Үндсэн хуулиас 1992 оны Үндсэн хуульд шилжих завсрын үеийн төрийн байгууллын тогтолцоог тодорхойлж байсан төдийгүй шинэ Үндсэн хууль батлагдан гарах урьдач нөхцөлийг бүрдүүлсэн байна.¹⁵⁵

¹⁴⁹ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 189 дэх тал.

¹⁵⁰ Амарсанаа Ж., Батсайхан О. Монгол Улсын Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992). УБ., 2009 он. 8 дахь тал.

¹⁵¹ Батбаяр Б. “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба Үндсэн хуулийн зөрчил” өгүүлэл. Эрх зүй, цуврал 45. 2019 он. №1. 29-30 дахь талууд.

¹⁵² Амарсанаа Ж., Батсайхан О. Монгол Улсын Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992). УБ., 2009 он. 282 дахь тал.

¹⁵³ БНМАУ-ын Ардын Их Хурлын регламент. БНМАУ-ын хууль. 1981.06.29. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Зургаадугаар боть. (1971 - 1985.IV сар). УБ., 2010 он. 420 дахь тал. Эх сурвалж: Батбаяр Б. “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба Үндсэн хуулийн зөрчил” өгүүлэл. Эрх зүй, цуврал 45. 2019 он. №1. 41-42 дахь талууд.

¹⁵⁴ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 191 дэх тал

¹⁵⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал (Хураангуй танилцуулга). Редактор: Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. УИХ-ын Тамгын газрын ПССХ. 2022 он.

1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн¹⁵⁶ 68, 69 дүгээр зүйлд түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын үндсийг тогтоож өгсөн: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал (УИХ)-ын 76 гишүүн, Засгийн газар санаачилна; Үндсэн хуулийн цэц (ҮХЦ) нь уг асуудлаарх саналаа УИХ-д өргөн мэдүүлж болно; нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-ын нийт гишүүдийн 3/4-ийн саналаар батална; хэрэв төслийг хэлэлцсэн ч баталж чадаагүй бол тухайн УИХ бүрэн эрхийнхээ хугацаанд дахин авч хэлэлцэхгүй; УИХ-ын бүрэн эрхийнхээ сүүлийн 6-н сард Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй байхаар зохицуулсан. Энэ нь нэг талаар нэмэлт, өөрчлөлтийг дур зоргоор оруулахгүй байхыг, нөгөө талаар төрийн тогтвортой байдлыг эрх зүйн үүднээс баталгаажуулах зорилготой.¹⁵⁷

1999, 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Үндсэн хуулийг хэрэгжүүлэх явцад тулгарсан асуудал нь түүний зарим зүйл, заалтыг эргэн харахад хүргэжээ. Тухайлбал, Засгийн газрыг шинээр эмхлэн байгуулж чадахгүй хэт их хугацаа алдах; УИХ-ын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах асуудлыг нарийвчлан зохицуулаагүй; УИХ-ын хуралдааны ирцийг гишүүдийн дийлэнх олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцохоор заасан нь чуулганы үйл ажиллагаа тасалдах нөхцөл болжээ.¹⁵⁸

1999 оны эцсээр дээрх асуудлыг шийдвэрлэх талаар УИХ-д суудалтай байсан гурван нам зөвшилцөж¹⁵⁹, 1999 оны 12 дугаар сарын 23-ны өдөр УИХ-ын 65 гишүүнээс Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-д өргөн мэдүүлжээ. 12 дугаар сарын 24-ний өдөр УИХ төслийг хэлэлцэн Үндсэн хуульд нэмэлт (§22.2; 39.2), өөрчлөлт (§24.1; 27.2; 27.6; 29.1; 33.1.2) оруулсан.¹⁶⁰

УИХ төслийг хэлэлцэн батлахдаа Үндсэн хууль, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль (1997 он), Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хууль (1997 он)-д заасан журмыг баримталсан байна.

Гэвч УИХ уг төслийн талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас санал аваагүй, тэдэнд танилцуулаагүй, олон нийтэд мэдээлээгүй зэргээр хуулийн төсөл боловсруулж, хэлэлцэн батлах журам, шаардлагуудыг мөрдөөгүй байна. Тийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд бүхэлд нь хориг тавьсан (1999.12.31)¹⁶¹ боловч УИХ уг хоригийг хүлээж аваагүй.¹⁶² Мөн ҮХЦ-ээс уг нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай дүгнэлт (2000.03.15, №03) гаргасныг¹⁶³ УИХ уг дүгнэлтийг авч хэлэлцсэн боловч ямар нэгэн шийдвэр гаргаагүй.¹⁶⁴ ҮХЦ уг асуудлыг дахин авч хэлэлцээд Үндсэн хуулийн 68.1 дэх хэсэгт үндэслэн УИХ-ыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг

¹⁵⁶ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

¹⁵⁷ Мөн тэнд. 207 дахь тал.

¹⁵⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал (Хураангуй танилцуулга). Редактор: Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. УИХ-ын Тамгын газрын ПССХ. 2022 он.

¹⁵⁹ УИХ-ын 1999 оны намрын ээлжит чуулганыг хааж УИХ-ын дарга Р.Гончигдоржийн хэлсэн үг. *Эх сурвалж: Монгол Улсын Парламент (УИХ-ын чуулганы хуралдаанд хэлсэн үгийн эмхэтгэл, 1990-2000 он). УИХ, УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв, НҮБХХ. УБ., 2005 он. 494 дэх тал.*

¹⁶⁰ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 59 дугаарт нийтлэгдсэн.

¹⁶¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориг. 1999.12.31. Дугаар Е/67. *Эх сурвалж: Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль; Ерөнхийлөгчийн хоригийн тухай тогтоол; Үндсэн хуулийн цэцийн 03 тоот дүгнэлт. 1999-2000 он. УИХ-ын Тамгын газрын архив. Д-5, ХН-28. 28-29 дэх тал.*

¹⁶² “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” УИХ-ын 2000 оны 01 дүгээр тогтоол “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2000 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

¹⁶³ “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай” ҮХЦ-ийн 2000 оны 03 дугаар дүгнэлт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2000 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

¹⁶⁴ Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль; Ерөнхийлөгчийн хоригийн тухай тогтоол; Үндсэн хуулийн цэцийн 03 тоот дүгнэлт. 1999-2000 он. УИХ-ын Тамгын газрын архив. Д-5, ХН-28.

санаачлахдаа Ерөнхийлөгч, ҮХЦ-тэй зөвшилцөх байсныг хэрэгжүүлээгүй¹⁶⁵, дээрх нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгожээ (2000.11.29, №02).¹⁶⁶

ҮХЦ ийнхүү шийдвэрлэснээр тухайн үед Ерөнхий сайд, Засгийн газрын 4 гишүүн нь УИХ-ын гишүүн байсан бөгөөд тэд суудлаасаа чөлөөлөгдөх нөхцөл үүссэн байв. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд 2000 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-ын 65 гишүүнээс Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 1999 онд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй яг ижил томъёоллоор УИХ-д өргөн мэдүүлжээ.

Үүнтэй зэрэгцэн уг төслийг Ерөнхийлөгч, Засгийн газар, ҮХЦ-д хүргүүлснээс төслийн талаар Засгийн газар дэмжсэн бол Ерөнхийлөгч, ҮХЦ-ээс саналуудаа ирүүлжээ. Гэвч УИХ саналуудыг төсөлд тусгалгүй Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40.11 дэх хэсэгт заасны дагуу 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр төслийг бүхэлд нь баталжээ.¹⁶⁷

Ерөнхийлөгч уг нэмэлт, өөрчлөлтөд хориг тавьсан (2000.12.20)¹⁶⁸ боловч УИХ хүлээн авах боломжгүй гэж үзсэн (2000.12.22)¹⁶⁹ байна.

Эцсийн дүнд улс төрийн идэвхтэй зөвшилцөл явагдсаны дүнд 2001 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Ерөнхийлөгч хүлээн авч, ҮХЦ эсэргүүцээгүй байна.¹⁷⁰

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг батлах хэрэгцээ, шаардлага: Дээрх үйл явдлын дараа хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын зааг ялгаа бүдгэрч, Үндсэн хуулиар тунхагласан хариуцлагын тогтолцоо алдагдаж байгаа талаар олон нийтийн зүгээс шүүмжлэл дагуулсан асуудлуудад УИХ анхаарлаа хандуулж эхэлсэн.¹⁷¹

Мөн асуудал дагуулсан нэмэлт, өөрчлөлтийг баталсан процесс, түүнийг тойрсон улс төрийн зөрчилдөөн нь Үндсэн хуульд дархлаа бүрэн тогтоогүйг харуулсан. Иймд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээ, хязгаарыг тогтоох, ингэхдээ түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг хаахгүй байх; мөн нэмэлт, өөрчлөлт оруулахад Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (цаашид “Дэгийн тухай хууль” гэнэ)-ийн зохицуулалт хангалтгүй байсан тул процессын асуудлыг нарийвчлан журамлах шаардлагатай болсон. Үүнийг тухайн үед судалсан гадаадын 120 улсын Үндсэн хуулийн зохицуулалт ч баталсан байна.¹⁷²

Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн шийдвэрлэх тодорхой дэг, журмыг зохицуулсан бие даасан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль (цаашид “Журмын тухай хууль” гэнэ)-ийг 2010 онд УИХ-аас баталсан.

Энэ хуульд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндсэн зарчим болох Үндсэн хуулийг

¹⁶⁵ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 195 дахь тал.

¹⁶⁶ “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн хэлэлцсэн тухай” ҮХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоол “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2000 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

¹⁶⁷ Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт; “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” УИХ-ын 54 дүгээр тогтоол. 2000 он. УИХ-ын Тамгын газрын архив. Д-5, ХН-47.

¹⁶⁸ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориг. 2000.12.20. Дугаар Е/51. Эх сурвалж: Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт; “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” УИХ-ын 54 дүгээр тогтоол. 2000 он. УИХ-ын Тамгын газрын архив. Д-5, ХН-47.

¹⁶⁹ “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” УИХ-ын 2000 оны 54 дүгээр тогтоол “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2000 оны 50 дугаарт нийтлэгдсэн.

¹⁷⁰ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 195-196 дахь талууд.

¹⁷¹ Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал (Хураангуй танилцуулга). Редактор: Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. УИХ-ын Тамгын газрын ПССХ. 2022 он.

¹⁷² Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль. Боть-1.

дээдлэн сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах, ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах, бодитой ил тод байх зэрэг зарчим, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нарийвчилсан журам, мөн өөрчлөхийг хориглосон заалтуудыг тодорхой болгож өгсөн. Тоймловол, энэ хуулиар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зарчмын үндсийг тогтоож, мөн Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйлийг хэрэглэх журмыг тодорхойлсон юм. Тэр нь Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангах, дээрх 2 зүйлийг зөв хэрэглэхэд чиглэснээрээ үндсэн хуульчилсан маш чухал хууль юм.¹⁷³

Журмын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт: Энэ хууль 2010 онд батлагдсанаас хойш нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсноос зарчмын шинжтэй томоохон нэмэлт, өөрчлөлтүүдийг авч үзвэл:

- Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн хүрээнд Журмын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт (2017.02.09) – Журмын тухай хуулийн 5.3.3 дахь хэсэгт зааснаар Үндсэн хуулийн 5.4, 20, 30.1, 30.1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвлөлдөх санал асуулгыг явуулахаар; 5.3.4 дэх хэсэгт зааснаар санал асуулгын дүнгээр дээрх асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжсэн бол УИХ заавал авч хэлэлцэхээр тусгасан;

- УИХ-ын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг УИХ хүлээн авсантай холбогдуулан Журмын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт (2019.10.11)¹⁷⁴ – Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлүүлэхтэй холбоотой асуудлыг тодруулсан; нэмэлт, өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үед төсөлд тусгагдаагүй шинэ томъёолол оруулахгүй байхаар хязгаарласан; нэмэлт, өөрчлөлтийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийн санал, хураалт явуулах үндэслэлийг тодорхой болгосон;

- ҮХЦ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн 39.1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийг хүчингүй болгосонтой холбогдуулан Журмын тухай хуульд орсон өөрчлөлт (2022.08.24)¹⁷⁵ – Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Дэгийн тухай, Журмын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт оруулж, ҮХЦ-ийн эцсийн шийдвэр (тогтоол)-ээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хуулийн хүрээнд УИХ-аар хэлэлцэх боломжийг бүрдүүлж өгсөн.

2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, санаачилгын талаар Монгол Улсын хэмжээнд Зөвлөлдөх санал асуулга, олон нийтийн хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал, улс төрийн намуудын хэлэлцүүлгийг тодорхой үе шаттайгаар зохион байгуулжээ.

Тухайн үед Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, саналыг УИХ-ын 62 гишүүнээс (2019.06.06) болон Монгол Улсын Ерөнхийлөгчөөс (2019.07.16) УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ төслүүдийг хамтатган хэлэлцэж 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг оруулахдаа Журмын тухай хуулийн 5.1.2, 5.3 дахь хэсэгт заасны дагуу бүх талын оролцоог хангах, тэдэнд саналаа чөлөөтэй илэрхийлэх бололцоог олгох үндсэн зарчмыг баримталжээ. Ингэснээр уг нэмэлт, өөрчлөлт бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдөж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах сайн жишиг, дэг жаягийг тогтоосон.¹⁷⁶

2022 онд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт: ҮХЦ 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн

¹⁷³ Чимид Б. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан зарим асуудал. Хууль дээдлэх ёс. Цуврал 35. 2011 он. 22 дахь тал.

¹⁷⁴ УИХ-ын 2019 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга (Албан хэрэгцээнд). УИХ-ын Тамгын газар. УБ., 2020 он. 88 дахь тал.

¹⁷⁵ УИХ-ын 2022 оны ээлжит бус чуулганы үйл ажиллагааны танилцуулга (Албан хэрэгцээнд). УИХ-ын Тамгын газар. УБ., 2022 он. 21 дэх тал.

¹⁷⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал (Хураангуй танилцуулга). Редактор: Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. УИХ-ын Тамгын газрын ПССХ. 2022 он.

их суудлын хуралдаанаараа 2019 онд өөрчлөн найруулсан Үндсэн хуулийн 39.1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэсэн нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд харшилж, Үндсэн хуулийн зохих зүйл, хэсэгт нийцээгүй гэж үзэн хүчингүй болгожээ.

Үүний тулд дээрх асуудлыг УИХ-аар хэлэлцэх журам, дэгтэй холбоотой хуулийн зарим зохицуулалт хийжээ. 08 дугаар сарын 24-ний өдөр УИХ-аар Дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (§54¹), Журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай (§1.4; 18) болон бусад хуулийн төслүүдийг баталсан.

УИХ-аар ҮХЦ-ийн эцсийн шийдвэр (тогтоол)-ээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хуулийн хүрээнд хэлэлцэх боломжийг бүрдүүлсний дараа УИХ-ын 62 гишүүнээс Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 08 дугаар сарын 25-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

Журмын тухай хуулийн дагуу УИХ Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр хэлэлцүүлгийг хийж, төслийн 2 дахь хэлэлцүүлгээр Журмын тухай хуулийн 18.10 дахь хэсэгт заасны дагуу УИХ-ын нийт гишүүдийн 98.4 хувийн саналаар Үндсэн хуулийн 39.1 дэх хэсгийн “...Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэсэн 2 дахь өгүүлбэрийг хүчингүй болгосон.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах олон улсын нийтлэг жишиг: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам хүндрүүлсэн процедуртай, өндөр босготой байх тусам Үндсэн хуулийг өөрчлөхөд хэцүү байдаг. Үндсэн хууль судлалд үндсэн хуулийг өөрчлөх журмаас хамааран үндсэн хуулиудыг хоёр ангилдаг: ердийн олонхоор баталдаг бол “уян”, парламентаар хэлэлцэн, ард нийтийн санал асуулгаар баталдаг, эсхүл орон нутгийн парламентын дийлэнх олонхын дэмжлэг авч баталдаг бол “хатуу” үндсэн хууль гэдэг.¹⁷⁷

Улс орнуудын хувьд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуралдааны санал хураалтын квотыг дийлэнх олонхоор тогтоох нь элбэг байна. Жишээ нь, Болгар, Герман, Унгар, Энэтхэг зэрэг улсад – 2/3, Америкт – 3/4-ын санал шаардлагатай байдаг.

Мөн дэлхийн улс орнуудын практикт үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хэд хэдэн хувилбар байна. Тухайлбал, үндсэн хуулийг анх баталсан шийдвэр нь ард түмний итгэл үнэмшил байдаг тул түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг бүх ард түмний санал асуулгаар шийдвэрлэх зарчим (Япон¹⁷⁸); үндсэн хуульд хоёр чуулган дамжин нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалттай ба ингэхдээ хоёр чуулган хооронд сонгууль явуулах нь иргэдийн санаа бодлыг тусгаж буй нэг хэлбэр гэж үздэг (Норвеги¹⁷⁹) байна.

Дээрх хязгаарлалтаас гадна агуулгын хувьд хязгаарлалт тогтоосон 75 үндсэн хууль байна.¹⁸⁰ Тухайлбал, үндсэн хуулийн тодорхой бүлэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглох



¹⁷⁷ Лүндээжанцан Д. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол арга зүйн харьцуулалт үндэслэл, Шинэ толь, №31, 2000 он.

¹⁷⁸ Япон Улсын Үндсэн хууль, <https://www.sangiin.go.jp/eng/law/tcoj/index.htm>

¹⁷⁹ Норвегийн Хаант Улсын Үндсэн хууль, <https://lovdata.no/dokument/NLE/lov/1814-05-17?q=grunnloven>

¹⁸⁰ Олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

бөгөөд тус хязгаарлалт үндсэн хууль өөрт нь агуулагдаж буй тохиолдолд түүнийг үүрдийн баталгаа (eternity clause) гэж нэрлэж байна.¹⁸¹ (Индонез¹⁸², Франц¹⁸³, Итали¹⁸⁴, Герман¹⁸⁵)

Мөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаарыг Үндсэн хуульд өөрт нь тусгаагүй боловч уг хязгаарыг тусгай журмаар тогтоосон байдаг. (Монгол)

Үндсэн хуулийн үндсэн бүтцийн номлол (basic structure doctrine) гэх үзэл санаа нь үндсэн хуульд тухайн үндсэн хуулийн суурь болон гол шинжийг агуулсан зарчмууд туссан байдаг гэх үзэл санаа юм.¹⁸⁶ Аль ч үндсэн хуульд хэзээ ч өөрчилж үл болох гол гол зарчмууд байдаг гэдэг үзэл санааг үндсэн хуулийн үндсэн бүтцийн номлол гэдэг. Үндсэн бүтцийн номлолын хамрах хүрээ маш тодорхой бөгөөд энэ нь үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хөндөж болохгүй гэж заасан үндсэн хуулийн заалтууд юм. (Бангладеш¹⁸⁷). Үндсэн бүтцийн номлол нь олон улсын практикт хууль тогтоох замаар, эсхүл үндсэн хуулийн шинжтэй маргааныг хянан хэлэлцэх явцдаа үндсэн хуулийн шүүх, эсхүл Дээд шүүхээс жишиг тогтоосон шүүхийн шийдвэр гаргах замаар хэрэгждэг.¹⁸⁸

Үндсэн хуулийн албан ёсны нэмэлт, өөрчлөлтөөс гадуурх өөрчлөлт: Үндсэн хуулийн хяналтын тогтолцоо бүхий улс орнуудад үндсэн хуульд тайлбар хийх замаар түүний зарим зохицуулалтын агуулга, утга, үзэл баримтлалыг өөрчилж болдог. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь хатуу, чанга байхын хэрээр үндсэн хуульд тайлбар хийх замаар өөрчлөх явдал нэмэгдэх (АНУ) магадлалтай.¹⁸⁹

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах албан ёсны журам нь өөрчлөлт оруулахад шаардлагатай хууль зүйн процессыг тодорхойлдог бол тухайн нэмэлт, өөрчлөлтийг дэмжих, хүлээн зөвшөөрүүлэхэд шаардагдах улс төрийн процесс нь дээрхээс ялгаатай байж болох юм.¹⁹⁰ Тухалбал, Словакийн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Парламентын гишүүдийн 3/5-ын саналаар шийдвэрлэдэг. Нэмэлт, өөрчлөлт оруулахад ард нийтийн санал асуулга явуулах албан ёсны шаардлага байхгүй ч практик дээр хэд хэдэн удаа томоохон нэмэлт, өөрчлөлтүүд оруулахаас өмнө зөвлөлдөх санал асуулга явуулжээ.¹⁹¹

Мөн сонгуулийн хууль тогтоомж, парламентын хуралдааны дэг зэрэг нь Үндсэн хуулийн бүрэлдэхүүн хэсэг болохгүй ч үндсэн хуулийн практик, үйл ажиллагаанд нөлөөлж болох юм. Тухайлбал, Нидерландын Үндсэн хуульд албан ёсны өөрчлөлт оруулах бус зөвхөн Парламентын дэгд өөрчлөлт оруулах замаар сайд нарын томилгооны процесс дахь Эзэн хааны үүргийг хязгаарлаж, Парламентын үүргийг нэмэгдүүлсэн байна.¹⁹²

(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү.)

¹⁸¹ Сарантуяа Ц. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаар: онолын асуудал ба Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. Хууль дээдлэх ёс. №1(51). УБ., 2015 он. 46 дахь тал

¹⁸² Бүгд Найрамдах Индонез Улсын Үндсэн хууль, <https://www.mkri.id/public/content/infoumum/regulation/pdf/uud45%20eng.pdf>

¹⁸³ Бүгд Найрамдах Франц Улсын Үндсэн хууль, https://www.conseil-constitutionnel.fr/sites/default/files/as/root/bank_mm/anglais/constitution_anglais_oct2009.pdf

¹⁸⁴ Бүгд Найрамдах Итали Улсын Үндсэн хууль, https://www.senato.it/documenti/repository/istituzione/costituzione_inglese.pdf

¹⁸⁵ Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль, <https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf>

¹⁸⁶ The Basic Structure of the Indian Constitution, <https://constitutionnet.org/vl/item/basic-structure-indian-constitution>

¹⁸⁷ Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсын Үндсэн хууль, <http://bdlaws.minlaw.gov.bd/act-367/section-41504.html>

¹⁸⁸ Одбаяр Д. Үндсэн хуулийн бүтцийн номлол, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (Онол, арга зүйн хэрэгжилт). УБ., 2017. 103 дахь тал.

¹⁸⁹ IDEA (2017), Constitutional Amendment Procedures, <https://www.idea.int/sites/default/files/publications/constitutional-amendment-procedures-primer.pdf>

¹⁹⁰ Мөн тэнд.

¹⁹¹ Мөн тэнд.

¹⁹² Мөн тэнд.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

Нэг. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЭРХ
ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ПРАКТИК ТУРШЛАГА**1.1.БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудад тусгагдсан нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалт ба түүний хэрэгжилт**

1924 оноос хойш Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-д гурван удаа Үндсэн хууль батлагдан мөрдөж байсан ч бусад орнуудтай харьцуулахад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг нарийвчлан тогтоож байгаагүй.¹⁹³ Эдгээр Үндсэн хуулиар түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн эрхийг төрийн эрх барих дээд байгууллагад олгож байжээ. Тухайлбал:

1924 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд “Улсын Үндсэн хуулийг өөрчлөх, батлах явдлыг гагцхүү Улсын Их Хурлаас эрхлэн шийтгэвэл зохино” гэж товчхон заасан байв.¹⁹⁴

1940 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Улсын Их Хурлаас дангаар эрхлэх хэрэгүүд нь: БНМАУ-ын Үндсэн хуулийг батлах ба өөрчлөх,” гэж заасан байна.¹⁹⁵ Мөн Үндсэн хуулийн “БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлөх журам” гэсэн 12 дугаар бүлэгт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг анх удаа журамлажээ.¹⁹⁶ Энэ бүлгийн 95 дугаар зүйлд “БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлөх явдлыг Улсын Их Хурлаар гүйцэтгэх бөгөөд Их Хурлын тэргүүлэгчдийн гуравны хоёроос доош бус хувийн гар өргөж баталснаар өөрчилнө” хэмээн тогтоожээ.¹⁹⁷

Гэвч тэр үеэс хойш Үндсэн хуульд оруулсан 16 удаагийн нэмэлт, өөрчлөлтийн 9-ийг (56,3 хувь) нь хуулиар бус Улсын Бага Хурал (УБХ)-ын тогтоол, Ардын Их Хурал (АИХ)-ын тэргүүлэгчдийн зарлигаар оруулж¹⁹⁸, Үндсэн хуульд заасан журмыг төдийлөн мөрдөөгүй байна.

1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “БНМАУ-ын АИХ төрийн бүх эрхийг барих бөгөөд үүнээс тухайлбал: а) БНМАУ-ын Үндсэн хуулийг батлах, өөрчлөх эрхтэй,” гэж заасан.¹⁹⁹ Мөн “БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлөх ба халах тухай” гэсэн 10 дугаар бүлгийн 93 дугаар зүйлд “БНМАУ-ын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг гагцхүү АИХ-аар хэлэлцэж, түүний депутатуудын гуравны хоёроос доошгүй нь баталснаар оруулна” гэж тогтоожээ.²⁰⁰

Түүнчлэн 1981 онд батлагдсан АИХ-ын регламентын 48 дугаар зүйлд “БНМАУ-ын АИХ-ын чуулганаар хэлэлцсэн хуулийн төсөл бүх депутатуудын олонхийн санал авснаар батлагдана. Харин БНМАУ-ын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг депутатуудын гуравны хоёроос доошгүй нь баталснаар оруулна.”²⁰¹ гэж Үндсэн хуулийн дээрх зохицуулалтыг

¹⁹³ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 191 дэх тал.

¹⁹⁴ Амарсанаа Ж., Батсайхан О. Монгол Улсын Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992). УБ., 2009 он. 8 дахь тал.

¹⁹⁵ Мөн тэнд. 92 дахь тал.

¹⁹⁶ Батбаяр Б. “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба Үндсэн хуулийн зөрчил” өгүүлэл. Эрх зүй, цуврал 45. 2019 он. №1. 29-30 дахь талууд.

¹⁹⁷ Амарсанаа Ж., Батсайхан О. Монгол Улсын Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992). УБ., 2009 он. 120 дахь тал.

¹⁹⁸ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 191 дэх тал.

¹⁹⁹ Амарсанаа Ж., Батсайхан О. Монгол Улсын Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992). УБ., 2009 он. 254 дэх тал.

²⁰⁰ Мөн тэнд. 282 дахь тал.

²⁰¹ БНМАУ-ын Ардын Их Хурлын регламент. БНМАУ-ын хууль. 1981.06.29. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Зургаадугаар боть. (1971 - 1985.IV сар). УБ., 2010 он. 420 дахь тал. Эх сурвалж: Батбаяр Б. “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба Үндсэн хуулийн зөрчил” өгүүлэл. Эрх зүй, цуврал 45. 2019 он. №1. 41-42 дахь талууд.

бататган хуульчилжээ.

Гэвч энэ үеэс хойш Үндсэн хуульд оруулсан 16 удаагийн нэмэлт, өөрчлөлтийн 6-г (31,6 хувь) нь АИХ-ын тэргүүлэгчдийн зарлигаар оруулж²⁰² мөн л Үндсэн хуулийн журмыг мөрдөөгүй байна.

1.2.1992 оны Үндсэн хууль ба түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалт

1992 оны Үндсэн хууль батлагдсан үйл явц²⁰³

1980-аад оны сүүл үеэс тухайн үеийн БНМАУ-д төрийн эрх мэдлийн хуваарилах зарчмыг суурьшуулах, манай улсад илүү тохиромжтой засаглалын хэлбэрийг сонгох чиглэлээр нэлээд санал, санаачилга гарч тодорхой ажил хийгдэж байжээ.

Ингээд 1990 оны 05 дугаар сард чуулсан АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн IX чуулганаар төрийн эрх барих дээд байгууллагын бүтцийг өөрчлөн шинэчлэх тухай асуудлыг хэлэлцэн, улмаар 05 дугаар сарын 10-ны өдөр **БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг** баталжээ. Энэхүү хууль нь 1960 оны Үндсэн хуулиас 1992 оны Үндсэн хуульд шилжих завсрын үеийн төрийн байгууллын тогтолцоог тодорхойлж байсан төдийгүй шинэ Үндсэн хууль батлагдан гарах урьдач нөхцөлийг бүрдүүлсэн чухал ач холбогдол, агуулга бүхий хууль байв.

23 зүйл бүхий энэхүү хуулийн “Төгсгөлийн заалт”-д уг хуулийг дагаж мөрдөх хугацааг “...БНМАУ-ын АИХ шинэчлэн сонгогдож ажилдаа орсноос эхлэн БНМАУ-ын Үндсэн хуулийг шинэчлэн батлах хүртэл...” гэж тогтоож, мөн АИХ, УБХ байгуулагдмагц 1960 оны Үндсэн хуулийн 3 дугаар бүлэг (Төрийн эрхийг барих дээд байгууллагууд), 4 дүгээр бүлэг (Төрийн захиргааны дээд ба төвийн байгууллагууд) хүчингүй болохоор хуульчилжээ.²⁰⁴

Энэ хуулийн дагуу АИХ-ыг сонгох анхны ардчилсан сонгууль мажоритар тогтолцоогоор, УБХ-ыг сонгох сонгууль хувь тэнцүүлсэн тогтолцоогоор явагдсан байна.

1990 оны 10 дугаар сарын 03-ны өдөр УБХ-ын тогтоолоор байгуулагдсан Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комисс нь төсөл боловсруулах ажлыг хариуцан гүйцэтгэж, Үндсэн хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулан 1991 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр УБХ-д хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлжээ.

УБХ нь 1991 оны 05 дугаар сарын 17-ны өдөр шинэ Үндсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эхэлснээс хойш эрдэмтэн судлаачид, ард нийтээр хэлэлцүүлэн санал авах ажлуудыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж, гарсан саналуудыг Үндсэн хуулийн төсөлд тусгаж, УБХ-ын чуулганаар дахин хэлэлцэж, зарим засвар, өөрчлөлт оруулан, 1991 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр АИХ-д “Монгол Улсын Их цааз” нэртэйгээр өргөн мэдүүлсэн.

АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн II чуулганы хуралдаанаар “Монгол Улсын Их цааз”-ын төслийг 76 хоногийн турш шүүн хэлэлцэж, 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр **Монгол Улсын Үндсэн хуулийг** эцэслэн баталсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэх бүхий л үе шат ард түмэнд нээлттэй, ил тод байж, тэдний оролцоог хангаж, хэлэлцэн баталжээ.

²⁰² Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 191 дэх тал.

²⁰³ Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал (Хураангуй танилцуулга). Редактор: Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. УИХ-ын Тамгын газрын ПССХ. 2022 он.

²⁰⁴ Амарсанаа Ж., Батсайхан О. Монгол Улсын Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992). УБ., 2009 он. 360-373 дахь талууд.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд тусгагдсан нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалт

1992 оны Үндсэн хуулийн²⁰⁵ 6 дугаар бүлгийн 68, 69 дүгээр зүйлд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын үндсийг тогтоосон. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, тодруулбал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал (УИХ)-ын 76 гишүүн, Засгийн газар санаачлахаар хуульчилсан.

Мөн Үндсэн хуулийн цэц (ҮХЦ)-ээс уг асуудлаарх саналаа УИХ-д өргөн мэдүүлж болно. Үүнийг логик болон системийн үүднээс хууль зүйн доктор, профессор Д.Лүндээжанцан “*ҮХЦ Үндсэн хууль зөрчсөн маргаантай асуудлыг шийдвэрлэх явцдаа Үндсэн хуулийн доторх хоорондоо зөрчилдсөн болон нэгдмэл ойлголтод хүрэхгүй тодорхой бус байгаа хэм хэмжээнүүдийг тодотгон, ойлголтын зөрүүг арилгах шаардлагын үүднээс энэхүү санал гаргах эрхийг нээж өгсөн хэрэг юм.*”²⁰⁶ хэмээн тайлбарлажээ.

Түүнчлэн “*төрийн эрх мэдлийн гурван салаа мөчирт харьяалагдах Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Засгийн газар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, өөр өөрийн бүрэн эрхийг өргөтгөхөд чиглэсэн төсөл санаачилсан бол ҮХЦ-ийн саналыг тэргүүн ээлжинд авч үзэх нь илүү зөв*” хэмээн УБХ, УИХ-ын гишүүн асан Ц.Товуусүрэн²⁰⁷ бичсэн байна.

Үндсэн хуулийн шаардлагын дагуу УИХ-ын нийт гишүүдийн 3/4 буюу 76 гишүүний 57-ийн саналаар нэмэлт, өөрчлөлтийн төслийг батална. Хэрэв төслийг хэлэлцсэн ч баталж чадаагүй бол тухайн УИХ бүрэн эрхийнхээ хугацаанд дахин авч хэлэлцэхгүй байх, мөн УИХ-ын бүрэн эрхийнхээ сүүлийн зургаан сард Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй байхаар зохицуулсан. Энэ нь нэг талаар нэмэлт, өөрчлөлтийг дур зоргоор оруулахгүй байхыг, нөгөө талаар төрийн тогтвортой байдлыг эрх зүйн үүднээс баталгаажуулж байгаа хэрэг юм.²⁰⁸

Мөн уг асуудлаар УИХ-ын гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулгыг Үндсэн хуулийн 25.1.16 дахь хэсэгт заасан үндэслэл, журмаар явуулж болохыг Үндсэн хуулийн 68.2 дахь хэсэгт заасан байна.

Тодруулбал, Үндсэн хуулийн 25.1.16 дахь хэсэгт зааснаар ард нийтийн санал асуулгыг сонгуулийн эрх бүхий иргэдийн олонх нь оролцсон тохиолдолд хүчинтэй гэж тооцож, олонхын санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзэх юм. Ард нийтийн санал асуулга явуулах зарчим, журмыг тодорхойлж, санал асуулгыг бэлтгэн зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг Ард нийтийн санал асуулгын тухай хуулиар зохицуулна.²⁰⁹

Шигтгээ. Үндсэн хуулийн цэц (ҮХЦ) байгуулагдах нөхцөл бүрэлдсэн нь

Үндсэн хуулийн хяналтын төрөлжсөн институцын талаар БНМАУ-ын Үндсэн хуулиудаар зохицуулагдаагүй байсан. Харин 1992 онд шинэ Үндсэн хуулийн төсөлд Үндсэн хуулийн мэргэжлийн хяналтыг эрхэлдэг хараат бус, бие даасан институц зайлшгүй байхаар тогтсон.²¹⁰

Тухайн үед төсөл боловсруулагчид гадаад улсуудын Үндсэн хуулийн хяналтын загваруудыг судлахад үндсэн гурван загвар байжээ: Үндсэн хуулийн дээд хяналтыг Дээд шүүхэд харьяалдаг Америкийн загвар, Үндсэн хуулийн шүүх хэмээх төрөлжсөн шүүх хэрэгжүүлдэг Австрийн загвар, Үндсэн хуулийн

²⁰⁵ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²⁰⁶ Лүндээжанцан Д. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол арга зүйн харьцуулалт үндэслэл, Шинэ толь, №31, 2000 он.

²⁰⁷ Товуусүрэн Ц. Үндсэн хуулиа ойлгохуй: Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар. Хоёр дахь хэвлэл. УБ., 2020 он. 206 дахь тал.

²⁰⁸ Мөн тэнд. 207 дахь тал.

²⁰⁹ Ард нийтийн санал асуулгын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 9 дугаарт нийтлэгдсэн.

²¹⁰ Совд Г. 2019 он.

зөвлөлд харьяалдаг Францын загвар²¹¹ байв. Төсөл боловсруулагчид эдгээр загварыг судалсны эцэст өөрийн орны эрх зүйн уламжлалыг харгалзан үзэж, Австрийн загварыг үлгэр болгон Үндсэн хуулийн хяналтын Монголын хувилбарыг гаргаж иржээ.²¹²

Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх үед депутатууд нэлээдгүй маргаж, зарим үед шийдэж чадахгүй удааширдаг хүндрэлтэй асуудлуудын нэг нь ҮХЦ-ийн асуудал байв. Учир нь *нэгт*, Монгол Улсад урьд нь Үндсэн хуулийн хяналтын механизм байгаагүй учраас депутатууд ҮХЦ-ийн чиг үүрэг, ач холбогдлыг бүрэн ойлгоход хугацаа шаардлагатай байсан, *хоёрт*, ҮХЦ-ийг шүүх засаглалын дотор хуульчлахад хэлмэгдлийн үед ажиллаж байсан байгууллагууд шиг болох вий гэж болгоомжилж байсан, *гуравт*, ҮХЦ-ийн ач холбогдлыг тайлбарлах гэсэн зарим депутатууд, хуульчдыг өөрсдөдөө өндөр албан тушаал бэлдэх гэж байна хэмээн хардах үзэгдэл ч байсан.²¹³

1) Үндсэн хуулийн төслийн анхны хувилбарыг УБХ-аар хэлэлцэж дуусаад ард нийтээр хэлэлцүүлсэн төслийн 3 дугаар бүлгийн “Шүүх эрх мэдэл” гэсэн 4 дэх хэсгийн 52.1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх, Их цаазын цэц тус тус хэрэгжүүлнэ.” гэж шүүхийн тогтолцооны дотор оруулсан байв.²¹⁴ Төслийн 62 дугаар зүйлд “Монгол Улсын Их цаазын цэц бол Монгол Улсын Их цаазыг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж тодорхойлоод 63-65 дугаар зүйлд Их цаазын цэц (Цэц)-ийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, бүрэн эрхийг тусгажээ.

Уг төсөлд Цэц 9 жилийн хугацаатай ажиллах 6 гишүүнтэй байх, үндсэн асуудлаасаа гадна УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар хоорондын эрх хэмжээний талаар гарсан маргааныг хянан шийдвэрлэх, мөн төрийн дээд байгууллагууд, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг Ерөнхийлөгчийн хүсэлтээр хянан дүгнэлт гаргахаар тусгасан. Гэвч энэ тохиолдолд Цэцэд маргааныг чухам ямар үндэслэлээр үүсгэх тухай асуудлыг тодорхой заагаагүй, мөн Цэцийн шийдвэрийг УИХ хүлээн зөвшөөрөхгүй байхыг тусгаагүй. Харин ард нийтийн санал асуулгын дүнгээр Цэцийн шийдвэрийг УИХ хэрэгсэхгүй болгохоор тусгажээ.²¹⁵

2) Ард нийтээр хэлэлцэх үед гарсан саналуудыг судалж, нэгтгэн боловсруулсан төслийг УБХ-аас АИХ-д 1991 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн.²¹⁶ Уг төслийн 48 дугаар зүйлд “Шүүхийн үндсэн тогтолцоо Их цаазын цэц, Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, хошуу, хорооны шүүхээс бүрдэх...” гэж тусгасан байв. Цэцийн чиг үүрэг, бүрэн эрх, бүтэц зохион байгуулалтыг төслийн 50-53 дугаар зүйлд тусгажээ.

Энэхүү төсөлд Цэц бол Их цаазын биелэлтэд дээд хяналт тавих, Их цаазын заалтыг хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, Их цаазыг зөрчсөн тухай маргаан үүсгэх, УИХ-ын гишүүн Цэцэд маргаан үүсгэх хүсэлт гаргаж болох зэрэг зохицуулалтууд нэмэгдсэнээр харьяалах асуудал болон шийдвэрийн талаар илүү тодорхой болгож, харин бусад асуудлыг хянан үзэхийг хасжээ. Мөн Цэцийн шийдвэрийг ард нийтийн санал хураалтаар хүчингүй болгохыг хасаж, Цэцийн эхний шийдвэрийг УИХ авч хэлэлцэх зохицуулалтыг нэмж оруулжээ.

3) АИХ-ын чуулганаар төслийн анхны хэлэлцүүлгээр төсөлд хэд хэдэн засвар хийсний эцэст Цэцийг “Шүүх эрх мэдэл”-ээс салгаж, “БНМАУ-ын Их засаг хуулийг сахиулах баталгаа” гэсэн бие даасан 5 дугаар бүлэгт тусгаж, иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу Цэц өөрийн санаачилгаар Их цаазын маргааныг үүсгэж болохоор тусгасан байна.

4) 1992 оны 01 дүгээр сард болсон Үндсэн хуулийн хоёр дахь хэлэлцүүлгээр “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц” гэсэн 5 дугаар бүлгийг хэлэлцэн АИХ-ын депутатуудын 70 хувийн саналаар баталжээ.²¹⁷



²¹¹ Энэ загвар Франц Улсын 1958 оны Үндсэн хуульд батлагдсан боловч, 2008 оноос эхлэн Австри-Германы загварыг авч Зөвлөл хууль батлагдсаны дараа хэрэгжилтийн асуудлаарх маргааныг авч хэлэлцдэг болсон. Эх сурвалж: Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 175 дахь тал.

²¹² Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 175, 176 дахь тал.

²¹³ БНМАУ-ын АИХ-ын хоёрдугаар хуралдааны тэмдэглэл. 1991.12.16. УИХ-ын Тамгын газрын архив. 176, 179-182 дахь талууд.

²¹⁴ БНМАУ-ын УБХ-ын дөрөвдүгээр хуралдааны тэмдэглэл. 1991.10.10. УИХ-ын Тамгын газрын архив. 166 дахь тал.

²¹⁵ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 176 дахь тал.

²¹⁶ Мөн тэнд. 14 дэх тал.

²¹⁷ Мөн тэнд. 177 дахь тал.

1.3.1999, 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт

1999 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан үйл явц

Монгол Улсын Үндсэн хуулийг хэрэгжүүлэх явцад тулгарсан эхний бэрхшээл нь түүний зарим зүйл, заалтыг эргэн харахад хүргэсэн байна.²¹⁸ Үүнд:

- УИХ ээлжит сонгуулийн дараа Засгийн газрыг шинээр эмхлэн байгуулж чадахгүй хэт их хугацаа алдах болсон. Учир нь Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ-д оруулах, Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний талаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөхөд Ерөнхийлөгчид хэт давуу байдал бий болсон, цаашлаад ийнхүү хугацаа алдсан тохиолдолд хүлээх хариуцлагыг нь орхигдуулсны улмаас нэгэнт огцорсон Засгийн газар удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэн ажиллах нөхцөл бүрдэж байсан;
- УИХ-ын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах талаар нарийвчлан зохицуулаагүйгээс Үндсэн хуулийн маргаан гарах болсон;
- УИХ, түүний бүтцийн нэгжийн хуралдааны ирцийг гишүүдийн дийлэнх олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцохоор зааснаар чуулганы үйл ажиллагаа тасалдах явдал газар авах болсон.

1999 оны эцсээр УИХ-ын гишүүн Засгийн газарт орж ажиллахыг зөвшөөрсөн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулахаар УИХ-д суудалтай байсан гурван нам харилцан санал солилцож зөвшилцжээ.²¹⁹ Үүний дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 1999 оны 12 дугаар сарын 23-ны өдөр УИХ-ын 65 гишүүнээс УИХ-д өргөн мэдүүлснийг маргааш нь буюу 24-ний өдөр Төрийн байгуулалтын байнгын хороо (ТББХ)-ны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн Үндсэн хуулийн 2 заалтад нэмэлт (§22.2; 39.2), 5 заалтад өөрчлөлт (§24.1; 27.2; 27.6; 29.1; 33.1.2) оруулжээ.²²⁰ (Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг *Хавсралт 1-ээс дэлгэрүүлж үзнэ үү.*)

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг УИХ хэлэлцэн батлахдаа Үндсэн хуулийн холбогдох заалтаас гадна Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль (1997 он), Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хууль (1997 он)-д заасан журмыг баримталсан.

Гэвч Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн²²¹ 40.3 дахь хэсэгт заасан “Чуулганаар хэлэлцэхээр тогтсон төслийн дүгнэлт, холбогдох бусад баримт бичгийн хамт УИХ-ын гишүүдэд уг төсөл хэлэлцэж эхлэхээс 7 хоногийн өмнө зохих Байнгын хороо эрхлэн тараана...” гэснийг мөрдөөгүй байна.

Мөн УИХ-ын 65 гишүүн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхдээ Үндсэн хуулийн 69.1 дэх хэсгээс гадна Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн²²² 3.1.4 дэх хэсэгт заасныг мөрдөөгүй. Энэ хуулийн 3.1.4 дэх хэсэгт “Хууль санаачлагч хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэхдээ дараах асуудлыг шийдвэрлэсэн байна: 4/ ...УИХ-ын гишүүн нь санаачилж буй хуулийн төслийнхөө талаар Засгийн газрын,

²¹⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал (Хураангуй танилцуулга). Редактор: Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. УИХ-ын Тамгын газрын ПССХ. 2022 он.

²¹⁹ УИХ-ын 1999 оны намрын ээлжит чуулганыг хааж УИХ-ын дарга Р.Гончигдоржийн хэлсэн үг. *Эх сурвалж: Монгол Улсын Парламент (УИХ-ын чуулганы хуралдаанд хэлсэн үгийн эмхэтгэл, 1990-2000 он). УИХ, УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв, НҮБХХ. УБ., 2005 он. 494 дэх тал.*

²²⁰ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 59 дугаарт нийтлэгдсэн.

²²¹ Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1997 оны 4 дугаарт нийтлэгдсэн.

²²² Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль 1997 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан.

түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагын санал, дүгнэлтийг авсан байх.” гэж заасан байв.

Өөрөөр хэлбэл, төслийн талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас санал авах нь битгий хэл тэдэнд танилцуулаагүй, олон нийт (улс төрийн нам, эрдэмтэн судлаачид, иргэд гэх мэт)-д мэдээлээгүй зэрэг нь хуулийн төсөл боловсруулж, хэлэлцэн батлах журам, шаардлагуудыг мөрдөөгүй байна. Үүнийг зарим судлаачид төсөлд гарын үсгээ зурж, өргөн мэдүүлсэн нь дээрх гишүүд уг нэмэлт, өөрчлөлтийг “урьдчилан баталсан” хэмээн хатуухан дүгнэжээ.²²³


Гэтэл 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс үзэхэд, УИХ-ын гишүүн Ж.Гомбожав “Ерөнхийлөгчийн болон ҮХЦ-ийн саналыг сонсох нь зүйтэй” гэсэн горимын санал гаргасан боловч бусад гишүүд дэмжээгүй ажээ. Иймд нэгдсэн хуралдаанаар ТББХ-ны оруулж ирсэн саналаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь ийнхүү баталжээ.²²⁴

Ерөнхийлөгчийн хориг: 1999 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Ерөнхийлөгч дараах үндэслэлээр Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд бүхэлд нь хориг тавьжээ:²²⁵

- Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ҮХЦ-д саналаа өгөх боломжийг олгоогүй нь Үндсэн хуулийн 68.1 дэх хэсгийг зөрчсөн;
- УИХ хагас жил тутам нэг удаа 75-аас доошгүй өдөр чуулдаг байсныг 50 болгон багасгаж, УИХ-ын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны ирцийг бууруулсан нь 20-хон гишүүний саналаар хууль баталж болохоор хэт хялбарчилсан;
- УИХ-ын гишүүдийн заримынх нь УИХ-ын дэд даргаар сонгогдох эрхийг хязгаарласан нь хүнийг аль нэг нам, олон нийтийн бусад байгууллагын гишүүний хувьд ялгаварлан гадуурхахыг хориглоно гэсэн Үндсэн хуулийн 16.10 дахь хэсэгт харшилсан;
- УИХ-аар хэлэлцэн шийдвэрлэхдээ Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40.3, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 3.1.4, 18.5 дахь хэсгийг зөрчсөн гэсэн байна.

Ерөнхийлөгчийн хоригийг 2000 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр ТББХ хэлэлцээд “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн авах боломжгүй” гэж, 01 дүгээр сарын 05-ны өдөр ХЗБХ хэлэлцээд “хоригийг хүлээн авах хууль зүйн үндэслэлгүй” бөгөөд “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн тулгуур зарчмууд болон бусад хуультай зөрчилдөөгүй” гэж тус тус үзжээ.²²⁶

2000 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр нэгдсэн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцээд “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд Ерөнхийлөгчөөс бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авах боломжгүй” гэж шийдвэрлэн УИХ-ын тогтоолыг²²⁷ баталжээ.



²²³ Батбаяр Б. “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба Үндсэн хуулийн зөрчил” өгүүлэл. Эрх зүй, цуврал 45. 2019 он. №1. 51-52 дахь талууд.

²²⁴ Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль; Ерөнхийлөгчийн хоригийн тухай тогтоол; Үндсэн хуулийн цэцийн 03 тоот дүгнэлт. 1999-2000 он. Д-5, ХН-28.

²²⁵ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориг. 1999.12.31. Дугаар Е/67. Эх сурвалж: Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль; Ерөнхийлөгчийн хоригийн тухай тогтоол; Үндсэн хуулийн цэцийн 03 тоот дүгнэлт. 1999-2000 он. УИХ-ын Тамгын газрын архив. Д-5, ХН-28.

²²⁶ Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль; Ерөнхийлөгчийн хоригийн тухай тогтоол; Үндсэн хуулийн цэцийн 03 тоот дүгнэлт. 1999-2000 он. Д-5, ХН-28.

²²⁷ “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” УИХ-ын 2000 оны 01 дүгээр тогтоол “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2000 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

ҮХЦ-ийн дүгнэлт: ҮХЦ-ийн 2000 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар уг асуудлыг хянан үзээд 1999 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж дүгнэжээ.²²⁸

ҮХЦ-ийн 2000 оны 03 дугаар дүгнэлтэд:

- УИХ 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулиудын холбогдох заалтуудыг зөрчсөн нь Үндсэн хуулийн 1.2, 70.1 дэх хэсэгт нийцээгүй;
- УИХ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн 68.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх боломжийг ҮХЦ-д олгоогүй;
- Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн 1.2, 68.1, 70.1 дэх хэсгийг зөрчиж байна гэсэн иргэн С.Нарангэрэл, Н.Хайдав, Н.Баасанжав, Д.Чулуунжав, Н.Отгон, О.Жамбалдорж нарын гомдлыг хангах үндэслэлтэй гэсэн байна.

Нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн дараах заалтуудыг зөрчсөн хэмээн ҮХЦ дүгнэсэн:

- Үндсэн хуулийн 1.2 дахь хэсэгт заасан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг;
- Үндсэн хуулийн 68.1 дэх хэсэгт заасан “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.” гэснийг;
- Үндсэн хуулийн 70.1 дэх хэсэгт заасан “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн²²⁹ дагуу ҮХЦ-ийн дээрх дүгнэлтийг хүргүүлснээс хойш 15 хоногийн дотор хүлээн авах эсэх нь УИХ-ын бүрэн эрхийн асуудал байдаг. УИХ энэ бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй тул ҮХЦ маргааныг дахин авч үзэж, Үндсэн хуулийн 66.4 дэх хэсэгт заасан эцсийн шийдвэр гаргах боломжгүй болсон.²³⁰

УИХ-ын 2000 оны ээлжит сонгуулийн дараа буюу 2000 оны 07 дугаар сарын 28-ны өдөр УИХ-аас ҮХЦ-ийн 03 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу авч хэлэлцсэн боловч ямар нэгэн шийдвэр гаргаагүй.²³¹ Тодруулбал, 07 дугаар сарын 27-ны өдөр ТББХ, ХЗБХ-ны хуралдаанаар, 07 дугаар сарын 28-ны өдөр нэгдсэн хуралдаанаар уг асуудлыг тус тус хэлэлцээд “ҮХЦ нь Үндсэн хууль, Цэцийн тухай болон бусад хуульд заасан өөрийн бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар дүгнэлт гаргасан тул ҮХЦ-ийн 2000 оны 03 дугаар дүгнэлтийн талаар хүлээн зөвшөөрөх, зөвшөөрөхгүй байх тухай УИХ-ын ямар нэгэн шийдвэр гаргах боломжгүй” гэжээ.

ҮХЦ-ийн тогтоол: Дээрх үйл явдлын дараа ҮХЦ-ийн 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн их суудлын хуралдаанаар 1999 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн

²²⁸ “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай” ҮХЦ-ийн 2000 оны 03 дугаар дүгнэлт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2000 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

²²⁹ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1997 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

²³⁰ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 194-195 дахь талууд.

²³¹ Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль; Ерөнхийлөгчийн хориогийн тухай тогтоол; Үндсэн хуулийн цэцийн 03 тоот дүгнэлт. 1999-2000 он. УИХ-ын Тамгын газрын архив. Д-5, ХН-28.

талаар дахин авч хэлэлцээд Үндсэн хууль зөрчсөн тул уг нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгож, 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Үндсэн хуулийн бүх заалт хүчинтэй хэмээн эцэслэн шийдвэрлэсэн.²³²

Ингэхдээ ҮХЦ процессын хэм хэмжээнд тулгуурлан Үндсэн хуулийн 68.1 дэх хэсэгт үндэслэжээ. ҮХЦ үүнийг онцгой тохиолдол гэж үзсэн бөгөөд УИХ Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг санаачлахдаа Ерөнхийлөгч болон ҮХЦ-тэй зөвшилцөх байсныг хэрэгжүүлээгүй нь Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн.²³³

2000 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан үйл явц²³⁴

ҮХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоол гарснаар тухайн үеийн Засгийн газар мухардмал байдалд оржээ. Тодруулбал, Ерөнхий сайд, Засгийн газрын 4 гишүүн нь УИХ-ын гишүүн байсан бөгөөд дээрх шийдвэрийн дагуу тэд суудлаасаа чөлөөлөгдөх нөхцөл үүссэн байв.

Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд 2000 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-ын 65 гишүүнээс Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 1999 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт (ҮХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон)-тэй яг ижил томъёоллоор УИХ-д өргөн мэдүүлжээ.

Мөн уг төслийг Ерөнхийлөгч, Засгийн газар, ҮХЦ-д хүргүүлжээ. Уг төслийн талаар Засгийн газар дэмжсэн бол Ерөнхийлөгч, ҮХЦ-ээс (мөн улс төрийн зарим намаас) саналуудаа ирүүлсэн боловч УИХ төсөлд тусгаагүйгээр баталсныг дараах үйл явцаас харж болно.

ТББХ 2000 оны 12 дугаар сарын 04-ний өдөр уг төслийн хэлэлцэх эсэх асуудлыг, 12 дугаар сарын 13-ны өдөр уг төслийн анхны хэлэлцүүлэг (энэ үеэр Ерөнхийлөгч, ҮХЦ-ээс ирүүлсэн саналтай танилцсан)-ийг хийсэн бөгөөд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг дэмжжээ. Харин дээрх хэлэлцүүлгүүдэд УИХ-ын гишүүн Л.Гүндалай, Ж.Наранцацралт, С.Оюун, Б.Эрдэнэбат нар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ажлын хэсэг байгуулах, төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, ард нийтийн санал асуулга явуулах тухай саналаа илэрхийлэн цөөнх болжээ.

Мөн 12 дугаар сарын 14-ний өдөр ХЗБХ уг төслийн анхны хэлэлцүүлгээр Ерөнхийлөгч, ҮХЦ-ээс ирүүлсэн саналтай танилцаж, өөрсдийн байр суурийг илэрхийлсний эцэст “...төсөл нь Үндсэн хуулийн агуулга, зарчимтай зөрчилдөхгүй байна” гэж үзжээ.

Ийнхүү “ТББХ, ХЗБХ-оос уг асуудлаар анхны хэлэлцүүлэг хийх явцад зарчмын зөрүүтэй санал гараагүй тул” УИХ 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг хийж, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40.11 дэх хэсэгт заасны дагуу УИХ төслийг бүхэлд нь баталжээ.

Ерөнхийлөгчийн хориг: 2000 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Ерөнхийлөгч Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хориг тавьжээ. Ерөнхийлөгч уг нэмэлт, өөрчлөлтийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хүчингүй болгох, мөн 2 дугаар зүйлийн 1, 3, 4 дэх хэсгийг өөрчлөх нь зүйтэй гэж үзсэн байв.²³⁵

²³² “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн хэлэлцсэн тухай” ҮХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоол “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2000 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

²³³ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 195 дахь тал.

²³⁴ Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт; “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” УИХ-ын 54 дүгээр тогтоол. 2000 он. УИХ-ын Тамгын газрын архив. Д-5, ХН-47.

²³⁵ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориг. 2000.12.20. Дугаар Е/51. Эх сурвалж: Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт; “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” УИХ-ын 54 дүгээр тогтоол. 2000 он. УИХ-ын Тамгын газрын архив. Д-5, ХН-47.

2000 оны 12 дугаар сарын 21-ний өдөр ТББХ уг хоригийг хэлэлцээд хүлээн авах боломжгүй гэж үзжээ. Харин уг асуудлаар УИХ-ын гишүүн Л.Гүндалай, Ж.Наранцацралт нар цөөнх болжээ. 2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр нэгдсэн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцээд хүлээн авах боломжгүй гэж үзэн УИХ-ын тогтоолыг²³⁶ баталжээ.

Эцсийн дүнд улс төрийн идэвхтэй зөвшилцөл явагдсаны дүнд 2001 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Ерөнхийлөгч хүлээн авч, ҮХЦ эсэргүүцээгүй байна.²³⁷

1999, 2000 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан туршлага, сургамж

Үндсэн хуулийн хэрэгжилтэд тулгарсан дээрх бэрхшээлийг даван туулах зорилгоор ийнхүү хоёр удаагийн оролдлогоор 1999, 2000 онд Үндсэн хуулийн 6 зүйлийн 7 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь тулгарсан зарим бэрхшээлийг шийдвэрлэж, парламентат ёсны төлөвшилд тодорхой ахиц гаргасан ч “дордуулсан 7 өөрчлөлт” гэж олон түмний дунд шүүмжлэгдэх болсон нь дор дурдсан заалтуудтай холбоотой байсан.²³⁸ Үүнд:

- УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болох хязгаар тогтоогоогүйгээс Засгийн газрын гишүүд бүгдээрээ парламентын гишүүн болж, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хяналт, тэнцлийг алдагдуулсан;
- УИХ-ын ээлжит чуулганы үргэлжлэх хугацаа 75 хоног байсныг 50 хоног болгон өөрчилснөөр УИХ байнгын ажиллагаатай парламент байх шинжээ зарим талаар алдсан;
- УИХ-ын хуралдааны хүчинтэй байх ирцийг 50 хувь+1 гэж тогтоож, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэхээр тогтоосон нь УИХ хэт цөөн гишүүний саналаар хууль баталдаг болсон.

Тухайн үед тулгарсан бэрхшээлийг зөвшилцөл, шийдлээр давж туулахын оронд Үндсэн хуульдаа дур зоргоор халдаж нэмэлт, өөрчлөлт хийх замыг сонгосноор хориод жилийн турш шүүмжлэл дагуулсан, ард түмнээр хүлээн зөвшөөрөгдөөгүй нэмэлт, өөрчлөлт болсон.²³⁹ Зарим судлаачид энэхүү үйл явдлыг эрх зүйт төрд байх ёсгүй буруу жишиг, томоохон гажуудал үүсгэсэн гэж үзжээ.²⁴⁰

Гэвч 2000 онд Үндсэн хуульд оруулсан 7 нэмэлт, өөрчлөлтийн 6-г нь 2019 онд дахин өөрчилсөн юм.

Хоёр. 2010 ОНД БАТЛАГДСАН МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ БА ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

2.1. Журмын тухай хууль батлах хэрэгцээ, шаардлага

2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дараах жилүүдэд хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын зааг ялгаа бүдгэрч, төрийн эрх мэдлийн нөлөө, Үндсэн хуулиар тунхагласан хариуцлагын тогтолцоо алдагдаж байгаа талаар эрдэмтэн судлаачид, ард иргэд, улс төрчдийн зүгээс байнга шүүмжилж байв. УИХ Засгийн газрын гишүүнийг хүн нэг бүрээр хэлэлцэн томилдог, Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийг өөрийн

²³⁶ “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” УИХ-ын 2000 оны 54 дүгээр тогтоол “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2000 оны 50 дугаарт нийтлэгдсэн.

²³⁷ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. 195-196 дахь талууд.

²³⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал (Хураангуй танилцуулга). Редактор: Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. УИХ-ын Тамгын газрын ПССХ. 2022 он.

²³⁹ Мөн тэнд.

²⁴⁰ Батбаяр Б. “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба Үндсэн хуулийн зөрчил” өгүүлэл. Эрх зүй, цуврал 45. 2019 он. №1. 52 дахь тал.

үзэмжээр өөрчилдөг явдал нь Засгийн газрын төсөв, мөнгөний эрх мэдэл, Ерөнхий сайд танхимаа өөрөө бүрдүүлж, Засгийн газрын гишүүнийг томилох эрх эдэлдэггүй нь танхимын зарчмаар ажиллахад саад учруулж байв.²⁴¹

Мөн асуудал дагуулсан нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн баталсан процесс, түүнийг тойрсон улс төрийн зөрчилдөөн нь Үндсэн хуульд дархлаа бүрэн тогтоогүйг харуулсан тул Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг нарийвчилсан журмаар зохицуулахад УИХ анхаарал хандуулах болсон.

УИХ-ын даргын 2009 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн захирамжаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль (цаашид “Журмын тухай хууль” гэнэ)-ийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ТББХ-ны даргаар ахлуулан байгуулжээ. Мөн уг ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийг ч байгуулж, Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимидээр ахлуулжээ.

Жил гаруй хугацаанд дээрх ажлын хэсгүүд гадаадын 120 улсын туршлагыг судалж, өөрийн орны сургамжид тулгуурлан хуулийн төслийг боловсруулжээ. Ийнхүү 2010 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг Журмын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэв. Уг төслийн үзэл баримтлалд: *“Үндсэн хууль батлагдсанаас хойш 18 жилийн хугацаа өнгөрч, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёл оюун, улс төрийн харилцаа энэ үндсэн дээр боловсронгуй болон төлөвшиж байна. Мөн Үндсэн хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага ч гарч байна гэж олон нийт үзэж байгаа учраас ямар журмаар нэмэлт, өөрчлөлтийг хийх асуудлыг хуульчлан өгөх зайлшгүй шаардлага байна.*

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын тусгаар тогтносон, бүрэн эрхт байдлын үндэс тулгуур, ардчилал, хүний эрх, эрх чөлөө, нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлсэн Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн зайлшгүй тулгамдсан асуудлаар уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд Үндсэн хуулиа дээдлэх журмыг тогтооход чиглэгдсэн болно.

Үндсэн хуулийн үзэл баримтлал, ялангуяа Зургадугаар бүлгийн “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” тухай 68, 69 дүгээр зүйлийг хууль тогтоох үйл ажиллагаанд зөв хэрэглэх, сахин биелүүлэх зарчмыг баримталлаа.” гэсэн байна.²⁴²

Эндээс үзэхэд, *Нэгт*, Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангах үүднээс түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээ, хязгаарыг тогтоох, ингэхдээ түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг хаахгүй байх шаардлагатай байсан. *Хоёрт*, нэмэлт, өөрчлөлт оруулахад Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйлийн болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай²⁴³ (цаашид “Дэгийн тухай” гэнэ) хуулийн зохицуулалтууд хангалтгүй байсан тул процессын асуудлыг нарийн журамлах шаардлагатай байсан. Өөрөөр хэлбэл, бусад хууль тогтоомжийн хувьд хууль санаачлагч нь Засгийн газраас санал авах ба хэрэв 30 хоногийн дотор санал ирүүлээгүй бол төслөө УИХ-д шууд өргөн мэдүүлэх процессоор явагдаж байсан. Харин Үндсэн хуулийн хувьд бусад ердийн хуультай адил процессоор явж болохгүй, илүү тодорхой зохицуулах шаардлагатай байсан. Тухайлбал, үндэсний аюулгүй байдалтай

²⁴¹ Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал (Хураангуй танилцуулга). Редактор: Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. УИХ-ын Тамгын газрын ПССХ. 2022 он.

²⁴² Хуулийн хувийн хэрэг – Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль. Боть-1.

²⁴³ Энэ үед 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 39 дугаарт нийтлэгдсэн.

холбогдсон асуудлаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн, хүний эрхийн асуудлаар Хүний эрхийн Үндэсний Комиссын санал авах зэрэг нарийвчилсан зохицуулалт хэрэгтэй байсан.

Өмнө нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан сургамждаа суурилан²⁴⁴ Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангах, дур зоргоороо өөрчлөхөөс урьдчилан сэргийлэх, Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйлд заасан журмыг тодорхой болгох зорилготойгоор бие даасан Журмын тухай хуулийг 2010 онд баталсан.

Энэ хуульд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндсэн зарчим болох Үндсэн хуулийг дээдлэн сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах, ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах, бодитой ил тод байх зэрэг зарчим, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нарийвчилсан журам, мөн өөрчлөхийг хориглосон заалтуудыг тодорхой болгож өгсөн. Тоймловол, энэ хуулиар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зарчмын үндсийг тогтоож, мөн Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйлийг хэрэглэх журмыг тодорхойлсон юм. Тэр нь Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангах, дээрх 2 зүйлийг зөв хэрэглэхэд чиглэсэнээрээ үндсэн хуульчилсан маш чухал хууль юм.²⁴⁵

2.2. Журмын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тойм

Журмын тухай хууль 2010 онд батлагдсанаас хойш 6 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь дараах шалтгаанаар хийгдэж байжээ. (*Журмын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн лавлагааг Хавсралт 2-оос дэлгэрүүлж үзнэ үү.*) Үүнд:

- 1) 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Хууль тогтоомжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж өөрчлөлт орсон;
- 2) 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Ард нийтийн санал асуулгын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж өөрчлөлт орсон;
- 3) 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Зөвлөлдөх санал асуулгын тухай (анхдагч) хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон;
- 4) 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон;
- 5) 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр УИХ-ын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг УИХ хүлээн авсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орсон;
- 6) 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр ҮХЦ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн 39.1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэсэн хэсгийг хүчингүй болгосонтой холбогдуулан өөрчлөлт орсон.

Дээрх нэмэлт, өөрчлөлтүүдээс Журмын тухай хуульд орсон зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлтүүдийг авч үзвэл:

2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Зөвлөлдөх санал асуулгын тухай (анхдагч) хуулийн хүрээнд орсон нэмэлт, өөрчлөлт: 2017 онд батлагдсан Зөвлөлдөх санал асуулгын тухай (анхдагч) хуулийг дагаж Журмын тухай хуулийн 5.3.3-т зөвлөлдөх санал

²⁴⁴ Товуусүрэн Ц. Үндсэн хуулиа ойлгохуй: Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар. Хоёр дахь хэвлэл. УБ., 2020 он. 206 дахь тал.

²⁴⁵ Чимид Б. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан зарим асуудал. Хууль дээдлэх ёс. Цуврал 35. 2011 он. 22 дахь тал.

асуулга явуулах асуудлыг тодорхой болгож нэмсэн байна. Тодруулбал, Үндсэн хуулийн дараах зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвлөлдөх санал асуулгыг явуулна:

- 5.4 дэх хэсэгт заасан “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэсэн асуудлаар;
- 20 дугаар зүйлд заасан “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэсэн асуудлаар;
- 30.1 дэх хэсэгт заасан “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэсэн асуудлаар;
- 41.1 дэх хэсэгт заасан “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэсэн асуудлаар.

Мөн Журмын тухай хуулийн 5.3.4 дэх хэсэгт санал асуулгын дүнгээр дээрх асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжсэн бол УИХ заавал авч хэлэлцэхээр тусгажээ.

2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр УИХ-ын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг УИХ хүлээн авсантай холбогдуулан орсон нэмэлт, өөрчлөлт²⁴⁶: Ерөнхийлөгчийн хоригийг УИХ 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авсантай холбогдуулан Дэгийн тухай хуулийн 31.8, 31.9 дэх хэсэгт заасныг үндэслэн ТББХ-оос боловсруулсан Журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталжээ.

Энэ хуулиар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлүүлэхтэй холбоотой асуудлыг тодруулж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг баталгаажуулахтай холбоотойгоор хугацаа зааж, түүнчлэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийн санал, хураалт явуулах үндэслэлийг тодорхой болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэхтэй холбоотойгоор УИХ-аас батлах хугацааг нь тусгайлан заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх боломжийг Журмын тухай хуульд нэмж, хууль хоорондын зөрчлийг арилгасан байна. Мөн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх шатанд Байнгын хороо болон нам, эвслийн бүлэг саналын түвшинд харгалзан үзсэнээс бусад төсөлд тусгагдаагүй шинэ хэсэг, заалтын саналын томъёолол санал, дүгнэлтдээ оруулахгүй байхаар тусгасан.

2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр ҮХЦ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн 39.1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн хэсгийг хүчингүй болгосонтой холбогдуулан орсон өөрчлөлт²⁴⁷: Энэ нь Дэгийн тухай, Журмын тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулж, ҮХЦ-ийн эцсийн шийдвэр (тогтоол)-ээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хуулийн хүрээнд хэлэлцэх боломжийг бүрдүүлж өгчээ. Үүний дагуу УИХ-ын 62 гишүүнээс Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулан УИХ-д 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлжээ.

²⁴⁶ УИХ-ын 2019 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга (Албан хэрэгцээнд). УИХ-ын Тамгын газар. УБ., 2020 он. 88 дахь тал.

²⁴⁷ УИХ-ын 2022 оны ээлжит бус чуулганы үйл ажиллагааны танилцуулга (Албан хэрэгцээнд). УИХ-ын Тамгын газар. УБ., 2022 он. 21 дэх тал.

2.3.2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан үйл явц²⁴⁸

Эрдэм шинжилгээний олон хурал, зөвлөгөөний үеэр УИХ-ын гишүүд, эрдэмтэн судлаачид, улс төрчдийн зүгээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал санаачилга удаа дараа гарч байв. УИХ-ын гишүүдээс түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэд хэдэн удаа өргөн мэдүүлж байсан.

2012-2016 оны УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нэлээд өргөн хүрээнд яригдаж эхэлсэн юм. Тухайн үед УИХ-ын 48 гишүүнээс нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн боловч УИХ-ын тухайн бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж амжаагүй.

2016 оноос Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар судалгаа шинжилгээ хийх, иргэд, олон нийтийн санаа бодлыг тандан судлах, үндэслэл, шаардлагыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгүүд байгуулагдан ажилласан. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг судлах зорилгоор эрдэмтэн судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг байгуулсан бөгөөд уг ажлын хэсгээс төв, орон нутагт явуулсан судалгааны үр дүнд Үндсэн хуулийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргаж, 46 заалттай төсөл, судалгааны ажлын тайлан, дүгнэлтийг УИХ-д танилцуулсан юм.

УИХ уг төсөл, тайлан, дүгнэлттэй танилцаад 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 24 дүгээр тогтоолоороо²⁴⁹ Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн дагуу Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Анхдугаар Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулж, Зөвлөлдөх зөвлөлийг байгуулан ажиллуулж, дараах 6 багц асуудлаар 2 шат бүхий зөвлөлдөх санал асуулгыг зохион явуулсан билээ. Үүнд:

1. УИХ, Засгийн газрын эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангах;
2. Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, энэ чиглэлд ажил, үүргийн давхардлыг арилгах үүднээс Ерөнхийлөгчийн эрх, үүргийг тодорхой болгох;
3. Улс төрөөс хараат бус, мэргэшсэн, чадварлаг, нэр хүндтэй төрийн албыг бэхжүүлэх;
4. Засаг захиргаа, нутгийн удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлэх;
5. Төрийн хариуцлага, сахилга, шударга ёсыг бэхжүүлэх, хууль хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах;
6. Төрийн эрх барих дээд байгууллага нь АИХ, хууль тогтоох байгууллага УБХ гэсэн хоёр танхимтай байх асуудлаар нээлттэй хэлэлцэх нөхцөлийг хангах зэрэг байв.

УИХ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 78 дугаар захирамжаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан байна. Уг ажлын хэсгээс Зөвлөлдөх санал асуулгаар дэмжигдэж, Зөвлөлдөх зөвлөлөөс санал болгосон 5 багц асуудлаар 22 заалт бүхий төсөл боловсруулжээ.

УИХ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд ард иргэдийн саналыг харгалзах шаардлагатай гэж үзсэний үндсэн дээр УИХ-ын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор²⁵⁰ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард түмний бүрэн

²⁴⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал (Хураангуй танилцуулга). Редактор: Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. УИХ-ын Тамгын газрын ПССХ. 2022 он.

²⁴⁹ “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар Зөвлөлдөх санал асуулга явуулах, Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай” УИХ-ын 2017 оны 24 дүгээр тогтоол “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 15 дугаарт нийтлэгдсэн.

²⁵⁰ “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах тухай” УИХ-ын 2017 оны 39 дүгээр тогтоол “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2000 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

эрхт байдал, оролцоог хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, улмаар УИХ-ын даргын 107 дугаар захирамжаар олон нийтийн хэлэлцүүлгийг улсын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулав. Үүний дагуу УИХ-ын Тамгын газар 2017 оны 07 дугаар сараас 09 дүгээр сар хүртэл 21 аймаг, нийслэлийн дүүргүүдэд 68 удаагийн бүсчилсэн хэлэлцүүлэг зохион байгуулсан юм.

Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгээс “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол практикийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, мөн зарим эрдэм шинжилгээний байгууллагаас 10 орчим эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр УИХ-ын 62 гишүүнээс Үндсэн хуулийн 20 зүйл, 44 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлсэн юм.

Төслийн анхны хэлэлцүүлгийн дараа Монгол Улсын Ерөнхийлөгч 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдөр Үндсэн хуулийн 20 зүйл, 49 заалтад оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, саналыг УИХ-д өргөн мэдүүлсэн. Уг төслийг УИХ-ын гишүүдээс өргөн мэдүүлсэн төслийн хамт хамтатган хэлэлцсэн байдаг.

Төслийн хэлэлцүүлгийн хооронд улс төрийн намуудын хэлэлцүүлгийг зохион байгуулж, мөн гишүүд тойрогтоо ажиллахдаа төслийн зохицуулалтын учир холбогдлыг сонгогчдодоо тайлбарлан таниулж, саналыг нь авч, хэлэлцүүлгийг олон түмэнд нээлттэй ил тод явуулж, иргэд байгууллага саналаа илэрхийлэх боломжтойгоор зохион байгуулжээ.

Өөрөөр хэлбэл, УИХ нь Журмын тухай хуулийн 5.1.2, 5.3 дахь хэсэгт заасны дагуу иргэд, улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллагын оролцоог хангах, тэдэнд саналаа чөлөөтэй илэрхийлэх бололцоог олгох үндсэн зарчмыг баримталж ажиллажээ.

Ийнхүү уг төслийг 2019 оны 06 дугаар сараас 11 дүгээр сарын 14-ний өдрийн хооронд хэлэлцэн баталсан юм.

Үндсэн хуульд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа шаардлагатай эсэхийг судалж, тандахаас эхлээд зөвлөлдөх санал асуулга, ард нийтийн хэлэлцүүлэг явуулж, тэдний санал бодлыг тусгаж, улс төрийн намуудын болон эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулж, бүх талын зөвшилцлийг хангаснаар уг нэмэлт, өөрчлөлт бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдөж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах сайн жишиг, дэг жаягийг тогтоосон билээ.

Ерөнхийлөгчийн хориг^{251, 252}: “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” УИХ-ын 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолд Ерөнхийлөгч 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан байна.

2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр УИХ уг хоригийг хэлэлцэж, хүлээн авсан. (2019.10.04, Дугаар 77) Үүнтэй холбогдуулан Дэгийн тухай хуулийн 31.8, 31.9 дэх хэсэгт заасныг үндэслэн ТББХ-оос боловсруулсан Дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталжээ.

²⁵¹ УИХ-ын 2019 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга (Албан хэрэгцээнд). УИХ-ын Тамгын газар. УБ., 2020 он. 88 дахь тал.

²⁵² УИХ-ын 2019 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл. 2019.10.11.

<https://www.parliament.mn/nn/9553/>

2.3.2022 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан үйл явц

ҮХЦ 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн их суудлын хуралдаанаараа Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцээд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан Үндсэн хуулийн 39.1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн заалт нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд харшилж, Монгол Улсын Үндсэн хуулийн зохих зүйл, хэсэгт нийцээгүй гэж үзэн хүчингүй болгож эцэслэн шийдвэрлэсэн байна.

Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд УИХ-д суудал бүхий нам, эвслийн төлөөлөл болон УИХ-ын нэр бүхий хуульч гишүүдийг оролцуулсан ажлын хэсгийг УИХ-ын даргын 2022 оны 123 дугаар захирамжаар байгуулсан.

Уг ажлын хэсэг 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр хуралдаж, дээрх асуудлыг хэлэлцэх журам, дэгтэй холбоотой хуулийн зарим зохицуулалт хийхээр болжээ. Ажлын хэсэг Дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (§54¹) болон Журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай (§1.4; 18), Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (§8.2.1), Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай (§13.1.1) хуулийн төслүүдийг боловсруулан УИХ-д 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлжээ. ТББХ-ны болон нэгдсэн хуралдаанаар мөн өдрөө хуулийн төслүүдийг хэлэлцэн баталсан:

- Дэгийн тухай хууль – ҮХЦ-ийн эцсийн шийдвэр (тогтоол)-ээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг Журмын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан журмын дагуу, харин Журмын тухай хуулиар зохицуулаагүй асуудлыг Дэгийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан хууль хэлэлцэх ерөнхий журмыг баримтлан хэлэлцэнэ (§54¹);
- Журмын тухай хууль – ҮХЦ-ийн эцсийн шийдвэр (тогтоол) гарсантай холбоотойгоор Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, батлахтай холбогдсон харилцааг УИХ тусгайлсан дэгээр хэлэлцэж болно (§1.4); ҮХЦ-ийн эцсийн шийдвэр (тогтоол)-ээр Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхэд энэ хуулийн 3.3 дахь хэсэг, 10 дугаар зүйл, 11.4 дэх хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 40.1 дэх хэсэгт заасныг баримтлахгүй байж болно (§18.2); ТББХ-ны (тус Байнгын хороонд харьяалагддаг нийт гишүүний 2/3-оос доошгүйн ирцтэй бол) болон нэгдсэн (нийт гишүүний 3/4 доошгүйн ирцтэй буюу 57 нь хүрэлцэн ирсэн бол) хуралдааны хүчин төгөлдөр гэж үзэх квотыг тогтоосон (§18.3); Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр хэлэлцүүлгээр шийдвэрлэнэ (§18.4);

Ийнхүү ҮХЦ-ийн эцсийн шийдвэр (тогтоол)-ээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хуулийн хүрээнд хэлэлцэх боломжийг бүрдүүлжээ. Бүрэн эрхийнхээ дагуу УИХ-ын 62 гишүүнээс Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж, УИХ-д 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Журмын тухай хуулийн дагуу УИХ Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр удаа хэлэлцүүлэг явуулсан юм.

УИХ Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Журмын тухай хуулийн 18.3, 18.4 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцсэн байдлыг үзүүлбэл:

2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Журмын тухай хуулийн 18.5, 18.6 дахь хэсэгт заасны дагуу, ТББХ-ны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн байна.

Төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Дэгийн хуулийн 54^{1.3}, Журмын тухай хуулийн 18.9 дэх хэсэгт заасны дагуу ТББХ нэгдсэн хуралдаанд дэмжигдсэн саналыг нэгтгэн Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болгон эцсийн хувилбарыг бэлтгэсэн санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулсан. Журмын тухай хуулийн 18.10 дахь хэсэгт заасны дагуу нэгдсэн хуралдаанд нийт гишүүдийн 98.4 хувийн саналаар Үндсэн хуулийн 39.1 дэх хэсгийн “... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн 2 дахь өгүүлбэрийг хүчингүй болгосон.

Гурав. ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ ЖИШИГ

3.1. Үндсэн хуулийн хэв шинж ба Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаар

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам хүнд процедуртай, өндөр босготой байх тусам түүнд өөрчлөлт оруулах нь хэцүү байдаг. Үндсэн хууль судлалын өнөөгийн түвшинд үндсэн хуулийг өөрчлөх нарийн төвөгтэй байдлаас хамааран үндсэн хуулиудыг “уян” болон “хатуу” гэж ангилах нь түгээмэл байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ердийн олонхоор батлах зэрэг хялбар журам тогтоосныг “уян”, харин парламентын хуралдааны санал хураалтын өндөр квот тогтоосон, парламентаар хэлэлцэн, ард нийтийн санал асуулгаар баталдаг, хоёр чуулган/парламент дамждаг, зарим холбооны улсын хувьд муж улсын парламентын дийлэнх олонхын дэмжлэг авч баталдаг зэрэг процедурын шинжтэй хориглолт, хязгаарлалт ихтэй бол “хатуу” үндсэн хууль гэдэг.²⁵³

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад тавигдах зарим процедурын хориглолт, хязгаарлалтуудын талаар дэлгэрүүлэн авч үзье.

Улс орнуудын хувьд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуралдааны санал хураалтын квотыг дийлэнх олонхоор тогтоох нь элбэг байна. Жишээ нь, Болгар, Герман, Унгар зэрэг улсад – 2/3, Америкт – 3/4-ын санал шаардлагатай байна.

Түүнчлэн, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хэд хэдэн хувилбар бүхий улс орнууд байна. Тухайлбал, Энэтхэгийн Парламентын танхим тус бүрийн гишүүдийн олонх хүрэлцэн ирж, гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар нэмэлт, өөрчлөлт оруулдаг бол төрийн байгууламжтай холбоотой асуудлаар дээрхээс гадна муж улсуудын талаас дээшхийн санал шаардлагатай байна.²⁵⁴

Үндсэн хуулийг анх баталсан шийдвэр нь ард түмний итгэл үнэмшил байдаг тул түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг бүх ард түмний санал асуулгаар шийдвэрлэх зарчим үйлчилдэг. Тухайлбал, Японы Үндсэн хуулийн 96 дугаар зүйлд: “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг Парламент гаргах бөгөөд Парламентын танхим бүрийн нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар зөвшөөрөгдсөн төслийг ард түмнээр батлуулахаар шилжүүлнэ; ард нийтийн санал асуулгад оролцогсдын олонхын дэмжлэг авсан, эсхүл Парламентын сонгуулиар шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлтийг ард түмний нэрийн өмнөөс Эзэн хаан батлах бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн бүрэлдэхүүн хэсэг нь болно.” гэж заажээ.²⁵⁵

Зарим Үндсэн хууль хоёр чуулган дамжин нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалттай байна. Ингэхдээ хоёр чуулган хооронд сонгууль явуулах нь иргэдийн санаа бодлыг тусгаж буй нэг хэлбэр гэж үздэг байна. Тухайлбал, Норвегийн Үндсэн хуульд заасны дагуу нэг парламентын

²⁵³ Лүндээжанцан Д. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол арга зүйн харьцуулалт үндэслэл, Шинэ толь, №31, 2000 он.

²⁵⁴ IDEA (2018), Constitutional beginnings: Making and amending constitutions, <https://www.idea.int/sites/default/files/publications/constitutional-beginnings-making-amending-constitutions.pdf>

²⁵⁵ Япон Улсын Үндсэн хууль, <https://www.sangiin.go.jp/eng/law/tcoj/index.htm>

бүрэн эрхийн хугацаанд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулан олон нийтэд танилцуулж, парламентын сонгуулийн үр дүнд байгуулагдсан дараагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэн шийдвэрлэдэг байна.²⁵⁶

Зарим орнууд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санаачилга гаргах субъектэд хязгаарлалт тавьдаг. Тухайлбал, Оросын Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлд зааснаар ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх тодорхой асуудлаар хууль санаачлах эрхтэй боловч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга гаргах эрхгүй байна.²⁵⁷

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаар: Дээр дурдсан процедурын хязгаарлалтуудаас гадна агуулгын хувьд өөрчлөлт оруулахад хязгаарлалт тогтоосон 75 Үндсэн хууль байна.²⁵⁸ Зарим орнууд Үндсэн хуулийн тодорхой бүлэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглох бөгөөд тус хязгаарлалт Үндсэн хууль өөрт нь агуулагдаж буй тохиолдолд түүнийг *eternity clause* буюу үүрдийн баталгаа гэж нэрлэж байна.²⁵⁹

Тухайлбал, Индонезийн Үндсэн хуульд²⁶⁰ төрийн байгууламж нутаг дэвсгэрийн нэгдмэл байдал болон бүгд найрамдах төрийн хэлбэрийн тухай, Франц²⁶¹ болон Италийн²⁶² Үндсэн хуульд бүгд найрамдах төрийн хэлбэрийн тухай, Германы Үндсэн хуульд²⁶³ Холбооны улс нь муж улсад хуваагдах, муж улс нь хууль тогтоох ажиллагаанд оролцох тухай, мөн тус хуулийн 1 болон 20 дугаар зүйлд заасан зарчмыг өөрчлөх, эдгээрт өөрчлөлт оруулах санал гаргахыг тус тус хориглосон байна.

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Үндсэн хуулийн 5 дугаар зүйл²⁶⁴

АНУ-ын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд “Конгресс хоёр танхимын гишүүдийн гуравны хоёр нь зайлшгүй шаардлагатай гэж үзсэн үед энэхүү Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал болгох, эсхүл муж улсуудын хууль тогтоох хурлын гуравны хоёрын санаачилгаар Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Чуулган зарлан хуралдуулж болно. Конгресс батламжийн хоёр аргын аль хэлбэрийг нь санал болгосноос шалтгаалан, эсхүл муж улсуудын хууль тогтоох хурлын дөрөвний гурав нь, эсхүл Үндсэн хуулийн чуулганы дөрөвний гурав нь баталсны дараа тухайн нэмэлт, өөрчлөлтийг энэхүү Үндсэн хуулийн бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж хүчин төгөлдөр болгоно.

Гэхдээ 1808 он хүртэлх хугацаанд оруулсан ямар ч нэмэлт, өөрчлөлт нэгдүгээр зүйлийн есдүгээр хэсгийн нэг дэх болон дөрөв дэх заалтыг ямар нэг байдлаар хөндөж үл болох бөгөөд муж улс өөрөө зөвшөөрөлгүй бол Сенатын танхим дахь бусадтай тэнцүү тооны саналаа алдах ёсгүй.

²⁵⁶ Норвегийн Хаант Улсын Үндсэн хууль, <https://lovdata.no/dokument/NLE/lov/1814-05-17?q=grunnloven>

²⁵⁷ Оросын Холбооны Улсын Үндсэн хууль, <http://www.constitution.ru/>

²⁵⁸ Олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

²⁵⁹ Сарантуяа Ц. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаар: онолын асуудал ба Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. Хууль дээдлэх ёс. №1(51). УБ., 2015 он. 46 дахь тал

²⁶⁰ Бүгд Найрамдах Индонез Улсын Үндсэн хууль, <https://www.mkri.id/public/content/infoumum/regulation/pdf/uud45%20eng.pdf>

²⁶¹ Бүгд Найрамдах Франц Улсын Үндсэн хууль, https://www.conseil-constitutionnel.fr/sites/default/files/as/root/bank_mm/anglais/constiution_anglais_oct2009.pdf

²⁶² Бүгд Найрамдах Итали Улсын Үндсэн хууль, https://www.senato.it/documenti/repository/istituzione/costituzione_inglese.pdf

²⁶³ ХБНГУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд хүний эрхэм чанар салшгүй бөгөөд төрийн бүхий л эрх мэдэл түүнийг дээдлэх үүрэгтэй, хүний эрх нь хүн төрөлхтний энх тайван, шударга ёсны үндэс бөгөөд Үндсэн хуульд заасан үндсэн бүх эрх нь хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг хязгаарлах тухай заажээ. Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд ХБНГУ нь ардчилсан нийгмийн баримжаат төр, төрийн бүх эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй, хууль тогтоох эрх мэдэл Үндсэн хуулиар бэхжүүлсэн нийгмийн хэв журамд, гүйцэтгэх болон шүүх эрх мэдэл хууль болох эрх зүйд захирагдах болохыг заажээ.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль, <https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf>

²⁶⁴ Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль, <https://www.archives.gov/>

Улс орнуудын хувьд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаарыг Үндсэн хуульд өөрт нь тусгаагүй боловч уг хязгаарыг тусгай журмаар тогтоосон байдаг. 2010 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль нь үүний нэг жишээ болж байна.

Үндсэн хуулийн үндсэн бүтцийн номлол буюу *Basic structure doctrine* гэх энэхүү үзэл санаа нь Үндсэн хуульд тухайн Үндсэн хуулийн суурь болон гол шинжийг агуулсан зарчмууд туссан байдаг гэх үзэл санаа юм. 1960-70-аад онд Энэтхэгийн Дээд шүүхээс тус улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ тус номлолыг анх томьёолсон гэж үздэг.²⁶⁵

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр Үндсэн хуулийн үндсэн бүтцийн номлолын талаар “Аль ч Үндсэн хуульд хэзээ ч өөрчилж үл болох гол гол зарчмууд байдаг гэдэг үзэл санааг Үндсэн хуулийн Үндсэн бүтцийн номлол гэдэг. Үндсэн бүтцийн номлолын хамрах хүрээ маш тодорхой бөгөөд энэ нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хөндөж болохгүй гэж заасан Үндсэн хуулийн заалтууд юм.

...Үндсэн бүтцийн номлол нь олон улсын практикт хоёр гол арга замаар хөгжиж байгаа бөгөөд энэ нь нэгдүгээрт хууль тогтоох замаар, хоёр дахь нь Үндсэн хуулийн шинжтэй маргааныг хянан хэлэлцэх явцдаа Үндсэн хуулийн шүүх, эсхүл энэ төрлийн дагнасан шүүхгүй оронд Дээд шүүхээс жишиг тогтоосон шүүхийн шийдвэр гаргах замаар хэрэгждэг байна.” гэж бичжээ.²⁶⁶

Зарим нөхцөлд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг шүүхээс хянах нь аливаа нэг субъектийн түрэмгийлэл, дур зоргыг хязгаарлах ач холбогдолтой бол зарим үед Үндсэн хуулийн шинэтгэлд саад болох, олон талын зөвшилцөл, ойлголцлыг мухардуулж болзошгүй талаар Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (International IDEA)-гээс гаргасан судалгааны тайлангуудад дурдсан байна.²⁶⁷

Үндсэн бүтцийн номлолын олон улсын практикийн хувьд үндсэн бүтцийн номлолыг Үндсэн хуулиар хуульчилсан цорын ганц улс нь Бангладеш байна. Тус улсын Үндсэн хуулийн 7В-д “Үндсэн хуулийн 142 дугаар зүйлд тусгагдсаныг үл харгалзан, Үндсэн хуулийн Оршил хэсэг, I бүлгийн бүх зүйл, II бүлгийн бүх зүйл, IXA бүлэгт заасны дагуу III бүлгийн бүх зүйл болон Үндсэн хуулийн үндсэн бүтэцтэй холбоотой аливаа зүйл (үүнд XI бүлгийн 150 дугаар зүйл орно)-д нэмэлт, өөрчлөлт оруулах, орлуулах, хүчингүй болгох болон бусад байдлаар өөрчлөхгүй.” гэж заажээ.²⁶⁸

3.2. Үндсэн хуулийн албан ёсны нэмэлт, өөрчлөлтөөс гадуурх өөрчлөлтийн талаар

Үндсэн хуулийн хяналтын тогтолцоо бүхий улс орнуудад Үндсэн хуульд тайлбар хийх замаар Үндсэн хуулийн зарим зохицуулалтын агуулга, утга, үзэл баримтлалыг өөрчилж болдог байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь хатуу, чанга байхын хэрээр Үндсэн хуульд тайлбар хийх замаар өөрчлөх явдал нэмэгдэх магадлалтай гэж үзэх нь бий.²⁶⁹

Тухайлбал, өдгөө АНУ-ын Үндсэн хуульд нийт 27 нэмэлт, өөрчлөлт оруулсан ба АНУ-ын Үндсэн хуулийг хянан үзэх тухай саналыг 200 гаруй жилийн туршид Конгресст арван мянга гаруй удаа хэлэлцсэнээр дээрх нэмэлт, өөрчлөлт орсон байна. АНУ-ын Үндсэн хуульд нэмэлт,

²⁶⁵ The Basic Structure of the Indian Constitution, <https://constitutionnet.org/vl/item/basic-structure-indian-constitution>

²⁶⁶ Одбаяр Д. Үндсэн хуулийн бүтцийн номлол, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (Онол, арга зүйн хэрэгжилт). УБ., 2017. 103 дахь тал.

²⁶⁷ IDEA (2018), Constitutional beginnings: Making and amending constitutions,

<https://www.idea.int/sites/default/files/publications/constitutional-beginnings-making-amending-constitutions.pdf>

²⁶⁸ Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсын Үндсэн хууль, <http://bdlaws.minlaw.gov.bd/act-367/section-41504.html>

²⁶⁹ IDEA (2017), Constitutional Amendment Procedures, <https://www.idea.int/sites/default/files/publications/constitutional-amendment-procedures-primer.pdf>

өөрчлөлт оруулах анхны төслийг 1789 онд боловсруулж, хоёр жил гаруй Конгрессоор хэлэлцэн 1791 онд баталсан түүхтэй. Харин 27 дахь буюу анх 1789 онд санаачилсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг бүтэн 203 жилийн турш хэлэлцэж 1992 оны 05 дугаар сарын 07-ны өдөр баталсан байна.

Харин АНУ-ын Дээд шүүхээс АНУ-ын Үндсэн хууль болон түүний зарим заалтад тайлбар цөөнгүй хийгдэж, ялангуяа тодорхой бус зохицуулалтын утга, агуулгыг өөрчилж ирсэн байна.²⁷⁰

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах албан ёсны журам нь өөрчлөлт оруулахад шаардлагатай хууль зүйн процессыг тодорхойлдог бол тухайн нэмэлт, өөрчлөлтийг дэмжих, хүлээн зөвшөөрүүлэхэд шаардагдах улс төрийн процесс нь дээрхээс ялгаатай байж болох юм.²⁷¹

Тухалбал, Словакийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь маш хялбар бөгөөд нэг танхим бүхий парламентын тавны гурвын олонхын саналаар шийдвэрлэх зохицуулалттай. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад ард нийтийн санал асуулга явуулах албан ёсны шаардлага байхгүй хэдий ч практикт Үндсэн хуульд хэд хэдэн удаа томоохон өөрчлөлтүүд оруулахаас өмнө зөвлөлдөх санал асуулга явуулж ирсэн нь өдгөө бичигдээгүй дүрэм болсон байна. Ийнхүү санал асуулга явуулахгүй байх, эсхүл үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй байх нь уг нэмэлт, өөрчлөлтийн хүлээн зөвшөөрөгдөх байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.²⁷²

Үүнээс гадна сонгуулийн хууль тогтоомж, парламентын хуралдааны дэг зэрэг нь Үндсэн хуулийн бүрэлдэхүүн хэсэг болохгүй хэдий ч Үндсэн хуулийн практик, үйл ажиллагаанд нөлөөлж болох юм.

Тухайлбал, Нидерландын Үндсэн хуульд албан ёсны өөрчлөлт оруулах бус зөвхөн Парламентын дэг журамд өөрчлөлт оруулах замаар сайд нарын томилгоо (Засгийн газрыг бүрдүүлэх)-ны процесс дахь Эзэн хааны үүргийг хязгаарлаж, Парламентын үүргийг нэмэгдүүлсэн байна.²⁷³



²⁷⁰ Мөн тэнд.

²⁷¹ Мөн тэнд.

²⁷² Мөн тэнд.

²⁷³ Мөн тэнд.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Ном бүтээл:

- Амарсанаа Ж., Батсайхан О. Монгол Улсын Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992) УБ., 2009 он.
- Батбаяр Б. “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба Үндсэн хуулийн зөрчил” өгүүлэл. Эрх зүй, цуврал 45. 2019 он. №1. <https://www.academia.edu>
- Лүндээжанцан Д. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол арга зүйн харьцуулалт үндэслэл, Шинэ толь, №31, 2000 он. <https://academy.edu.mn/content/003154-2/>
- Одбаяр Д. Үндсэн хуулийн бүтцийн номлол, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (Онол, арга зүйн хэрэгжилт). УБ., 2017 он.
- Сарантуяа Ц. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаар: онолын асуудал ба Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. Хууль дээдлэх ёс. №1 (51), УБ. 2015 он.
- Совд Г. “Монгол Улсад Үндсэн хуулийн цэц байгуулагдсан нь” өгүүлэл. 2019 он. (Совд Г. 2019 он)
- Товуусүрэн Ц. Үндсэн хуулиа ойлгохуй: Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар. Хоёр дахь хэвлэл. УБ., 2020 он.
- Чимид Б. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн тулгамдсан зарим асуудал. Хууль дээдлэх ёс. Цуврал 35. 2011 он. (Чимид Б. 2011 он)
- Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ, НҮБХХ. УБ., 2016 он. <https://www.undp.org/mongolia/publications>
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (Эх сурвалж, харьцуулсан судалгаа, 1999-2017 он). УИХ-ын Тамгын газар. УБ., 2018 он.
- Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал (Хураангуй танилцуулга). Редактор: Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар. УИХ-ын Тамгын газрын ПССХ. 2022 он.
- Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт. Харьцуулсан судалгаа (СТ-15/206). УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс. Судалгааны эмхэтгэл – 20 дугаар боть. 2015 он.
- УИХ-ын 2019 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга (Албан хэрэгцээнд). УИХ-ын Тамгын газар. УБ., 2020 он.
- УИХ-ын 2022 оны ээлжит бус чуулганы үйл ажиллагааны танилцуулга (Албан хэрэгцээнд). УИХ-ын Тамгын газар. УБ., 2022 он.
- Монгол Улсын Парламент (УИХ-ын чуулганы хуралдаанд хэлсэн үгийн эмхэтгэл, 1990-2000 он). УИХ, УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв, НҮБХХ. УБ., 2005 он.

Эрх зүйн баримт бичиг:

- БНМАУ-ын Үндсэн хууль (1924 он). <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1924.html>
- БНМАУ-ын Үндсэн хууль (1940 он). <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1940.html>
- БНМАУ-ын Үндсэн хууль (1960 он). <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1960.html>
- Ард нийтийн санал асуулгын тухай хууль (2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон). <https://legalinfo.mn/mn/detail?lawid=52>
- Ард нийтийн санал асуулгын тухай хууль (Шинэчилсэн найруулга). (2016 он). <https://legalinfo.mn/mn/detail?lawid=11704>

УИХ-ын Тамгын газрын архивт байгаа хуулийн хувийн хэрэг:

- Ард нийтийн санал асуулгын тухай хууль (Шинэчилсэн найруулга). 2016 он. Д-8, ХН-2195.
- Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль. 2016-2017 он. Д-9, ХН-460.

- Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль. 2010 он. **Боть-01:** Д-7, ХН-808; **Боть-02:** Д-7, ХН-809; **Боть-03:** Д-7, ХН-810; **Боть-04:** Д-7, ХН-811.
- Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль. 2011 он. Д-7, ХН-1316.
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль; Ерөнхийлөгчийн хоригийн тухай тогтоол; Үндсэн хуулийн цэцийн 03 тоот дүгнэлт. 1999-2000 он. Д-5, ХН-28.
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт; “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” УИХ-ын 54 дүгээр тогтоол. 2000 он. УИХ-ын Тамгын газрын архив. Д-5, ХН-47.
- Хууль тогтоомжийн тухай хууль. 2015 он. **Боть-01:** Д-8, ХН-1415; **Боть-02:** Д-8, ХН-1416.
- Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль. 2017 он. Д-9, ХН-491.

Хуралдааны тэмдэглэл:

- БНМАУ-ын АИХ-ын хоёрдугаар хуралдааны тэмдэглэл. 1991.12.16. УИХ-ын Тамгын газрын архив.
- БНМАУ-ын УБХ-ын дөрөвдүгээр хуралдааны тэмдэглэл. 1991.10.10. УИХ-ын Тамгын газрын архив.
- УИХ-ын 1999 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл. 1999.12.24. УИХ-ын Тамгын газрын архив.
- УИХ-ын 2010 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл. 2010.12.02. <https://www.parliament.mn/nn/5162/>
- УИХ-ын 2019 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл. 2019.10.11. <https://www.parliament.mn/nn/9553/>
- УИХ-ын 1999 оны намрын ээлжит чуулганы ТББХ-ны хуралдааны тэмдэглэл. 1999.12.24. УИХ-ын Тамгын газрын архив.
- УИХ-ын 2022 оны ээлжит бус чуулганы ТББХ-ны хуралдааны тэмдэглэл. 2022.08.24, 2022.08.25. <https://www.parliament.mn>
- УИХ-ын 2022 оны ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл. 2022.08.24, 2022.08.25. <https://www.parliament.mn>

Гадаад хэл дээрх эх сурвалж:

- Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль, <https://www.archives.gov/>
- Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсын Үндсэн хууль, <http://bdlaws.minlaw.gov.bd/act-367/section-41504.html>
- Бүгд Найрамдах Индонез Улсын Үндсэн хууль, <https://www.mkri.id/public/content/infoumum/regulation/pdf/uud45%20eng.pdf>
- Бүгд Найрамдах Итали Улсын Үндсэн хууль, https://www.senato.it/documenti/repository/istituzione/costituzione_inglese.pdf
- Бүгд Найрамдах Франц Улсын Үндсэн хууль, https://www.conseil-constitutionnel.fr/sites/default/files/as/root/bank_mm/anglais/constitition_anglais_oct2009.pdf
- Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Үндсэн хууль, <https://constitutionnet.org/vl/item/basic-structure-indian-constitution>
- Норвегийн Хаант Улсын Үндсэн хууль, <https://lovdata.no/dokument/NLE/lov/1814-05-17?q=grunnloven>
- Олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан, www.constituteproject.org

Хавсралт 1. **Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн лавлагаа (1999²⁷⁴, 2000²⁷⁵, 2019²⁷⁶, 2022²⁷⁷ онуудад)**

ТАЙЛБАР: -үг, өгүүлбэр шинээр нэмэгдсэнийг **тод хараар** (“**bold**”),
 -үг, өгүүлбэрийг өөрчлөн найруулсныг доогуур зураасаар (“underline”),
 -үг, өгүүлбэр хасагдсаныг дундуур зураасаар (“~~strikethrough~~”) тус тус тэмдэглэв.

Монгол Улсын Үндсэн хууль²⁷⁸ (1992.01.13)	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Монгол Улсын бүрэн эрхт байдал		
6.2.Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.	<u>6.2.Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.</u> <u>Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.</u> <u>Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.</u> <u>Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.</u>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр найруулсан.
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Хүний эрх, эрх чөлөө		
	19¹.1. Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана. 19¹.2. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна. 19¹.3. Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам,	Энэ зүйлийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн. 19 ¹ .2 дахь хэсгийг 2028.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

²⁷⁴ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 59 дугаарт нийтлэгдсэн.

²⁷⁵ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2000 оны 47 дугаарт нийтлэгдсэн.

²⁷⁶ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 45 дугаарт нийтлэгдсэн.

²⁷⁷ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 33 дугаарт нийтлэгдсэн.

²⁷⁸ “Ардын эрх” сонин, 1992.01.14, №9 /313/. Эх сурвалж: *Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт. Харьцуулсан судалгаа (СТ-15/206). УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс. 2015 он. Судалгааны эмхэтгэл - XX боть.*

Монгол Улсын Үндсэн хууль²⁷⁸ (1992.01.13)	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо
	санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.	
ГУРАВДУГААР БҮЛЭГ. Монгол Улсын төрийн байгуулал		
НЭГ. Монгол Улсын Их Хурал		
21.4.Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.	<u>21.4.Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.</u>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
22.2.Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ.	22.2.Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана.	Энэ хэсгийг 1999.12.24 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн бөгөөд уг нэмэлтийг <u>ҮХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хучингүй болгосон.</u>
	22.2.Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана.	Мөн хэсгийг 2000.12.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.
	<u>22.2.Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзэж, эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж санал болгосон бол Улсын Их Хурлын нийт</u>	Мөн хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт,

Монгол Улсын Үндсэн хууль²⁷⁸ (1992.01.13)	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо
	<u>гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно.</u>	өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
	<p>22.3.Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш дөчин тав хоногийн дотор, эсхүл Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас, түүнчлэн дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш гуч хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана.</p> <p>22.4.Энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш Улсын Их Хурал арав хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, жар хоногийн дотор явуулна. Шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хадгална.</p>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.
24.1. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа нууцаар гаргаж сонгоно.	<p><u>24.1.Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.</u></p> <p><u>24.1.Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно.Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.</u></p>	<p>Энэ хэсгийг 1999.12.24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд уг өөрчлөлтийг <u>ҮХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хучингүй болгосон.</u></p> <p>Мөн хэсгийг 2000.12.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.</p>
25.1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 6/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын	<p>25.1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:</p> <p>6/ <u>Ерөнхий сайд</u>, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;</p>	Энэ заалтад 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөлт оруулсан.

Монгол Улсын Үндсэн хууль²⁷⁸ (1992.01.13)	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо
бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;		
7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;	<p><u>7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;</u></p> <p><u>Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.</u></p> <p><u>Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно.</u></p> <p><u>Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно;</u></p>	Энэ заалтад 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөлт оруулсан.
16/ ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ;	<p>16/ ард нийтийн санал асуулга явуулах. Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно; Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ;</p>	Энэ заалтад 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2 дахь өгүүлбэр нэмсэн.
26.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ.	<u>26.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.</u>	Энэ заалтад 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөлт оруулсан.
27.2.Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан таваас доошгүй ажлын өдөр чуулна.	<p><u>27.2.Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна.</u></p> <p><u>27.2.Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна.</u></p>	<p>Энэ хэсгийг 1999.12.24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд уг өөрчлөлтийг <u>УХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.</u></p> <p>Мөн хэсгийг 2000.12.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.</p>

Монгол Улсын Үндсэн хууль²⁷⁸ (1992.01.13)	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо
	27.2.Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа <u>далан таваас доошгүй ажлын өдөр</u> чуулна.	Мөн хэсэгт 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөлт оруулсан.
27.6.Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний <u>дийлэнх</u> олонхи нь хүрэлцэн ирснээр чуулганыг хүчинтэйд үзэж, чуулганд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.	27.6.Улсын Их Хурлын чуулганы болон <u>Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ.</u>	Энэ хэсгийг 1999.12.24 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд уг өөрчлөлтийг <u>ҮХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.</u>
	27.6.Улсын Их Хурлын чуулганы болон <u>Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ.</u>	Мөн хэсгийг 2000.12.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
	27.6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон <u>Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар хуулийг эцэслэн батална.</u>	Мөн хэсэгт 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөлт оруулсан.
	27.7.Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол нууц санал хураалт явуулна.	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.
28.2.Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно.	28.2.Хуулийн биелэлтийг хангахтай <u>холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.</u>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
29.1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна.	29.1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн <u>эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий</u>	Энэ хэсгийг 1999.12.24 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд

Монгол Улсын Үндсэн хууль²⁷⁸ (1992.01.13)	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо
Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй.	<p><u>сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.</u></p> <p><u>29.1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.</u></p>	<p>оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд уг өөрчлөлтийг <u>ҮХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хучингүй болгосон.</u></p> <p>Мөн хэсгийг 2000.12.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.</p>
29.3.Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.	29.3.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.	Энэ хэсэгт 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 1 дэх өгүүлбэр нэмсэн.
ХОЁР. Монгол Улсын Ерөнхийлөгч		
30.2.Ерөнхийлөгчөөр 45 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно.	<u>30.2.Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.</u>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
31.7.Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.	<u>31.7. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.</u>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хучингүй болсонд тооцсон.
33.1.Ерөнхийлөгч дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан намтай, аль ч нам олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн	33.1.Ерөнхийлөгч дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: <u>2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг, аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг, хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг</u>	Энэ хэсгийг 1999.12.24 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд уг өөрчлөлтийг <u>ҮХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хучингүй болгосон.</u>

Монгол Улсын Үндсэн хууль²⁷⁸ (1992.01.13)	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо
газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах;	<p><u>Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;</u></p> <p>33.1.Ерөнхийлөгч дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: <u>2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;</u></p> <p>33.1.Ерөнхийлөгч дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: <u>2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;</u></p>	<p>Мөн хэсгийг 2000.12.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.</p> <p>Энэ хэсэгт 2019.11.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хүчингүй болсонд тооцсон.</p>
33.4.Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно.	33.4.Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно.	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
ГУРАВ. Монгол Улсын Засгийн газар		
39.1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.	<p>39.1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.</p> <p>39.1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.</p>	<p>Энэ хэсгийг 2019.11.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.</p> <p>Энэ хэсгийн 2 дахь өгүүлбэрийг 2022.08.25-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр 2022.08.25-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон.</p>

Монгол Улсын Үндсэн хууль²⁷⁸ (1992.01.13)	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо
<p>39.2.Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p>	<p>39.2.Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p> <p>Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.</p> <p>39.2.Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p> <p>Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.</p> <p><u>39.2.Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; бусад тохиолдолд Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилж саналыг Ерөнхийлөгч тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна.</u></p>	<p>Энэ хэсгийг 1999.12.24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн бөгөөд уг нэмэлтийг <u>ҮХЦ-ийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хучингүй болгосон.</u></p> <p>Мөн хэсгийг 2000.12.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.</p> <p>Энэ хэсгийг 2019.11.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.</p>
<p>39.3.Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно.</p>	<p>39.3.Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.</p> <p>39.4.Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.</p>	<p>Энэ хэсгийг 2019.11.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.</p>
<p>43.1.Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.</p> <p>43.2.Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.</p>	<p><u>43.1.Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи үг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.</u></p>	<p>Энэ зүйлийг 2019.11.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.</p>

Монгол Улсын Үндсэн хууль²⁷⁸ (1992.01.13)	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо
	<u>43.2.Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.</u>	
44.Өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурал уул асуудлыг дөчин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ.	44.1.Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. 45.2.Улсын Их Хурал тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.	Энэ зүйлийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
ДӨРӨВ. Шүүх эрх мэдэл		
48.1.Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.	<u>48.1.Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.</u>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
49.5.Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.	<u>49.5.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.</u>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
	<u>49.6.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны</u>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.

Монгол Улсын Үндсэн хууль²⁷⁸ (1992.01.13)	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо
	журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.	
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага	
57.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.	57.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. <u>Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.</u>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
57.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.	57.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.
59.2.Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.	59.2.Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна. <u>Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй.</u> <u>Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно.</u>	Энэ хэсгийг 2019.11.14 -ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.



Хавсралт 2. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн лавлагаа

(Эх сурвалж: хуулийн хувийн хэргийн материалд үндэслэн боловсруулав.)

№	Огноо	Журмын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт орсон заалт	Нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл хүчингүй болсон шалтгаан	Тайлбар
1	2	3	4	5
1	2015.05.29	Хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн ""Төрийн мэдээлэл" эмхэтгэл" гэснийг ""Хууль тогтоомжийн эмхэтгэл"-д" гэж өөрчилсөн.	Хууль тогтоомжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж өөрчлөлт орсон.	2001 онд батлагдаж байсан Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль нэртэйгээр шинэчлэн найруулсан. Шинэчилсэн найруулгын 43-т "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн нэрийг "Хууль тогтоомжийн эмхэтгэл" гэж өөрчилсөн.
2	2016.02.05	Хуулийн 17.12 дахь хэсгийн "25 дугаар зүйл, 26 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэгт заасныг" гэснийг "21 дүгээр зүйлд заасныг" гэж өөрчилсөн. (Жич: Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн 17.13 дахь заалт)	Ард нийтийн санал асуулгын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж өөрчлөлт орсон.	1995 онд батлагдаж байсан Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг шинэчлэн найруулсан. Шинэчилсэн найруулгын 25-д заасан "Санал авах хэсэгт санал авалтыг хүчингүй болсонд тооцох, дахин санал авах" ²⁷⁹ , 26.3, 26.6-д заасан "Санал асуулгын талаар Сонгуулийн ерөнхий хорооны гаргасан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц үзсэн бол санал асуулгыг дахин явуулна" гэсэн зохицуулалтуудыг шинэчилсэн найруулгын "Санал хураалтыг хүчингүйд тооцох, дахин санал хураах" ²⁸⁰ гэсэн 21 дүгээр зүйлд тусган өөрчилсөн.
3	2017.02.09	5.3.3.Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хорьдугаар зүйл, Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар зөвлөлдөх санал асуулгыг явуулах; 5.3.4.Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 6.1.1-д заасны дагуу явуулсан санал асуулгын дүнгээр энэ хуулийн 5.3.3-т заасан асуудлаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжсэн бол Улсын Их Хурал заавал	Зөвлөлдөх санал асуулгын тухай (анхдагч) хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.	Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 6.1.1-д зааснаар "Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.3.3-т заасан асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлох" гэж заасныг Журмын тухай хуульд нэмж оруулсан.

²⁷⁹ Ард нийтийн санал асуулгын тухай хууль (2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон). <https://legalinfo.mn/mn/detail?lawid=52>

²⁸⁰ Ард нийтийн санал асуулгын тухай хууль (Шинэчилсэн найруулга). <https://legalinfo.mn/mn/detail?lawid=11704>

1	2	3	4	5
		<p>авч хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах.</p> <p>Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын "Тавдугаар зүйлийн 1-4 дэх хэсэг" гэснийг "Тавдугаар зүйлийн 1-3 дахь хэсэг" гэж, "Дөчин нэг" гэснийг "Дөчин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг" гэж тус тус өөрчилсөн.</p> <p>Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын "Хорьдугаар зүйл," "Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэг," гэснийг тус тус хассан.</p>		<p>Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын "Тавдугаар зүйлийн 1-4 дэх хэсэг" гэснийг "Тавдугаар зүйлийн 1-3 дахь хэсэг" гэж өөрчилсөн. Энэ нь Үндсэн хуулийн 5.4-т "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна." гэж заасныг хассан.</p> <p>Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын "Дөчин нэг" гэснийг "Дөчин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг" гэж өөрчилсөн. Энэ нь Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн "1.Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.</p> <p>2.Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана." гэж заасны 41.1 дэх хэсгийг хассан байна.</p> <p>Учир нь дээрх 2 заалтын асуудлаар зөвлөлдөх санал асуулга явуулахаар 5.3.3-т нэмсэн.</p> <p>Үндсэн хуулийн 20 дугаар зүйл "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.", 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг "Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн." гэж заасныг хассан.</p> <p>Учир нь дээрх 2 заалтын асуудлаар зөвлөлдөх санал асуулга явуулахаар 5.3.3-т нэмсэн.</p>
4	2017.05.12	Хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн "Хууль тогтоомжийн эмхэтгэл"-д гэснийг "Төрийн мэдээлэл" эмхэтгэл"-д гэж өөрчилсөн.	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.	Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн гарчгийг "Хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, хууль тогтоомжийг нийтлэх, олон нийтэд сурталчилах" гэж, 43.1, 43.2 дахь хэсгийн "“Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д” гэснийг ““Төрийн мэдээлэл” эмхэтгэлд” гэж өөрчлөлт орсон.
5	2019.10.11	17.4.Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4.2-т зааснаар ард нийтийн санал асуулга явуулах нь зүйтэй гэж үзсэн бол ард нийтийн санал асуулгад оруулах эхийг зөвшөөрөх, эсхүл	УИХ-ын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай	Журмын тухай болон Дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдээр “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл” гэсэн нэр томъёотой холбоотой нийт 26 хэсэг, заалтад холбогдох өөрчлөлт оруулж, Үндсэн хуультай нийцүүлэв. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн

1	2	3	4	5
		<p>татгалзахаас өөр асуудлаар ард нийтийн санал асуулга хамтатган явуулахыг хориглоно.</p> <p>Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн "хойшлуулшгүй" гэсний дараа ", түүнчлэн хуулиар Улсын Их Хурлаас батлах хугацааг нь тусгайлан заасан" гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн "бүлэг нь" гэсний дараа "энэ хуулийн 11.3.4-т заасан саналын түвшинд харгалзсанаас бусад" гэж тус тус нэмсэн.</p> <p>4 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн "энэ тухай хууль" гэснийг "уг нэмэлт, өөрчлөлт" гэж, мөн зүйлийн 3.4 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 2 дугаар бүлгийн гарчиг, 11 дүгээр зүйлийн гарчгийн "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг" гэснийг "Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг" гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.3.4 дэх заалтын "Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл" гэснийг "Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл" гэж, 6, 7, 8, 9 дүгээр зүйлийн гарчиг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль" гэснийг "Үндсэн хуульд оруулах</p>	<p>холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>санал асуулгаар шийдвэрлүүлэхтэй холбоотой асуудлыг тодруулж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг баталгаажуулахтай холбоотойгоор хугацаа зааж, түүнчлэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийн санал, хураалт явуулах үндэслэлийг тодорхой болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулав.</p> <p>Түүнчлэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэхтэй холбоотойгоор УИХ-аас батлах хугацааг нь тусгайлан заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх боломжийг Журмын тухай хуульд нэмж, хууль хоорондын зөрчлийг арилгасан.</p> <p>Мөн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх шатанд Байнгын хороо болон нам, эвслийн бүлэг саналын түвшинд харгалзан үзсэнээс бусад төсөлд тусгагдаагүй шинэ заалт, саналын томьёолол, санал, дүгнэлтдээ оруулахгүй байх зэрэг нэмэлт, өөрчлөлтийг²⁸¹ оруулжээ.</p>



²⁸¹ УИХ-ын 2019 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл. 2019.10.11. <https://www.parliament.mn/nn/9553/>

1	2	3	4	5
		<p>нэмэлт, өөрчлөлтийн төсөл" гэж, 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсгийн "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль" гэснийг "Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт" гэж, 10 дугаар зүйлийн гарчгийн "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд" гэснийг "Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд" гэж, 16 дугаар зүйлийн гарчиг, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн" гэснийг "Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн" гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг" гэснийг "Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг" гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд" гэснийг "Хууль тогтоомжийн тухай хуульд" гэж, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн "хуулийг бүхэлд нь" гэснийг "төслийг бүхэлд нь" гэж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн "уг хууль" гэснийг "уг эх" гэж, 17 дугаар зүйлийн 17.8, 17.9, 17.11 дэх хэсгийн "хуулийг" гэснийг "эхийг", мөн зүйлийн 17.10 дахь хэсгийн "хуульд" гэснийг "эхэд" гэж, 17.4-17.12 дахь хэсгийн дугаарыг "17.5-17.13" гэж тус тус өөрчилсөн.</p> <p>Хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5, 15.6</p>		

1	2	3	4	5
		дахь хэсгийг тус тус хүчингүй болгосон.		
6	2022.08.24	<p>1.4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр /тогтоол/ гарсантай холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, батлахтай холбогдсон харилцааг Монгол Улсын Их Хурал тусгайлсан дэгээр хэлэлцэж болно.</p> <p>18 дугаар зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр /тогтоол/-ээр Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх журам</p>	<p>ҮХЦ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн 39.1 дэх заалтын “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэсэн хэсгийг хүчингүй болгосонтой холбогдуулан өөрчлөлт орсон.</p>	<p>ҮХЦ 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн их суудлын хуралдаанаар 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн зохих зүйл, хэсэгт нийцээгүй гэж үзэж, хүчингүй болгон эцэслэн шийдвэрлэсэн.</p> <p>Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд УИХ-аас Дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн баталсан.</p> <p>Ингэснээр ҮХЦ-ийн эцсийн шийдвэр (тогтоол)-ээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хуулийн хүрээнд хэлэлцэх боломжийг бүрдүүлсэн байна.</p>



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮЛЭГ III

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**СТАНДАРТЫН ТАЛААР МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ГАДААД УЛС ОРНЫ САЙН ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D),
Д.Аюуш, О.Билгүүтэй, С.Золжаргал, Д.Халиун*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СТАНДАРТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СТАНДАРТЫН ТАЛААР МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1.Хууль, эрх зүйн орчин

2.2.Монгол Улсын Стандартчиллын асуудлыг хариуцсан байгууллага (Стандарт,
хэмжил зүйн газар)

2.3.Монгол Улсын стандарт

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАДААД УЛС ОРНУУДЫН САЙН ТУРШЛАГА

3.1.АНУ

3.1.1.Бүтэц, зохион байгуулалт

3.1.2.АНУ-ын тохирлын үнэлгээний тогтолцоо

3.1.3.Эрх зүйн орчин

3.2.БНСУ

3.2.1.Бүтэц, зохион байгуулалт

3.2.2.Эрх зүйн орчин

3.3.ХБНГУ

3.4.ЯПОН УЛС

3.4.1.Бүтэц, зохион байгуулалт

3.4.2.Эрх зүйн орчин

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АҮСХ	Америкийн үндэсний стандартын хүрээлэн
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ЕАЭЗХ	Евроазийн эдийн засгийн холбоо
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ОУСБ/ISO	Олон улсын стандартчиллын байгууллага
СББ	Стандарт боловсруулагч байгууллага
ТУХН	Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл
ҮСБ	Үндэсний стандартчиллын байгууллага
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ANS	АНУ-ын үндэсний стандарт
ANAB	Үндэсний магадлан итгэмжлэх зөвлөл
CEN	Европын стандартчиллын хороо
CENELEC	Европын цахилгаан техникийн стандартчиллын хороо
COPANT	Пан Америкийн стандартын комисс
ETSI	Европын мэдээлэл, харилцаа холбооны стандартчиллын хүрээлэн
IEC	Олон улсын цахилгаан техникийн комисс
ITU	Олон улсын цахилгаан холбооны байгууллага
JIS	Японы аж үйлдвэрийн стандарт
KS	БНСУ-ын үндэсний стандарт
MNS	Монгол Улсын үндэсний стандарт
PASC	Ази Номхон далайн бүсийн стандартын конгресс
USSS	АНУ-ын стандартчиллын стратеги

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Үндэсний, бүс нутгийн болон олон улсын стандартын уялдаа
- Зураг 2. Европын стандартыг нэвтрүүлсэн, нэвтрүүлж буй улс орнууд, 2022 он
- Зураг 3. Стандарт, хэмжил зүйн газрын бүтэц, зохион байгуулалт
- Зураг 4. АНУ-ын стандартчилал, тохирлын тогтолцооны ялгаатай байдал
- Зураг 5. АНУ-ын стандартчиллын тогтолцооны бүдүүвч, АҮСХ
- Зураг 6. БНСУ-ын технологи, стандартын агентлагийн бүтэц
- Зураг 7. БНСУ-ын технологи, стандартын агентлагийн чиг үүрэг
- Зураг 8. БНСУ-ын стандарт боловсруулах хамтын ажиллагааны тогтолцоо
- Зураг 9. БНСУ-ын стандартын холбооны бүтэц

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгын дагуу “Стандартын талаар Монгол Улс дахь хууль тогтоомжийн зохицуулалт болон гадаад улс орны сайн туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Энэхүү судалгаагаар гадаадын улс орнуудын стандартчиллын тогтолцоо, хөгжлийн чиг хандлага, туршлага зэргийг судлахыг зорьсон болно. Судалгаанд АНУ, БНСУ, ХБНГУ, Японы үндэсний стандартчиллын тогтолцоо, холбогдох эрх зүйн орчин, стандартын талаарх Монгол Улс дахь хууль тогтоомжийн зохицуулалтыг тусгахаас гадна стандартын талаарх ерөнхий ойлголтыг тусгасан болно.

Судалгааны хамрах хүрээ: Судалгааны захиалгын хүрээнд гадаад улсын сайн туршлага АНУ, БНСУ, ХБНГУ, Япон зэрэг орнуудыг сонгон авлаа. Мөн захиалагчийн хүсэлтэд дурдсаны дагуу стандартын талаар Монгол Улс дахь хууль тогтоомжийн зохицуулалтыг судалсан болно.

Судалгааны ажил нь гурван бүлэгтэй. *Нэгдүгээр бүлэгт*, стандарттай холбоотой ерөнхий ойлголт, олон улсын нийтлэг жишгийн талаар, *Хоёрдугаар бүлэгт*, стандартын талаарх Монгол Улс дахь хууль тогтоомжийн зохицуулалт, *Гуравдугаар бүлэгт*, гадаад улс орнуудын сайн туршлага: АНУ, БНСУ, ХБНГУ, Япон улсуудын үндэсний стандарт боловсруулах, хяналт тавих эрх бүхий байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, холбогдох хууль тогтоомжийн талаар авч үзэв.

Түлхүүр үг: *Стандартчилал, олон улсын ISO стандарт, үндэсний стандарт MNS*

Keywords: *Standardization, ISO international standards, national standard MNS*



СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Стандартын хэрэглээг зохицуулсан хамгийн гол олон улсын баримт бичиг нь Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр юм. Уг хэлэлцээр нь олон улсын стандарт, техникийн зохицуулалтууд, үндэсний стандартын бэлтгэл, нутагшуулалт, хэрэглээнд зориулсан хэм, хэмжээг тогтоодог.


Стандарт нь олон улсын, бүс нутгийн, үндэсний, байгууллагын гэх төрөлтэй байдаг. Олон улсын стандарт гэж нэг буюу түүнээс дээш тооны олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн орнуудын хүрээнд боловсруулж, зөвшилцсөн баримт бичиг юм. Зарим олон улсын стандартчиллын байгууллагын бүх гишүүн улс нь ижил статустай байдаг бол Олон улсын стандартчиллын байгууллага ISO болон Олон улсын цахилгаан техникийн комисс (IEC)-ийн гишүүнчлэлийн хувьд дотроо олон ангилалд хуваагдах бөгөөд жинхэнэ гишүүд нь эдгээр байгууллагын бүх үйл ажиллагаанд, харин дэмжигч, ажиглагч зэрэг статустай гишүүд байгууллагын үйл ажиллагаанд хязгаарлагдмал хүрээнд оролцдог байна.

Бүс нутгийн стандарт гэдэг нь тухайн бүс нутгийн хэмжээнд оролцогч орнууд боловсруулж, зөвшилцсөн баримт бичгийг ойлгох бөгөөд үүний нэг жишээ Европын стандарт юм. Үндэсний стандартын жишээг дурдвал манай улсын MNS, АНУ-ын ANS, БНСУ-ын KS, Япон Улсын JIS гэх мэт тухайн улс үндэснийхээ түвшинд боловсруулан мөрдөж буй стандартыг дурдаж болно. Үндэсний стандартад тусгагдаагүй үзүүлэлт, шаардлагад зохистой хэм хэмжээг илүү нарийвчлан тодорхойлох, үндэсний стандарттай уялдуулан хөгжүүлэх боломжоор хангах зорилгоор байгууллагын стандартыг боловсруулдаг.

Өдгөө үндэсний хэмжээнд стандарт боловсруулах хоёр загвар түгээмэл ашиглагддаг. Ихэнх улс орон төвлөрсөн (дээрээс доош чиглэсэн) загвар буюу нэг байгууллага, гол төлөв Засгийн газрын агентлаг үндэсний стандартыг боловсруулдаг, эсхүл баталдаг тогтолцоотой бол АНУ зэрэг улс оронд төвлөрсөн бус (доороос дээш чиглэсэн) загвар дэлгэрсэн байна. Доороос дээш чиглэсэн загвар нь зах зээлийн эрэлтэд суурилсан стандарт боловсруулах загвар бөгөөд үүнд хувийн сектор илүү идэвхтэй оролцдог. БНСУ нь тус загварыг Стандарт боловсруулах хамтын ажиллагааны байгууллагаар дамжуулан нэвтрүүлж байна.

Стандартын хэрэглээ нь сайн дурын үндсэн дээр, эсхүл хуулиар тогтоосон албан журмын буюу заавал мөрдөх стандарт байдаг. Тухайлбал, Германы Аж үйлдвэрийн хэм хэмжээний стандарт DIN-ыг сайн дураар хэрэглэдэг. Харин түүнийг гэрээ хэлцэл, хууль тогтоомж болон дүрэм журамд тусгасан бол албан журмаар хэрэглэнэ.

Дэлгэрүүлж судалгааны хэсгээс үзнэ үү.



СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СТАНДАРТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Стандарт гэж хэрэглэгч зэрэг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг хэлнэ. Сонирхогч талуудын оролцоог хангах нь шударга байдлыг хангахаас гадна стандартыг хэрэглэх итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Олон улсын стандартчиллын байгууллага (ОУСБ) болох ISO нь дээрх үзэл баримтлалыг чухалчлан авч үзэж, стандарт боловсруулах явц дахь хэрэглэгчийн оролцоог Ёс зүйн дүрэм²⁸² болон өөрийн Стратеги төлөвлөгөөндөө тусгасан байдаг.

Стандарт, түүний агуулга

Стандарт нь зөвхөн бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг агуулдаггүй бөгөөд туршилтын арга, үйл ажиллагааны дүрэм, удирдлагын тогтолцооны стандарт, зөвлөмж, удирдамж болон хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагауд байж болдог.

Стандартын үйлчлэх хугацааг урьдчилан тогтоодоггүй, харин технологийн сүүлийн үеийн хөгжил, зах зээлийн чиг хандлагыг харгалзан үзэх зорилгоор тогтмол хянан, шинэчилдэг. Тухайлбал, олон улсын ISO стандартыг 5 жил тутам хянан үздэг.

Удирдлагын тогтолцооны стандарт нь чанарыг баталгаажуулах үйл явц, эсхүл хүнсний аюулгүй байдал, байгаль орчин хамгаалал, мэдээллийн тогтолцооны аюулгүй байдал зэрэг тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд холбогдох үйл ажиллагаа эрхлэгчдэд үйлдвэрлэл, үйл явцын тасралтгүй сайжруулалтыг хэрхэн удирдан явуулахыг тодорхойлж өгдөг.

Стандарт нь олон улсын, бүс нутгийн, үндэсний, байгууллагын гэх зэрэг төрөлтэй байдаг. *Олон улсын стандарт* гэж нэг буюу түүнээс дээш тооны олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн орнуудын хүрээнд боловсруулж, зөвшилцсөн баримт бичиг юм. Олон улсын стандарт боловсруулагч хамгийн томоохон байгууллага нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)²⁸³ бөгөөд Олон улсын цахилгаан

²⁸² ISO Code of Ethics, <https://www.iso.org/publication/PUB100011.html>

²⁸³ International Organisation for Standardisation, <https://www.iso.org/home.html>

Олон улсын стандартчиллын байгууллага (ISO) нь 167 гишүүн (2022 оны 7 дугаар сарын 20-ны байдлаар) улсын стандартын байгууллагуудаас бүрдсэн бие даасан, төрийн бус олон улсын байгууллага юм. Эдгээрийн 125 орон нь жинхэнэ гишүүн (member bodies), 39 улс дэмжигч гишүүн (correspondent members) болон 3 улс ажиглагч статустай (subscriber members) байна. Гишүүн бүр нь нэг улсыг төлөөлөх ба улс бүрээс зөвхөн нэг гишүүн байдаг.

ISO-ийн гишүүнчлэл нь жинхэнэ, дэмжигч, ажиглагч гэсэн гурван ангилалтай байх бөгөөд ISO тогтолцоонд нөлөөлөх болон ISO стандартад нэвтрэх түвшний хувьд ялгаатай байна. Жинхэнэ гишүүн нь ISO-ийн техникийн болон бодлогын хуралд оролцож, санал өгөх замаар ISO стандартын хөгжил, стратегид нөлөөлдөг. Жинхэнэ гишүүд нь үндэсний хэмжээнд ISO олон улсын стандартыг борлуулах, хэрэглэх эрхтэй. Дэмжигч гишүүн нь ISO-ийн техникийн болон бодлогын хурал, чуулганд ажиглагч статустай оролцох замаар ISO стандартын хөгжил, стратегийн чиг хандлагыг ажиглана. Үндэсний стандартчиллын нэгж бүхий дэмжигч гишүүд үндэсний хэмжээнд ISO олон улсын стандартыг борлуулах, хэрэглэх эрхтэй байна. Үндэсний стандартчиллын нэгж бус дэмжигч гишүүд өөрийн нутаг дэвсгэртээ ISO олон улсын стандартыг борлуулах, хэрэглэх эрхтэй. Ажиглагч статустай гишүүд нь ISO-ийн үйл ажиллагаа, шинэчлэлүүдийн талаарх мэдээллээр хангагдах боловч үйл ажиллагаанд нь оролцох эрхгүй байна. Тэдгээр нь үндэсний хэмжээнд ISO олон улсын стандартыг борлуулах, хэрэглэх эрхгүй байна. Монгол Улсын хувьд 1979 онд Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүнээр элссэн.

холбооны байгууллага (ITU)²⁸⁴, Олон улсын цахилгаан техникийн комисс (IEC)²⁸⁵-той нийлэн Дэлхийн стандартчиллын хамтын нөхөрлөлийн түншлэл²⁸⁶-ийг бүрдүүлдэг.

ISO-ийн гишүүн улс бүр шинэ стандарт боловсруулах төслийг санал болгож болдог. Төслийг тодорхой тооны гишүүн улс дэмжсэнээр дараагийн шатанд шилжинэ. Хэрэв тухайн асуудлыг хамаарах Техникийн хороо байхгүй тохиолдолд шинэ Техникийн хороог байгуулах бөгөөд ISO-ийн гишүүн улс бүрээс тухайн процесст оролцогч, эсхүл ажиглагч гишүүний статусаар оролцохыг нь лавладаг. Стандарт боловсруулах процесст оролцогч гишүүн бүр нэг саналын эрхтэй оролцоно. Дэмжээгүй саналуудыг оролцогч бүх гишүүдэд хэлэлцүүлэхээр тараадаг.

ISO стандартыг боловсруулах процесс дууссаны эцэст гишүүн улс тухайн стандартыг үндэсний стандарт болгон батлах боломжтой. Түүнчлэн, улс орнууд ISO стандартыг нутагшуулахдаа өөрийн төр засаг, үйлдвэрлэл, эдийн засгийн өвөрмөц хэрэгцээ, эсхүл хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлийг хангуулахад өөрийн улсад тохирсон өөрчлөлтийг оруулж болдог.

Дээр дурдсан олон улсын стандартчиллын байгууллагуудаас гадна дараах ОУСБ-уудыг дурдаж болох юм. Тухайлбал, The Codex Alimentarius Commission (CAC) нь НҮБ-ын бүлд хамаарах Засгийн газар хоорондын байгууллага юм. 1963 онд байгуулагдсан Ром хотноо төвтэй тус байгууллага нь хүнсний бүтээгдэхүүний олон улсын стандартыг бие даан болон бусад ОУСБ-тай (ISO зэрэг) хамтран баталдаг. Энд мөн Олон улсын ургамал хамгаалах конвенц (IPPC)²⁸⁷, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (OIE) зэрэг байгууллагуудыг дурдаж болох юм.

ITU, CAC, IPPC болон OIE зэрэг байгууллагад бүх гишүүн улс нь ижил статустай байна. Харин ISO болон IEC-ийн гишүүнчлэлийн хувьд дотроо олон ангилалд хуваагдах бөгөөд жинхэнэ гишүүд нь эдгээр байгууллагын бүх үйл ажиллагаанд оролцохдоо дэмжигч, ажиглагч зэрэг статустай гишүүд байгууллагын үйл ажиллагаанд хязгаарлагдмал хүрээнд оролцдог.

Бүс нутгийн стандарт гэдэг нь тухайн бүс нутгийн хэмжээнд оролцогч орнууд боловсруулж, зөвшилцсөн баримт бичгийг ойлгох бөгөөд үүний нэг жишээ Европын стандарт юм. Европын Холбооны гишүүн орнуудын хооронд нэгдсэн нэг зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чөлөөт шилжилтийг бий болгоход нэгдсэн шаардлага тогтоох зорилгоор Европын стандартыг анх бий болгосон. Европын стандартыг:

- Европын стандартчиллын хороо (CEN)²⁸⁸-өргөн хэрэглээний бараа, үйлчилгээ, технологийн салбарын Европын стандартчиллын байгууллага;
- Европын цахилгаан техникийн стандартчиллын хороо (CENELEC)²⁸⁹-цахилгаан техникийн шийдэлтэй холбоотой Европын стандартчиллын байгууллага;
- Европын мэдээлэл, харилцаа холбооны стандартчиллын хүрээлэн (ETSI)²⁹⁰-мэдээлэл, харилцаа холбооны Европын стандартчиллын байгууллага гэсэн төрөлжсөн гурван байгууллага боловсруулдаг.

²⁸⁴ International Telecommunication Union, <https://www.itu.int/en/Pages/default.aspx>

²⁸⁵ International Electrotechnical Commission, <https://www.iec.ch/homepage>

²⁸⁶ World Standardization Cooperation, <https://www.worldstandardscooperation.org/>

²⁸⁷ The International Plant Protection Convention, <https://www.ippc.int/en/>

²⁸⁸ The European Committee For Standardization, <https://www.cenelec.eu/>

²⁸⁹ The European Committee For Electrotechnical Standardization, <https://www.cenelec.eu/>

²⁹⁰ European Telecommunications Standards Institute, <https://www.etsi.org/>

Мөн энд Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (ТУХН)-ийн Стандартчилал, хэмжил зүй, гэрчилгээжүүлэлтийн улс хоорондын зөвлөлөөс баталсан Улс хоорондын стандарт-ГОСТ²⁹¹-ыг дурдаж болох юм. Тус бүс нутгийн стандартыг Евроазийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ)²⁹²-ны газар нутагт сайн дурын зарчмын үндсэн дээр хэрэглэдэг.

Стандартын хэрэглээ нь сайн дурын үндсэн дээр, эсхүл хуулиар тогтоосон албан журмынх буюу заавал мөрдөх стандарт байдаг.

Үндэсний стандартын жишээг дурдвал манай улсын MNS, АНУ-ын ANS, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын GB, Бүгд Найрамдах Солонгос Улсын KS, Японы JIS зэрэг тухайн улс үндэснийхээ түвшинд боловсруулан мөрдөж буй стандартыг дурдаж болох юм. Үндэсний стандартад тусгагдаагүй үзүүлэлт, шаардлагад зохистой хэм хэмжээг илүү нарийвчлан тодорхойлох, үндэсний стандарттай уялдуулан хөгжүүлэх боломжоор хангах зорилгоор *байгууллагын стандартыг* боловсруулдаг.

Өдгөө үндэсний хэмжээнд стандарт боловсруулах хоёр загвар түгээмэл тархсан байдаг. Ихэнх улс орон төвлөрсөн загвар буюу нэг байгууллага, гол төлөв Засгийн газрын агентлаг үндэсний стандартыг боловсруулдаг, эсхүл баталдаг тогтолцоотой бол АНУ зэрэг улс оронд төвлөрсөн бус загвар дэлгэрсэн байна. Энэ нь өөр өөр олон төрлийн байгууллагууд үндэсний стандартыг боловсруулах, батлах тогтолцоо юм.

ДХБ-ын Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр нь олон улсын стандарт, техникийн зохицуулалтууд, үндэсний стандартын бэлтгэл, нутагшуулалт, хэрэглээнд зориулсан хэм хэмжээг тогтоодог. Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний үйл явц ялгаварлан гадуурхалгүй, худалдаанд шаардлагагүй хүндрэл учруулдаггүй байлгах нь энэ хэлэлцээрийн гол зорилго юм. Хэрэгцээгүй зөвшөөрөл, гэрчилгээ шаардах, эсхүл хэт их зохицуулалт хийх гэх мэт шаардлагагүй саад тотгорыг худалдаанд үүсгэж болохгүй. Худалдаанд үүсдэг иймэрхүү саад бэрхшээлийг хөнгөвчлөх зорилгоор энэхүү хэлэлцээрт үндэсний стандартыг олон улсын стандарттай уялдуулан нийцүүлэхийг шаардаж, ДХБ-ын гишүүдийг хоорондоо харилцан хүлээн зөвшөөрөх гэрээгээр нэг нэгнийхээ стандарт, техникийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөхийг уриалдаг.

ДХБ-ын Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн журмын үр дагаварт нь сайн дурын бичиг баримт болгон боловсруулсан олон улсын стандарт заавал мөрдөх ёстой дүрэм болон хувирч болдог. ДХБ-ын Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрт олон улсын стандартыг үндэсний зохицуулалт, стандартыг хөгжүүлэх үндэс болгон хэрэглэхээр тусгасан байдаг тул тэд улс орнуудад дүрэм журам болон шууд үйлчлэх боломжтой. Стандарт нь бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл зүйл, чанар, аюулгүй байдал, аль бараа хэрхэн худалдаалагддаг болохыг тодорхойлдог тул зах зээл, худалдаанд шууд бусаар нөлөөлдөг.²⁹³

²⁹¹ Межгосударственный стандарт ГОСТ- ЗХУ-ын Засгийн газраас стандартчиллын стратегийн хүрээнд боловсруулагдсан ГОСТ стандартыг 1992 онд Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнууд тухайн нэршлээр нь шинэ болон шинэчлэгдэх улс хоорондын стандартын тухайд хэрэглэхээр тохиролцсон.


²⁹² Договор о Евразийском экономическом союзе, ст. 51, п. 1, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_163855/

²⁹³ Стандарт эдийн засагт хэрхэн нөлөөлдөг вэ? Стандарт, хэмжилзүй сэтгүүлийн 2020 оны 2-р улирлын дугаар, https://issuu.com/informationmasm/docs/standart__1_


ДХБ-ын Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрээс:

2.4. Техникийн дүрэм шаардагдаж байгаа бөгөөд олон улсын холбогдох стандарт нь бэлэн байгаа, аль эсхүл тэдгээрийг боловсруулах ажил дуусч байгаа нөхцөлд гишүүд тэдгээрийг бүхэлд нь эсхүл, зарим холбогдох хэсгийг эдгээр олон улсын стандарт буюу тэдгээрийн холбогдох хэсгүүд нь хууль ёсны зорилтуудыг биелүүлэхэд, тухайлбал, цаг уур буюу газар зүйн үндсэн хүчин зүйл, эсхүл технологийн гол асуудлаас шалтгаалан үр ашиггүй буюу зохимжгүй хэрэгсэл болохоос бусад тохиолдолд өөрийн техникийн дүрмийн үндэс болгож ашиглана.

Зураг 2. Үндэсний, бүс нутгийн болон олон улсын стандартын уялдаа



Зураг 3. Европын стандартыг нэвтрүүлсэн, нэвтрүүлж буй улс орнууд, 2022 он



Эх сурвалж: Global Outreach Report, June 2022, CEN, CENELEC²⁹⁵

²⁹⁴ https://www.omron.com.au/service_support/technical_guide/safety_component/safety_requirements.asp

²⁹⁵ https://www.cenelec.eu/media/CEN-CENELEC/European%20Standardization/Documents/IC/globaloutreach_june_2022.pdf

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СТАНДАРТЫН ТАЛААР МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1.Хууль, эрх зүйн орчин

Монгол Улсад стандартын талаар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай²⁹⁶ болон Хэмжил зүйн тухай²⁹⁷, Төрийн хяналт шалгалтын тухай²⁹⁸ зэрэг хуулиуд үйлчилж байна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг байна.

Хэмжил зүйн тухай хууль нь хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд хэмжил зүйн бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоож, хэмжил зүйн чиглэлээр хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн харилцааг зохицуулж байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар дээрх хоёр хуульд заасан төрийн хяналт, шалгалтын үйл ажиллагааг зохицуулдаг байна. Энэ чиг үүргийг мэргэжлийн хяналтын байгууллага болон гаалийн байгууллага хэрэгжүүлэхээр заасан байна. Тус хуульд төрийн хяналт шалгалтын тогтолцоо, төрийн захиргааны хяналт шалгалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Мөн Монгол Улсын Засгийн газраас 2016 онд **Үндэсний чанарын хөтөлбөр**²⁹⁹-ийг баталсан. Энэ хөтөлбөрийн зорилго нь чанарын дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгосны үндсэн дээр экспортын чиг баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүний эрүүл мэнд, амь нас, хүрээлэн буй орчны болон хүнсний аюулгүй байдлыг хамгаалан иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэхээр заажээ.

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

- 1) чанарын дэд бүтцийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- 2) чанарын дэд бүтцийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн бүрдүүлж хөгжүүлэх;
- 3) чанарын дэд бүтцийн хүний нөөцийн чадавхыг сайжруулах;
- 4) хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн чанарын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх;
- 5) бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, байгаль орчинд ээлтэй ногоон технологийг нэвтрүүлэх;
- 6) экспортын тэргүүлэх салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;

²⁹⁶ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2017.12.21, <https://legalinfo.mn/mn/detail/13071>

²⁹⁷ Хэмжил зүйн тухай хууль, 2019.05.09, <https://legalinfo.mn/mn/detail/14440>

²⁹⁸ Төрийн хяналт шалгалтын тухай хууль, 2003.01.03, <https://legalinfo.mn/mn/detail/500>

²⁹⁹ Үндэсний чанарын хөтөлбөр батлах тухай, Монгол Улсын засгийн газрын 2016 оны 344-р тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail/12140>

- 7) импортыг орлох бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 8) чанарын дэд бүтцийн байгууллагуудын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, аюулгүй байдлыг хангах.

Монгол Улсад стандартын талаар УИХ-аас баталсан дээрх хуулиуд болон Засгийн газраас баталсан хөтөлбөр үйлчлэхээс гадна **Стандарт, хэмжил зүйн газраас гаргасан дараах журам, заавар, дэг үйлчилж байна**. Үүнд:

- Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх журам;³⁰⁰
- Стандарт боловсруулах, өртөг тооцох заавар;³⁰¹
- Техникийн хорооны бизнес төлөвлөгөө боловсруулах заавар;³⁰²
- Техникийн хорооны хуралдааны дэг;³⁰³
- Олон улсын стандартад санал өгөх журам;³⁰⁴
- Стандартчиллын техникийн хорооны үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх журам;³⁰⁵
- Олон улсын стандартыг орчуулах, санхүүжүүлэх журам³⁰⁶ ... зэрэг байна.

2.2. Монгол Улсын Стандартчиллын асуудлыг хариуцсан байгууллага (Стандарт, хэмжил зүйн газар)

Монгол Улсын стандартчиллын асуудлыг хариуцсан байгууллага нь хуульд³⁰⁷ зааснаар Монгол Улсын Засгийн газрын харьяанд Монгол Улсын Шадар Сайдын эрхлэх асуудлын хүрээнд Стандарт, хэмжил зүйн газар нэртэйгээр ажиллаж байна. Анх 1923 онд Жин хэмжүүрийн товчоо нэртэйгээр байгуулагдсанаас хойш өдгөө Стандарт, хэмжил зүйн газар нэрийн дор Стратегийн бодлого, төлөвлөлт, дотоод аудитын газар, Тамгын газар, Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газар, Итгэмжлэлийн газар, Үнэт металлын сорьцын хяналтын газар, Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газар, Хэмжил зүйн хүрээлэн, Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын газар, Хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулгын алба, Стандартын мэдээлэл лавлагаа сургалтын үндэсний төв гэсэн үндсэн 9 нэгж, 1 алба мөн орон нутгийн 20 аймагт салбар, бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.



³⁰⁰ Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/251 тоот тушаал

³⁰¹ Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/230 тоот тушаал

³⁰² Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/74 тоот тушаал

³⁰³ Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/233 тоот тушаал


³⁰⁴ Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/228 тоот тушаал

³⁰⁵ Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/231 тоот тушаал

³⁰⁶ Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2017 оны А/129 тоот тушаал

³⁰⁷ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2017.12.21

Зураг 4. Стандарт, хэмжил зүйн газрын бүтэц, зохион байгуулалт.



Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг:

- Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах, үндэсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хэмжлийн нэгдмэл байдлыг хангах бодлогоор дэмжиж, Монгол Улсын хэмжлийн тогтолцоо, хэмжлийн нэгжийн үндэсний эталон, хууль эрхийн хэмжил зүйн техникийн чадавхыг нэмэгдүүлж олон улсын түвшинд хүргэх;
- Олон улсын шаардлагад нийцсэн тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн тогтолцоог бий болгох, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Бүтээгдэхүүн үйлчилгээний болон удирдлагын тогтолцоо (ISO 9001, ISO 14000 HACCP)-ны баталгаажуулалтын үйл ажиллагаагаар худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, тэдэнд зах зээл дээр шударга өрсөлдөх таатай нөхцөлийг бүрдүүлэх;

- Сорьцын баталгааг олон улсын түвшинд хүргэх, үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох үйлчилгээг олон улсын стандартын дагуу хийж хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах.

2.3. Монгол Улсын стандарт

Estandard.gov.mn - цахим сан нь 2016 оны 07 дугаар сарын 1-ний байдлаар Монгол Улсын стандартын улсын бүртгэлд байгаа 6199 стандартын мэдээллийг олон улсын стандартын ангиллын дагуу бүлэглэсэн цахим сан бөгөөд үндэсний болон үндэсний болгосон олон улсын стандарт, арга зүйн бусад баримт бичгийн жагсаалт, хүчингүй болсон стандартын жагсаалт, төв, орон нутгийн Стандарт, хэмжил зүйн салбарын хаяг, хэмжил зүйн болон баталгаажуулалтын журмын сангуудын мэдээллийг агуулдаг.

Монгол Улсын бүртгэлд байгаа **стандартыг дараах байдлаар ангилж** байна. Үүнд:

1. Тайлбар толь
2. Нийтлэг зүйл, нэр томъёо, стандартчилал, баримт бичиг
3. Үйлчилгээ, компанийн зохион байгуулалт, менежмент ба чанар. Захиргаа. Тээвэр. Социологи.
4. Математик. Байгалийн шинжлэх ухаан
5. Эмнэлгийн тусламжийн технологи
6. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийн хамгаалал. Аюулгүй байдал
7. Хэмжил зүй ба хэмжилт. Физик үзэгдэл
8. Сорилт
9. Нийтлэг хэрэглээний механик тогтолцоо ба бүрэлдэхүүн хэсэг
10. Нийтлэг хэрэглээний урсамтгай материалын тогтолцоо ба бүрэлдэхүүн хэсэг
11. Үйлдвэрлэлийн техник
12. Эрчим хүч ба дулаан дамжуулах техник
13. Цахилгаан техник
14. Электроник
15. Цахилгаан холбоо. Дуу, дүрсний техник
16. Мэдээллийн технологи. Албан тасалгааны машин, техник хэрэгсэл
17. Дүрслэлийн технологи
18. Нарийн механик. Үнэт эдлэл
19. Авто замын тээврийн хэрэгслийн техник
20. Төмөр замын техник
21. Хөлөг онгоцны үйлдвэрлэл, усан онгоцны бүтэц
22. Нисэх онгоц ба сансрын тээврийн хэрэгслийн техник
23. Материал зөөвөрлөх тоног төхөөрөмж
24. Барааны сав, баглаа боодол ба хуваарилалт
25. Нэхмэлийн ба арьс ширний технологи
26. Хувцасны үйлдвэр
27. Хөдөө аж ахуй
28. Хүнсний технологи
29. Химийн технологи
30. Уул уурхай, ашигт малтмал
31. Газрын тос, холбогдох технологи
32. Металлурги
33. Модны технологи



34. Шил, керамикийн үйлдвэр
35. Каучук ба хуванцрын үйлдвэр
36. Цаасны технологи
37. Будаг, будгийн үйлдвэр
38. Барилга, барилгын материал
39. Иргэний байгууламж
40. Цэргийн техник
41. Ахуйн ба худалдааны тоног төхөөрөмж. Соёлын үйлчилгээ. Спорт
42. Гарчиггүй
43. Хэмжигдэхүүн ба нэгж
44. Өнгөөр кодчилох
45. Үсгэн тэмдэгт
46. График тэмдэг
47. Техникийн зураг
48. Бүтээгдэхүүний техникийн баримт бичиг
49. Стандартчилал, нийтлэг дүрэм
50. Мэдээллийн шинжлэх ухаан. Хэвлэл ... зэрэг.

Одоогийн байдлаар (2022 оны 07 дугаар сарын 29-ний байдлаар) Монгол Улсын стандарт, техникийн зохицуулалтын **улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй хүчин төгөлдөр хэрэгжиж буй 6555 стандарт байна**. Стандартын жагсаалтыг дараах холбоосоор <https://estandard.gov.mn/mongol-ulsiiin-standartiin-jagsaalt-mon/v/393> үзэж болох (318 хуудас) бөгөөд жил бүр тодорхой хэмжээний стандарт нь хүчингүй болж нэмэлт, өөрчлөлт орж, шинээр батлагддаг. 2021 онд нийт 81 стандарт³⁰⁸ хүчингүй болж, 6 стандартад³⁰⁹ нэмэлт, өөрчлөлт орж, 54 стандарт³¹⁰ шинээр батлагджээ.



³⁰⁸ 2021 онд хүчингүй болсон стандартын жагсаалт, <https://estandard.gov.mn/mongol-ulsiiin-standartiin-jagsaalt-mon/v/97>

³⁰⁹ 2021 онд нэмэлт, өөрчлөлт орсон стандартын жагсаалт, <https://estandard.gov.mn/mongol-ulsiiin-standartiin-jagsaalt-mon/v/96>

³¹⁰ 2021 онд шинээр батлагдсан стандартын жагсаалт, <https://estandard.gov.mn/mongol-ulsiiin-standartiin-jagsaalt-mon/v/95>

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАДААД УЛС ОРНУУДЫН САЙН ТУРШЛАГА


3.1. АНУ

АНУ-ын хувьд стандарт болон тохирлын үнэлгээтэй холбоотой үйл ажиллагаа нь үндэсний эдийн засгийн бүхий л салбартай холбогдож, тус улсын дэлхийд өрсөлдөх чадварт нэн чухалд тооцогддог. АНУ-ын Худалдааны департаментын Олон улсын худалдааны газраас гаргасан тайланд тэмдэглэснээр дэлхийн бараа бүтээгдэхүүний экспортын 93% нь стандартад нийцсэн байдал тулгуурладаг байна.³¹¹

АНУ-ын стандартчиллын тогтолцоог тус улсын түүхэн дэх хамгийн өргөн цар хүрээтэй бөгөөд үр нөлөө бүхий төр хувийн хэвшлийн түншлэлийн нэг гэж хэлж болох бөгөөд америкчуудын өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг бараг бүхий л бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээ зэргийн аюулгүй, тогтвортой байдал, гүйцэтгэл, тохиромжтой байдлыг хөгжүүлэхэд стандартыг боловсруулдаг байна.

Тус улсын төр болон хувийн хэвшлийн оролцогч талуудын зүгээс стандартыг АНУ-ын инновац, өрсөлдөх чадвар, аюулгүй байдал, мөн амьдралын чанарын суурь хэсэг гэж хүлээн зөвшөөрч, үүнийг хууль тогтоомж, АНУ-ын стандартчиллын стратеги (USSS)³¹² зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгасан байдаг.³¹³

Зураг 5. АНУ-ын стандартчилал, тохирлын тогтолцооны ялгаатай байдал³¹⁴



ҮСБ-ууд нь стандартчиллын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ихэнхдээ холбогдох хууль, эрх зүйн актаар эрхээ хэрэгжүүлж, санхүүжилт авдаг.

АНУ-ын загвар

3.1.1. Бүтэц, зохион байгуулалт

АНУ-д стандартыг хувийн сектор удирдан хариуцаж, аж үйлдвэр, эрдэм шинжилгээний байгууллага, хэрэглэгч, төрийн оролцоог хангадаг тогтолцоотой байна. АНУ-ын стандартчиллын энэхүү тогтолцоо нь сүүлийн 100 гаруй жилийн хугацаанд АНУ-ын аж үйлдвэр, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэн хөгжиж ирсэн байна. АНУ-ын хувийн секторын стандартын тогтолцооны зохицуулагчийн үүргийг **Америкийн**

³¹¹ U.S. Department of Commerce. International Trade Administration. June 2016. *Standards and Regulations: Measuring the Link to Goods Trade*. Washington, D.C. https://legacy.trade.gov/td/osip/documents/osip_standards_trade_full_paper.pdf

³¹² The United States Standards Strategy (USSS), <https://www.ansi.org/resource-center/publications-subscriptions/uss>

³¹³ Written Testimony of the American National Standards Institute before the United States House of Representatives Committee on Science, Space, and Technology Research and Technology Subcommittee, Hearing: “Setting the Standards: Strengthening U.S. Leadership in Technical Standards” March 17, 2022


³¹⁴ U.S. Standards System: Introduction, ANSI, https://www.standardsportal.org/usa_en/standards_system/introduction.aspx

үндэсний стандартын хүрээлэн (АҮСХ)³¹⁵ хэрэгжүүлдэг. Мөн АҮСХ нь ISO, IEC-ийн жинхэнэ гишүүн юм.

Тус байгууллага нь Америкийн Үндэсний стандарт болох ANS-ыг боловсруулах, мөн стандарт боловсруулагч байгууллага (СББ)-ууд, АНУ-ын Техникийн зөвлөх бүлгүүдийг итгэмжлэх замаар ДХБ-ын Стандарт боловсруулах олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудыг хөхиүлэн дэмждэг.

Эдгээр зарчмууд нь ил тод, нээлттэй байдал, төвийг сахисан, үр дүнтэй, тохиромжтой байх, зөвшилцсөн, гүйцэтгэлд суурилсан уялдаа, эрх зүйн зохих ёсны процедур, мөн шаардлагатай бол техникийн туслалцаа үзүүлэх зэрэг байна.

Зураг 6. АНУ-ын стандартчиллын тогтолцооны бүдүүвч, АҮСХ³¹⁶



3.1.1.1.Америкийн үндэсний стандартын хүрээлэн (АҮСХ)³¹⁷

Америкийн үндэсний стандартын хүрээлэн нь АНУ-ын сайн дурын стандарт болон тохирлын үнэлгээний тогтолцоог удирдан зохион байгуулж, үйл ажиллагааг уялдуулах хувийн, ашгийн бус байгууллага юм. Тус байгууллага нь 1918 онд байгуулагдсан бөгөөд үндэсний болон олон улсын стандарт, тохиролд суурилсан шийдлүүдийг тодорхойлж, боловсруулахад аж үйлдвэр, Засгийн газартай нягт хамтран ажилладаг. АҮСХ-ийн зорилго нь АНУ-ын бизнесийн дэлхийд өрсөлдөх чадвар, мөн АНУ-ын амьдралын чанарыг дээшлүүлэх явдал юм.

³¹⁵ American National Standards Institute (ANSI), <https://www.ansi.org/>

³¹⁶ Мөн тэнд

³¹⁷ Мөн тэнд

Ингэхдээ тус байгууллага нь өөрөө стандарт боловсруулдаггүй, харин Америкийн Үндэсний стандарт болох ANS-ийг боловсруулах СББ-уудыг итгэмжилж, тэдгээрээс боловсруулсан баримт бичгийг Үндэсний стандарт болгон баталдаг. АУСХ-ийг зүгээс стандарт боловсруулах явцад тус хүрээлэн болон олон улсаас тавигддаг шаардлага, зарчмуудыг баримталсан, мөн сонирхогч талуудын оролцоог хангасан эсэхэд хяналт тавьж оролцдог.

АУСХ-ийн удирдлагын бүтэц, баримтлах бодлогыг АУСХ-ийн дүрмээр тогтоож өгсөн.³¹⁸ АУСХ-ийн удирдлагыг Захирлуудын зөвлөл хэрэгжүүлэх бөгөөд тус байгууллага нь хороодын бүтэцтэй, тэдгээр шийдвэр гаргах бүтэцэд дэмжлэг үзүүлэх зөвлөх бүлгүүд, чуулгануудтай. Бүх бүлгүүд нь АУСХ-ийн гишүүн компани, байгууллагуудын сайн дурын төлөөлөгчөөс бүрдэнэ.

3.1.1.2. Үндэсний стандарт боловсруулагч байгууллагууд (Хувийн сектор)³¹⁹

СББ-ууд нь бие даасан байгууллагууд байх бөгөөд тэдгээр нь ямар стандарт боловсруулахаа өөрсдөө шийдвэрлэдэг. Бусад тогтолцооноос ялгаатай нь АНУ-д АУСХ-ээс холбогдох СББ-д тодорхой стандарт боловсруулахыг үүрэг болгож болдоггүй. Харин СББ бүр зах зээлийн хэрэгцээ шаардлагыг гол тодорхойлогч болгон холбогдох стандартыг боловсруулдаг.

СББ нь ихэвчлэн хувийн секторын ашгийн бус байгууллагууд байх бөгөөд гишүүнчлэлийн төлбөр, хэвлэлийн орлого, гэрчилгээжүүлэлтийн үйлчилгээний орлого зэргээс санхүүждэг, гол төлөв төрөөс дэмжлэг, санхүүжилт авдаггүй байна. Өөрийгөө санхүүжүүлдэг байгууллагын хувьд тэдгээр нь зөвхөн тэдгээрт хамаарах зах зээлийн шаардлагад тохирсон стандартыг боловсруулахад гол анхаарлаа хандуулдаг.

3.1.1.3. Төрийн зохицуулагчид

Төрийн зохицуулагч байгууллагууд нь хувийн секторын стандартыг хэрэглэх, стандарт боловсруулахад хувийн сектортой хамтран ажиллах, эсхүл төрд хамаарах стандартыг боловсруулах үүргийг хүлээдэг. АНУ-ын холбооны хууль тогтоомжуудад хувийн секторын стандартыг дурдсан 6000 гаруй эшлэл байдаг. АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг, АНУ-ын Батлан хамгаалах департамент, Хэрэглэгчийн бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлын комисс зэрэг байгууллагууд нь иргэдийн эрүүл мэнд, аюулгүй, сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой салбаруудад сайн дурын стандарт боловсруулахад шаардлагатай техникийн мэдээллээр дэмжлэг үзүүлж ажилладаг.

Төрийн зохицуулагч байгууллагууд нь өөрийн эрхлэх асуудал, чиг үүргийн хүрээнд стандарт боловсруулахад оролцдог. Экспертүүд нь төр-хувийн секторын стандарт боловсруулах үйл ажиллагаанд хувийн секторын сонирхогч талуудад эрх тэгш хамтрагчийн хувьд оролцдог.

Стандарт, технологийн үндэсний хүрээлэн (СТҮХ)³²⁰ нь АНУ-ын Худалдааны департаментын харьяа зохицуулагч бус төрийн агентлаг юм. Тус байгууллага нь 1901 онд байгуулагдсан, АНУ-ын үндэсний хэмжил зүйн хүрээлэн юм. СТҮХ нь бусад холбооны агентлагуудад стандартчиллын үйл ажиллагаатай холбоотой хяналт

³¹⁸https://share.ansi.org/Shared%20Documents/About%20ANSI/Current_Versions_Proc_Docs_for_Website/ANSI-By-Laws-current.pdf

³¹⁹ Standards developing organizations, https://www.standardsportal.org/usa_en/standards_system/sdo_private.aspx

³²⁰ The National Institute of Standards and Technology (NIST), <https://www.nist.gov/about-nist>

тавьдаггүй хэдий ч холбооны агентлагуудад сайн дурын стандарттай холбоотой үйл ажиллагаанд оролцох, хэрэглэхтэй холбоотой удирдамжаар хангадаг. СТУХ-ийн мэргэжилтнүүд үндэсний болон олон улсын стандартын үйл ажиллагаанд оролцох замаар сайн дурын стандарт боловсруулах ажилд техникийн ихээхэн хувь нэмэр оруулдаг.

Үндэсний технологи дамжуулах, хөгжүүлэх тухай хууль³²¹-д заасны дагуу СТУХ нь холбооны агентлагууд, муж, орон нутгийн захиргааны байгууллага зэрэг бүхий л төрийн байгууллагуудыг сайн дурын зөвшилцлийн стандартчиллын байгууллагуудаас боловсруулсан стандартын ашиглалтыг нэмэгдүүлэх, төрийн агентлагуудын стандартын хэрэглээг бууруулах шаардлага тавьж ажилладаг.³²²

Дээрх хуульд заасан шаардлагыг агентлагууд хэрхэн хэрэгжүүлж байгааг үнэлэх, тайлагнахад ашиглах удирдамжийг Төсөв, менежментийн албанаас баталсан Захирамж (Circular A-119)³²³-аар баталсан. Уг захирамжаар СТУХ-ийг тохирлын үнэлгээтэй холбоотой үйл ажиллагааны гол зохицуулагч байгууллагаар тогтоож, холбоотой агентлагуудын сайн дурын стандартын хэрэглээ, гарсан ахиц дэвшлийн талаар жил бүр Төсөв, менежментийн албанд тайлагнахыг үүрэг болгосон.

3.1.2. АНУ-ын тохирлын үнэлгээний тогтолцоо

Тохирлын үнэлгээ гэх нэр томъёог бараа, үйл явц, тогтолцоо, эсхүл ажилтныг тодорхой стандартад заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлэхэд үйлдвэрлэгч болон бусад талуудын авч хэрэгжүүлсэн алхмуудыг тодорхойлоход ашиглана. Туршилт, гэрчилгээжүүлэлт, магадлан итгэмжлэл зэрэг тохирлын үнэлгээний үйл ажиллагаанууд нь стандарттай нягт уялдаж, үйлчлүүлэгч, эсхүл эцсийн хэрэглэгчийн авсан бараа, үйлчилгээнд итгэх тодорхой хэмжээний итгэлийг бий болгодог. Энэ утгаараа тохирлын үнэлгээ нь дэлхийн зах зээлд явуулах бизнесийн нэн чухал хэсэг болсон. Тохирлын үнэлгээний үр дүнг бүтээгдэхүүний тэмдэглэгээ, маркетинг болон сурталчилгааны ажлаар дамжуулан олон нийтэд хүргэж болох юм.

АНУ-ын Үндэсний тохирлын үнэлгээний зарчмууд нь хэрэглэгч, худалдан авагч, худалдагч, зохицуулагч болон бусад сонирхогч талуудад тохирлын үнэлгээний үр дүнг, үйл явцад итгэлтэй болоход нь дэмжлэг үзүүлэхийн сацуу худалдаанд шаардлагагүй саад тотгор үүсгэхээс сэргийлж байдаг.

АСУХ-ийн тохирлын үнэлгээнд хүлээх үүрэг нь бүтээгдэхүүн, ажилтнууд нь хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцэж байгаа эсэхийг тогтоодог байгууллагуудыг магадлан итгэмжилдэг. **АСУХ-ийн Үндэсний магадлан итгэмжлэх зөвлөл** (ҮМИЗ - ANSI National Accreditation Board ANAB)³²⁴ нь АНУ-ын менежментийн тогтолцооны магадлан итгэмжлэгч байгууллага юм. ҮМИЗ нь ISO 9001 чанарын удирдлагын тогтолцоо, ISO 14001 байгаль орчны удирдлагын тогтолцоо, ISO 27001 мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, ISO хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, ANSI/AIHA Z10 ажил мэргэжлийн эрүүл мэнд, хамгааллын удирдлагын тогтолцоо болон олон тооны аж үйлдвэрийн тусгай шаардлага зэргийн гэрчилгээжүүлэгч байгууллагуудыг магадлан итгэмжилдэг. Мөн ҮМИЗ нь ISO/IEC 17025 сорилтын болон шалгалт тохируулгын лаборатори, ISO Удирдамж 34, ISO/IEC 17020 хяналт шалгалтын

³²¹ <https://www.nist.gov/standardsgov/national-technology-transfer-and-advancement-act-1995>

³²² <https://www.nist.gov/standardsgov/ntaa-reports>

³²³ https://www.nist.gov/system/files/revise/circular_a-119_as_of_01-22-2016.pdf

³²⁴ The ANSI National Accreditation Board, <https://anab.ansi.org/>

байгууллагуудын лавлах материал үйлдвэрлэгчдийн лабораторийн магадлан итгэмжлэлийг хариуцдаг.

3.1.3. Эрх зүйн орчин

Стандарт, техникийн үзүүлэлтийн хамгийн том боловсруулагч, хэрэглэгч нь АНУ-ын Холбооны Засгийн газар юм. Одоогийн тооцоогоор 44000 гаруй хууль, техникийн зохицуулалт, худалдан авах техникийн үзүүлэлт хүчин төгөлдөр мөрдөгддөг байна. АНУ-ын Засгийн газрын хэрэглээнд аль стандарт хамгийн их тохиромжтой талаарх шийдвэрүүд нь тухайн агентлагууд өөрсдөө гаргадаг хэдий ч сүүлийн үеийн чиг хандлагаас харахад үндэсний болон олон улсын стандартчиллын байгууллагуудаас баталсан сайн дурын зөвшилцлийн стандартыг АНУ-ын агентлаг болон зохицуулагч байгууллагууд хэрэглэх нь эрс нэмэгдэж байна.

Дээрх тоон дээр АНУ-ын хувийн секторын 50000 гаруй стандартыг нэмбэл стандартын тоо 100000 дөхөх юм. Эдгээр баримт бичгийг 600 орчим стандартчиллын байгууллага боловсруулж, мөрддөг бол 200 орчим нь АУСХ-оос Америкийн Үндэсний стандарт (ANS) боловсруулагч хэмээн итгэмжлэгдсэн байдаг. Үүнээс гадна, шаардлагатай гэж үзвэл олон улсын стандарт боловсруулагч байгууллага болох ISO, IEC-ээс боловсруулсан бүхий л стандартыг АНУ-ын Холбооны Засгийн газрын агентлагууд дүрэм, журамд ашиглах буюу эшлэх боломжтой.

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай Холбооны бодлого нь 1996 онд батлагдсан **Үндэсний технологи дамжуулах, хөгжүүлэх тухай хууль**³²⁵ (National Technology Transfer and Advancement Act)-ийн тодорхой гол зохицуулалтуудад тусгагдсан байдаг. Уг хуулиар:

Холбооны бүх агентлаг, департамент (яам)-ууд сайн дурын зөвшилцлийн стандартчиллын байгууллагуудаас боловсруулан, баталсан техникийн стандартыг хэрэглэх бөгөөд ийм техникийн стандартыг тухайн агентлаг, департамент (яам)-ууд бодлогын чиг үүрэг, хууль тогтоомжоор тогтоосон үйл ажиллагаа явуулахдаа ашиглана.

Холбооны агентлаг, департаментууд нийтийн ашиг сонирхол, мөн тухайн байгууллагын чиг үүрэг, бүрэн эрх, нэн тэргүүний ач холбогдол бүхий асуудлыг хөндсөн, төсвийн боломжтой уялдаж байгаа зэрэг тохиолдолд сайн дурын, хувийн секторын зөвшилцлийн стандартчиллын байгууллагуудтай холбогдох техникийн стандарт боловсруулахад хамтран оролцоно.

Холбогдох бусад хуулиудаас дурдвал:

2004 оны **Стандарт боловсруулагч байгууллагуудыг хөгжүүлэх тухай хууль** (Standards Development Organization Advancement Act of 2004) нь шаардлага хангасан стандарт боловсруулагчдад монополийн эсрэг хууль тогтоолыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагаас хязгаарлагдмал хэмжээнд чөлөөлөгдөх боломжоор хангах юм. Энэхүү хамгаалалт нь 1993 оноос хойш Үндэсний хамтын судалгаа, үйлдвэрлэлийн хуулийн дагуу хамтарсан компаниудад олгодог хамгаалалттай адил бөгөөд консорциум зэрэг албан бус үйл явцыг ашиглаж буй стандарт боловсруулагчдад үйлчлэх юм.

Хэрэглэгчийн бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль (The Consumer Product Safety Act)-ийн дагуу Бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлын комисс нь өөрөө стандарт боловсруулахаас илүүтэйгээр сайн дурын зөвшилцлийн

³²⁵ <https://www.congress.gov/bill/104th-congress/house-bill/2196>

байгууллагаас боловсруулсан хэрэглэгчийн бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлын стандартыг илүүд авч үзэх юм.

1995 оны **Эрүүл мэндийн даатгалын мэдээлэл дамжуулах, хариуцлагын тухай хууль** (The Health Insurance Portability and Accountability Act)-аар Үндэсний стандартын хүрээлэнгээс магадлан итгэмжлэгдсэн стандарт боловсруулагчдын боловсруулсан стандартыг хэрэглэхийг шаардлага болгодог.

1996 оны **Харилцаа холбооны тухай хууль** (The Telecommunications Act)-д Харилцаа холбооны комисс (ХХК)-ыг хувийн секторын стандартыг ашиглах түлхэц болгосон хэд хэдэн зохицуулалтыг тусгасан. Ялангуяа ХХК нь харилцаа холбооны секторын стандартыг нээлттэй явуулах хүрээнд, зөвшилцөлд үндэслэн боловсруулахыг шаардлага тавьдаг нь АУСХ-ны магадлан итгэмжлэлийн шаардлагатай нийцэж байгаа юм.

1997 оны **Хүнс, эмийн газрыг шинэчлэх тухай хууль** (The Food and Drug Administration (FDA) Modernization Act)-д зааснаар зарим тохиолдолд үйлдвэрлэгчдийн эмнэлгийн цахилгаан төхөөрөмжийг зах зээлд нийлүүлэхээс өмнөх үнэлгээнд тодорхой стандартыг хангасан гэх мэдээллийг хүлээн зөвшөөрөхөөр заасан. Энэ нь эмнэлгийн зарим хэрэгслийг зах зээлд гаргах цаг хугацааг багасгахын сацуу эрүүл мэнд, аюулгүй байдлын үндсэн шаардлагуудыг хангуулах юм.

Худалдан авах ажиллагааны шинэчлэл: АНУ-ын Засгийн газар нь төрийн худалдан авах ажиллагаандаа хувийн секторын стандартын хэрэглээг нэмэгдүүлж байна. 1994 онд Батлан хамгаалахын сайд Батлан хамгаалах яамны эн тэргүүнд тавих зүйлсийн нэг нь ирээдүйд цэрэг, эдийн засаг болон бодлогын зорилгоо зардал багатайгаар хангахын тулд зэвсэгт хүчинд мөрдөгдөх онцлог стандартаас хувийн секторын стандартыг мөрдөхөд чиглэнэ гэж мэдэгдсэн байдаг.

3.2.БНСУ

3.2.1.Бүтэц, зохион байгуулалт

3.2.1.1.Солонгосын технологи, стандартын агентлаг (Korean Agency for Technology and Standards)

Улс орнууд дэлхийн зах зээлд хил хязгааргүй, хором бүрээр өргөжин дэвшиж буй өрсөлдөөний эрин үетэй нүүр тулж байна. Ийм нөхцөлд дэлхийн зах зээлд олон улсын стандарт нь улс орон, аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадвар, эдийн засгийн дэвшлийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болж байна.Түүнээс гадна эдийн засаг, нийгмийн хөгжилд стандартын үүрэг, цар хүрээг үйлдвэрлэлээс эхлээд үйлчилгээ, хүний эрх, ёс зүй хүртэл өргөжүүлэхэд хүргэсэн. Үүний үр дүнд стандартчилал нь аж үйлдвэрийг хөгжүүлэх, хүмүүсийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлж байна.

Солонгосын технологи, стандартын агентлагийн үндсэн үүрэг нь Засгийн газрын яамдтай хамтран үндэсний стандартын удирдлагын тогтолцоог бий болгох ба салбар бүрд стандарт боловсруулж, хэрэгжүүлэх, төрийн яамдуудтай хамтран ажиллах удирдлага, зохицуулалтын үүргийг гүйцэтгэдэг. Нийт холбогдох 7 яамдад 3010 төрлийн стандартыг боловсруулан хэрэгжүүлсэн байна.³²⁶

³²⁶ <https://www.kats.go.kr/en/content.do?cmsid=533>

Дэлхийн эдийн засаг, нийгмийн шинэ орчинтой уялдуулан Солонгосын Технологи, стандартын агентлаг (KATS) нь стандарт, технологийн хоорондын харилцааг хөгжүүлэх стратегийн бодлогыг боловсруулж, үндэсний эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, мэдлэгт суурилсан нийгэмд хүрэх платформ боловсруулсан байна.

Солонгосын технологи, стандартын агентлаг нь хувийн хэвшлийн оролцогч талуудыг стандарт боловсруулах үйл явцад илүү идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн доороос дээш чиглэсэн шинэ хандлагыг боловсруулж хэрэгжүүлдэг байна.

БНСУ-ын Үндэсний стандартын салбарын бүх яамдыг төлөөлдөг Солонгосын технологи, стандартын агентлаг нь ISO, IEC, PASC зэрэг олон улсын болон бүс нутгийн стандартчиллын байгууллагуудын гишүүний үүргээр үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцдог.

Бизнесийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэхийн тулд салбар бүрд тодорхой стандарт баталгаажуулалтын системийг бий болгосон байна.

Зураг 7.БНСУ-ын Технологи, стандартын агентлагийн бүтэц

стандартын гэрчилгээний системийг хөгжүүлсэн байна.

Үүнд стандартад нийцсэн гэрчилгээнд суурилсан ижил төстэй гэрчилгээг нэгтгэх, дэлхийн жишигт нийцсэн

Хувийн хэвшлийн стандартыг хөгжүүлэх ажлын хүрээнд Стандарт боловсруулах хамтын ажиллагааны байгууллагыг (COSD: Cooperation Organization for Standards Development) үүсгэн стандарт боловсруулах санал авах, оролцоог нэмэгдүүлдэг байна.




Дэлхийд тэргүүлэгч олон улсын стандартыг дэмжих тогтолцоог бэхжүүлэх зорилготой Олон улсын стандартчиллын байгууллагад илгээсэн удирдах ажилтнуудын тоог нэмэгдүүлэх, олон улсын стандартын хурал зохион байгуулах замаар байнгын гишүүн болох нэгдсэн сан байгуулах зэрэг олон улсын стандартчиллын үйл ажиллагааг идэвхтэй дэмжин ажиллаж байна.

Солонгосын технологи, стандартын агентлаг нь стандартын бодлогын товчоо, бүтээгдэхүүний аюулгүй байдлын товчоо, нийцтэй байдлын товчоо, худалдаан дахь техникийн саад тотгортой холбоотой асуудал хариуцсан товчоо гэсэн үндсэн 4 товчоотой ба

эдгээрийн удирдлагад 19 хэлтэс холбогдох салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 8.БНСУ-ын технологи, стандартын агентлагийн чиг үүрэг



3.2.1.2.Стандарт боловсруулах хамтын ажиллагааны байгууллага (Cooperation Organization for Standards Development)


Стандарт боловсруулах хамтын ажиллагааны байгууллага нь үйлдвэрлэлийн стандартчилалтай холбоотой үүрэг даалгаврыг гүйцэтгэдэг корпорац ба байгууллагуудын дунд төрөлжсөн салбарын стандартыг боловсруулах, түнш байгууллагыг томилж үндэсний стандартын ажлыг голлон хариуцдаг төрийн бус байгууллага юм.

Үндэсний стандартын стратегийн төлөвлөлт, бодлогын дагуу стандартыг боловсруулах техникийн дэмжлэгийг Стандарт боловсруулах хамтын ажиллагааны байгууллага гүйцэтгэдэг байна.³²⁷



³²⁷ <https://www.kpetro.or.kr/eng/lay1/S210T399C407/contents.do>

Зураг 9.БНСУ-ын Стандарт боловсруулах хамтын ажиллагааны тогтолцоо



БНСУ-ын үндэсний стандарт болох **Солонгосын стандарт KS нь** Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хуулийн дагуу Аж үйлдвэрийн стандартчиллын зөвлөлөөр хэлэлцүүлж, Техникийн стандартын захирлын тогтоосон үндэсний стандарт юм. Солонгосын стандарт нь 21 төрөл 3 үндсэн хэсэгт хуваагддаг.

- Бүтээгдэхүүний стандарт: Бүтээгдэхүүний сайжруулалт, хэмжээ, чанарыг тодорхойлох;
- Туршилтын стандарт: туршилт, шинжилгээ, шалгалт, хэмжилтийн арга, ажлын стандартыг тодорхойлох;
- Дамжуулах стандарт: Нэр томьёо, технологи, нэгж, дараалал гэх мэт

Солонгосын стандартын төрөл


Үндсэн стандарт (A)	Механик инженерчлэл (B)	Цахилгаан ба электрон инженерчлэл (C)	Металл (D)	Уул,Уурхай (E)	Барилга (F)	Бусад хэрэглээ
Хүнсний бүтээгдэхүүн (H)	Байгаль орчин (I)	Амьд бие (J)	Ваар савны үйлдвэрлэл (L)	Хими (M)	Анагаах ухаан (P)	Чанарын менежмент (Q)
Тээврийн хэрэгсэл (R)	Үйлчилгээ (S)	Логистик (T)	Усан онгоц (V)	Сансар судлал (W)	Мэдээлэл (X)	Утас (K)

3.2.1.3.Солонгосын стандартын холбоо (Korean Standards Association)

Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хуулийн (Industrial Standardization Act) 32 дугаар зүйлд 1962 онд Солонгосын стандартын холбоо (Korean Standards Association) байгуулагдсан. Солонгосын стандартын холбоо нь стандарт болон чанарын суурь шалгуурыг тогтоож иргэдэд стандартчиллын чиглэлээр сургалт, мэдээлэл өгөх үүрэгтэй байна. Солонгосын стандартын холбоо нь 5 салбар оффис, 7 хэлтэс 304 гаруй ажилтантай байна.³²⁸

³²⁸ https://www.ksa.or.kr/ksa_english/5176/subview.do

Зураг 10.БНСУ-ын стандартын холбооны бүтэц



Мөн Солонгосын стандартын холбоо нь дотоодын стандартчиллын үндсэн бодлого, чиг хандлагыг судлан гарсан үр дүнг Засгийн газарт бодлогын зөвлөмж хэлбэрээр өргөн барьдаг байна. БНСУ-ын стандартчиллыг цаашид хөгжүүлэх, тулгамдаж буй өнөөгийн асуудал, онол бодлогын чиглэлийг хэлэлцэх форумыг зохион байгуулж, стандартчиллын талаарх эрдэм шинжилгээний болон практик судалгааг зохион байгуулдаг байна. Солонгосын стандартын холбоо нь Худалдаа, үйлдвэр, эрчим хүчний яамны (Ministry of Trade, Industry and Energy) харьяа Солонгосын технологи, стандартын агентлаг (KATS)-ийн боловсруулсан стандартыг хэвлэн нийтэлж, гарын авлага, цахим хуудсаар дамжуулан хэрэглэгчдэд шуурхай хүргэдэг байна.

3.2.2.Эрх зүйн орчин

Дараах хууль тогтоомжууд нь Солонгосын стандартчилал, хэмжилт зүйтэй холбоотой харилцааг зохицуулдаг ба Худалдаа, үйлдвэр, эрчим хүчний яам хариуцан ажилладаг байна.³²⁹

Үндэсний стандартын тухай суурь хууль (Framework Act on National Standards)

Үндэсний стандартын тухай суурь хуулийн зорилго нь үндэсний стандартын тогтолцоог бий болгоход шаардагдах үндсэн шаардлагыг хангахад оршино. Нийт 20 зүйл заалттай ба 1999 оны 02 сард анх батлагдсан бөгөөд хамгийн сүүлд 2019 оны 05 сард нэмэлт, өөрчлөлт орсон байна. Уг хууль дараах үндсэн агуулгатай байна.

- Солонгосын Засгийн газрын яам хооронд стандарттай холбоотой асуудлыг хэлэлцэх, зохицуулах;
- Солонгосын аж үйлдвэрийн стандарт (Korean Industrial Standards), мэдээлэл, харилцаа холбооны стандарт, хэмжилтийн стандарт, техникийн зохицуулалтыг олон улсын стандарттай уялдуулах;

³²⁹ <https://www.moleg.go.kr/index.es?sid=a1>

- Хяналт, /шинжилгээний лаборатори, туршилт/ баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний тогтолцоог бий болгох.

Үйлдвэрийн стандартчиллын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай тогтоол (Enforcement Decree of the Industrial Standardization Act): Энэхүү тогтоол нь Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хуульд заасан болон хуулийн хүрээнд тусгасан харилцааг зохицуулдаг ба хамгийн сүүлд 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Уг тогтоолын хүрээнд стандарттай холбогдох Аж үйлдвэрийн стандартын зөвлөл, зөвлөлийн үйл ажиллагаа, зөвлөлийн хэлэлцэх асуудал, Стандартын бага хурлын бүрэлдэхүүн, үйл ажиллагаа зэрэг стандарттай холбогдох заалтууд орсон байдаг. Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар Аж үйлдвэрийн стандартын зөвлөлийг байгуулдаг (The Industrial Standards Council) ба нэг дарга, хоёр дэд дарга мөн таван зуугаас илүүгүй гишүүнээс бүрдэнэ. Уг зөвлөл нь хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Стандартын бага хурлыг (Operation of Conference on Standards) зохион байгуулдаг байна.

Үйлдвэрлэлийн стандартыг батлах тухай урьдчилсан мэдэгдэл: Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хуулийн дагуу үйлдвэрлэлийн стандартыг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох стандартыг нийтэд зарлах зэрэг үйл ажиллагааг явуулдаг. Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хуулийн 16 дугаар зүйлд Үйлдвэрлэлийн стандартыг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгохоор төлөвлөж байгаа бол 60 хоногт багтаан төлөвлөх, хэрэв хамтын стандартыг үйлдвэрлэлийн стандарт болгон батлах гэж байгаа бол 30-аас илүүгүй хоногийн хугацаанд багтааж болно хэмээн заасан байдаг.³³⁰ Уг хууль дараах үндсэн агуулгатай байна.

- Солонгосын үндэсний стандартыг бий болгох, тэдгээрийг боловсруулах, хянан үзэх, түгээх;
- Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор стандарт, магадлан итгэмжлэлийг бий болгох;
- Уул уурхай, аж үйлдвэрийн томоохон бүтээгдэхүүн, эд анги, материалыг тэдгээрийн нийцтэй байдлыг хангахын тулд шаардлагатай уялдуулах, хялбарчлах.³³¹

Хэмжил зүйн тухай хууль (Measures Act) Энэ хууль нь 1961 онд батлагдсан ба гол зорилго нь хэмжил зүйн шалгуурт нийцсэн хэмжилтийн зохих практикийг хэрэгжүүлэхэд оршино.³³² Уг хууль дараах үндсэн агуулгатай байна.

- Олон улсын нэгжийн системд (international system of units) нийцсэн хууль эрх зүйн хэмжил зүй;
- Бүтээгдэхүүнийг хүргэхээс өмнө үнэн зөв хэмжилтийг баталгаажуулахын тулд хэмжих хэрэгслийн төрлийг батлах, баталгаажуулах;
- Сав баглаа боодол, шошго бүтээгдэхүүнд хамаарах зүйл, зөвшөөрөгдөх алдаа, савласан бүтээгдэхүүний шошгын стандарт.

Дээр дурдсан хуулиудаас гадна стандарт, техникийн зохицуулалтын тодорхой хэсэгт хамаарах хэд хэдэн хуулиуд байдаг. Доорх хүснэгтэд эдгээрийн заримыг жагсаав.

³³⁰ <https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=standatization&x=0&y=0>

³³¹ http://korea.standards-portal.kr/kats_en/OverView/ov_acts/pop_act.html

³³² <http://gwanbo.korea.go.kr/main.jsp>

Стандарт	Холбогдох хууль
Чанарын менежментийн гэрчилгээ	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний менежментийн удирдлага, аюулгүй байдлын хяналтын тухай хууль (Quality Management & Safety Control of Industrial Products Act)
Байгаль орчны менежментийн гэрчилгээ	Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн тухай хууль (Act on the Promotion of the Conversion into Environment-Friendly Industrial Structure)
Мэдээлэл, харилцааны стандарт	Харилцаа холбооны тухай хууль (Framework Act on Telecommunications) Мэдээллийн системийг түгээх, ашиглах тухай хууль (ct on Expansion of Dissemination and Promotion of Utilization of Information System)
Гэрчилгээ, хяналт	Цахилгаан хэрэгслийн аюулгүй байдлын хяналтын тухай хууль (Electrical Appliances Safety Control Act) Далайн бохирдлоос урьдчилан сэргийлэх тухай хууль (Prevention of Marine Pollution Act) Байгаль орчинд ээлтэй технологийн дэвшлийг дэмжих тухай хууль (Development of and Support for Environmental Technology Act) Агаарын чанарыг хамгаалах тухай хууль (Clean Air Conservation Act) Дуу чимээ, чичиргээний хяналтын тухай хуулийн 33 дугаар зүйл (Article 33 of Noise and Vibration Control Act)

3.3.ХБНГУ

Стандартчилал гэж техник технологи болон эдийн засгийн салбарт бараа материал, үйлчилгээний эд анги, боловсруулах технологи, хэмжих нэгж, процесс үйл ажиллагаа, хийц бүтэц болон нэр төрлийг жигдрүүлэн хэм хэмжээнд оруулахыг хэлнэ. Үүний эсрэг нь ондоошил юм.³³³

Стандартчиллын үр дүнд хазайлт багасах учиртай. Зорилго нь оршин буй олон хувилбар хазайлтыг аль болох ойлгомжтой харагдах хэмжээнд цөөлөх явдал юм. Иймээс стандартчилал нь үйлдвэрлэгчийн хувьд шилж сонгох процесс бөгөөд хэрэв олон үйлдвэрлэгч байвал тохируулан зохицуулах процесс байдаг байна. Стандартчилал нь зах зээлийн ил тод байдал болон зардал бууруулахад (үйлдвэрийн зардал, мэдээллийн зардал, шилжүүлгийн зардал, тээврийн зардал, борлуулалтын зардал, солилцооны зардал) нөлөөлдөг байна.

Стандартчилал нь факт баримт, институц байгуулал болон хууль тогтоох засаглалын гэсэн 3 төрөлтэй. Зах зээлийн харилцаанд оролцогч талууд өөрсдөө сайн дураар стандартаа сонгож хэрэглэхийг факт баримтын стандартчилал гэдэг байна. Хэрэв Стандартчиллын олон улсын байгууллага (ISO), Олон улсын Электрон техникийн комисс (IEC), Америкийн үндэсний стандартын хүрээлэн (ANSI), Германы Хэм хэмжээсийн институт (DIN) зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартчиллын байгууллагуудын хүрээнд бол институц байгууллын стандартчилал хэмээн үздэг байна. Хэрэв тодорхой параметр үзүүлэлтийг хуульчилж төр улсын хэмжээнд зохицуулсан бол хууль тогтоох засаглалын стандартчилал гэж ярьдаг байна.

³³³ Стандартчилал-Standardisierung-*германаар* <https://de.wikipedia.org/wiki/Standardisierung>

Германы Хэм хэмжээсийн Институт (DIN)-ийн боловсруулсан Германы Аж үйлдвэрийн хэм хэмжээний стандарт (DIN)-ыг сайн дураар хэрэглэдэг байна³³⁴. Харин түүнийг гэрээ хэлцэл, хууль тогтоомж болон дүрэм журамд тусгасан бол албан журмаар хэрэглэх шаардлага тулгардаг. Мөн түүнийг хариуцлага хүлээлгэх зорилгоор түгээмэл ашигладаг байна. Ерөнхийдөө стандартыг технологийн дүрэм журам хэмээн хүлээн зөвшөөрдөг байна. Стандарт ашигласан байна гэдэг нь сайн туршлагад тооцогддог юм.³³⁵

DIN хэм хэмжээг талууд гэрээ хэлцэлдээ тусгаагүй, мөн хууль тогтоомжийн дагуу үүрэг хүлээгээгүй тохиолдолд шүүхийн маргааныг таслан шийдвэрлэхэд, тухайлбал, хариуцлагын процесст хэрэглэдэг байна. Гологдол барагдуулах эрх зүй болон гэм буруугийн эрх зүй, бүтээгдэхүүний хариуцлагын эрх зүйн салбарт хэм хэмжээс болон боловсруулах технологийн техникийн дүрэм журмыг баримтлан үйлдвэрлэгч нь нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээсийг дагасан эсэх, түүнчлэн тээврийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсан эсэх талаар яллах дүгнэлт гаргадаг байна.³³⁶

Худалдах болон бүтээх гэрээний эрх зүй: Хэм хэмжээ гологдолгүй хийсний хэмжүүр болох нь

Техникийн хэм хэмжээ нь ялангуяа Худалдах болон бүтээх гэрээний эрх зүйн хувьд ач холбогдолтой байдаг байна. Бүтээгдэхүүн гологдолтой эсэхийг тогтоохын тулд шүүгч нь хэм хэмжээг баримталдаг. Ингэхдээ тухайн бүтээгдэхүүнийг хэрхэн хийсэн байх талаар оролцогч бус шинжээчийн дүгнэлтийг үндэслэдэг байна. Шүүх нь DIN хэм хэмжээсийг нийтээр хүлээн зөвшөөрсөн техникийн дүрэм журам гэж үздэг. Хэм хэмжээг баримтлан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн байна гэж үзвэл улмаар шүүх нь бүтээгдэхүүн тээвэрлэлт даахуйцаар хийгдсэн эсэхийг тогтооно.

Хэм хэмжээг баримтлах талаар гэрээнд тусгаагүй ч гэлээ түүнийг баримтлаагүй нь гологдол болоход хүргэх албагүй юм. Тээвэрлэлт даахуйцаар хийхэд хэм хэмжээсийг баримтлахгүй байж болно, тэгээд ч энэ нь сайн дурын юм. Худалдагч буюу үйлдвэрлэгч нь хэм хэмжээс баримтлаагүй ч уг бүтээгдэхүүн тээвэрлэлт даах шаардлагуудыг хангаж буйг гэхдээ өөр байдлаар нотлох шаардлагатай. Энэхүү нотолгоо нь хангалтгүй бол худалдан авагч нь хуулийн дагуу нөхөн олговор авах эрх нь үүснэ. Тэрээр гологдол дутагдлыг арилгуулах, гологдол дутагдалгүй бүтээгдэхүүн нийлүүлэх болон гологдол дутагдлаас шалтгаалан хохирол учирсан бол нөхөн олговор гаргуулах эрхтэй болно.

Хариуцлагын эрх зүй: Буруугийд хэм хэмжээс үнэлгээний хэмжүүр болох нь ба хохирол барагдуулах хариуцлагын эрх зүйн нэмэлт тооцоо

Гэрээний бус эд хөрөнгийн буюу хүний биеийн хохирлын хариуцлагын хувьд ялангуяа Бүтээгдэхүүний хариуцлагын хууль болон Гэм буруугийн ерөнхий эрх зүй нь маш их ач холбогдолтой юм. Шүүгч нь хэм хэмжээсийн тусламжтайгаар бүтээгдэхүүн алдаатай эсэх, эсвэл үйлдвэрлэгч хохирлыг барагдуулах эсэх талаар шийдвэр гаргадаг байна.

- **Бүтээгдэхүүний хариуцлагын хууль - Буруугийд үл хамаарах хариуцлага:** Хэрэв бүтээгдэхүүн алдаатай байгаад түүнээс шалтгаалан хүний бие болон эд хөрөнгөд хохирол учирсан бол уг бүтээгдэхүүний үйлдвэрлэгч нь хуулийн дагуу хохирлын нөхөн олговрын хариуцлага хүлээж,

³³⁴ DIN Хэм хэмжээс-DIN-Norm-*германаар* <https://de.wikipedia.org/wiki/DIN-Norm>

³³⁵ Стандарт ба хууль-Standards and the Law-*англиар* <https://www.din.de/en/about-standards/standards-and-the-law>

³³⁶ Хэм хэмжээг баримтлан эрх зүйн хариуцлага хүлээлгэх-Rechtsverbindlichkeit durch Normen-*германаар* <https://www.din.de/de/ueber-normen-und-standards/normen-und-recht/rechtsverbindlichkeit-durch-normen>

учирсан хохирлыг барагдуулна. Энэхүү гэрээний бус хариуцлагыг уг бүтээгдэхүүнийг хэрэглэсний улмаас хохирол амссан хэний ч эсрэг хүлээнэ. Бүтээгдэхүүний хариуцлагын үед уг бүтээгдэхүүний алдааг тогтооход баримталсан техникийн хэм хэмжээс нь дутуу үнэлэхийн аргагүй үүрэг рольтой юм.

- **Гэм буруугийн эрх зүй - Буруугүйд хамаарах хариуцлага:** Хэрэв үйлдвэрлэгч буруугүй бөгөөд хайнга хандсан ялаас хэлтрүүлэх нотолгоо гаргаж чадахгүй бол алдаатай бүтээгдэхүүний улмаас хүний бие буюу эд хөрөнгөд хохирол учирсан үед тэрээр гэм буруугийн эрх зүйн хүрээнд хариуцлага хүлээнэ. Үйлдвэрлэгч нь хэм хэмжээсийг баримталснаар нийтээр хүлээн зөвшөөрсөн техникийн дүрэм журмыг дагасан гэдгээ нотолсон тул шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхэд түүнд ийнхүү шийдвэрлэх давуу байдал олгодог байна. Нотлох баримтын үндсэн зарчмын дагуу шүүгч, үйлдвэрлэх явцад нягт нямбай ажилласан байх бөгөөд хайнга хандсаны улмаас нягт нямбай ажиллагааг зөрчин гэм буруутайд тооцох үндэслэлгүй хэмээн үзэх болно.

DIN хэм хэмжээс буюу стандарт нь сурах бичиг биш юм. Мэргэжлийн хүмүүсийн хэрэглээ бөгөөд хэрэглэгч нь өөрийн үйл ажиллагаандаа хүлээх үүрэг хариуцлагын хэрээр мэргэжлийн түвшинд ойлгосон байвал зохино.

3.4. ЯПОН УЛС

3.4.1. Бүтэц, зохион байгуулалт

Японы Стандартчиллын нийгэмлэг³³⁷ (JSA GROUP)

Японы Стандартчиллын нийгэмлэг³³⁸ (JSA) нь анх 1945 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Худалдаа аж үйлдвэрийн сайдын тушаалаар байгуулагдсан. 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Японы Стандартчиллын нийгэмлэг-Солюшн ХХК³³⁹ (JSA-SOL) болон Японы мэргэжлийн гэрчилгээ олгох нийгэмлэг³⁴⁰(JRCA)-ийг шинээр байгуулж, тодорхой хугацааны бэлтгэл хийсний дараа 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дээрх гурван байгууллага Японы Стандартчиллын нийгэмлэг групп нэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Японы Стандартчиллын нийгэмлэг нь Стандартчилал, менежментийн технологийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх, улмаар нийгэм эдийн засгийн хөгжил, ард иргэдийн амьдралыг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилтыг хэрэгжүүлдэг байна. Түүнчлэн, стандартчилал, чанарын удирдлагатай холбоотой зөвлөгөө өгөхөөс эхлээд стандарт боловсруулах, стандартыг ашиглахад дэмжлэг үзүүлэх, байгууллага, ажилтнуудыг баталгаажуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Стандартыг хамрах хүрээ болон агуулгаар нь хоёр ангилна.

Хамрах хүрээний хувьд:

- Олон улсын стандартууд: Дэлхийн улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг стандартууд (ISO стандарт, IEC стандарт гэх мэт);

³³⁷ <https://webdesk.jsa.or.jp/common/W10K0400/>

³³⁸ <https://www.jsa.or.jp/>

³³⁹ <https://shinsaweb.jsa.or.jp/>

³⁴⁰ <https://www.jrca-isa.or.jp/>

- Бүс нутгийн стандартууд: Тодорхой бүс нутгийн улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг стандартууд (EN стандарт гэх мэт);
- Үндэсний стандарт: Тухайн улс оронд голчлон ашигладаг стандартууд (JIS гэх мэт);
- Байгууллагын стандартууд: Нэг салбар, эсхүл нэг компанид хэрэглэгддэг стандартууд (салбарын стандарт, компанийн стандарт гэх мэт).

Стандартыг агуулгын дагуу ангилах:

- Үндсэн стандартууд: Нэр томъёо, тэмдэг, нэгж зэрэг үндсэн асуудлуудыг тодорхойлсон стандартууд.
- Аргын стандарт: Туршилт, дүн шинжилгээ, үзлэг, хэмжилтийн арга, ажлын арга гэх мэтийг заасан стандартууд.
- Бүтээгдэхүүний стандарт: Бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, материал, орц, чанар, гүйцэтгэл, эдэлгээ, аюулгүй байдал, үйл ажиллагаа гэх мэтийг тодорхойлсон стандартууд.
- Удирдлагын тогтолцооны стандарт: Байгууллагад бодлого, зорилго тавьж, түүндээ хүрэх тогтолцоог тодорхойлсон стандарт юм. Байгууллагын удирдлагыг тасралтгүй сайжруулах зорилгоор PDCA (дээд удирдлагын бодлогод үндэслэн төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх гарын авлагыг бий болгож ажиллуулах, шалгаж, дүгнэх).

Японы Стандартчиллын нийгэмлэг (JSA) нь Японы аж үйлдвэрийн стандарт JIS-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгад үндэслэн Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны стандартчиллыг дэмжих тогтолцоог бэхжүүлэх зорилгоор магадлан итгэмжлэлийн хувийн байгууллага болохыг зорьж байна. Үүний зэрэгцээ стандартчиллын үйл ажиллагааг даяаршуулахын тулд стандарт боловсруулах болон гэрчилгээжүүлэлтийн чиг үүргийг салгасан тогтолцоог бий болгох талаар ажиллан, үүний үр дүнд 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдөр тус нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн хурлаар групп байгуулах төлөвлөгөөг баталж, дараах тогтолцоог бий болгосон.³⁴¹

	Японы стандартын холбоо (JSA)	Японы Стандартчиллын нийгэмлэг-Солюшн ХХК (JSA-SOL)	Японы мэргэжлийн гэрчилгээ олгох нийгэмлэг (JRCA)
Байгуулагдсан огноо	1945.12.06-ны өдрийн Худалдаа аж үйлдвэрийн сайдын тушаалаар	2018.10.01	2018.10.01
Үйл ажиллагааны чиглэл	Стандарт боловсруулах газар, Стандартчиллыг сурталчлах газар (Гэхдээ стандарт, ном, нийтлэл хэвлэх, семинар зохион байгуулах, чанарын хяналтын шалгалтыг хариуцах этгээд нь Японы Стандартчиллын нийгэмлэг хэвээр байх болно.)	Борлуулалтын алба, Хэвлэлийн мэдээллийн алба, Сургалтын алба, Байгууллагын баталгаажуулалтын алба (Гэхдээ стандарт, ном, нийтлэл хэвлэх, семинар зохион байгуулах, чанарын хяналтын шалгалтыг хариуцах этгээд нь Японы Стандартчиллын нийгэмлэг хэвээр байх болно.)	Боловсон хүчний гэрчилгээ олгох хэлтэс

³⁴¹ <https://webdesk.jisa.or.jp/common/W10K0400/>

3.4.2. Эрх зүйн орчин

Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хууль³⁴² (Industrial Standardization Act)

Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хууль нь 1949 онд батлагдсан бөгөөд энэ нь Японы аж үйлдвэрийн стандартын эрх зүйн үндсийг бүрдүүлдэг. Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хуулийг 2004 онд шинэчлэн найруулж, JIS бүтээгдэхүүний баталгаажуулалтын тэмдгийг өөрчилсөн.

2008 оны 10 дугаар сарын 01-ээс хойш үйлдвэрлэсэн JIS-ийн гэрчилгээтэй Японы бүх бүтээгдэхүүн шинэ JIS тэмдэгтэй болсон.

1949 оны 185 дугаар Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хууль нь үйлдвэрлэлийн зохистой, оновчтой стандартыг бий болгож, түгээн дэлгэрүүлэх, олон улсын стандартыг бий болгох, уул уурхай, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар зэрэгт хамтран ажиллах замаар үйлдвэрлэлийн стандартчиллыг дэмжиж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийг оновчтой болгох, ажил гүйлгээг хялбарчлах, хэрэглээ буюу хэрэглээг оновчтой болгох замаар нийтийн сайн сайхны төлөө "үйлдвэрлэлийн стандартчилал"-ыг улсын хэмжээнд нэгтгэх буюу хялбарчлах зорилт зорилготой. Тус хуулийн хамрах хүрээ нь:

- Уул уурхай, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн (эмийн бүтээгдэхүүн, пестицид, химийн бордоо, торгоны утас, хөдөө аж ахуй, ойн аж ахуйн хангамж.Тэдгээрийн төрөл, загвар, хэлбэр, хэмжээ, бүтэц, тоног төхөөрөмж, чанар, зэрэг, найрлага, гүйцэтгэл, эдэлгээ, аюулгүй байдал;
- Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн арга, дизайны арга, зураг зурах арга, ашиглалтын арга буюу үндсэн нэгж, эсхүл үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотой ажлын арга, аюулгүй байдлын нөхцөл;
- Үйлдвэрийн бүтээгдэхүүний сав баглаа боодлын төрөл, загвар, хэлбэр, хэмжээ, бүтэц, гүйцэтгэл, зэрэглэл, савлах арга;
- Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний туршилт, дүн шинжилгээ, үнэлгээ, шалгалт, баталгаажуулалт эсвэл хэмжилтийн арга.

Хөдөө аж ахуйн стандартын тухай хууль³⁴³ (Agricultural Standards Act)

Энэ хууль нь 1950 онд батлагдсан бөгөөд хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуйн салбарт зохих, үндэслэлтэй стандартыг баталж, зохих гэрчилгээ, туршилтын хэрэгжилтийг хангах, хүнс, ундаанаас бусад хөдөө аж ахуй, ойн гаралтай бүтээгдэхүүнийг зохих ёсоор чанарын дагуу шошголохтой холбоотой харилцааг зохицуулдаг. Хуулийн зорилго нь хөдөө аж ахуй, ойн аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйлдвэрлэл, борлуулалт болон бусад зохицуулалтыг оновчтой болгох, урагшлуулах, хөдөө аж ахуй, ойн аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой гүйлгээг хөнгөвчлөх, хэрэглэгчдэд оновчтой сонголт хийх боломжийг өргөжүүлэх, ингэснээр хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурыг хөгжүүлэх, холбогдох салбаруудыг зөв хөгжүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг болно.

³⁴² <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=324AC0000000185>

³⁴³ https://elaws.e-gov.go.jp/document?lawid=325AC0000000175_20220525_504AC0000000049

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Consumers and Standards: Partnership for a Better World, ISO, https://www.iso.org/sites/ConsumersStandards/1_standards.html
- Good Standardization Practices, ISO, 2019, <https://www.iso.org/publication/PUB100440.html>
- Худалдаан дахь техникийн саад тоггорын тухай хэлэлцээр, <https://legalinfo.mn/mn/detail/10681>
- Стандартууд эдийн засагт хэрхэн нөлөөлдөг вэ? Стандарт, хэмжилзүй сэтгүүлийн 2020 оны 2-р улирлын дугаар, https://issuu.com/informationmasm/docs/standart__1_

МОНГОЛ УЛС

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, 2017.12.21
- Хэмжил зүйн тухай хууль, 2019.05.09
- Үндэсний чанарын хөтөлбөр батлах тухай, Монгол Улсын засгийн газрын 2016 оны 344-р тогтоол
- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/251 тоот тушаал
- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/230 тоот тушаал
- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/74 тоот тушаал
- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/233 тоот тушаал
- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/228 тоот тушаал
- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/231 тоот тушаал
- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2017 оны А/129 тоот тушаал

АНУ

- U.S. Department of Commerce. International Trade Administration. June 2016. *Standards and Regulations: Measuring the Link to Goods Trade*. Washington, D.C. https://legacy.trade.gov/td/osip/documents/osip_standards_trade_full_paper.pdf
- Written Testimony of the American National Standards Institute before the United States House of Representatives Committee on Science, Space, and Technology Research and Technology Subcommittee, Hearing: “Setting the Standards: Strengthening U.S. Leadership in Technical Standards” March 17, 2022
- American National Standards Institute, <https://www.ansi.org/>
- The National Institute of Standards and Technology, <https://www.nist.gov/about-nist>
- The ANSI National Accreditation Board, <https://anab.ansi.org/>
- National Technology and Advancement Act of 1995, <https://www.congress.gov/bill/104th-congress/house-bill/2196>
- The United States Standards Strategy, <https://www.ansi.org/resource-center/publications-subscriptions/usss>

БНСУ

- Солонгосын Технологи, Стандартын Агентлаг www.kats.go.kr
- Стандарт Боловсруулах Хамтын Ажиллагааны Байгууллага www.kpetro.or.kr
- Солонгосын Стандартчлалын Холбоо www.ksa.or.kr
- Үйлдвэрийн Стандартчиллын Тухай Хууль <https://Law.Go.Kr/Lsw/Eng/Englssc.Do?Menuid=2&Section=Lawnm&Query=Standatization&X=0&Y=0>
- https://www.standardsportal.org/usa_kr/e/resources/standards_laws.aspx

ЯПОН УЛС

- <https://webdesk.jsa.or.jp/common/W10K0400/>
- <https://www.jsa.or.jp/>
- <https://shinsaweb.jsa.or.jp/>
- <https://www.jrca-isa.or.jp/>



**СПОРТЫН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D),
О.Билгүүтэй, Б.Баянмөнх*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

БНСУ

Олон улсын тэмцээн зохион байгуулсан туршлага

БНСУ-ын спортын бодлого, бүтэц тогтолцоо

Спортын товчоо (Sports Bureau)

БНСУ-ын спортыг дэмжих сан (Korean Sports Promotion Foundation)

- *Хөрөнгө босгох ба сангийн менежмент:*
- *Спортын байгууллага, аж ахуйн нэгжүүдийг санхүүжүүлэх:*
- *Спортын үйлдвэрлэлийг дэмжих:*

Спортын бодлого ба спортын судалгаа:

- *Сөүлийн олимпийн өв:*

ХБНГУ

Зах зээл ба төрийн харилцан хүчинд орших спортын санхүүжилт

Их спортын арга хэмжээний үед тосгодоод олгох тэтгэлэг:

Татвар ногдуулалт буюу нийгмийн эрх ашиг

Хураамжийн орлого буюу нуугдмал татаас

Спортыг татварын бодлогоор дэмжих нь

Германы Спортыг Дэмжих Сан

- *Дэмжлэг*
- *Дэмжлэг авах тамирчин*
- *Дэмжлэгийн бодлого*
- *Үндсэн дэмжлэг*
- *Ирээдүйн шилдэг баг (Үндсэн дэмжлэгийн нэмэлт)*
- *Шилдэг баг (Үндсэн дэмжлэгийн нэмэлт)*
- *Зодог тайлсны дараах тэтгэлэг*
- *Санхүүжилт*

Өмнөд Африк

Өмнөд Африкийн спортын салбарын бодлого

Өмнөд Африкийн спортын тогтолцооны бүтэц

Өмнөд Африкийн спортын санхүүжилт

Үндэсний сугалааны итгэлцлийн сан (NLDTF):

Япон Улс

Японы спортын удирдлагын бүтэц

Спортын тухай хууль

Японы спортын зөвлөл түүний бүтэц, спортыг дэмжих сан

Спортыг дэмжих сан

Спортыг дэмжих сугалаа

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Спортын санхүүжилтийн тогтолцооны талаарх гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн Судалгааны албаны Байгаль орчин, хөдөө аж ахуйн хэсэгт гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Гадаадын зарим орнуудын нийтийн биеийн тамир, их спортыг дэмжих сан, тухайн асуудлыг хариуцсан төрийн байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилтийн тогтолцооны талаарх туршлагыг харьцуулан судлахад чиглэгдэнэ.

Хамрах хүрээ:

Судалгаанд ХБНГУ, Өмнөд Солонгос, Өмнөд Африк, Япон зэрэг 4 орны туршлагыг хамруулан спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, төрөөс баримталж буй бодлого, спортыг дэмжих сан, төрийн дэмжлэг, тусламж, татварын орчин зэрэг спортын санхүүжилтийн тогтолцоотой холбоотой асуудлуудыг судлав.

Түлхүүр үг: спортын санхүүжилт, спортыг дэмжих сан, спортын салбарын удирдлага, төрийн бодлого, их спорт, нийтийн биеийн тамир.

Keywords: sport financing, sport funding, sport management, government policy, elite sport, mass sport.



СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Спортын салбарыг хөгжүүлэх, мэргэжлийн болон нийтийн биеийн тамир спортын удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтыг амжилттай хэрэгжүүлэхэд нь санхүүжилтийн тогтолцоо чухал үүрэгтэй. Хязгаарлагдмал нөөцөөр спортын салбарт амжилт гаргахын тулд тухайн салбарыг хариуцсан байгууллагууд, ялангуяа спортын хороо, нийгэмлэгүүд хандивлагчид, дэмжигчид болон орон тооны бус ажилтнуудын хүчийг ашиглах, боломжтой бүх арга замуудаар хөрөнгө, санхүүжилт босгох шаардлагатай тулгардаг. Тиймээс спортын салбарын удирдлага, менежментийн хамгийн чухал асуудал нь спортын санхүүжилт юм. Иймд бүтэц, зохион байгуулалтаас хамаарах санхүүгийн удирдлага бус тодорхой бүтэц, тогтолцоо (тухайлбал, спортын хороо болон спортын холбоод)-оор дамжуулан санхүүжилтийн боломжит эх үүсвэрийг татан төвлөрүүлэх, хуваарилах механизм талаас нь авч үзэх онцлогтой юм.

Спортын хороо болон спортын холбоодын зохион байгуулдаг спортын арга хэмжээний санхүүжилтийн гол эх үүсвэр нь ихэвчлэн гишүүний татвар хураамж, хандив болон төрийн тэтгэлэг болдог байна. Иймээс төрийн спортын тэтгэлэг, түүнийг олгох журам, энэ төрлийн арга хэрэгслүүд нь энэ салбарын удирдлага, зохион байгуулалтанд хүчтэй үр нөлөө үзүүлдэг байна. Спортын санхүүжилтэнд татвар төлөгчийн мөнгөнөөс гадна төрийн зохицуулалт бүхий азын тоглоом (сугалаа)-ны орлогын тодорхой хувийг зарцуулдаг байна. Иймээс спортын асуудал хариуцсан байгууллагын удирдах ажилтнууд зөвхөн төсвийн санхүүжилтэнд найдах биш олон нийтийн спортыг дэмжих хүсэл дээр тулгуурлан бооцоот тэмцээн, спорт лотерей зэргийг ашиглан хөрөнгө санхүүжилт босгох тал дээр түлхүү анхаарч ажилладаг хандлага ажиглагдаж байна.

Өнөө үед спортын арга хэмжээний санхүүжилт босгоход спортын асуудал хариуцсан төрийн байгууллагууд, сан бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулагчид, хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны байгууллагууд, дэмжигч компаниуд, ялангуяа үзэгчдийн оролцоо их байдаг байна.

Спорт, бизнес болон улс төрийн хамтын ажиллагаа нь тийм ч эв найрамдалтай бус байдаг бөгөөд сэтгэл зүйн хувьд “гурвалсан зангилаа” үүсгэж, хэн нь ч дангаараа бүрэн хариуцлага хүлээх боломжгүй байдаг байна.

Спортын эдийн засгийн асуудлыг зөвлөх шинжлэх ухааны төрлөөр хөгжүүлэн, олон улсын сайн туршлагад тулгуурлан практикт хэрэгжих боломжтой санхүүжилтийн загварыг боловсруулах нь зүйтэй байна. Эдгээр загварууд нь татварын болон татварын бус санхүүгийн эх үүсвэрүүдийг хослуулсан байх шаардлагатай. Загварт түүхэн уламжлал, бүс нутгийн онцлог, спортын улс төрийн болон зохион байгуулалтын хамаарал, үр нөлөөг тусгасан байвал зохино.

Спортын салбар дахь төрийн дэмжлэгийн тухайд санхүүжилтийн тогтсон загвар байхгүй ба төрийн дэмжлэгийн төрлүүд нь тухайн тохиолдол бүрд шинэлэг бөгөөд олон янз хэлбэртэй байна. Хураамжийн орлого буюу татаасаар төдийлөн орлого олдоггүй бөгөөд зарим уралдаан тэмцээний хувьд (тухайлбал, гүйлтийн уралдаан) харьцангуй өндөр хувьтай орлого бий болгодог туршлага байна.

Спорт нь олон нийтэд хамааралтай салбар учраас спортын салбарыг дэмжихэд олон нийтийн оролцоо чухал гэдгийг нийгэм хүлээн зөвшөөрсөн байдаг байна.

Судалгаанаас үзэхэд, нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн спортын салбарыг дэмжих зорилгоор улсын төсөвт суулгах байдлаар санхүүжүүлэхээр хуульчилсан байдаг байна.

Төрийн дэмжлэгийн шууд хэлбэр нь улсын төсвийн санхүүжилт болон спортын тэтгэлэг байдаг.

Тухайлбал, нийт спортын санхүүжилтэнд засгийн газрын тэтгэлгийн эзлэх хувь хэмжээ БНСУ-д 2008 онд 47% байсан бол 2022 онд 7% болж буурсан байна. Германы хувьд, 2018 оноос эхлэн спортын санхүүжилтэнд тодорхой хэмжээний засгийн газрын тэтгэлэг олгож эхэлсэн байна. Японы хувьд, 2022 онд спортын санхүүжилтийн 11% нь төсвөөс, үлдсэн 89% нь сугалаанаас орсон байна. Өмнөд Африкт 2018 онд төсвийн санхүүжилт 15%-ийг эзэлж байсан байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагаас үзэхэд, спортын санхүүжилтийн хөрөнгө босгох зорилгоор бооцоот азын тоглоомыг маш өргөн хүрээнд ашигладаг байна. Үүнд: Герман-лотто, БНСУ-тото, Өмнөд Африк-сугалаа, Япон-сугалаа гэх мэт.


Спортын санхүүжилтийн эх үүсвэр нь Орлогын албан татвар (ОАТ) болон Аж ахуйн нэгжийн албан татвар (ААНАТ)-аас бүрддэг. Спортын хороо, холбоод аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй учраас ААН-ийн албан татвараас чөлөөлөгдөнө. Энэхүү татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд түрээс, хүү, лизингийн хүү, лицензийн орлого, ивээн тэтгэлгийн орлого зэрэг орлогын эх үүсвэрүүд хамрагддаг. Түүнчлэн спортын хороо, холбооны үндсэн чиг үүргийн хүрээнд зорилтот үйл ажиллагаа явуулж буй байгууллага, үйлдвэрийн газрууд энэхүү хөнгөлөлтийг мөн эдэлнэ.

Мөн олон улсын спортын арга хэмжээ зохион байгуулах болон олон улсын холбоо дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй улс орны эдийн засагт ач холбогдол бүхий онцгой арга хэмжээ (олимпын наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн г.м)-ний үед орлогын албан татвараас чөлөөлдөг.

Цалин хөлс, хөрөнгийн орлогын албан татварын хувьд спортын салбарт тусгайлан үзүүлдэг хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалт байхгүй байна. Газрын албан татварын хувьд спортын холбооны чиг үүргийг хэрэгжүүлэх зориулалтын бүх төхөөрөмж (талбай) газрын татвараас чөлөөлөгдсөн байдаг байна.

Эдгээр зохицуулалтыг үндэслэн гаргасан төсвийн орлого, зарлагын шинжилгээ, татварын орлогын доод хэмжээг (ялангуяа ААНАТ болон ОАТ-ын) тогтоосон судалгааны мэдээ хараахан алга байна. Гэхдээ төрөөс хэдий хэмжээний тэтгэлэг, нөхөн олговор буюу ивээн тэтгэлэг олгож, зориулалтын дагуу зарцуулж байгаа нь тодорхой байдаг байна. Энэ тал дээр чухам ямар тэтгэлгийг татаас гэж тодорхойлох, нэгдсэн бодлого, удирдамжаар хангах хэрэгцээ шаардлага тулгардаг байна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү)



СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

БНСУ

Сүүлийн жилүүдэд Солонгосын спортын салбар дэлхийн тавцанд өндөр амжилт үзүүлж байгаа ба олон улсын тэмцээн, уралдаануудыг мөн эх нутагтаа амжилттай зохион байгуулсан байна. БНСУ спортыг бодлогоор дэмжиж эрүүл чийрэг хүчирхэг иргэдтэй орон болгох, иргэдийг спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэн эрүүл улсыг цогцлоох алсын хараатай, спортын хүчирхэг гүрэн болохын тулд спортод ээлтэй орчныг бүрдүүлэн ажиллаж байна.

Олон улсын тэмцээн зохион байгуулсан туршлага

1988 оны Сөүлийн зуны олимп: 1988 онд XXIV зуны олимпийн наадам Сөүл хотноо зохион байгуулагджээ. Уг XXIV зуны олимпийн наадамд нийт 160 орны 13304 тамирчид оролцсон ба БНСУ-ын тамирчид 12 алт, 10 мөнгө, 11 хүрэл медаль хүртэж, нийт улсуудаас 4-р байрт жагссан байна.³⁴⁴

2002 оны дэлхийн хөл бөмбөгийн ДАШТ Солонгос/Япон: 2002 онд 31 хоног (05.31-06.30-ны хооронд) зохиогдсон 17 дахь удаагийн хөл бөмбөгийн ДАШТ-ийг Солонгос/Япон хоёр улс хамтран зохион байгуулсан байна. Энэ нь Европ, Америк тивээс гадна зохион байгуулагдсан анхны Дэлхийн цомын тэмцээн байв.

2011 оны хөнгөн атлетикийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн: 2011 оны 08-р сарын 27-ноос 09-р сарын 04-ний хооронд тус улсын гурав дахь том хот болох Дэгү хотод Хөнгөн атлетикийн 13 дахь удаагийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болсон. Орчин үеийн технологийг нэвтрүүлсэн Дэгү хотын “Blue Arc” цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулсан хөнгөн атлетикийн тэмцээнийг дэлхийн өнцөг булан бүрд байгаа хөгжөөн дэмжигчдэд дэвшилтэт технологитой хослуулсан өндөр нягтралтай цахим самбараар шууд дамжуулан үзүүлсэн байна.


2015 оны зуны Универсиад наадам: (2015 Summer Universiade) 2015 оны зуны Универсиад наадам 2015 оны 07-р сарын 03-наас 14-ний хооронд Гванжу хотод болсон ба энэ нь Өмнөд Солонгост зохиогдсон гурав дахь Универсиад наадам юм. Спортын 21 төрлөөр 143 орны 17036 тамирчин оролцсон байна.

Пёнчан 2018 өвлийн олимп: Энэхүү өвлийн олимп нь 2018 оны 02-р сарын 09-нөөс 25-ны хооронд зохиогдсон. Энэхүү олон улсын тэмцээнд 92 орны 2920 тамирчин оролцсон бөгөөд БНСУ-д зохиогдсон хамгийн том тэмцээн болсон байна.

БНСУ-ын спортын бодлого, бүтэц тогтолцоо

Соёл, спортын бодлого түүнтэй холбоотой ажлуудыг Соёл, спорт, аялал жуулчлалын яам (Ministry of Culture, Sport and Tourism MCST) хариуцдаг. Соёл, спорт, аялал жуулчлалын яам нь удирдлагын хувьд дараах бүтэцтэй байна.

³⁴⁴ <https://www.koreanculture.org/korea-information-sports>



Спортын товчоо (Sports Bureau)

Спортын товчоо нь Соёл, спорт, аялал жуулчлалын яамны 2 дугаар дэд сайдын удирдлагад үйл ажиллагаа явуулдаг ба 3 хэлтэстэй.³⁴⁵ Үүнд:

- Спортын бодлогын хэлтэс;
- Спортыг олон нийтэд таниулах сурталчлах хэлтэс;
- Спортын үйлдвэрлэлийн хэлтэс;


Дээрх товчоонд мөн Спортын хамтын ажиллагааны (Sports Cooperation Bureau) тасаг багтдаг. Үүнд:

- Олон улсын спортын хэлтэс;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан спорт;
- Спорт уламжлалын хэлтэс.

2021 оны Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас гаргасан статистик мэдээллээр спорт (урлаг) ба амралт зугаалгатай холбоотой үйлчилгээний бизнест оюуны өмчийн эрхийн худалдааны тэнцэл 2 сая долларын ашигтай ажилласан бол спортын тоног төхөөрөмж, хэрэгслийн худалдааны тэнцэл 2.07 тэрбум долларын алдагдалтай гарсан байна.³⁴⁶

Спорт (урлаг) ба амралт зугаалгатай холбоотой үйлчилгээний бизнест оюуны өмчийн эрхийн импорт/экспорт мөнгөн дүнгээр


Import/Export of Intellectual Property Rights on Service Business related to Sports (Arts) & Recreation



Спортын тоног төхөөрөмжийн импорт/экспорт мөнгөн дүнгээр

³⁴⁵ <https://www.mcst.go.kr/english/about/orgChart.jsp>

³⁴⁶ <https://www.mcst.go.kr/english/statistics/statistics.jsp>



Солонгосын спортыг дэмжих сан (Korean Sports Promotion Foundation)

БНСУ-ын спортын салбар санхүүжилтийн үндсэн хоёр эх үүсвэртэй байдаг ба тэдгээр нь татвар төлөгчдийн мөнгөнөөс бүрддэг Үндэсний сан (National Treasury) болон Солонгосын спортыг дэмжих сан (Korean Sports Promotion Foundation) тус тус байна. Солонгосын спортыг дэмжих сан нь 1988 оны Сөүлийн Олимпын дараа 1989 онд анх байгуулагдсан ба төрийн байгууллага юм.³⁴⁷ Тус сан нь спортын салбарыг хөгжүүлэх, олон улсын спортын ажлын байр бий болгох, ур чадварыг хөгжүүлэх, спортын бодлого, спортын шинжлэх ухааныг судлах, спортын төрөл бүрийн салбарт дэмжлэг үзүүлэх төслүүдийг хэрэгжүүлэн эрүүл Солонгосыг бий болгож, хүн бүр спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэхийн төлөө ажилладаг байна.

Мөн Сөүлийн олимп нь спортын соёлыг хойч үедээ түгээн дэлгэрүүлэх замаар олимпын нэн тэргүүний зорилго болох спортоор дамжуулан хүн төрөлхтний эв найрамдал, зөрчилдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг тогтооход хувь нэмэр оруулах зорилготой байна. Унадаг дугуй, спортын сугалаа (тото), моторт завины уралдаанаас олсон орлогыг тус санд төвлөрүүлж, спортын байгууламж барих, медальтнуудын тэтгэврийн хөтөлбөрийг санхүүжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортыг сурталчлах, спортын шинжлэх ухааны судалгаа хийхэд дэмжлэг үзүүлдэг байна. Улс орон даяар нийт 17 салбартай ба уралдааныг том дэлгэцээр үзэх спортын мөрий тавих боломжтой байна. Хөл бөмбөг, бейсбол, сагсан бөмбөг, волейбол, гольфийг хамарсан спортын төрлүүдээр бооцоо тавих үйлчилгээ үзүүлдэг уг Sports Toto компани нь бизнесийн хэлбэрээр ашиг олдог ба үүнээс Солонгосын спортыг дэмжих сангийн санхүүгийн эх үүсвэрийн дийлэнхийг бүрдүүлдэг. Солонгосын спортыг дэмжих сан нь 1989-2011 оны хооронд ойролцоогоор 3.8 их наяд вон цуглуулсан. Энэ нь ойролцоогоор Солонгосын спортын сангийн нийт төсвийн 80 орчим хувийг эзэлж байна.

Солонгосын спортыг дэмжих сангийн мэдээлснээр 2002 оны хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний цэнгэлдэх хүрээлэнг барихад 190 тэрбум вон тус сангаас зарцуулсан байна.

Солонгосын спортыг дэмжих сан дараах үндсэн чиглэлд үйл ажиллагаагаа явуулдаг.

Хөрөнгө босгох ба сангийн менежмент:

- Засгийн газрын болон тус сангийн өөрөө бий болгосон хөрөнгийг спортын хангамж үйлчилгээний чанарыг сайжруулах, спортыг хүн бүрд хүртээмжтэй түгээхэд ашигладаг.

³⁴⁷ The development of sport policy and management in South Korea, Eunah Hong, 2014

- Спортыг дэмжих сан нь унадаг дугуй ба моторт завины уралдаан, спортын бооцооны (тото) тасалбар зарах замаар сангийн хөрөнгийг нэмэгдүүлдэг.

Спортын байгууллага, аж ахуйн нэгжүүдийг санхүүжүүлэх:

Спортын үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллагуудыг санхүүжүүлдэг. Эдгээр санхүүжилт үндсэндээ дараах зүйлсэд зориулагддаг:

- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан спорт;
- өсвөр насны хүүхдүүдийн спортын авьяасыг хөгжүүлэх;
- спортын салбарын дэд бүтцийг хөгжүүлэх;
- аюулгүй байдал, хяналт шалгалтын үйл ажиллагааг хөгжүүлэх;
- олон улсын спортын тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- үндэсний фитнес 100 хөтөлбөр.

Спортын үйлдвэрлэлийг дэмжих:

- олон нийтийн спорттой холбоотой салбаруудыг хөгжүүлэхэд санхүүгийн хувь нэмэр оруулах;
- мэргэжлийн тамирчдыг хөгжүүлэх, Сөүлийн олон нийтийн чөлөөт цагаа өнгөрүүлэх спортын үзэсгэлэн SPOEX-г санхүүжүүлэх;
- бусад спортын байгууллагуудад буцалтгүй тусламж, зээл олгох замаар дэмжлэг үзүүлдэг.


Спортын бодлого ба спортын судалгаа:

- мэргэжлийн тамирчдад боловсрол олгох;
- спортын шинжлэх ухааны сургалт явуулах;
- спортын бодлогын чиглэлээр судалгаа хийх.

Сөүлийн олимпийн өв:


- Олимпийн цэцэрлэгт хүрээлэн, цэнгэлдэх хүрээлэн, спортын байгууламжууд, Сөүлийн Олимпийн музейг удирдан, үйл ажиллагаа явуулах.

Солонгосын спортыг дэмжих сангийн нийт төвлөрсөн хөрөнгө, жилээр (1 ам.доллар = 1100 вон)



Тайлбар: Нийт Солонгосын спортыг дэмжих сангийн төвлөрсөн дүн нь бооцооны тасалбар, дугуйн уралдаан, моторт завины уралдааны орлогоос гадна сугалаа, гольфийн талбай, хуримтлагдсан хүүгийн орлого багтсан дүн юм.³⁴⁸

Засгийн газраас олгосон санхүүжилт болон Солонгосын спортыг дэмжих сангийн спортод хөрөнгө оруулсан хувь хэмжээ




Спортыг дэмжих сангийн спортын тогоогоос олсон орлогоос 2001-2021 оны хооронд 13.8 тэрбум воныг спортын салбарт зарцуулсан байна. Үүнд:

- тухайн санд нийт 12.7 тэрбум вон;
- зохион байгуулалтын үйл ажиллагаанд 406 сая вон;
- спортын болон соёлын төсөлд 329 сая вон;
- дэлхийн цомын үйл ажиллагаанд 164 сая вон;
- спортын байгууламжийн засвар үйлчилгээнд 150 сая вон тус тус зарцуулсан байна.

Мөн бусад спортын үйл ажиллагааны тасалбараас олсон орлогоос 2011-2021 оны хооронд 269 сая воныг спортын салбарт зарцуулсан байна. Үүнд:

- спортын олон улсын үйл ажиллагаанд 254 сая ам.доллар
- тухайн санд 9.5 сая ам.доллар
- үйл ажиллагаа зохион байгуулах зардалд 6.3 сая ам.доллар тус тус зарцуулсан байна.



³⁴⁸ 2022 KSPO PR Brochure

Мөн дээр дурдсан спортыг дэмжих сангуудаас гадна Самсунг, LG, Хьондай зэрэг бизнесийн том корпорацууд олон арван жилийн турш Солонгосын элит спортын амжилтад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн ба сонирхогчийн болон мэргэжлийн түвшинд олон тооны спортын багийг эзэмших, зарим салбарын үндэсний багийг ивээн тэтгэх зэрэг дэмжлэгээр Солонгосын спортын санхүүгийн тал дээр хувь нэмрээ оруулсан байна.

ХБНГУ

Аливаа удирдлагын процессыг гүйцэтгэхэд тодорхой хөтөлбөр, стратеги төлөвлөлт, үзэл баримтлалтай байх нь маш чухал утгвар нөхцөл болдог байна.³⁴⁹ Спортын салбарын удирдлага төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлэх үндэс нь санхүүжилт бөгөөд түүнээс гадна ялангуяа спортын хороо, нийгэмлэгүүдийн хувьд орон тооны бус ажилтнуудын хүчээр ажлаа явуулах шаардлага тулгардаг байна. Тиймээс спортын салбар дахь удирдлагын хамгийн гол, салшгүй сэдэв бол спортын санхүүжилт юм. Ингэхдээ бүтэц зохион байгуулалтаас хамаарах санхүүгийн удирдлага бус харин спортын хороо болон спортын холбоодын санхүүжилтийн боломжит эх үүсвэр, түүний хуваарилалтын механизмын өнцгөөс авч үзэх онцлогтой юм. Иймээс юуны өмнө холбооны улсын янз бүрийн түвшин, түүнчлэн холбооны улс, муж улс болон тосгодын хооронд, спортын холбоодын хооронд, мөн спортын хороо болон спортын холбоодын хооронд спортыг зохион байгуулах санхүүгийн хэрэгслийн эх сурвалж болон хэрэгслийг оноох үндсэн арга аргачлалыг тойрсон асуудал юм.

Спортын хороо болон спортын холбоодын зохион байгуулдаг спортын арга хэмжээний хувьд ихэвчлэн гишүүний татвар хураамж болон хандив, ялангуяа төрийн тэтгэлэг нь санхүүжилтийн гол эх үүсвэр болдог байна. Иймээс төрийн спортын тэтгэлгийн журам, арга хэрэгсэл нь энэ салбарын удирдлагын агуулгад маш хүчтэй үр нөлөө үзүүлдэг байна. Спортын байгууллагуудад ийм замаар татвар төлөгчийн мөнгөнөөс гадна төрийн зохицуулалт бүхий азын тоглоомын орлогын тодорхой хувь оногдох тул спортын салбарын удирдах ажилтан нь спортын улс төрийн үндсэн зарчмын талаар мэдээлэл мэдлэгтэй байвал зохино.

Спортын салбарын удирдлага нь спортын хороо, спортын холбоо, түүнчлэн мэргэжлийн багийн спортын хөрөнгийн компанийн ерөнхий санхүүжилтийн загварыг баримжаалан шийдвэрлэх боломж байвч спортын байгууллагын онцлог, нөхцөл байдалд тохируулан тусгайлан, бие даан шийдвэр гаргавал зохино.

Зах зээл ба төрийн харилцан хүчинд орших спортын санхүүжилт

ХБНГУ-ын спортын салбар нь 2009 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д 1.5% эзэлж байна.³⁵⁰ Спорт нь нийгмийн салбар мөн бөгөөд улсын төсвийн зарлага талд суудаг, эдийн засгийн бусад салбартай адилгүй татварын таатай орчинтой, заримдаа олон нийтийн дэмжлэг (төсвийн санхүүжилт) авдаг салбар юм. Спорт нь санхүүжилтийн талаараа чөлөөт зах зээлийн үйлчилгээ болон татварын тогтолцооны зохицуулалт бүхий үйлчилгээний салбарын хооронд оршино. Биеийн чадвар, чадавхын үзүүлэлтээр амжилт гаргадаг талаараа спорт нь соёлын өв юм. Байгууллага гэдэг утгаараа спорт нь

³⁴⁹ Спорт дахь санхүүжилт-Спортын төрийн дэмжлэг-Staatliche Sportförderung – Finanzierung im Sport-германаар <https://www.degruyter.com/document/doi/10.1524/9783486717525.143/pdf>

³⁵⁰ Зах зээл ба төрийн харилцан хүчинд орших спортын санхүүжилт, Хамбургийн Их сургуулийн хэвлэн нийтлэл, 2009-Sportfinanzierung – Spannungen zwischen Markt und Staat, Hamburg University Press, 2009-германаар

<https://library.oapen.org/bitstream/handle/20.500.12657/27635/1002370.pdf>

өөрийн удирдлага болон орон тооны бус алба юм. Олон улсын түвшинд спорт нь улс үндэстнийг төлөөлөх илэрхийлэл болдог байна. Түүнчлэн спорт нь нийтийн биеийн тамир гэдэг утгаараа зугаа цэнгэлд хамаарна.

Их спортын арга хэмжээний үед тосгодод олгох тэтгэлэг:

Амьдрал дээр бид өдгөө нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага (спортын холбоо), ашгийн төлөөх бялдаржуулах төв болон том, бага олон янзын спортын арга хэмжээнээс спортыг харж болно. Спортын арга хэмжээг оролцогч талууд болох зохион байгуулагч, улсын төсвийн санхүүжилт, медиа (хэвлэл мэдээлэл, өргөн нийтлэл), аж ахуй эрхлэгч (компани) болон ялангуяа үзэгчийн оролцоогүй хийх боломжгүй болсон байна.

Спорт, бизнес болон улс төрийн хамтын ажиллагаа нь тийм ч эв найрамдалтай бус байдаг бөгөөд сэтгэл зүйн хувьд “гурвалсан зангилаа”³⁵¹ үүсгэж, хэн нь ч дангаараа бүрэн хариуцлага хүлээх боломжгүй байдаг байна.

Засаг захиргааны анхан шатны түвшинд (тосгон) спортын арга хэмжээг зохион байгуулагч нь сургуулийн спортоос бусад бүх тохиолдолд хот өөрөө биш байдаг байна. Ялангуяа медиад үр нөлөө бүхий спортын арга хэмжээг зохион байгуулагч нь хэрэв нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага (спортын хороо, холбоо) энэхүү үүргийг хүлээн авсан бол хувийн хэвшлийн аж ахуйн нэгж (ААН) ихэвчлэн зохион байгуулдаг буюу ААН өргөн хүрээнд ивээн тэтгэгчээр орж ирсэн байдаг байна.

Нөхцөл байдлын ярвигтай нарийн шинж байдал, боломжийн талаар дараах зурагт үзүүлэв.

Зураг №1. Тосгоны тусламжийн бүдүүвч

Тосгоны зардлууд

- шууд тэтгэлэг;
- шууд бус тэтгэлэг (жишээ нь муж улсын спортын холбоо, спорт лотто г.м.);
- дэд бүтэц (спортын ордон, автомашины зогсоол г.м.);
- ерөнхий зохион байгуулалтын үйлчилгээ (цагдаа г.м.);
- тусгай зохион байгуулалтын үйлчилгээ (хаалт хашилт г.м.);
- харилцаа холбоо (олон нийтийг мэдээллээр хангах);
- зөвлөх ба зохицуулах үйлчилгээ;
- татварын хорогдол (хандив, тусламж).

Тосгон нь нөгөөтэйгүүр бэлэн мөнгөний үйл ажиллагаа явуулж орлого олох боломжийг төлбөр хураамжийн журамд тусгасан байдаг байна. Томоохон орлогын жагсаалтыг дараах зурагт үзүүлэв.

Зураг №2. Спортын үйл ажиллагаанаас тосгоны олох ашиг тусын талаарх чанарын бүдүүвч

Тосгоны орлого ба ашиг

- төлбөр хураамж;
- шууд татвар (жишээ нь цалин хөлсний татвар);
- шууд бус татвар (жишээ нь тасалбар борлуулах);
- зар сурталчилгаа, имиж (дүр төрх) бүрдүүлэх;
- имиж болон бүрэн эрхийн үр шимийг дамжуулах;
- болзошгүй үйлчилгээ болон дэд бүтэц;
- гадаад тэтгэлгийн хэрэгсэл.

³⁵¹ triple-bind-situation-англиар

Боломж олгох үүднээс ААН, компаниудыг ихээхэн тэтгэлгээр дэмжих буюу төлбөр хураамжаас чөлөөлөх нь өрсөлдөх чадварыг хохироох сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй байдаг байна.

Арга хэмжээг зохион байгуулахад төрийн талын оролцоонд сайтар дүн шинжилгээ хийж, өөрийн ашиг сонирхлыг тодорхой болгосны үндсэн дээр зохион байгуулагч болон ивээн тэтгэгчийн эсрэг итгэл дүүрэн илэрхийлбэл зохино. Хотын байршлын маркетингийн асуудлыг өдгөө ирээдүйн төлөвлөлтийн хэмжээнд хүлээн зөвшөөрөөд байгаа билээ.

Спортын эдийн засгийг зөвлөх шинжлэх ухааны төрлөөр хөгжүүлэн төрөл бүрийн олон арга хэмжээний туршлагыг үндэслэн практикт чиглэсэн загвар боловсруулах нь зүйтэй байна. Загвар нь татварын болон татварын бус санхүүгийн олон төрлийн ээдрээтэй үйл ажиллагааг зохицуулах чадвартай, тодорхой илэрхийлсэн байвал зохино. Зардал-Ашгийн-Дүн шинжилгээ дангаар хангалтгүй.

Загварт түүхэн, бүс нутгийн онцлог, спортын улс төрийн болон зохион байгуулалтын тусгай үр нөлөөг тусгасан байвал зохино. Гэхдээ энэ нь нутгийн удирдлагын улс төрийн шийдвэрийг орлохгүй бөгөөд харин шийдвэр гаргах процессыг ил тод болгож байгаа явдал юм.

Татвар ногдуулалт буюу нийгмийн эрх ашиг

Спорт нь нийтийн ашиг сонирхолд нийцсэн байх, гишүүдийн төлбөр хураамж болон хөрөнгийн удирдлагын хүрээнд явагддаг байна. Харин бизнесийн үйл ажиллагааны хүрээнд спорт нь ААН-үүдтэй “дампинг үнэ”-ээр өрсөлдөж болохгүй бөгөөд бизнесийн үйл ажиллагааны зарчмыг баримтлан татварын эрх зүйн харьцангуй зохицуулалтыг хэрэгжүүлбэл зохино.

Хураамжийн орлого буюу нуугдмал татаас

Спортын салбар дахь төрийн тусламж дэмжлэгийн төрлийн хүрээнд тогтсон загвар, саналын жагсаалт байхгүй бөгөөд үндэсний болон олон улсын хэмжээнд ч тэр бүр харьцуулсан арга хэрэгсэл, зөвлөмж болгох арга хэмжээний жагсаалт гэж байхгүй байна. Иймээс спортын салбар дахь төрийн дэмжлэгийн төрөл нь тохиолдол бүрд шинэлэг бөгөөд олон янз хэлбэртэй байна. Аливаа арга хэмжээ дэмжлэг авах эсэхийг тодорхойлох үзүүлэлт ч гэж бас байхгүй байна.

Хураамжийн орлого буюу татаасаар ихэнх зохион байгуулагч олигтой орлого олдоггүй боловч гүйлтийн уралдааны хувьд харин эерэг үр дүн харагддаг байна. Жишээ нь, Лондонгийн марафон зохион байгуулагч болох нийгэмд үйлчилдэг байгууллага нь оролцогчдын сайн санааны акцын үр дүнд 20 сая фунтын (30 сая евро) орлого олдог бол Нью-Йорк-сити болон Чикагогийн марафон зохион байгуулагчид 5 сая ам.доллар олдог байна.

Спортыг татварын бодлогоор дэмжих нь

Спорт нь олон нийтийн чиг үүрэгт хамаарна. Спортын дэмжлэг нь мөн адил олон нийтийн чиг үүрэгт хамаарах болсныг нийгэм хүлээн зөвшөөрсөн байдаг байна. Нэгдүгээрт, спорт нь эв нэгдлийн үр нөлөө үзүүлдэг. Үүний жишээ нь гадаад болон хөгжлийн бэрхшээлтэй (биеийн болон оюун ухааны хомсдол) тамирчдын оролцооноос харж болно. Хоёрдугаарт, спортод залуу хүн хүмүүс хоорондын харилцаа, нийгэмд биеэ авч явах болон бусдыг халамжлах тал дээр суралцаж, нийгмийн бүрэлдэхүүн хэсэг болж байдаг байна. Гуравдугаарт, төрийн хувьд спорт нь төлөөлөх, улс үндэстний нэр хүндийг өргөх,

таниулахад маш их ач холбогдолтой. Жишээ нь: Их спортын арга хэмжээ зохион байгуулах нь гадагшаа улс орны нэр төрийг гаргаж, төлөөлөхөд маш чухал үр нөлөө үзүүлдэг байна.

Гэвч дэмжиж боломгүй, осол гэмтэл их гардаг спортын төрлүүд бас бий. Тухайлбал, цанын спорт. Иймэрхүү өөр олон спортын төрлөөс болоод спортыг төрөөс дэмжих эсэх, нийтийн ашиг сонирхолд нийцэх эсэх талаар маргаан дэгдэж байсан тохиолдол бий. 1980-аад онд нийтийн ашиг сонирхлын эрх зүйн байдлыг шинэчлэн тогтоох зорилгоор комисс байгуулагдаж, нийтийн ашиг сонирхолд нийцсэн (нийгэмд ашиг тустай) үйл ажиллагаа (ажилбар)-ны каталог (жагсаалт)-оос спортыг бүхэлд нь хасах тухай санал гаргаж байсан байдаг. Харин ч улс төрчид эсрэгээр нь жагсаалтыг улам өргөжүүлэн тэлсэн байдаг байна. Нийгэмд ашиг тустай үйл ажиллагаанд амьтан тэжээхээс авахуулаад ургамал тарих, ногооны жижиг тариалалт, уламжлалт зан үйл, багт наадам, сонирхогчийн радио холбоо, нисэх загвар болон нохойн спорт хүртэл багтдаг байна.

Спортын дэмжлэгийг нийтийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор улсын төсөвт суулгах байдлаар хуульчилсан байдаг байна. Төрийн дэмжлэгийн шууд хэлбэр нь холбооны улс, муж улс болон тосгоны түвшинд улсын төсөвт суулгасан тэтгэлэг юм.

Дараах хэлбэр нь муж улсын төсөвт орлого байдалтай тусдаг лотто болон тотоны орлого буюу зорилтот орлого юм. Спортын бооцооны ирээдүйн зохицуулалт тодорхой бус байгаа тул спортыг санхүүжүүлэх болон бусад нийтийн ашиг сонирхлын чиг үүргийг хангахад ашиглах талаар эцэслэн дүгнэлт хийх хараахан боломжгүй байна. Үндсэн хуулийн цэцээс төрийн бооцооны монополын талаар гаргасан шийдвэрийн дагуу бооцоот тоглоомыг сурталчлахыг хориглох бөгөөд төрийн монополын зорилго нь тоглоомонд донтох явдлыг бууруулахад оршиж байна. Хувийн хэвшлийн бооцооны үйлчилгээ үзүүлэгч нь төрийн лоттоны нийгэмлэгийн адил татвар төлөхгүй, мөн төрд зорилтот орлого оруулах үүрэг хүлээхгүй боловч зар сурталчилгаа явуулахыг хориглодог байна. Төр нь лоттоны орлогыг спортын дэмжлэг, хөшөө дурсгал сэргээн засварлах, байгаль орчин хамгаалах буюу бусад соёлын зорилгоор дамжуулан шилжүүлдэг байна. Харин хэрхэн зарцуулах нь муж улс тус бүрээр өөр өөр байдаг байна. Жишээ нь Райнланд-Пфалц муж улсад жилд ойролцоогоор 250 сая евро лоттоны орлого мужийн төсөвт ордог нь ДНБ-ний 5% орчим юм. Холбооны улсын хэмжээнд авч үзвэл, сугалааны орлогыг оруулан 4-5 тэрбум евро орлого ордог байна.

Спортын санхүүжилт юуны өмнө орлогын албан татвар (ОАТ) болон аж ахуйн нэгжийн албан татвар (ААНАТ)-ын эрх зүйд хэрэгждэг байна. Спортын хороо, холбоод аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй бол ААН-ийн албан татвараас чөлөөлөгдөхөөр Татвар ногдуулах журамд заасан байна. Энэхүү татварын чөлөөлөлт нь түрээс, хүү, лизингийн хүү, лицензийн орлого, ивээн тэтгэлгийн тодорхой орлого зэрэг хөрөнгийн удирдлагын орлогын өргөн хүрээг хамардаг байна. Дээрх чөлөөлөлтийг 30 678 евро орлогын хязгаар даваагүй ААН мөн эдэлнэ.

Түүнээс гадна спортын хороо, холбооны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллагын зорилтот үйлдвэрийн газрын хувьд 30 678 евро орлогын хязгаарыг давсан орлоготой боловч энэхүү хөнгөлөлтийг эдлүүлэхээр нэмэлт журамд тусгасан байна.

ААНАТ-тай адилаар тэтгэлэг хэмээн нэрлэгддэг хандивын хувьд ОАТ-ын чөлөөлөлт мөн байдаг байна. Нийт орлогын 5% буюу борлуулалтын орлого болон цалингийн сангийн

2‰³⁵² хүртэл хэмжээний орлогын дүнтэй тэнцэх хэмжээний тусгай зарлагыг байгууллагын зардалд суулгаж болно.

Харин спортын холбооны гишүүнчлэлийн татварыг (хураамжийг) тэтгэлгийн зохицуулалтанд хамруулдаггүй байна. Мөн их хэмжээний хандивын зохицуулалт ч гишүүний хураамжийг тооцдоггүй байна. Иймд гишүүний хураамжинд ОАТ ногдуулна.

Хэдэн жилийн өмнөөс нийгэмд үйлчилдэг санг дэмжих зорилгоор ОАТ-ын тусгай зохицуулалтыг нэвтрүүлсэн. Уг зохицуулалтын дагуу спортын сан нь 10 жилийн туршид жил тутам 51 150 евро ОАТ төлж болно.

Түүнчлэн дасгалжуулагчийн нөхөн олговор хэмээх 1848 евро хэмжээний цалин хөлсийг ОАТ-аас чөлөөлдөг байна.

Мөн олон улсын спортын арга хэмжээ болон олон улсын холбоог дэмжих зорилгоор үндэсний хэмжээнд янз бүрийн ерөнхий нөхцөлүүд байдаг байна. ОАТ-ын тухай хуулийн 50 дахь зүйлийн 7 дахь хэсэгт улсын эдийн засагт ач холбогдол бүхий онцгой арга хэмжээний хувьд татварын үүргийг хязгаарлах тухай тусгай заалтыг тусгасан байна. Тухайлбал, энэ зохицуулалтаар 2006 оны хөлбөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (ДАШТ)-ийг татвараас чөлөөлсөн бол 2008/09 оны мөсний хоккейн ДАШТ-ийг улсын эдийн засагт ач холбогдолтой гэж үзээгүй байна.

Цалин хөлс буюу хөрөнгийн орлогын албан татварын хувьд спортын салбартай холбогдох зохицуулалт байхгүй байна. Гэвч эдгээр эрх зүйн орчны ерөнхий зохицуулалт спортод хамаарна. Тухайлбал, ажилтныг ажилд авч, ажиллуулах.

Газрын албан татварын хувьд спортын холбооны чиг үүргийг хэрэгжүүлэх зориулалтын бүх төхөөрөмж (талбай) газрын татвараас чөлөөлөгдсөн байдаг байна. Энэхүү зохицуулалт нь бүх төрлийн туслах өрөө тасалгаа, тухайлбал хувцас солих, усанд орох, шүршүүр, сургалтын болон хичээлийн гэх мэт өрөөнд ч мөн адил хамаарна.

Түүнчлэн морин уралдааны бооцооны болон лоттоны татвар гэж байдаг байна. Морин уралдаан зохион байгуулдаг морин уралдааны холбоо л гэхэд морь үржүүлгийн ажлаа санхүүжүүлэхийн тулд татварын зардлын 96% хүртэл хувийг буцаан авдаг байна.

Эцэст нь өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвараас спортын холбооны эзэмшиж байгаа тусгай зориулалтын автомашиныг чөлөөлдөг байна. Гэхдээ үүнийг татварын эрх зүйгээр бус харин замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрлийн журмын дагуу хэрэгжүүлдэг байна.

Эдгээр зохицуулалтыг үндэслэн төсвийн шинжилгээ хийж, татварын орлогын доод хэмжээг (ялангуяа ААНАТ болон ОАТ-ын) тогтоосон судалгааны мэдээ харахан алга байна. Энэ талаар нарийн тоо гаргах боломж байхгүй юм. Гэхдээ төрийн хэмжээнд хэдий хэмжээний тэтгэлэг, нөхөн олговор буюу ивээн тэтгэлгийн зориулалтаар дэмжлэгт зарцуулж байгаа нь тодорхой байдаг байна. Энэ тал дээр Европын комиссоос чухам ямар тэтгэлгийг татаас гэж тодорхойлох талаар нэгдсэн удирдамжаар хангах шаардлага тулгарч байна.

Германы Спортыг дэмжих сан

Германы Спортыг дэмжих сан (“Герман спортын тусламж”) нь иргэний эрх зүйн дагуу 1967 онд байгуулагдсан нийгэмд үйлчилдэг сан бөгөөд олон улсын аварга шалгаруулах

³⁵² промилль

тэмцээнд оролцож, улс үндэстнээ төлөөлөх замаар тамирчны гаргасан хүчин чармайлтыг үнэлэхэд нийгмийн, сэтгэл санааны болон материаллаг дэмжлэг үзүүлэх зорилготой юм.³⁵³ Эх орныхоо нүүр царайг илтгэхэд оруулсан хувь нэмрийнхээ хариуд тамирчин санхүүгийн дэмжлэг авах нь зүйд нийцнэ. Тус сан нь Холбооны улсын Ерөнхийлөгчийн ивээл дор байдаг байна.

Спортын оргил амжилт үзүүлэхээр бэлтгэж байгаа, үзүүлж буй болон үзүүлсэн тамирчин нь өөрийн байгаа байдал, амжилт гаргах бэлэн байдлаараа үндэсний болон олон улсын хэмжээнд ХБНГУ болон түүний нийгэмд үлгэр дууриал бөгөөд нийтийн биеийн тамирын хөдөлгөөний хөдөлгөх хүч³⁵⁴ мөн юм.

Дэмжлэг

Их спортыг хөгжүүлэхэд зориулсан 50 жилийн үйл ажиллагааны туршид тус сан нь тамирчдыг дэмжих бодлогоо байнга боловсронгуй болгож ирсэн. Энэхүү дэмжлэгийг авснаар тамирчин нь орчин үеийн их спортын уралдаан тэмцээнд амжилт гаргахын зэрэгцээ их спортыг орхисон хойно ч ажил мэргэжлийн замналаа (дунд сургууль дүүргэх, мэргэжлийн сургалт авах, дээд боловсрол эзэмших, мэргэжлээрээ ажиллах) ахиулан дээшлүүлэх боломжтой болох юм.

Сан нь үндэсний мэргэжлийн холбоодтой маш нарийн тохиролцсоны үндсэн дээр спортын оргил амжилт гаргахад нь бэлтгэх, гаргах буюу бүр гаргачихсан байгаа 4 000 орчим тамирчинд тасралтгүй дэмжлэг үзүүлж байна. Олон улсын уралдаан тэмцээнд гаргасан амжилт нь тамирчныг сонгон шалгаруулахад шийдвэрлэх үзүүлэлт болдог бол залгамж халааны хувьд амжилтын ирээдүйг нь харгалзан үздэг байна.

Дэмжлэг авах тамирчин

Олимпын төрлийн холбооны улсын шигшээ багийн тамирчин болон олимпын бус төрлийн шилэгдсэн тамирчин дэмжлэг авна. Паралимпын тамирчин нь олимпын төрлийн “Шилдэг баг” болон “Ирээдүйн шилдэг баг” хөтөлбөртэй адил үндсэн дэмжлэг авах бөгөөд спортын амжилт болон ажил мэргэжлийн байдлаас хамааран нэмэлт хөтөлбөрөөс сонгон хамрагдана. Сонсголгүй хүний спортын хувьд дийфлимпын шигшээ багийн бүх тамирчин нь сар тутмын үндсэн дэмжлэг дээр нэмэлтээр зорилтот хөтөлбөрөөс сонгон авдаг байна.

Дэмжлэгийн бодлого

Одоогийн дэмжлэгийн бодлогыг их спортын үндэсний холбоод болон тамирчдын төлөөлөлтэй хамтран боловсруулсан. Бодлого нь спортын амжилт болон ирээдүйн олон улсын хандлагад тулгуурлан тамирчны хувийн хэрэгцээнд чиглэсэн байх бөгөөд ур чадвартаа тохирсон мэргэжлийн ажилтай болох хүртэл нь туслахад оршино. Сүүлийн үед бодлого нь их спортыг мэргэжлийн сургалттай холбоход илүү хүчин чармайлт гаргахад чиглэж байна. Иймд энэ нь үнэ цэн (үнэлэмж)-д чиглэсэн спортын дэмжлэг гэдгийг харуулахын сацуу медиа болон зах зээлийн наймаачны хэмжүүрээр харалгүйгээр олон жилийн турш, цаашлаад идэвхтэй замналаас нь хойш ч тамирчныг халамжлах, шийдвэрлэх үүрэг хариуцлагын илэрхийлэл юм.

³⁵³ Германы спортыг дэмжих сан-Stiftung Deutsche Sporthilfe-*германаар*
https://de.wikipedia.org/wiki/Stiftung_Deutsche_Sporthilfe

³⁵⁴ Motivator-*германаар*

Үндсэн дэмжлэг

Үндэсний шигшээ багийн тамирчин нь дараах үндсэн дэмжлэгийг авна:

- осол аваар, хувийн хариуцлага, эрх зүйн хамгаалалт болон гадаадын эрүүл мэндийн даатгалыг багтаасан даатгалын багц;
- үнэгүй бүтээгдэхүүн болон үйлчилгээний өргөн хүрээний санал тавих;
- мэргэжлийн баримжаа олгох, зар сурталчилгааны дасгал, медиатай харилцах гэх мэт үнэгүй семинарт хамруулах;
- богино хугацааны дадлага хийх, мэргэжлийн ажилд зуучлахад түлхүүр үгээр сонгон шалгаруулах зорилготой олон тооны компани бүхий “Ирээдүйн үсрэх самбар” нэртэй сангийн замналын порталд нэвтрэх эрх.

Үндсэн дэмжлэгийн хүрээнд дараах санхүүгийн тусламжийг авах боломжтой: сангаас амжилтын дагуу зардалд (жишээ нь, спортын амжилтын зорилгод хүрэхийн төлөө, спортын буюу мэргэжлийн сургалтын зардал) нийцүүлэн шилэгдмэл тамирчдыг дэмжин нэг удаа буюу тогтмол санхүүжүүлэх зорилгоор их спортын холбоо тус бүрд жил тутам төсөв хуваарилдаг байна. Үнэлгээний хорооны зөвшөөрлийг үндэслэн тамирчин тус бүрд мөнгийг нь шууд олгодог байна.

Мөн шилэгдмэл өсвөрийн хөл бөмбөгийн тамирчинд DFL (Германы Хөл бөмбөгийн Лиг) сангийн санхүүжилтээр сар тутам 200 евро тэтгэлгийг олгодог байна.

Ирээдүйн шилдэг баг (Үндсэн дэмжлэгийн нэмэлт)

Энэхүү дэмжлэгийг Холбооны улсын Дотоод хэрэг, Барилга болон Эх орны яам санхүүжүүлдэг бөгөөд ДАШТ буюу олимпын наадам, паралимпэд эхний 8 байранд шалгарсан тамирчдад ойрын 1-8 жилийн хугацаанд олгодог байна. Сарын тэтгэлгийн хэмжээ нь 700 евро буюу 300 евро байна. Үүн дээр нэмээд:

- оюутан бол Германы Банк (Deutsche Bank)-ны тэтгэлэг (сард 300 евро);
- мэргэжлийн сургуулийн сурагч бол сард 300 евро хүртэл;
- дунд сургуулийн сурагч бол дотуур байрны тэтгэлэг сард 100 евро;
- тус дэмийн нөхөн олговор (жилд 2 000 евро хүртэл);
- ажилтан бол холбооны арга хэмжээнд оролцохоор ажлаас чөлөөлөгдсөний төлбөр.

Түүнээс гадна Ирээдүйн шилдэг багийн тамирчин нь ажилд орохоор бол хувийн ментор томилж өгдөг байна.

Шилдэг баг (Үндсэн дэмжлэгийн нэмэлт)

ДАШТ буюу олимпын наадам, паралимпод эхний 8 байранд шалгарсан буюу адилтгах амжилт гаргасан (голдуу олимпын шигшээ багийн) тамирчдад сар тутам 800 евро буюу 400 евро тэтгэлэг олгодог байна. Нэмэлтээр:

- оюутан бол Германы Банкны тэтгэлэг (сард 300 евро);
- мэргэжлийн сургуулийн сурагч бол сард 300 евро хүртэл;
- дунд сургуулийн сурагч бол дотуур байрны тэтгэлэг сард 100 евро;
- мус дэмийн нөхөн олговор (жилд 2 000 евро хүртэл);
- ажилтан бол холбооны арга хэмжээнд оролцохоор ажлаас чөлөөлөгдсөний төлбөр.

Түүнээс гадна Шилдэг багийн тамирчин нь ажилд орохоор бол хувийн ментор томилж өгдөг байна. Мөн ганцаарчилсан олимпын төрөлд ДАШТ-ний медальтан бол Mercedes-Benz компанийн нэрэмжит элитийн тэтгэлэг хүртэнэ (сард 400 евро нэмэлт).

Спортын тэтгэлгийн албанд харьяалалгүй (Холбооны Улсын Зэвсэгт хүчин г.м.) тамирчны хувьд олимпын наадмын бэлтгэлийн үеэр PwC компанийн нэрэмжит тэтгэлгийг 18 сар хүртэлх хугацаагаар шууд авдаг байна (сард 1,000 евро нэмэлт). “Герман спортын тусламж”-ийн Магадлан итгэмжлэх үнэлгээний хорооны шийдвэрээр тус тэтгэлгийн элсэлтийг зохион байгуулдаг байна.

Зодог тайлсны дараах тэтгэлэг

Шилдэг багийн тэтгэлэг нэг удаа хүртсэн тамирчин нь спортын замналаа орхисон хойно дараах санхүүгийн дэмжлэг хүртдэг байна:

- Германы Банкны тэтгэлгийг (сард 300 евро, ердийн суралцах хугацаа буюу 3 жил хүртэл);

Түүнээс гадна өрсөлдөх чадвар бүхий мэргэжлийн ажлын гарааг нь дэмжин дараах тусламжийг үзүүлдэг байна. Үүнд:

- ажилд орох хүртэл нь ментор багшаар хангах;
- тус сангийн “Ирээдүйн үсрэх самбар” замналын порталд нэвтрэх эрх;
- Дюссельдорф дахь WHU-Otto Beisheim Удирдлагын Дээд сургуульд Бизнесийн удирдлагын магистр (MBA-Master of Business Administration) мэргэжлээр суралцвал сургалтын төлбөрийг санхүүжүүлэх боломж.

Санхүүжилт

Тус сан нь 1967 оноос хойш залуу авьяастнууд болон шигшээ багийн тамирчдад зориулан 477 сая евро гаруй санхүүжилт гаргажээ. 2018 онд гэхэд ойролцоогоор 18 сая евро байв. Санхүүжилтийн ихэнх хэсгийг сан нь аж ахуйн нэгжүүдийн хэрэглэдэг хөрөнгө босгох аргыг ашиглан жил тутам шинээр олдог байна. Харин 2018 оноос хойш тус сан нь тамирчдыг дэмжих зориулалтаар төрийн шууд санхүүжилт авдаг болсон байна.

2017 оны байдлаар (төрийн санхүүжилтгүй үе), халамжлагч (итгэмжит хүн), ивээн тэтгэгч нарын оруулсан хандив, тэтгэлэг тус сангийн жилийн орлогын 31% бүрдүүлж байв. Харин 38% нь улам нэмэгдэн буй ач холбогдол бүхий арга хэмжээний³⁵⁵, дэмжлэгийн³⁵⁶ болон үр ашгийн³⁵⁷ хөтөлбөрийн орлогоос орсон байна. Германы Олимпын Спортын Холбооны олимпын зар сурталчилгаанаас олсон нэмэлт хөрөнгийн тусламж үүнд багтана. 19% орчим нь „GlücksSpirale“ (азын спираль) лоттоны орлого бол 12% нь бусад орлогоос бүрдэж байна.

ӨМНӨД АФРИК

Өмнөд Африкийн үндэсний соёлд спортын салбар хамгийн том байр суурь эзэлдэг ба Британийн колоничлолын үеэс хөгжиж эхэлсэн хамгийн түгээмэл гурван спорт байдаг ба үүнд хөл бөмбөг, регби, крикет багтдаг байна. Өмнөд Африк бол крикет, хөл бөмбөг, регби гэсэн спортоор нэгэн зэрэг дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон

³⁵⁵ Event-

³⁵⁶ Förderer-

³⁵⁷ Benefiz-

цөөхөн орны нэг юм. 2021 оны байдлаар дэлхийд спортын салбарт амжилт гаргасан нийт улс орнуудын чансаагаар Өмнөд Африк³⁵⁸ 26 дугаар байранд жагсаж байна.

Өмнөд Африкийн спортын салбарын бодлого

Өмнөд Африкийн спортын тогтолцоо нь иргэдийг нэгтгэх, зөв эрүүл нийгмийг бүтээх, спортын үйл ажиллагааны тогтолцоог тогтвортой хөгжүүлэх үүрэгтэй байна. 1993 онд Үндэсний Спортын Зөвлөл (National Sports Council) нь ардчилсан спортын бүтцийг бий болгох, тэгш шударга спортыг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг дэмжих “Спортын алсын хараа” (Vision for Sport) хэмээх үндэсний спортын бага хурлыг зохион байгуулсан нь одоогийн спортын бодлого, үйл ажиллагааны эхлэлийг тавьсан байна. 2003 онд бие даасан спортын байгууллага, институтүүдийг байгуулсан байна. Үүнд:

- Өмнөд Африкийн Спортын Зөвлөл (South African Council of Sport);
- Өмнөд Африкийн тэгш эрх бүхий олимпийн хороо (South African Non-racial Olympic Committee);
- Өмнөд Африкийн үндэсний олимпийн хороо (National Olympic Committee of SA);
- Үндэсний спортын зөвлөл (National Sport Council).

Үндэсний спорт, соёл амралтын төлөвлөгөө (The National Sport and Recreation Plan) нь спорт, соёл амралтын хүрээнд 8 жил тутамд тогтвортойгоор хэрэгжүүлдэг төлөвлөгөө юм. Үндэсний спорт, соёл амралтын төлөвлөгөө нь дараах гурван үндсэн тулгуур үйл ажиллагаанд суурилдаг байна:³⁵⁹

- иргэдийн спорт, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх хүртээмжийг нэмэгдүүлэх;
- олон улсын спортын амжилт гаргахад нь тамирчдыг дэмжих;
- дээр дурдсан хоёр тулгуур үйл ажиллагааг биелүүлэх таатай орчныг бүрдүүлэх.

Үндэсний биеийн тамир, соёл амралтын яам (The national department of sport and recreation) жил бүр дээрх гурван тулгуурт үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт шалгалт, мониторинг хийдэг байна.


Өмнөд Африкийн спортын тогтолцооны бүтэц

Нийтийн болон мэргэжлийн спортын системийн үйл ажиллагаа бодлогыг Засгийн газраас удирдаж санхүүжүүлдэг. Спортын бодлогын тэргүүлэх чиг үүрэгт үндэсний болон дэлхийн хэмжээнд спортын амжилт үзүүлэх мөн спортын аялал жуулчлал, спортоор хичээллэх ая тухтай орчныг бүрдүүлэх зэрэг багтсан байдаг.

Өмнөд Африкийн спортын тогтолцоог хэрэгжүүлэхэд төрийн эрх баригчид болон төрийн бус байгууллага (бүлэг) оролцдог ба эдгээрийг "оролцогч талууд" гэж нэрлэдэг. Эдгээр оролцогч талууд спорттой холбоотой үйл ажиллагаа, түүний шийдвэр, мөн спортын бодлогод нөлөөлдөг байна. Спортын тогтолцоонд эдгээр оролцогч талууд бие биедээ харилцан өөр өөрийн чиг үүргийн дагуу уялдан үйл ажиллагаа явуулдаг. Дараах схемд Өмнөд Африкийн спортын байгууллагуудын оролцогч талуудын харилцаа хамаарлыг дүрслэв.

³⁵⁸ <https://www.worldsportranking.info/2021-final-ranking>

³⁵⁹ Sports in South Africa, Shaundre Jacobs 2018



SRSA: Өмнөд Африкийн спорт, соёл амралтын яам
 SASCOC: Өмнөд Африкийн спортын холбоо, Олимпын хороо

Оролцогч талууд:

1. Өмнөд Африкийн спорт, соёл амралтын яам (Sport and Recreation South Africa)
Үүрэг (Responsibility): Бусад бүх бүтцэд дэмжлэг үзүүлэх;
Эрх үүрэг (Mandate): Хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх; Бодлого тодорхойлох; Санхүүжүүлэх; Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ;
2. Өмнөд Африкийн спортын холбоо, Олимпын хороо (South African Sport Confederation & Olympic Committee, SASCOC)
Үүрэг (Responsibility): Стратегийн чиглэл, удирдамжаар хангах;
Эрх үүрэг (Mandate): Академийн системийн ажлуудыг хэрэгжүүлэх; Академийн магадлан итгэмжлэл, удирдлагын ажлыг хариуцах; Дасгалжуулалтын систем ба бүтэц; Спортын шинжлэх ухаан, эрүүл мэнд эмнэлгийн үнэлгээ; Спортын технологи; Ажил мэргэжлийн боломж, зөвлөмж, авьяас чадварыг сонгох, хөгжүүлэх; Орон нутгийн спортын байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх.
3. Үндэсний спортын холбоод (National sporting federations)
Үүрэг (Responsibility): Өмнөд Африкийн спортын холбоо, Олимпын хорооноос хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэх;
Эрх үүрэг (Mandate): Спортын тусгай протоколын талаар зааварчилгаа өгөх; Орон нутагтай холбоотой спортын тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
4. Орон нутгийн спорт, соёл амралтын газрууд (Provincial Departments on Sport & Recreation)
Үүрэг (Responsibility): Орон нутгийн спортын байгууллагуудыг дэмжих;

Эрх үүрэг (Mandate): Тамирчдыг дэмжих ажлын явцыг хянах; Орон нутгийн спортын байгууллагуудыг санхүүжүүлэх; Спортын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах;
5. Орон нутгийн засаг захиргаа (Local government)
Үүрэг (Responsibility): Орон нутгийн түвшинд бодлого боловсруулах;
Эрх үүрэг (Mandate): Спорт, амралт чөлөөт цагийн бодлогыг хэрэгжүүлэх, хянах; Спортын байгууллагууд, клубууд болон хувь хүмүүсийг санхүүгийн дэмжлэг үзүүлэх; Хотын захиргаа, метро, дүүргийн спорт, амралт зугаалгын дэд бүтцийг барих, шинэчлэх, засвар үйлчилгээ, менежмент хийх.

Өмнөд Африкийн спортын санхүүжилт

Өмнөд Африкийн спортын салбарын нийтийн спорт болон мэргэжлийн спортыг улсаас санхүүжүүлдэг.³⁶⁰ Өмнөд Африкийн спорт, соёл амралтын газраас үзүүлж буй санхүүгийн дэмжлэг нь дээрх хүснэгтэд байгаа оролцогч талуудын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой юм. Өмнөд Африкийн спортын салбарын хөгжил Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, санхүүжилтээс шууд хамааралтай байна. Доорх хүснэгтэд 2013-2018 оны Засгийн газраас олгосон санхүүжилтийн үнийн дүнг харуулав.

Засгийн газраас Өмнөд Африкт спорт, соёл амралтын зардал, санхүүжилтийн үр дүнгийн зураглал (2013-2018)

Санхүүжилтийн жил	Нийт Төсөв	Спортын салбарын Санхүүжилт	Спортын дэд бүтцийн санхүүжилт
2013/2014	R1 073.5 bil	R115.8 mil	R4.6 mil
2014/2015	R966.8 mil	R148.9 mil	R4.9 mil
2015/2016	R979.9 mil	R153.9 mil	R2.8 mil
2016/2017	R1 023.6 bil	R147.1 mil	R12.5 mil
2017/2018	*R1 066.4 bil	*R149.6 mil	* R12.0 mil

Эх сурвалж: Budget 2017, Estimates of national expenditure (2017) (SRSA National treasury); Budget 2018, Estimates of national expenditure (2018)

Тайлбар: Санхүүгийн жил бүрийн нийт төсөвт тусгагдсан хөрөнгийн шилжүүлгийн зардал, татаас, хөрөнгийн төлбөрийг хүснэгтэд харуулаагүй болно. (*) 2017/2018 оны зардал (*) нь аудитаар баталгаажуулаагүй дүн юм. Валют: Нэг сая Өмнөд Африкийн ранд = 666369.307 евро (2018)

Өмнөд Африкийн төсвийн бүрэн хуваарилалтын талаарх тайланд тусгагдсанаар 2016 онд Спортын салбар бусад салбаруудтай харьцуулахад хамгийн бага төсөв хуваарилагдсан байна. Санхүүгийн нөхцөл байдлаас авч үзвэл, олон улсын спортын амжилтад хүргэдэг спортын төсөл нь мэргэжлийн спортод илүү их хөрөнгө зарцуулдаг улс орнууд тамирчдад амжилтад хүрэх илүү их боломжийг бүрдүүлдэг болохыг харуулсан (De Bosscher et al. 2015).

Спортын санхүүжилтийн хувьд орон нутгийн болон үндэсний Засгийн газраас авсан санхүүжилтээс гадна Үндэсний сугалааны итгэлцлийн сангаас (National lottery distribution trust fund NLDTF) мөн санхүүжилт авдаг (SRSA 2013). Үндэсний сугалааны итгэлцлийн сан нь ашгийн бус байгууллага бөгөөд сайн үйлсийн арга хэмжээнд зориулан олон нийтээс санхүүжилт босгодог. Олон жилийн турш Үндэсний сугалааны итгэлцлийн

³⁶⁰ Country profiles sport in South Africa 2018, Budget speech 2017,

сангаас нь Өмнөд Африкийн олон нийтийн спорт, мэргэжлийн спортыг хөгжүүлэхэд дөрвөн тэрбум Өмнөд Африк ранд (1 тэрбум SA ранд нь 2.7 тэрбум евротой тэнцэнэ) санхүүжүүлсэн байна (2017).

Үндэсний сугалааны итгэлцлийн сан (NLDTF):

Сугалааны тухай хуулийн дагуу удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан.³⁶¹ Уг сангаас үүссэн мөнгөний эх үүсвэрийг урлаг, соёл, сайн үйлсийн аян, спорт зэрэг салбаруудад хөрөнгө оруулалт хийдэг байна. Уг сан нь үндэсний сугалааны комисст харьяалагддаг ба жил бүр Үндэсний сугалааны итгэлцлийн санд оруулсан хөрөнгө оруулалтын тайланг парламентдаа тайлагнаж байх үүрэгтэй байна. Одоогийн байдлаар Үндэсний лоттерейн орлогын 27 хувь нь Үндэсний сугалааны итгэлцлийн санд шилжиж байна. Үүнд санд байгаа мөнгөнөөс олсон хүүгийн орлогыг мөн төвлөрүүлдэг ба тухайн санхүүгийн жилд хуваарилагдаагүй мөнгө тус санд үлдэж, дараагийн жилүүдэд спортын арга хэмжээнд олгох боломжтой юм.

Мөн дээрх Үндэсний сугалааны итгэлцлийн сангаас гадна бусад жижиг төрийн бус байгууллага болон хувийн спортын академиуд нь орон нутгийн спорт, амралт чөлөөт цагийг хөгжүүлэхэд нэмэлт туслалцаа үзүүлж, төрийн байгууллагуудтай хамтран ажилладаг байна. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшил, бизнес эрхлэгчид болон олон улсын хандивлагчид спортын клуб, холбоо эсвэл хувь тамирчдыг шууд ивээн тэтгэх хэлбэрээр өөрсдийн дансаар хөрөнгө оруулалт хийдэг (SRSA 2013). Гэхдээ эдгээр хувийн компаниуд төрөөс хэрэгжүүлж буй спортын бодлогод шууд нөлөөлдөггүй байна.

ЯПОН УЛС

Японы спортын удирдлагын бүтэц


Японы спортын удирдлага нь олон тооны яам, төрийн байгууллагуудыг хамардаг бөгөөд спортыг түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх, сурталчлах үндсэн ажлыг хэрэгжүүлэгч дээд байгууллага нь “Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам (MEXT)³⁶²” байна. Түүний дотор спортыг хариуцсан газар нь “Японы спортын агентлаг (JSA)³⁶³” байна. Японы спортын агентлаг нь спорттой холбоотой бодлогыг сурталчлах, спортод чиглэсэн улс орныг бий болгохоор ажиллаж байна. Японы спортын агентлаг нь дараах бүтэцтэй байна.



³⁶¹ <https://www.nlcsa.org.za/the-nldtf/#:~:text=The%20National%20Lottery%20Distribution%20Trust,use%20to%20benefit%20good%20causes.>

³⁶² <https://www.mext.go.jp/en/about/index.htm>

³⁶³ <https://www.mext.go.jp/sports/en/index.htm>



Японы спортын агентлагийн үйл ажиллагаа нь Спортын үндсэн хуулийн 9-р зүйлээр 2012 оны 03-р сард байгуулагдсан спортын үндсэн төлөвлөгөөнд суурилдаг. Энэхүү төлөвлөгөө нь 2012 оноос эхлэн 10 жилийн хугацаанд спортын бодлогыг хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг зааж өгсөн байна.

Спортын үндсэн төлөвлөгөөнд 2012-2016 он хүртэл таван жилийн хугацаанд долоон сэдвийг жагсаасан бөгөөд спортыг идэвхтэй сурталчлах, Япон улсыг спортын үндэстэн болгохыг эрмэлздэг. Тухайлбал,

1. хүүхдийн спортоор хичээллэх боломжийг нэмэгдүүлэх;
2. амьдралын үе шатанд нийцүүлэн спортын үйл ажиллагааг сурталчлах;
3. оршин суугчид идэвхтэй оролцох боломжтой олон нийтийн спортын орчныг сайжруулах;
4. олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд хүний нөөцийг сургах, спортын орчныг хөгжүүлэх;
5. Олимп, Пара-Олимпын наадам зэрэг олон улсын тэмцээн уралдаанд оролцох, зохион байгуулах тендерт оролцох замаар олон улсын солилцоо, хувь нэмрийг дэмжих;
6. спортын ертөнц дэх ил тод байдал, шударга ёсыг сайжруулах;
7. спортын ертөнцөд ээлтэй орчныг бий болгох.

Эдгээр долоон өргөн сэдвийн хүрээнд төлөвлөгөөнд 19 нарийн бодлого тусгагдсан бөгөөд үүнд хэрэгжүүлэх 165 тодорхой арга хэмжээг тусгасан байна.

2017 оны 03-р сард JSA Спортын үндсэн төлөвлөгөөг шинэчилсэн. 2017 оны 04-р сараас эхлэн хэрэгжүүлэх хоёр дахь таван жилийн төлөвлөгөө нь бодлогын үндсэн дөрвөн зорилтоос бүрдэнэ. Үүнд:

1. спортоор хичээллэдэг, үздэг, дэмждэг хүмүүсийн тоог нэмэгдүүлэх, түүнчлэн үүнийг бодит болгохын тулд боловсон хүчний бэлтгэл, орчин нөхцөлийг сайжруулах;

2. ард түмэн нь хүчтэй холбоогоор холбогдсон эрч хүчтэй нийгмийг бий болгохын тулд спортыг ашиглах;
3. олон улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх хүчтэй, тогтвортой орчин, сургалтын тогтолцоог хөгжүүлэх;
4. цэвэр, шударга спортын арга хэмжээг сурталчлах замаар спортын үнэ цэнийг нэмэгдүүлэх.

Эдгээр дөрвөн сэдвийг мөн адил хэрэгжүүлэх 139 тодорхой арга хэмжээг агуулсан 19 нарийн бодлогод хуваадаг байна.

Спортын тухай хууль

1961 онд Токиогийн олимпын наадам болоход гуравхан жилийн хугацаа үлдээд байсан бөгөөд ард түмнийхээ сэтгэл догдолж буй энэ үед Японы засгийн газар Японд спортыг дэмжих үндсэн суурь бодлогыг тодорхой болгох зорилгоор "Спортыг дэмжих тухай хууль"³⁶⁴-ийг баталжээ.

Уг хуулиар спортын төрлийг тодорхойлох, үндэсний болон орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, спортыг дэмжих арга хэмжээний талаар удирдлагуудыг урамшуулах, барилга байгууламжийн засвар үйлчилгээг сайжруулах, төрөөс үзүүлэх тусламжийг тодорхойлох зэрэг арга хэмжээг цогцоор нь тодорхойлсон. Энэ хууль нь тухайн цагаас хойш Японд спортыг хөгжүүлж дэлгэрүүлэх үндэс суурь болж ирсэн. 2011 оны 06-р сард Спортын хуульд 50 жилийн дараа анх удаа Спортыг дэмжих тухай хуулийг иж бүрэн шинэчлэн найруулж, баталсан. Уг хууль нь 35 зүйл, нэмэлт заалтаас бүрдэх ба оршил хэсэгт “Спорт бол хүн төрөлхтний нийтлэг соёл мөн” гэж тунхагласан байна. Цаашилбал, уг хуульд спортыг “Иргэд насан туршдаа эрүүл саруул, сэтгэл санаа, бие бялдрын хувьд бүрэн дүүрэн амьдрахад нэн чухал” гэж тодорхойлж, спортоор хичээллэж аз жаргалтай, үр бүтээлтэй амьдрах нь иргэн бүрийн эрх мөн гэдгийг тодорхой заасан байна.

Спорт нь зөвхөн хувь хүнд нөлөөлөөд зогсохгүй тухайн нутаг дэвсгэрийн эв нэгдэл, эрч хүчийг бий болгож, бүс нутгийн нийгмийг сэргээхэд хувь нэмрээ оруулах боломжтой гэж уг хуульд заасан байдаг. Энэ нь Японы тамирчид олон улсын тэмцээнд өндөр амжилт гаргахын чухлыг онцолж байна. Нэмж дурдахад, уг хуульд спортыг Японы олон улсын статусыг сайжруулах гол элемент гэж тодорхойлсон. Спорт нь манай нийгэмд эрч хүчийг бий болгож, үндэсний эдийн засгийг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж, олон улсын солилцоогоор дамжуулан дэлхийн харилцан ойлголцлыг хөхиүлэн дэмжиж, олон улсын энх тайвныг тогтооход ихээхэн хувь нэмэр оруулна гэж заасан.

Японы спортын зөвлөл түүний бүтэц, спортыг дэмжих сан

Японы спортын зөвлөл (JSC)³⁶⁵ нь “Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам (MEXT)”-ны харьяа спортыг сурталчлах, сургуулийн насны хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, бэхжүүлэх чиглэлээр мэргэшсэн бие даасан агентлаг юм.

JSC нь “Захиргааны байгууллагын ерөнхий дүрмийн тухай хууль (1999 оны 103-р хууль)” болон “Японы Спортын Зөвлөлийн тухай хууль (2002 оны 162-р хууль)” гэсэн хоёр том хууль тогтоомжийг үндэслэн байгуулагдсан.

³⁶⁴ Japan sport policy


³⁶⁵ <https://www.jpnsport.go.jp/corp/english/about/tabid/384/Default.aspx>

Спорт бол эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хангах хамгийн эхний арга зам юм. JSC нь орон нутгийн иргэдээс эхлээд дээд зэрэглэлийн тамирчид хүртэл Японы бүх хүмүүст спортоор хичээллэх боломжийг хөнгөвчлөх зорилготой.

JSC нь сургуулийн насны хүүхдүүдийн биеийн тамирыг сурталчлах, эрүүл мэндийг дэмжих зорилгоор өөрийн спортын байгууламжийг зохистой, үр ашигтай ажиллуулах; спортыг дэмжихэд шаардлагатай тусламж үзүүлэх, сургуулийн хүүхдийн гэмтэл, ослоос хамгаалах; спорт, хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, бэхжүүлэх чиглэлээр судалгаа хийх, спорттой холбоотой материал цуглуулах, хангах; дээр дурдсан үйл ажиллагаанд үндэслэн хүмүүсийн бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

JSC нь спортыг дэмжих, сурталчлах, тэр дундаа спортын олон улсад өрсөлдөх чадварыг сайжруулах, спортын орчныг олон нийтийн түвшинд хөгжүүлэх, сайжруулах зорилгоор “Спортыг дэмжих сан”³⁶⁶ болон “Спортыг дэмжих сугалаа” зэргээс спортыг хөгжүүлэх төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Сугалаанд суурилсан санхүүжилтийн системээрээ дамжуулан нийт хүн ам болон элит тамирчдын спортын дасгал сургуулилтыг нэгэн зэрэг хөгжүүлэх зорилтыг хангахуйц бизнесийн оновчтой загварыг санал болгож байна.

Японы спортын зөвлөл түүний бүтэц



Спортыг дэмжих сан болон спортыг дэмжих сугалаа нь улсын төсвөөс санхүүжих боломжгүй спортыг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагаанд мөнгөн дэмжлэг олгох замаар татаас дэмжлэг болох нэмэлт санхүүжилтийн үүрэг гүйцэтгэдэг.


Спортыг дэмжих сан

1990 онд зохиогдсон Азийн наадамд Япон улс тааруухан үр дүнтэй оролцсоны улмаас Японы спортыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварын түвшнийг сайжруулах шаардлага үүссэн. Үүнээс үүдэн, спортын салбарын удирдлагууд, эдийн засгийн хүрээнийхэн болон бусад хувийн хэвшлийн байгууллагуудын хүсэлтийн дагуу “Спортыг дэмжих санг” байгуулжээ. Спортыг дэмжих сангийн зорилго нь Японы спортын олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, спорт сонирхогчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор байгуулагдсан. Одоогийн байдлаар төрийн хандив, буцалтгүй тусламжаар олсон үйл ажиллагааны ашгийг спортын байгууллага, хувь тамирчин, дасгалжуулагчдын спортын үйл ажиллагаанд татаас болгон хуваарилж байна. Спортыг дэмжих сангийн төсвийг бүрдүүлэгчид нь дараах төрөлд байна.

1. Засгийн газраас үзүүлж буй мөнгөн тусламж;
2. Хувийн байгууллагын хандив тусламж;

³⁶⁶ <https://www.jpnsport.go.jp/corp/english/about/tabid/396/Default.aspx>

3. Спортыг дэмжих сугалааны орлого.




JCS нь 2022 онд спортыг дэмжих сангаас 1700 орчим төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулж санхүүжилт олгосон бөгөөд нийт 16.89 тэрбум иений³⁶⁷ мөнгөн тусламж үзүүлсэн байна Үүнд:

1. Спортыг дэмжих сугалааны татаас-14.76 тэрбум иен;
2. Спортыг дэмжих сангийн татаас- 1.85 тэрбум иен;
3. Өрсөлдөх чадварыг сайжруулах үйл ажиллагааны татаас- 0.28 тэрбум иен.

Спортыг дэмжих сангийн татаас 2022

Sports Promotion Fund subsidy in Japan in fiscal year 2022, by category (in billion Japanese yen)



³⁶⁷ <https://www.statista.com/statistics/1219568/japan-sports-promotion-fund-subsidy-by-category/>

Спортыг дэмжих сугалаа

1998 онд спортыг дэмжих санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор “Спортыг дэмжих сугалааны тухай хууль”³⁶⁸-ийг өргөн барьж баталсан байна. Уг хуульд үндэслэн 2001 онд спортыг дэмжих сугалааг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь Японы ард иргэдэд “Ж”-лигийн (Японы мэргэжлийн хөл бөмбөгийн) тоглолтын үр дүнгээр бооцоо тавих боломжийг олгосон. 2002 оноос хойш сугалааны ашгийн тодорхой хэсгийг спортыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан.

Тус хуулийн 21 дүгээр зүйлд сугалааны орлогыг орон нутгийн засаг захиргаа, спортын байгууллагуудад хэрхэн зарцуулах, хуваарилахыг заасан. Спортыг дэмжих сугалааны татаасын хуваарилалтыг МЕХТ-ээс боловсруулсан “Спортыг дэмжих сугалааны ашгаас олгох татаасын үндсэн бодлого”-ын дагуу тогтоодог.

Орон нутгийн засаг захиргаанд хуваарилагдсан санхүүжилтээр спортын холбоодод дэмжлэг хэлбэрээр олгодог бөгөөд ихэвчлэн хүн бүр спортоор хичээллэх боломжтой орчныг бүрдүүлэх хөтөлбөрүүдэд ашигладаг. Үүнд: Зүлэг талбайг тохижуулах, орон нутгийн спортын байгууламжийн зураг төсөл боловсруулах, орон нутагт спортын ангиудыг зохион байгуулах зэрэг төслүүд хамрагдсан байна.

Сугалааны тасалбарын борлуулалтын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгийг сугалаанд ялагчдад шагналын мөнгө болгон өгч, дараа нь үлдсэн ашгийн гуравны хоёрыг (удирдлагын зардлыг хассаны дараа) спортыг дэмжих татаас болгон, үлдсэн гуравны нэг нь улсын сан хөмрөгт орж, боловсрол, соёлыг хөгжүүлэхэд зориулагдана.

2016 оны нэмэлт, өөрчлөлтөөр орон нутгийн засаг захиргаа, спортын байгууллагуудад татаас болгон ашигладаг сугалааны ашгийн харьцааг гуравны нэгээс наймны гурав болгон нэмэгдүүлсэн байна.



³⁶⁸ https://www.ssf.or.jp/en/files/SportWhitePaperinJapan2017_c.pdf

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХБНГУ

- Спорт дахь санхүүжилт-Спортын төрийн дэмжлэг-Staatliche Sportförderung – Finanzierung im Sport-*германаар*
<https://www.degruyter.com/document/doi/10.1524/9783486717525.143/pdf>
- Зах зээл ба төрийн харилцан хүчинд орших спортын санхүүжилт, Хамбургийн Их сургуулийн хэвлэн нийтлэл, 2009-Sportfinanzierung – Spannungen zwischen Markt und Staat, Hamburg University Press, 2009- *германаар*
<https://library.oapen.org/bitstream/handle/20.500.12657/27635/1002370.pdf>
- Германы спортыг дэмжих сан-Stiftung Deutsche Sporthilfe-*германаар*
https://de.wikipedia.org/wiki/Stiftung_Deutsche_Sporthilfe
- Спортын барилга, байгууламж барихад үзүүлэх дэмжлэг: Холбоодод өгөх зөвлөмж-Förderung Sportstättenbau: Tipps für Vereine-*германаар*
<https://www.sportstaettenrechner.de/wissen/sportstaettenfoerderung/sportstaettenbau/>

БНСУ

- Соёл, спорт, аялал жуулчлалын яам
<https://www.mcst.go.kr/english/statistics/statistics.jsp>
- Спортын хорвоо <https://www.mcst.go.kr/english/useful/usefulLink.jsp>
- Спортын сан <https://www.mcst.go.kr/english/useful/usefulLink.jsp>
- Korean sports fund <https://olympics.com/ioc/legacy/seoul-1988/the-korea-sports-promotion-foundation>
- <https://www.worldsportranking.info/2021-final-ranking>

ӨМНӨД АФРИК

- Sports in South Africa, Shaundre Jacobs 2018
- Country profiles sport in South Africa 2018, Budget speech 2017,
- <https://www.nlcsa.org.za/thenldtf/#:~:text=The%20National%20Lottery%20Distributi,use%20to%20benefit%20good%20causes.>

ЯПОН

- Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам (MEXT)
<https://www.mext.go.jp/en/about/index.htm>
- Японы спортын агентлаг (JSA) <https://www.mext.go.jp/sports/en/index.htm>
- Спортыг дэмжих тухай хууль-Japan sport policy
- Японы спортын зөвлөл (JSC)
<https://www.jpnsport.go.jp/corp/english/about/tabid/384/Default.aspx>
- Спортыг дэмжих сан
<https://www.jpnsport.go.jp/corp/english/about/tabid/396/Default.aspx>
- Дүн мэдээ <https://www.statista.com/statistics/1219568/japan-sports-promotion-fund-subsidy-by-category/>
- Спортыг дэмжих сугалааны тухай хууль
https://www.ssf.or.jp/en/files/SportWhitePaperinJapan2017_c.pdf

UIH.MN
СУДАЛГААНЫ САН